



Мобифинанс ББСБ

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА


Андеррайтер:

Өлзий энд Ко капитал ҮЦК





## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД



“Мобифинанс ББСБ” /цаашид “Үнэт цаас гаргагч”, “Компани” гэх/ нь Монгол улсын “Компанийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Санхүүгийн зохицуулах хороо” болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн холбогдох журмын дагуу олон нийтэд анх удаа өрийн хэрэгслийг нээлттэй санал болгон гаргаж байгаа болно.

**ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Тус үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч таны өрийн хэрэгсэл худалдан авах шийдвэр гаргалтад туслах, шаардлагатай гэсэн бүхий л мэдээллийг оруулахыг зорилоо.

Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай болох буюу лавлах тодруулах нэмэлт зүйл гарвал Үнэт цаас гаргагч “Мобифинанс ББСБ” ХХК болон Андеррайтер “Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК-тай танилцуулгад тусгагдсан хаягаар хандана уу.





## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД



### ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ



“МОБИФИНАНС ББСБ” ХХК

📍 Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнеско гудамж, МПМ цогцолбор

✉ e-money@mobicom.mn

☎ +976-7575-2255

🌐 www.monpay.mn

### ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР



“ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК” ХХК

📍 Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити Центр, 10 давхар, 1003 тоот

✉ info@ucc.mn

☎ +976-7777-6377

🌐 www.ucc.mn

### АУДИТЫН КОМПАНИ

“ПРАЙС УОТЕРХАУС КУПЕРС АУДИТ” ХХК

📍 Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Сэнтрал Тауэр, 6 давхар, 601 тоот

🌐 www.pwc.com

☎ +976-7000 9089

📠 +976-11 322068

### ХУУЛИЙН ФИРМ



“ЭМ ДИ ЭС ХААНЛЕКС” ХХН

📍 Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

🌐 www.mdsa.mn

☎ +976-11 330048

📠 +976-11 330049





# ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ



## “МОБИФИНАНС ББСБ” ХХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 06 дугаар сарын 24

#АН-SHM 06/21

Улаанбаатар хот

“Мобиком Корпораци” ХХК (цаашид “Хувьцаа эзэмшигч” гэх) нь “Мобифинанс ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх) ийн зарласан болон гаргасан хувьцааны 100 хувийг дангаараа эзэмшиж буй цорын ганц хувьцаа эзэмшигч бөгөөд цорын ганц хувьцаа эзэмшигчийн хувьд Хувьцаа эзэмшигчийн дараах тогтоолыг гаргаж байна.

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэг, “Мобифинанс ББСБ” ХХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасныг тус тус **ҮНДЭСЛЭН**,


Компани нь бизнесийн үйл ажиллагаагаа өргөтгөн Банк Бус Санхүүгийн Үйл Ажиллагааны Тухай Хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооны “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын дагуу “Нээлттэй Бонд” гаргах хүсэлт гаргасныг **ХАРГАЛЗАН**,


“Мобифинанс ББСБ” ХХК-ийн Хувьцаа Эзэмшигчийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Энэхүү тогтоолын Хавсралт 1-д заасан нөхцөл бүхий компанийн “Нээлттэй Бонд”-ыг нийтэд санал болгон гаргахаар **ШИЙДВЭРЛЭСҮГЭЙ**.
2. Энэхүү шийдвэрийн хүрээнд өрийн бичгийн нийтэд санал болгон гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, шаардлагатай бичиг баримт, зөвшөөрлийг бүрдүүлэх, холбогдох журмын дагуу арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал Ш.Оюунчимэг-т **ДААЛГАСУГАЙ**.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮРЭН ЭРХИЙГ ХЭНЭГЖҮҮЛЭГЧ:

МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК-ИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮН ЕРӨНХИЙ  
ЗАХИРАЛ  
ТАЦУЯА ХАМАДА





**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД  
 ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД  
 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ  
 АГУУЛГА**

**НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР**

**НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ**

1.1	Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга	11
1.1.1	Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл, хаяг	13
1.1.2	Үнэт цаас гаргагчийн түүх	13
1.1.3	Үнэт цаас гаргагчийн ололт амжилтууд	14
1.1.4	Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлага	14
1.1.5	Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт	15
1.1.6	Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг	17
1.2	Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн мэдээлэл	20
1.2.1	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	21
1.2.2	Үнэт цаас гаргагчийн толгой компанийн мэдээлэл	21
1.3	Үнэт цаас гаргагчийн санхүү, үйл ажиллагааны мэдээлэл	27
1.3.1	Бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга	30
1.3.2	Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл	39
1.3.3	Үнэт цаас гаргагчийн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	45
1.4	Үнэт цаас гаргагчийн байгуулсан гэрээ, хэлцэл	48


**ХОЕР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ**


2.1	Зах зээлийн судалгаа, өрсөлдөгчийн судалгаа	50
2.1.1	Хэрэглэгчийн зан төлөвийн судалгаа	59
2.2	Макро эдийн засгийн судалгаа	61
2.3	Бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө	75
2.4	Үйл ажиллагааны төлөвлөгөө	77
2.4.1	Зээлийн үйл ажиллагааны төлөвлөгөө	77
2.4.2	Маркетплейс буюу онлайн худалдааны платформ	78
2.4.3	Цахим төлбөрийн хэрэгслийн хамрах хүрээг тэлэх, Хэрэглэгчдийг сургах чиглэл	78
2.4.4	Санхүүгийн төлөвлөгөө	81
2.5	Эрсдэлийн удирдлага	83

**ГУРАВ ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ**

3.1	Өрийн хэрэгслийн нэрлэсэн үнэ, хугацаа, нөхцөл	91
3.2	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	91
3.3	Эргэн төлөлтийн баталгаа	93
3.3.1	Толгой компанийн санхүүгийн тайлан	96
3.4	Үнэт цаасны хүүгийн төвшин тогтоосон үндэслэл	98
3.5	Өрийн бичгээр гэрчлэгдэх эрх, үүрэг	101
3.6	Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах тухай	104

**ДӨРӨВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН  
 БАЙГУУЛЛАГУУД**





- 4.1 Андеррайтерийн танилцуулга, дүгнэлт
- 4.2 Аудитын компанийн танилцуулга, дүгнэлт
- 4.3 Хуулийн компанийн танилцуулга, дүгнэлт

107  
124  
169

### ХҮСНЭГТ

Хүснэгт 1	Удирдлагын бүтэц	17
Хүснэгт 2	Дүрмийн сангийн өөрчлөлт	21
Хүснэгт 3	Мобиком корпорацийн хуулийн этгээдийн бүртгэл	22
Хүснэгт 4	Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлан	40
Хүснэгт 5	Үнэт цаас гаргагчийн орлого үр дүнгийн тайлан	41
Хүснэгт 6	Нээлттэй ХК-уудтай харьцуулсан үзүүлэлт	43
Хүснэгт 7	СЗХ-ны Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	45
Хүснэгт 8	Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	47
Хүснэгт 9	Гэрээ хэлцэл	48
Хүснэгт 10	Финтек бизнес модель	51
Хүснэгт 11	Финтек ББСБ	55
Хүснэгт 12	Санхүүгийн салбарын аппликейшнүүдийн татан авалтын тоо	57
Хүснэгт 13	Интернет болон мобайл банкны идэвхтэй хэрэглэгчдийн тоо	58
Хүснэгт 14	Төлбөр тооцооны аппликейшнүүдийн мэдээлэл	58
Хүснэгт 15	Ижил төрлийн аппликейшнүүдтэй харьцуулсан харьцуулалт	59
Хүснэгт 16	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд	62
Хүснэгт 17	Үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын хөрөнгийн хэмжээ	73
Хүснэгт 18	Зээлийн дэлгэрэнгүй мэдээлэл	77
Хүснэгт 19	Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл	82
Хүснэгт 20	Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл	82
Хүснэгт 21	Шинэ бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээний хуудас	86
Хүснэгт 22	Эрсдэлийн үнэлгээ хийх загвар	86
Хүснэгт 23	Эрсдэл тохиолдох магадлалыг үнэлэх	87
Хүснэгт 24	Эрсдэлийн үр нөлөөг үнэлэх	87
Хүснэгт 25	Системийн нэршил	89
Хүснэгт 26	Үнэт цаас гаргагчийн зээлийн үзүүлэлтийн төсөөлөл	93
Хүснэгт 27	Үнэт цаас гаргагчийн толгой компанийн орлогын тайлан	96
Хүснэгт 28	Үнэт цаас гаргагчийн толгой компанийн санхүүгий тайлан	97
Хүснэгт 29	Нээлттэй бондын давуу тал	100
Хүснэгт 30	Андеррайтерийн компанийн мэдээлэл	107

### ГРАФИК

График 1	Харилцагчид	27
График 2	Гаргасан зээлийн эргэн төлөлт болон шинэ харилцагчдын тоо	28
График 3	Зээлийн хүүгээс олох орлогын хэмжээ	28
График 4	Үнэт цаас гаргагчийн олгосон зээлийн хэмжээ болон зээлийн тоо	29
График 5	Зээлийн багцын чанарын үзүүлэлт	41
График 6	Олгосон зээлийн дүн	42
График 7	Олгосон зээлийн тоо	42
График 8	Цэвэр зээлийн багцын хэмжээ	42
График 9	Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн өсөлт	42
График 10	Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн харьцуулалт	43
График 11	Үнэт цаас гаргагчийн ROE, ROA харьцаа	43
График 12	Санхүүгийн хөшүүрэг	44
График 13	Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хэмжээ	52
График 14	Нийт хөрөнгө, нийт зээл болон ББСБ тоо	52
График 15	Банк болон ББСБ-н харьцуулсан үзүүлэлтүүд	53



2021 09 22

МОНГОЛЫН ХАРААНГАЙН ХАНАГАА  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2021-08-31  
БҮРТГЭЭ

График 16	ББСБ-н зээлийн үдэгдэл	54
График 17	ББСБ-н харилцагчид	54
График 18	Банк болон ББСБ салбарын зээлийн үзүүлэлт	55
График 19	Зээлийн жигнэсэн дундаж хүү	56
График 20	Ухаалаг утас болон дата хэрэглэгчид	57
График 21	Монгол Улсын ДНБ-ийн өсөлт	63
График 22	Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл	64
График 23	Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь	65
График 24	Хүүгийн харьцуулалт	65
График 25	Гадаад валютын албан нөөц	66
График 26	Голлох валютуудын төгрөгтэй харьцах ханш	66
График 27	Инфляцийн жилийн төвшин	67
График 28	Хөрөнгийн зах зээлийн ТОП 20 индекс	68
График 29	Сүүлийн нэг жилийн хугацаан дахь хадгаламжийн өсөлтийн хувь	68
График 30	Сүүлийн нэг жилийн хугацаан дахь зээлийн өсөлтийн хувь	69
График 31	Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ	69
График 32	Нийт ажиллах хүч болон ажилгүйдлийн хувь	70
График 33	Эдийн засгийн өсөлтийн цаашдын төсөөлөл	70
График 34	ББСБ тоо болон харилцагчдын тоон харьцаа	71
График 35	ББСБ салбар болон банкны салбарын зээлийн дундаж хүү	72
График 36	ББСБ салбарын нийт хөрөнгө болон нийт зээлийн харьцаа	73
График 37	ББСБ-ын салбарын хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хувь	74
График 38	ББСБ-ын салбарын санхүүжилтийн бүтэц	74
График 39	ББСБ-ын салбарын нийт орлого, цэвэр ашиг	75
График 40	ББСБ салбарын Z индекс	84
График 41	Зээл олголтын тоо	92
График 42	Банкууд болон нээлттэй бондуудын хүүгийн харьцуулалт	99
График 43	Татварын дараах хүүгийн харьцуулалт	100

**СХЕМ**

Схем 1	Бүтэц, зохион байгуулалт	16
Схем 2	Хувьцаа эзэмшил	21
Схем 3	Мобиком корпорацийн түүх	22
Схем 4	Монрау аппликейшний экосистем	76
Схем 5	Эрсдэлийн үнэлгээний матриц	88
Схем 6	Системийн бүтэц	88
Схем 7	Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах дараалал	104
Схем 8	Анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар	105

**ЗУРАГ**

Зураг 1	Авсан шагнал урамшуулал	14
Зураг 2	Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн төслүүд	15
Зураг 3	Мобиком аппликейшн	23
Зураг 4	Тацуяа Хамада	24
Зураг 5	Тацуяа Хамада	25
Зураг 6	ISO стандартын сертификат	25
Зураг 7	Өдрийн цай хөтөлбөр	26
Зураг 8	Монрау аппликейшн хэрэглэгчдийн өсөлт	29
Зураг 9	Монрау дижитал төлбөр тооцооны бизнес модел	31
Зураг 10	“Цахим мөнгө гаргах” тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагаа	32
Зураг 11	Үндэсний хэмжээний мерчантын сүлжээ бүхий экосистем	33
Зураг 12	Төлбөрийн шийдлүүд	33
Зураг 13	Монрау аппликейшний бусад үйлчилгээ	34
Зураг 14	Монрау шилжүүлгийн үйлчилгээ	34
Зураг 15	Монрау тасалбар худалдан авах үйлчилгээ	35
Зураг 16	Монрау онлайн дэлгүүр	35

**mobi finance**  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 ᠎. 5373271

**mobicom**  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК  
9021090552 ᠎. 2072572

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЭНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЙСК  
ХХК  
9021090552 ᠎. 2072572

2021.08.22 өдөр

Зураг 17	Монрау төрийн үйлчилгээний төлбөрийн систем	36
Зураг 18	Мини апп цэс	36
Зураг 19	Монрау маркет	37
Зураг 20	Монрау бичил зээлийн үйлчилгээ	37
Зураг 21	Цахим гарын үсэг	38
Зураг 22	Харилцах төвийн үйлчилгээ	39
Зураг 23	Төлбөр тооцооны дижитал шийдлүүд	47
Зураг 24	Монрау аппликейшний танигдсан байдал	60
Зураг 25	Мобифинанс ББСБ-ын зорилт	60
Зураг 26	Экосистемийн хөгжүүлэлт	76
Зураг 27	Монрау аппликейшнээр төлбөр төлөх загвар	76
Зураг 28	Хэрэглэгчийн хувийн мэдээллийн хамгаалалт	78
Зураг 29	ТҮЦ машины төлбөр төлөх үйлчилгээ	79
Зураг 30	Мобиком корпорацийн үйлчилгээний цар хүрээ	80


МОНГОЛЫН ХЭРЭМ, АШИГ  
MONGOLIAN STOCK  
2021-08-31  
БҮРТГЭВ

  
mobi  
finance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 ☎ 5373271

  
mobi  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК  
9021090552 ☎ 2072572

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЦК  
ХХК  
902131195 ☎ СТС2420





## НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР




Үнэт цаас гаргагч Үнэт цаасаа олон нийтэд худалдахаар санал болгож буй компани

Финтек	Санхүүгийн үйлчилгээг технологитой хамтатгасан бизнесийн төрөл
Бичил зээл	Бага хэмжээтэй хэрэглээний зээл
Аппликейшн	Гар утсанд суулгаж ашигладаг программ
Андеррайтер	Үнэт цаас гаргагчийн гаргаж буй үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагааг зохион байгуулагч компани
Их хэмжээний хэлцэл	Компанийн өөрийн хөрөнгийн 25 хувиас дээш хэмжээтэй гэрээ, хэлцэл
Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасныг ойлгоно
Анхдагч зах зээл	Анх удаа олон нийтэд үнэт цаасаа худалдаж байгаа арилжаа
Арилжаа	Үнэт цаас худалдах, худалдан авах ажиллагаа
Хиймэл оюун ухаан	Өөрийгөө хөгжүүлж байдаг программ
Лиценз Корпораци	Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх Хувь нийлүүлсэн байгууллага; эвлэл, нэгдэл

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХК	Хувьцаат компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
МХБ	Монголын хөрөнгийн бирж
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
IT	Information Technology(Мэдээллийн технологи)товчилсон үг
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
МБ	Монгол банк
ГВАН	Гадаад валютын албан нөөц
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ҮЦТХТ	Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв



2021-08-31

БҮРТГЭВ-03

CSX  
2021-08-31 2 даяа  
БҮРТГЭВ

# I. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

  
mobi  
Франсе  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 5373271

  
mobicom  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК  
9021090552 2072572

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЦК  
ХХК  
6188855  
9021031195 5373271

## 1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



**mobi  
finance**

“Үнэт цаас гаргагч” Мобифинанс ББСБ ХХК нь гар утсанд суурилсан цахим төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын үүрэн холбооны тэргүүлэгч оператор Мобиком Корпораци ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар 2010 оны 4 дүгээр сард үүсгэн байгуулагдсан. Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга”-ын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг авснаар Монгол Улсад анх удаа цахим мөнгөний “Мост Мони үйлчилгээ”-г 2010 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зах зээлд нэвтрүүлсэн. Түүнчлэн Мобифинанс нь 2018 онд Монголбанкнаас Монголын хамгийн анхны Цахим мөнгөний тусгай зөвшөөрлийг “Candy”-гээрээ авсан юм. Зөвшөөрөл авахтай зэрэгцэн Монголд анх удаа ухаалаг утсан дээр суурилсан, цахим мөнгөний албан ёсны төлбөрийн хэрэгсэл болох Candy Pay аппликейшныг танилцуулсан билээ. Гэвч “Candy нь зөвхөн Мобикомын хэрэглэгчдэд зориулагдсан уламжлалт Лоялти хөтөлбөр” гэсэн ойлголт хүчтэй хэвээр байсан тул 2020 онд “Candy Pay”-ийн брэнд имижийг өөрчлөх шийдвэр гаргаж, “MonPay” болгон шинэчилсэн.




Мобифинанс нь хэрэглэгчид, хамтрагчдадаа илүү олон боломж, илүү ашигтай, хүртээмжтэй үйлчилгээг хүргэх зорилгоор “Candy”-д хоёр удаагийн Ре-брендинг хийж, эдүгээ Монгол орон даяар 378 мянга гаруй идэвхтэй хэрэглэгчийг эгнээндээ нэгтгэж, 6000 гаруй мерчанттай хамтран ажиллаж байна. Мобифинанс ББСБ нь дараах тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд “MonPay” цахим санхүүгийн үйлчилгээг үзүүлж буй бөгөөд Финтекийн боломж, цар хүрээг улам тэлж, энэхүү салбарыг Монголд амжилттай хөгжүүлсээр байна.

### Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон зөвшөөрлүүд:

- 2010 оны 8-р сард “Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” тусгай зөвшөөрөл
- 2016 оны 4-р сард “Зээлийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл
- 2016 оны 7-р сард “Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах” тусгай зөвшөөрөл
- 2019 оны 11-р сард “Гадаад валют арилжаа” тусгай зөвшөөрөл





## Монгол банкнаас олгосон зөвшөөрөл

2018 оны 9-р сард “Цахим мөнгө гаргах” тусгай зөвшөөрөл

**ЭРХЭМ ЗОРИЛГО:** Бүх нийтийн Дижитал санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

“Мобифинанс ББСБ” нь эрхэм зорилгынхоо хүрээнд өөрсдийн бүтээсэн экосистем, дэд бүтэц, харилцагч, хамтрагчдын хүлээлт, чадварлаг мэргэшсэн мэргэжлийн баг хамт олон, эрсдэлээс сэргийлэх хууль, дүрэм журмын дагуу бизнесийн ёс зүйтэй шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх, хүртээл болгох боломжийг нээн ажилласаар байна.

Монгол Улсад одоогоор “Мобифинанс ББСБ”-тай ижилхэн цахим мөнгөний лиценз эзэмшигч зургаан компани байдаг бөгөөд зөвхөн эдгээр компаниуд л цахим мөнгө ашиглан, веб хуудас болон гар утасны аппликейшн дээр суурилсан санхүүгийн бизнес эрхлэх зөвшөөрөлтэй юм.

Хэрэглэгч Monpay аппликейшн болон [www.monpay.mn](http://www.monpay.mn) веб хуудсаар дамжуулан дараах цогц үйлчилгээг авах боломжтой.





Мобифинанс ББСБ нь Мобикомын үндсэн болон гэрээт (Улаанбаатарын 39, Орон нутгийн 40) салбаруудаар дамжуулан Monpay үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэн үзүүлж байна.

### 1.1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ, ХАЯГ

Компанийн нэр:	“ Мобифинанс ББСБ” ХХК (цаашид “Үнэт цаас гаргагч” гэх)
Байгуулагдсан огноо:	2010 оны 04-р сарын 20 өдөр
Улсын бүртгэлийн дугаар:	9015002025
Регистрийн дугаар:	5373271
Компанийн хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Зээл  
Үйл ажиллагааны чиглэл: Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах  
Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ  
Гадаад валютын арилжаа





Хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнеско гудамж, МПМ цогцолбор

Утас:

+976-7575-2255

Э-шуудан:

e-money@mobicom.mn

Цахим хуудас:

www.monpay.mn

## 1.1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТҮҮХ



2010 он – Монголын анхны цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг санхүүгийн зохицуулах хорооноос авч гар утсан дээр суурилсан Мост Мони цахим мөнгөний үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэв.



2011 он – Монголын анхны цахим мөнгөний үйлчилгээг илүү дэвшилтэт технологитой хослуулан зах зээлд нэвтрүүлж, үйлчилгээний брэнд нэрээ MobiXpress болгон өөрчилсөн.



2014 он – Үндэсний Лоялти Candy хөтөлбөрийг хэрэгжүүлж мобикомын хэрэглээ хийсэн хэрэглэгчдэдээ Candy оноог өгч, хэрэглэгчид цуглуулсан оноогоороо өдөр тутмын хэрэглээний зүйлсээ авах боломжийг бүрдүүлэв.



2016 он – Мобикомын хэрэглэгчид Бэлэн мөнгөө Candy болгож, Candy-гээ бэлэн мөнгө болгох үйлчилгээгээ улс орон даяар хүргэв.



2017 он – Мобифинанс ББСБ нь хэрэглэгч хэзээ ч, хаанаас ч мессэж болон аппликейшн ашиглан авч болох барьцаагүй онлайн бичил зээлийн үйлчилгээг зах зээлд танилцуулсан.




2018 он – Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу “Цахим мөнгө гаргах” тусгай зөвшөөрлийг Монгол банкнаас авч, Монгол улсын мөнгөн тэмдэгттэй ижил үнэ цэн бүхий цахим мөнгө бий болов.



2020 он – Зээлийн үйлчилгээгээ илүү сайжруулж, орчин үеийн дэвшилтэт технологи болох “Хиймэл оюун ухаан”-д суурилсан бичил зээлийн үйлчилгээг нэвтрүүлэв.




2020 он – Ре-брендинг хийж, Үндэсний төлбөрийн шийдэл “Monpay” нэрээр үйлчилгээгээ хүргэж эхлэв.





### 1.1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОЛОЛТ АМЖИЛТУУД



Мобифинанс ББСБ-н үйл ажиллагааны үр шим, хүртээмжийг үнэлэн дараах томоохон шагнал урамшууллыг нэр хүнд бүхий байгууллагуудаас гардуулсан байна.

#### Шагнал урамшууллууд:

- МХАУТ 2010 онд – “Дэвшилтэт технологи ноу хау нэвтрүүлэгч” шилдэг байгууллага
- МХАУТ 2011 онд – “Шилдэг үйлчилгээ нэвтрүүлэгч”
- МХХТГС 2011 онд – “Шилдэг бүтээгдэхүүн”
- ХХМТГ 2017 онд – “Мессэж зээл шилдэг үйлчилгээ”
- МББСБХ 2019 – “Алтан Од 2019” наадмын “Шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээ”-тэй ББСБ



Зураг 1. Авсан шагнал урамшуулал



### 1.1.4 ҮНЭТ ЦААС ГАРАГЧИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Мобиком групп компанийн хүрээнд хийгдсэн нийгмийн хариуцлагын ажлуудын зэрэгцээ Мобифинанс ББСБ нь хүүхэд хамгаалал чиглэлээр Monpay аппликейшнээр дамжуулан хандивын аян өрнүүлэн тодорхой төсөл, үйл ажиллагааг зохион байгуулдаг. Одоо идэвхтэй хэрэгжиж байгаа зарим арга хэмжээнүүдээс дурьдвал:

- **Ид шидийн орон** – Амьжиргааны төвшин доогуур, хүчирхийлэлд өртдөг болон хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөртэй, яаралтай тусламж дэмжлэг, хамгаалал шаардлагатай хүүхдүүдийн боловсрол, хүмүүжил, эрүүл мэнд, хамгаалал зэрэг цогц асуудлыг шийдэх чухал төсөл бөгөөд 2016 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.
- **Eye see төсөл** – 2013 оноос хойш хэрэгжиж буй төсөл бөгөөд гол зорилго нь бага насны хүүхдийн харааны бэрхшээлийг эрт үед нь оношилж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилготой. Төслийн хүрээнд ББСБ-н 5655 сурагчдыг анхан шатны үзлэгт хамруулж 655 хүүхдэд тохирох харааны шилийг гардуулжээ.
- **As one /Бидний нэг/ төсөл** – JCI байгууллагын санаачлагаар 2020 оноос эхэлсэн бөгөөд төслийн гол зорилго нь Аутизмын эмгэгтэй хүүхэд залуусын онцлог байдлыг эерэгээр хүлээн авч сурах, тусалж дэмжих, ялгаварлан гадуурхахгүй байх, олон нийтэд зөвөөр ойлгуулах гэсэн хүнлэг хандлагыг төлөвшүүлэх юм.



2021-09-22

МОНГОЛЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЖ  
MONGOLIAN STRATEGIC CONSULTANCY  
2021-08-31

- Хүүхдийн тусламжийн 108 дугаар – Хүүхдийн хүчирхийллийг бууруулахад эерэг нөлөө үзүүлэх зорилготой.
- Save angels төсөл – Сахиусан тэнгэрүүдээ хамгаалъя төсөлөөр Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Амгалан амаржих газруудад мэс заслын дараах нөхөн сэргээлтийн тоног төхөөрөмжийг бэлэглэсэн. Төслийн үр дүнд нярайн эндэгдэл 19.1%-с 5.6% болон багассан байна.

Цаашид ч Мобифинанс ББСБ нь нийгмийн хариуцлагын хүрээнд хандивын төсөл хөтөлбөрүүдэд нээлттэй хандан өөрсдийн бэлэн төлбөрийн шийдлийг үнэ төлбөргүйгээр хэрэглэх боломжоор хамтран ажиллахад бэлэн байна.



Зураг 2. Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн төслүүд

**1.1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Мобифинанс нь мэдээллийн шуурхай урсгал, нээлттэй, ил тод хяналтын бүтэц бүхий зохион байгуулалттайгаар, финтекийн өргөн боломж, цар хүрээг эрэлхийлэн ажилладаг.


Мобифинанс нь нийт 27 хүний бүрэлдэхүүнтэй, мэргэшсэн, цомхон баг хамт олонтойгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

Үүнээс гадна аутсорсинг хийж, хууль эрх зүй, бодлого зохицуулалт, хүний нөөц, захиргаа, мэдээллийн технологи, програм хангамж, санхүүгийн тайлагнал, маркетинг сурталчилгаа, хэрэглэгчийн борлуулалт, хэрэглэгчийн халамж үйлчилгээ, төлөөлөгчийн үйлчилгээ гэх мэт нийтлэг үйл ажиллагаагаа Мобифинансын хувь нийлүүлэгч болох Мобиком Корпорацийн чадварлаг, туршлагатай боловсон хүчин, баг хамт олноор гүйцэтгүүлдэг.

mobi finance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 Ж. 5373271

mobi fin  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК  
9021000052 Ж. 2072572

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮШК  
ХХК  
5100000  
9021031155 Ж. СТС2420



Схем 1. Компанийн бүтэц, зохион байгуулалт  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

Мобифинанс ББСБ нь нийт 2 хэлтэстэй бөгөөд хэлтсүүдийн чиг үүрэг нь:

### 1. Дижитал бизнесийн хэлтэс


- Монрау бизнесийн бодлого, стратегийг тодорхойлох, өсөлтийг хангах бүтээгдэхүүн, үйлчилгээ, урамшууллыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах;
- Монрау аппликейшний хэрэглээг нэмэгдүүлэх, аппликейшнийг хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэгцээгээ хангахад чиглэсэн амьдралын хэв маягийг хангах гол аппликейшн болгон хөгжүүлэх
- Монрау төлбөрийн шийдлийн экосистемийг бүрдүүлэхийн тулд хамтрагч байгууллагуудтай гэрээ байгуулах, элсүүлэх;
- Монрау платформ, экосистемийг бүрдүүлэхэд шаардлагатай ирээдүйн чиг хандлагыг судлах, хөгжүүлэх, нэвтрүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
- Үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, нэмэлт орлого олоход чиглэсэн шинэ төрлийн дижитал бизнесийг судалж, хэрэгжүүлэх;

### 2. Цахим мөнгөний хэлтэс


- Монрау зээлийн үйлчилгээний бодлого, стратегийг тодорхойлох;
- Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэх, нэвтрүүлэх, хянах, бүртгэл хөтлөх;
- Цахим мөнгөний үйлчилгээний оролцогчдын бүртгэл, данс хөтлөлт, төлбөр тооцоо, тооцоо нийлэлт, тайлагналыг хянах;







Цахим мөнгөний оролцогчдын өдөр тутмын гүйлгээний хяналт, эрсдэлийг үнэлэх шинжилгээ хийх;



## 1.1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГЫН БАГ

Мобифинанс ББСБ нь удирдлагын дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ (ХЭХ)	ХЭХ нь байгууллагын үйл ажиллагааг стратеги бодлогын төвшинд удирдан чиглүүлж, хувь нийлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, байгууллагын нийт үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалтанд хяналт тавих эрх, үүрэг бүхий засаглалын дээд нэгж юм. Хэх-ын эрхийг хэрэгжүүлэгч мобиком корпорацийн гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ	Гүйцэтгэх захирлыг Мобифинанс ББСБ-н ХЭХ-аас томилно. Гүйцэтгэх захирал нь ХЭХ-аас өгсөн стратеги зорилгын хүрээнд байгууллагын хэтийн болон богино хугацааны төлөвлөгөөг боловсруулан гаргах, өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, хяналт тавих үндсэн үүрэгтэй.

Хүснэгт 1. Удирдлагын бүтэц  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

### Гүйцэтгэх удирдлагын баг

#### Боловсрол

- Бизнесийн удирдлагын магистр, Кентийн их сургууль, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улс, 2012 Их Британи Улсын Засгийн газрын "Chevening Scholarship" хөтөлбөрийн хүрээнд Кентийн их сургуульд MBA зэрэг хамгаалсан
- Бизнесийн удирдлагын бакалавр (BBA), Компьютерийн техник, менежментийн сургууль, ШУТИС, Монгол улс, 2005 он



#### Туршлага

- Гүйцэтгэх захирал Мобифинанс ББСБ ХХК, 2021.04 – Одоог хүртэл
- Дижитал бизнесийн албаны захирал, Мобиком корпораци ХХК, 2019.10 – 2021.04
- Стратеги, шинэ бизнес хөгжлийн албаны захирал, Мобиком корпораци ХХК, 2016.01 – 2019.10



Ш. ОЮУНЧИМЭГ  
/Гүйцэтгэх захирал/





- Стратегийн төслийн менежер, Мобиком корпораци ХХК, 2015.01 – 2016.01
- Бодлого, зохицуулалтын хэлтсийн менежер, ахлах, Мобиком корпораци ХХК, 2014.01 – 2015.01
- Системийн нэгтгэлийн албаны ахлах мэргэжилтэн, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар, МУ-ын Засгийн газар, 2010.08 – 2012.05
- Төлөвлөлтийн албаны мэргэжилтэн, Мобиком корпораци ХХК, 2006.08-2010.08




М.БҮДБААЗАР  
/Цахим мөнгөний  
хэлтсийн менежер/

### Боловсрол

- Нягтлан бодогч Хяналт Бакалавр - Мандах Бүртгэл Дээд Сургууль:

### Туршлага

- Цахим мөнгөний хэлтсийн менежер, Мобифинанс ББСБ, 2019.06 сар – одоог хүртэл
- Цахим мөнгөний хэлтсийн Комплианс алхах мэргэжилтэн, Мобифинанс ББСБ, 2018.06-2019.06
- Цахим мөнгөний хэлтсийн ахлах мэргэжилтэн, Мобифинанс ББСБ, 2015.06-2018.06
- Маркетинг төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Мобифинанс ББСБ, 2012.07-2015.06
- Борлуулалтын хэлтэс мэргэжилтэн, Мобифинанс ББСБ, 2010.11-2012.07
- Ахлах теллер, Голомт банк 2008.07-2010.04






**А. АЛТАНБАГАНА**  
/Дижитал бизнесийн хэлтсийн менежер/



**Боловсрол**

- Бизнесийн удирдлага – Магистр Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль:
- Хими технологийн инженер – Бакалавр Монгол Улсын Их Сургууль: Химийн факультет



**Туршлага**

- Мобифинанс ББСБ ХК: Дижитал бизнесийн хэлтсийн менежер
- Мобиком корпораци ХХК: Байгууллагын борлуулалтын хэлтсийн менежер
- Юнител ХХК: Хэлтсийн менежер
- Юнител ХХК: Ахлах мэргэжилтэн
- Юнител ХХК: Байгууллагын борлуулалтын мэргэжилтэн
- Юнител ХХК: Байгууллага хариуцсан ажилтан

**Хөрөнгө оруулагчийн удирдлагын баг:**



**Ф. ЯСУХИКО**  
/Санхүү хариуцсан тэргүүн дэд захирал/

**Боловсрол**

- Бизнесийн удирдлага- Япон улс Мэйжигийн их сургууль

**Туршлага**

- Мобиком корпораци ХХК: Санхүү Хариуцсан Тэргүүн Дэд Захирал
- KDDI : Санхүүгийн менежер
- KDDI: KDDI Группд Төсвийн төлөвлөлт, хяналт хариуцсан ажилтан
- KDDI: Охин компаниудын менежмент, Корпорацийн стратеги төлөвлөлт, Шинэ үйлчилгээний хөгжүүлэлт зэрэг Корпорацийн менежментийн чиглэлээр мэргэшиж, туршлага хуримтлуулсан.




**Б. ҮНЭНБАТ**  
/Санхүүгийн асуудал эрхэлсэн дэд захирал/


**Боловсрол**

- Санхүү, эдийн засагч - Санхүү эдийн засгийн дээд сургууль
- Санхүү, бизнес - Шинэ Зеланд Улсын Веллингтон, Викториа их сургууль

**Туршлага**

- Мобиком корпораци ХХК: Санхүү эрхэлсэн дэд захирал





- Изинис Эйрвэйз ХХК: Санхүүгийн албаны захирал, Гүйцэтгэх захирлын орлогч
- Ньюком групп: Гүйцэтгэх захирал
- Ньюком групп: Дотоод аудитын захирал
- Ньюком групп: Санхүүгийн албаны захирал



**Б. БАЯРМАА**  
/Мэдээллийн Технологи  
эрхэлсэн дэд захирал/

#### Боловсрол

- Бизнесийн удирдлагын мастер - Бирмингэмийн их сургууль
- Радио, холбооны инженер (бакалавр) - Монгол Улсын шинжлэх ухаан технологийн их сургууль:

#### Туршлага

- Мобиком корпораци ХХК: Мэдээллийн Технологи эрхэлсэн дэд захирал
- Мобиком корпораци ХХК: Хэрэглэгчийн үйлчилгээ хариуцсан дэд захирал
- Мобиком корпораци ХХК: Хэрэглэгчийн борлуулалт хариуцсан дэд захирал
- Ньютел ХХК: Борлуулалт үйлчилгээний хэлтсийн захирал
- Ньютел ХХК: Хэрэглэгчийн дуудлагын төвийн менежер



Компанийн эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал Ш.Оюунчимэг, Цахим мөнгөний хэлтсийн менежер М.Бүдбазар, Дижитал бизнесийн хэлтсийн менежер А.Алтанбагана нар болон тус эрх бүхий албан тушаалтнуудаас гадна тус Компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч "Мобиком корпораци" ХХК-ийн Санхүүгийн асуудал эрхэлсэн дэд захирал Б.Үнэнбат, Дижитал бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хэлтсийн менежер Ж.Магвааншийрэв, Ахлах нягтлан бодогч Б.Бямбажаргал нар нь Аутсорсингийн гэрээний дагуу Компанийн тухайн чиглэлээрх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.




## 1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ



### 1.2.1 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ

Үнэт цаас гаргагчийн хувьцааны багцыг Мобиком Корпораци ХХК 100% эзэмшдэг. Мобиком Корпораци ХХК нь Монгол Улсын Ньюком ХХК, Япон Улсын Сумитомо болон KDDI Корпорациудын хамтарсан хөрөнгө оруулалттайгаар 1995 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр байгуулагдсан ба үйл ажиллагаагаа 1996 оны 3 дугаар сарын 18-ны өдөр нийслэл Улаанбаатар хотноо албан ёсоор эхлүүлсэн Монгол Улсын үүрэн холбооны салбарын анхдагч оператор юм.





Схем 2. Хувьцаа эзэмшил  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

2010-2018 онуудад дараах байдлаар Мобифинанс ББСБ-н дүрмийн санг нэмэгдүүлж ирсэн.


Өөрчлөлт хийсэн он	Тоо ширхэг	Эзэмших хувьцаа (үнэ ₮)		Эзэмших хувь
		нэгж	нийт	
2010 он	10,000	10,000	1,000,000,000	100%
2011 он	302,705	10,000	3,027,050,000	100%
2012 он	341,986	10,000	3,419,860,000	100%
2018 он	501,986	10,000	5,019,860,000	100%


Хүснэгт 2. Дүрмийн сангийн өөрчлөлт  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ



## 1.2.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОЛГОЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

ОНООСОН НЭР	Мобиком корпораци ХХК
БАЙГУУЛАГДСАН ОГНОО	1995.09.17
ХУВИЙН ХЭРГИЙН ДУГААР	9019005111
РЕГИСТРИЙН ДУГААР	2072572
КОМПАНИЙН ХЭЛБЭР	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭРХЭМ ЗОРИЛГО	Мобиком групп нь хамт олон, тэдний гэр бүлийн сайн сайхан болон оюунлаг сэтгэлгээний хөгжил дэвшлийг дэмжиж, хэрэглэгчид, түншүүдтэйгээ сэтгэлд хоногцсон






<b>АЛСЫН ХАРАА</b>	дурсамжуудыг хамтдаа бүтээж, бизнесийн шинэлэг арга барилаар итгэл дүүрэн, тэгш нийгмийг цогцлоох үйлсийг манлайлна.
<b>ҮНЭТ ЗҮЙЛС</b>	Бид тасралтгүй шинэчлэлээр хамтын үнэ цэнийг бүтээж, хүн бүрийн итгэлт хамтрагч байх болно. 1. Бид шударга ёс зүйтэй байна. 2. Бид өөрчлөлтийг эерэгээр хүлээн авч хэрэгжүүлнэ. 3. Бид шинийг эрэлхийлэгч байна. 4. Бид бусдыг ойлгож хүндэлнэ.
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ</b>	Монгол улсын нутаг дэвсгэрт мэдээлэл сүлжээний ашиглалт, үйлчилгээ эрхлэх, улс хоорондын телефон холбооны үйлчилгээ үзүүлэх
<b>ОХИН КОМПАНИУД</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Мобиком Нэтворкс ХХК</li> <li>• Ньютел ХХК</li> <li>• Мобинет ХХК</li> <li>• Монгол Контент ХХК</li> <li>• Ньюфонд ББСБ ХХК</li> <li>• МобиФинанс ББСБ ХХК</li> </ul>

Хүснэгт 3. Мобиком корпорацийн хуулийн этгээдийн бүртгэл  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох Мобиком Корпораци нь үүрэн холбоо, улс хоорондын холбоо, интернет, сансрын холбоо болон сүлжээний дэд бүтэц зэрэг харилцаа холбоо, мэдээллийн технологийн цогц үйлчилгээг байгууллагууд болон 1.6 сая гаруй хувь хэрэглэгчдээ тасралтгүй, найдвартай хүргэж байна.



Схем 3. Мобиком корпорацийн түүх  
Эх сурвалж: Мобиком Корпораци ХХК



2017.09.22

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн үйлчилгээг хэрэглэгчдэд улам ойртуулж хүргэх зорилгоор борлуулалтын томоохон сүлжээ бүхий үйлчилгээний оператор компани Ньютел ХХК /2000 он/, дижитал контент үйлдвэрлэгч-нийлүүлэгч Монгол Контент ХХК /2005 он/, WiMax технологид суурилсан утасгүй интернетийн үйлчилгээ үзүүлэгч Улуснет ХХК /2005 он/, өрхийн болон байгууллагын хэрэглэгчдэд зориулсан өндөр хурдны интернет, интернет протоколд суурилсан олон улсын яриа болон суурин утас (VoIP)-ны үйлчилгээг хэрэглэгчдэд түргэн шуурхай, чанартай хүргэх зорилго бүхий



Зураг 3. Мобиком аппликейшн

Мобинет ХХК /2009 он/, гар утсанд суурилсан цахим мөнгөний үйлчилгээг хүргэх МобиФинанс ББСБ /2010 он/ зэрэг охин компаниудыг байгуулан бизнесийн хүрээгээ тэлэн амжилттай ажиллаж байна. Ийнхүү хүрээгээ тэлснээр бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, бизнесийн үйл ажиллагааны үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх төдийгүй шинээр ажлын байр бий болгож байгаагаараа нийгэмд ач тусаа өгч байгаа. Мөн ажилтнуудаа халамжлах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлогын хүрээнд группийн бусад компаниудтай хамтран ажилтнуудад орон сууцны болон бусад хэрэгцээний хөнгөлөлттэй

зээл олгодог Ньюфонд ББСБ-ыг 2007 онд үүсгэн байгуулан ажиллаж байна. Харин хамгийн отгон охин компани 2013 оны 3 дугаар сард байгуулагдсан Мобиком Нэтворкс ХХК юм. Мобиком Нэтворкс ХХК нь хотын доторх, хот хооронд болон улс хооронд сувгийн түрээсийн үйлчилгээг үзүүлэхээс гадна Чайна телеком, Чайна Мобайл, Чайна Юником, Мегафон, Транстелеком компаниудтай холбогдсон шилэн кабелийн дэд бүтцийн тусламжтайгаар Ази, Европын үндсэн порттой шууд холбогдох интернэтийн бөөний урсгалын үйлчилгээг үзүүлэн ажилладаг.

### Ерөнхий захирал



**Тацуяа Хамада**

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Гишүүн  
Ерөнхий Захирал*

Тацуяа Хамада нь 2016 онд Мобиком Корпорацийн ТУЗ-ийн гишүүн, 2017 онд Ерөнхий Захирлын албан тушаалаа хүлээн авснаас хойш Мобиком Корпорацийн үйл ажиллагааг тасралтгүй өргөжүүлэн тэлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Тэрбээр 25 жилийн өмнө Японы олон улс дамнасан KDDI Корпорациас ажлын гараагаа эхэлж, Корпорацидаа Глобал ICT бизнес менежмент, Глобал маркетинг, борлуулалт хариуцсан Ерөнхий менежер, Захирал зэрэг удирдлагын өндөр албан тушаалуудыг хашиж иржээ.

Three official red stamps and signatures are present at the bottom of the page. The leftmost stamp is for 'MOBIFINANCE' with contact information: 'УЛААНБААТАР ХОТ МОБИФИНАНС ББСБ ХХК 9021101075 ф. 5373271'. The middle stamp is for 'MOBICOM' with contact information: 'УЛААНБААТАР ХОТ МОБИКОМ ХХК 9021021195 ф. 5070572'. The rightmost stamp is for 'OLZHIY END KO KAPITAL YNK' with contact information: 'УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮНК ХХК 5183805 9021021195 ф. СТС2420'. Handwritten signatures are overlaid on the stamps.

2021.09.22

МОНГОЛЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ХАМТ  
MONGOLIAN INVESTORS ASSOCIATION

2021-09-22

Тацуяа Хамада нь Японоос гадна 7 жилийн хугацаанд Бельгийн Брюссель, ХБНГУ-ын Франкфурт болон Дюссельдорф, Их Британийн Лондон зэрэг Европын том хотуудад KDDI Корпорацийн бизнесийг удирдан ажилласан арвин туршлагатай.



Зураг 4. Тацуяа Хамада

Мобиком Корпораци нь салбартаа тэргүүлэгч байсаар ирсэн төдийгүй бизнесийн цар хүрээ, нийгэмд оруулж байгаа хувь нэмрээрээ Монгол Улсын шилдэг компаниудын эхний эгнээнд бичигдсээр ирсэн. Бидний бүх цаг үед мөрдсөөр ирсэн, мөн цаашид ч баримтлах үндсэн зарчим бол “Шударга, ажил хэрэгч үйл ажиллагаа явуулснаар хэрэглэгч болон бизнесийн бусад оролцогчдын хэрэгцээ шаардлагыг хангаж, тэдэнд болон нийгэмд бүхэлд нь шинэ үнэ цэнийг бий болгох” явдал билээ. Энэхүү итгэл үнэмшил дээр Мобиком Корпорацийн эрхэм зорилго, хэтийн зорилго, үйл ажиллагааны болон удирдлагын зарчим, зорилтууд томъёологдож, бизнесийн үйл ажиллагааг чиглүүлж байдаг.

Мобиком Корпораци ХХК нь:

- Хүний нөөцийн хувьд 1,500 гаруй чадварлаг боловсон хүчнийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт нэгтгэж чадсан бөгөөд энэхүү салбараас гадна бизнесийн удирдлага, санхүү эдийн засаг, маркетингийн мэргэжилтэй чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулж байна.
- Техник технологийн хувьд дэлхийд хамгийн өргөн хүрээнд ашиглагддаг, сүүлийн үеийн тоон технологийн тоног төхөөрөмжөөр үндсэн сүлжээгээ тоногдосон. Түүнчлэн сүлжээ, үйлчилгээний найдвартай байдлыг хангах зорилгоор стандартад нийцсэн нөөц сүлжээг давхар ашиглаж байна. Бизнесийн хамтын ажиллагааны хүрээнд дэлхийн нэр хүндтэй компаниудтай түншилж ажилладаг нь хэрэглэгчдэдээ чанартай, сайн үйлчилгээг хүргэх үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг.
- Үйлчилгээний хамрах хүрээний хувьд хот, аймаг, сум, төв сууринг хамарсан 2G, 3G, 4G сүлжээг нэвтрүүлээд байна. Ингэснээр Монгол орны нийт сум суурин газарт байнгын оршин суугч хүн амын 95% орчимд үүрэн холбооны үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн.
- Хэрэглэгчийн үйлчилгээний хувьд улс даяар гар утас ашиглаж буй нийт хэрэглэгчийн тэн хагас буюу 1.6 сая хэрэгчид үүрэн холбооны үйлчилгээг

mobi  
finance

УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9921101075-Д, 5373271

mobicom

УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ХАМТ  
КОРПОРАЦИ ХХК  
9921070592-Д, 2092572

УЛААНБААТАР ХОТ

ӨЛСӨН ӨНД КӨ  
КАПИТАЛ УШК  
ХХК

5113055  
9921031165-Д, 0702420



2021.09.22

МОНГОЛЫН ИРЭГЭЭНИЙ ТҮНЭГ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2021.09.21  
STP115-2-03

үзүүлж байна. Мобиком Корпораци нь 89 салбар, 2200 агент, 10,000 орчим гэрээт борлуулагч болон бусад борлуулалтын цэгээр дамжуулан хэрэглэгчдэдээ үйлчилгээгээ түргэн, шуурхай хүргэж байна.

• **Үйлчилгээний стандартын хувьд** групп компанийн хэмжээнд үйл ажиллагааныхаа онцлогт тохируулж, олон улсын 3 төрлийн удирдлагын тогтолцоог амжилттай нэвтрүүлсэн Монгол дахь анхны компани болсон. Үүнд:

• **Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 стандарт**

ISO 9001:2015 тогтолцоо нь аливаа байгууллагыг дотоод зохион байгуулалт төдийгүй хэрэглэгчдийн хамтын ажиллагаанд ч анхаарал тавихыг шаарддаг тул хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн цогц бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэх боломжийг нээж өгдөг.

• **Олон улсын Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001 стандарт**

Хэрэглэгч болон хамтрагч байгууллагуудын үнэ цэнтэй нууц мэдээллийг боловсруулах, хадгалах үйл ажиллагаанд учирч болзошгүй Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлээс сэргийлж, үйл ажиллагаандаа стандартын 160 гаруй шаардлагыг ханган ажиллаж байна.

• **Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 45001 стандарт**

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой нийт 174 хууль, эрх зүйн бүхий л хэм хэмжээг дагаж, үйл ажиллагаандаа нийцүүлэн ажилладаг.



Зураг 6. ISO стандартын сертификат

Мобиком корпораци нь хэрэглэгчдийнхээ хүсэл шаардлага, эрэлт хэрэгцээнд нь нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхээс гадна дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн, салбартаа тэргүүлэгч байгууллага болохоор зорин ажиллаж байна.

**mobi finance**  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФНАНС ББСБ ХХК  
9021101075-У. 5373271

**mobikom**  
УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛЫН ИРЭГЭЭНИЙ ТҮНЭГ  
25  
УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛЫН ИРЭГЭЭНИЙ ТҮНЭГ  
9021026602-У. 2972572

**ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЙСК  
ХХК**  
УЛААНБААТАР ХОТ  
9021021199-У. 5173855  
СТО7430

2021-09-22

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ  
MONGOLIAN LEGISLATION  
2021-08-31

**Монгол Улсын нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмэр**

Мобиком Корпораци нь байгуулагдсан цагаасаа хойш төрийн болон бизнесийн байгууллагууд, олон улсын байгууллагуудын хөгжилд дэмжлэг үзүүлж, боловсрол, соёл, байгаль орчин, нийгмийн хамгааллын чиглэлээр нийгмийн хариуцлагын олон төсөл хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлж, салбартаа шилдгээр цоллуулах үе үеийн олон мянган залуусыг бэлдэн гаргаж, ажлын байрыг олноор нь бий болгож, түүнийгээ тогтвортой хадгалах бодлого баримтлан, улс эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмрийг оруулсаар байгаа билээ. Техник технологийн чиглэлээр 2020 онд Мобикомын инженер, техникийн ажилчид e-Mongolia аппликейшныг хөгжүүлэн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүлээлгэн өгсөн юм.

Мобиком Корпораци нь 25 жилийн хугацаанд нийгэмдээ хамтын үнэ цэн бүтээх компанийн сайн засаглалыг харуулсан нийгмийн хариуцлагын төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийж, ашиг тус хүртэгчдээрээ Монгол улсдаа манлайлж байна. Эдгээр төслүүдээс танилцуулбал:

Үдийн цай хөтөлбөр Үдийн цай төслийг анх нийслэл хотын захын дүүргийн 12 сургуулийн 1, 2 дугаар ангийн 3,334 сурагчийг хамруулан хэрэгжүүлсэн ба төслийн хугацааны үр дүнд сурагчдын хичээл таслалт, хоцролт 100 хувь арилж, мөн тэдний өвчлөлт эрс буурсан төдийгүй хичээлийн идэвх, оролцооны хувь нэмэгдсэн. Энэ ч утгаар нь тухайн үеийн Засгийн газар, БСШУЯ-аас дэмжин улс даяар бага, дунд ангийн бүх сурагчдад үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлсэн болно.



Зураг 7. Өдрийн цай хөтөлбөр

Хүүхдийн тусламжийн утас 108 төсөл Мобиком Корпораци нь 2014 оноос эхлэн НҮБ-ын Хүүхдийн сан, “Дэлхийн зөн Монгол” ОУБ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран 108 хүүхдийн тусламжийн утсыг амжилттай үйл ажиллагаагаар ханган ажиллаж байна.

“Хүүхэд бүрд цэвэр ус” төсөл “Хайр түгээе” тусгай цэнэглэгч картын орлогын 10%-ийг энэхүү төсөлдөө зарцуулж, хотын захын болон орон нутгийн 110 сургуульд нийт 216 ус цэвэршүүлэгчийг суурилуулснаар сурагч, багш ажилчид, эрүүл, аюулгүй ундны усыг хүссэн үедээ уух боломжтой болсон.

mobifinance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 ☎ 5373271

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ  
MONGOLIAN LEGISLATION  
2021-08-31

ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАРТИНГ УИСК  
ХХК  
5183805  
☎ 9921031102 ☎ СГС2428

2021-00 22 дөр

Ариун Цэвэр, эрүүл ахуйн байгууламж төсөл-WASH Мобиком Корпорациас Дэлхийн зөв ОУБ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 7 жилийн хугацаанд хэрэгжүүлж буй төсөл юм. Энэ хугацаанд сумдын 108 сургуулийн модон жорлонг чанар стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар сольсноор 65'500 гаруй хүүхэд гэдэсний халдварт өвчин тусах, жорлонд унаж бэртэх эрдсэлээс хамгаалагдаж чадсан.


Мобиком Корпорацийн үйл ажиллагааг төр засаг, салбарын удирдах байгууллага болон бусад байгууллагын зүгээс урамшуулан дэмжсээр ирсэн юм.

### Компанийн гол гол амжилтуудаас дурдвал:

- 2001 оноос хойш "TOP 100", "TOP 150 аж ахуйн нэгж"-ээр жил бүр дараалан шалгарч байна.
- "Манлай" болон "Шилдэг татвар төлөгч"
- Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулагч ААН
- Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэгч
- Тэргүүний хөрөнгө оруулагч
- Ази, Номхон далайн орнуудын Худалдаа аж үйлдвэрийн танхимын Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр Монгол Улсын 2010 оны шилдэг компаниар шалгарч "CACCI Golden Award" шагнал
- Компанийн нийгмийн хариуцлагыг манлайлагч
- Мэдээлэл технологийн манлай үйлдвэрлэгч
- Хүүхдийн төлөө хамт олон
- Бизнесийн эрхэмсэг оршихуйн шагнал
- Шилдэг үйлчилгээтэй байгууллага
- Азийн бүтээмжийн байгууллагын Үйлчилгээний салбарын үлгэр жишээ байгууллага болохыг нотолсон "Service Excellence" шагнал
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит "Үндэсний бүтэмжийн шагнал"

### 1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

#### Харилцагчид



- Зээлийн гэрээ байгуулсан нийт харилцагчийн тоо
- Цахим мөнгөний гэрээ байгуулсан нийт харилцагчийн тоо

2021 оны 1-р улиралд Мобифинанс ББСБ ХХК-ийн нийт харилцагчийн тоо оны эхнээс 24.9 мянгаар нэмэгдэж 378.3 мянгад хүрсэн байна. Нийт олгосон зээлийн тоо 48.6 мянга, нийт олгосон зээлийн дүн 12.7 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

График 1. Харилцагчид

Эх сурвалж: Мобифинанс ББСБ







График 2. Гаргасан зээлийн эргэн төлөлт болон шинэ харилцагчдын тоо  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

2020 онд зээлийн эргэн төлөлтийн таатай нөхцлийг бүрдүүлэн ажиллаж Мобифинанс ББСБ нь харилцагчдадаа зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах нөхцөлийг үргэлжлүүлэн олгосон.

Монгол Улсын хэмжээнд COVID-19 цар тахалтай холбоотой Монгол Улсын Засгийн Газрын газраас гаргасан 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн шийдвэр ("Зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүссэн зээлийг 2021 оны 7-р сарын 1ний өдрийг хүртэл сунгах")-ийг үндэслэн тус хугацаанд зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүссэн харилцагч нартаа зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгахаар болсон. Нийгмийн хариуцлагын хүрээнд харилцагчдынхаа санхүүгийн байдалд учирч болох эрсдэлийг хамтдаа шийдвэрлэх зорилгоор тухайн цаг үеийн шийдвэрүүдэд тохируулан түргэн шуурхай ажилласаар байна.




Зээлийн хүүгийн орлого өмнөх улирлаас 7.03 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд цар тахалын нөлөөллөөс үүдэн бууралт ажиглагдсан бол 2021 хагас жилээс сэргэх төлөвтэй байна.

График 3. Зээлийн хүүгээс олох орлогын хэмжээ  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ



2021.09.22  
БҮРТГЭЭ-03


Олгосон зээлийн тоо  
/мянган зээл /



Зээл олголтын тоо 2020 оны IV улирлаас эхлэн сэргэх төлөвт орсон ба цар тахалын нөлөөлөл буурсанаар зээл олголтын тоо нэмэгдэж байна.

МОНГОЛ-Ы ХИММОНГЫН ЭРӨГ  
MONGOLIAN STATE BANK  
2021-08-31  
БҮРТГЭЭ-03

Олгосон зээлийн хэмжээ  
/тэрбум.төг/



2020 онд олгосон зээлийн хэмжээ 48.3 тэрбум төгрөг байсан ба 2021 оны I улирлын байдлаар нийт 12.7 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Эдийн засгийн сэргэлттэй холбоотой олгож буй зээл 2021 оны хагас жилээс өсөх төлөвтэй байна. .

График 4. Үнэт цаас гаргагчийн олгосон зээлийн хэмжээ болон зээлийн тоо  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ



2020 оны дижитал төлбөр тооцооны үйл ажиллагааны хураангуй

2020 онд Мобифинанс нь Monday брэндийг зах зээлд шинэчлэн танилцуулж, “Үндэсний төлбөрийн шийдэл” уриатайгаар олон нийтэд дижитал төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ахицтай ажиллаж, аппликейшн ашиглаж буй хэрэглэгчийн болон гүйлгээний тоо хэмжээг даруй 2-3 дахин нэмэгдүүлээд байна.





Зураг 8. Monday аппликейшн хэрэглэгчдийн өсөлт

Дижитал төлбөр тооцооны хүрээнд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Номин, И-Март, CU, Петровис зэрэг үндэсний хэмжээний сүлжээ дэлгүүр, үйлчилгээний газруудыг экосистемдээ нэгтгэж хүрээгээ тэлэв.

mobifinance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 ф. 5373271

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД КО  
КЛАССИКАЛ УСК  
5132655  
9021031195 СТС2429



- Ухаалаг андройд системд суурилсан ПОС-ын системийг нэвтрүүлэв
- Монпрау дансаа дурын төлбөрийн карттай холбох боломжийг и-токен шийдлийг ашиглан бий болгов.
- Аппликейшнд суурилсан анхны маркетплейсийн платформыг партнер Зочил компанитай хамтран бий болгож, аппликейшн дээр онлайн худалдааны дэлгүүрээ үүсгэх боломжийг бий болгов.
- Хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чиглэлээр худалдан авалтын дүн нэмэгдэхийн хэрээр урамшуулал олгодог хөтөлбөрийг хэрэгжүүллээ.
- Аппликейшний системээ дахин шинэчилж, нууцлал аюулгүй байдлын төвшинг дахин хүчитгэв.
- Түүнчлэн, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгчдэд тавигддаг хууль дүрэм журмын хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг илүү нарийвчлан хөтөлбөр боловсруулж мөрдөн ажиллаж байна.



### 1.3.1 БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Мобифинанс ББСБ нь дижитал санхүүгийн хүртээмжийг (DFI - Digital Financial Inclusion) нэмэгдүүлэх чиглэлээр өнөөдөр гар утсанд суурилсан интернэт үйлчилгээний боломжийг ашиглан USSD болон аппликейшн дээр суурилсан дараах үйлчилгээнүүдийг голчлон үзүүлж байгаа бөгөөд тус тус танилцуулгыг дэлгэрэнгүй байдлаар хавсаргав.

1. Дижитал төлбөр тооцоо, цахим мөнгөний үйлчилгээ
2. Аппликейшн дээр суурилсан бичил зээлийн үйлчилгээ
3. Жижиг дунд бизнес эрхлэгчид өөрийн бизнесээ өргөжүүлэх боломжийг олгох Open API шийдлүүд
4. Онлайн худалдаа/маркетплейс ба платформ

#### Монпрау дижитал төлбөр тооцоо, цахим мөнгөний үйлчилгээ

Монпрау цахим мөнгөний үйлчилгээ нь хэрэглэгчид гар утасныхаа дугаарт холбогдсон цахим данснаасаа төлбөр тооцоо, худалдан авалт, мөнгөн шилжүүлгийг маш хялбараар, түргэн шуурхай хямд хийж гүйцэтгэх боломжийг олгодог.



2021.09.22

МОНГОЛЫН ИТЭГЭЭНЭЙ ХАМГААГАГЧ  
 МОНГОЛЫН СЭТГЭГ  
 2021.09.22

Цахим мөнгө нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт буюу төгрөгөөр (1Mongru=1₮) баталгааждаг. Mongru аппликейшн дэх төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлчилгээг Mongru цахим дансаараа дамжуулан хялбархан авах боломжийг хэрэглэгчдэд бүрдүүлдэг. Нөгөөтээгүүр, дижитал хэтэвчинд суурилсан энэхүү үйлчилгээг олон улсад “Супер аппликейшн” гэж нэрлэдэг бөгөөд хэрэглэгч өдөр тутам ашигладаг бүтээгдэхүүн үйлчилгээгээ нэг аппликейшнаас авч, төлбөр тооцоогоо дижитал хэлбэрээр шийдсэнээр тэдний амьдрал илүү хялбар болж, илүү чухал зүйлсдээ цаг зарцуулах боломж бүрддэг.



Зураг 9. Mongru дижитал төлбөр тооцооны бизнес модел

Дижитал төлбөр тооцооны гол давуу тал нь дээрх бизнес загварын хүрээнд нэг талаас салбар салбарын үйл ажиллагааны онцлогт тохируулан төрөл бүрийн шийдлүүдийг бий болгож, илүү бэлэн бус төлбөр тооцооны нийгмийг бий болгохыг зорьдог бол нөгөө талаасаа хувь хэрэглэгчдэд амар хялбар байдал, технологийн давуу талуудыг ашигласан нууцлал аюулгүй байдлыг хангаж өгдөгөөрөө зөвхөн гар утсаа ашиглан хаана ч өөрийн хэрэгцээгээ хангах боломжийг бүрдүүлдэг.

2018 оны 10 дугаар сард Мобифинанс ББСБ Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий бэлэн бус төлбөрийн хэрэгслээр тооцогдох “Цахим мөнгө гаргах” тусгай зөвшөөрлийн гэрчилгээг Монголбанкнаас албан ёсоор хүлээн авсан анхдагч байгууллага юм.

Тус арга хэмжээнд Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан Мобиком Корпорацийн Ерөнхий Захирал Тацуяа Хамадад “Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ”-г албан ёсоор гардуулан өгсөн юм.





Зураг 10. "Цахим мөнгө гаргах" тусгай зөвшөөрөл хүлээн авах үйл ажиллагаа

Монрау нь анх зөвхөн Мобикомын хэрэглэгчид ашиглах боломжтой байсан бол өдгөө Монгол орон даяар аль ч операторын хэрэглэгч ашиглах боломжтой болж ийнхүү Үндэсний төлбөрийн системд цоо шинэ төлбөрийн хэрэгсэл болон "мэндэлж" байгаа. Монрау цахим мөнгө нь:

- Монрау оноосон нэр бүхий;
- Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтээр төлбөр тооцоог гүйцэтгэдэг буюу 1 Монрау = 1 төгрөг гэсэн харьцааг бүх төрлийн төлбөр тооцоо, худалдан авалт, мөнгөн шилжүүлэгт баримталдаг;
- Цахим мөнгөний үйлчилгээнд оролцогч (хэрэглэгч, гэрээт хамтрагч, төлөөлөгч) бүх байгууллагуудын мөнгөн хөрөнгийг Монгол Улс дахь арилжааны банкуудад 100% байршуулсан;
- Цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчид хүссэн үедээ цахим төлбөр тооцоог ашиглан бэлэн мөнгийг цахим мөнгөн хэлбэрт хөрвүүлэх, буцаан хөрвүүлэх, мөнгөн шилжүүлэг хийх боломжтой юм.

2020 оны 4 сарын 30-ны байдлаар 1,4 сая хэрэглэгч гар утсандаа байршсан цахим дансан дахь мөнгөөр 200 гаруй бизнесийн байгууллага, 70 гаруй онлайн хамтрагч, 6,000 гаруй худалдаа үйлчилгээний цэгт төлбөр тооцоо гүйцэтгэх боломжтой болсон байна.







Зураг 11. Үндэсний хэмжээний мерчантын сүлжээ бүхий экосистем

Өнөөдөр Монрау-ийг бүхий л томоохон сүлжээ супермаркетууд, шатахуун түгээх станцууд, төрийн үйлчилгээнүүд ашиглах боломжтой болоод байгаа билээ.


Дээрх бүх экосистемийг бүрдүүлэхэд Монрау нь төрөл бүрийн төлбөрийн шийдлүүдийг нэвтрүүлж, бусад байгууллагуудад интеграци хийх боломж олгож байна. Үүнд:

- Өөрийн онлайн худалдааны вэбсайтаа Монрау аппликейшнд мини хэлбэртэй байршуулж, төлбөрийг нь шийдэх боломж;
- Дэлгэцэн дээр үнийн дүн агуулсан ухаалаг QR кодыг үүсгэж, хэрэглэгч уншуулан төлбөрөө хийх боломж;
- Хэрэглэгчийн апп доторх QR кодыг дэлгүүрийн уншигчаар уншуулан төлбөр гүйцэтгэх боломж;
- Өөрийн аппликейшн, вэбсайтуудад Монрау-ээр төлбөр төлөх боломжийг бүрдүүлэх deeplink шийдэл зэрэг болно.

Үүнээс гадна бүх банкны Qra, QR кодуудыг Монрау аппликейшнаар уншуулах боломжийг бүрдүүлснээр экосистемээ улам илүү өргөжүүлэн тэлээд байна.



Зураг 12. Төлбөрийн шийдлүүд



ХХК  
2021.09.22 өдөр  
ТЭГЭГЭВ  
Төлбөр төлөлт, цэнэглэлт

МОНГОЛЫН УРСЫН ХАМГААГАГЧ  
MONGOLIAN STATE LOTTERY & CASINO CO., LTD.  
2021-08-31  
03

Өөрсдийн экосистемдээ төлбөр төлөлт болон цэнэглэлт хийх хэсгийг нэвтрүүлсэн ба Мобикомын хэрэглэгчид өөрийн гар утасны төлбөр, Voo, Мобинет болон MNP75 үйлчилгээний төлбөр төлөх, нэгж дата худалдан авах, бүх операторын хэрэглэгчид бусдын төлбөр болон бусдад мобикомын нэгж дата худалдан авч өгөх бүрэн боломжтой. Түүнчлэн бүх операторын хэрэглэгчид зөвхөн Мобикомын бүтээгдэхүүнээс гадна ORI card худалдан авах, усны карт цэнэглэх, гар утасны тоглоом цэнэглэх гэх мэт үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлсэн байна.



Зураг 13. Monpay аппликейшний бусад үйлчилгээ

### Бүх төрлийн мөнгө шилжүүлэг, данс цэнэглэлт

Бид өдөр тутмын амьдралдаа үргэлж мөнгө ямар нэгэн мөнгө шилжүүлэх асуудалтай тулгардаг. Таксинд, ямар нэгэн зүйл худалдан авах, хэн нэгэнрүү мөнгө шилжүүлэх гэх мэт. Харин MonPay аппликейшнтай байхад бүх төрлийн мөнгөн шилжүүлгийг хаанаас ч хэзээ ч ямарч цагийн хязгаарлалтгүйгээр найдвартай хурдан шуурхай хийх боломжтой.

Монгол банкны АСН системд холбогдсон хамгийн анхны финтек компани болсноор бодит цагийн горимд Монгол банкаар давхар баталгаажсан бүх төрлийн гүйлгээг хормын дотор Monpay данс хооронд, Monpay данснаас бүх банкны дансруу, бүх банкнаас Monpay дансанд хүлээн авах боломжтой болжээ. Мөн аппликейшн нь E-Token үйлчилгээ буюу хэрэглэгч бүх төрлийн банкны картыг Monpay аппликейшндээ бүртгүүлснээр Monpay дансаа ямар нэгэн шимтгэлгүйгээр хормын дотор цэнэглэх боломжтой болсон. Мөн бүх төрлийн мөнгөн шилжүүлэг хийхэд хялбар болжээ.

МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

mobi finance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 э.х. 5373271

ХЯЛБАР, НАЙДВАРТАЙ  
ШИЛЖҮҮЛЭГ

Бүх банкны картаа холбоод MonPay дансаа цэнэглэдэг боллоо!

МОНГОЛЫН УРСЫН ХАМГААГАГЧ  
MONGOLIAN STATE LOTTERY & CASINO CO., LTD.  
2021-08-31  
03

УЛААНБААТАР ХОТ  
НО 34 КОРПОРАЦИ ХХК  
9021010000 э.х. 20207072

КАПИТАЛ ҮЙСК  
ХХК  
9021010000 э.х. 20207072

Зураг 14. Monpay шилжүүлгийн үйлчилгээ

2021.09.22

### Тасалбар худалдан авах

Хамгийн сүүлийн үеийн нээлтээ хийж буй цоо шинэ кино, дуртай хамтлаг дуучны тоглолтын тасалбар, УБТЗ-н тасалбарыг очиж авахад маш их цаг зарцуулахаас гадна дууссан байх, мөн суудлын сонголтгүй болчихсон байдаг. Харин Monpay аппликейшнээр бүх төрлийн тасалбарыг өөрийн хүссэн суудал, цагийг сонгон урьдчилан авах боломжийг олгож байна.



Зураг 15. Monpay тасалбар худалдан авах үйлчилгээ

### Онлайн дэлгүүр

Дэлхий нийтээр нүүрлээд буй цар тахлын энэ хүнд хэцүү цаг үед дэлгүүр хэсэх амаргүй болсон. Ийм ч учраас онлайн дэлгүүрээр үйлчлүүлэх хэрэглэгчдийн тоо эрс өссөөр байна. Monpay аппликейшнтэй тохиолдолд гэрээсээ гаралгүйгээр ямарч аюулгүйгээр хүссэнээрээ



Зураг 16. Monpay онлайн дэлгүүр

хоол, хүнс, хувцас, электрон бараа, эм, гоо сайхны бүтээгдэхүүн, ном сонин сэтгүүл гэх зэрэг хэрэгцээтэй бүх зүйлсээ нэг дороос захиалж хүргүүлэн авахаас гадна давхар урамшуулалд хамрагдах боломжтой юм. Мобифинанс ББСБ нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан онлайн дэлгүүр хамтрагчдыг нэмэн экосистемээ тэлсээр байгаа бөгөөд одоогоор онлайн дэлгүүрт 70 гаруй төрлийн дэлгүүрүүд элсэн орсон байна. Цаашид онлайн дэлгүүрээ өргөжүүлсээр байх болно.

### Бүх төрлийн төрийн үйлчилгээ

Монгол Улсын төрийн бүх үйлчилгээг цахимжуулах, цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор E-Mongolia төслийг Монгол Улсын Засгийн газар үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор энэхүү төслийг дэмжин E-Mongolia, төрийн үйлчилгээний ТҮЦ машины төлбөрийн систем, татварын E-barimt систем, хот хоорондын авто замын хураамж төлөх дамжин өнгөрөх цэгүүдийн төлбөрийн системүүдэд амжилттай холбогдоод байна. Энэхүү төслийн нэг хэсэг болох E-Mongolia аппликейшнээс төрийн 23 байгууллагын 181 нэр төрлийн үйлчилгээг авах боломжтой байдаг. Иргэдэд илүү ойр, хялбар байх үүднээс төлбөрийн сонголтыг нэмэгдүүлж зөвхөн банкны аппликейшнээр бус харин дээрх үйлчилгээнүүдийн төлбөрийг Monpay-р хийх боломжтой болсон.

Мөн төрийн үйлчилгээний “ТҮЦ” машины үйлчилгээний төлбөрийг бэлэн мөнгө, банкны карт ашиглах шаардлагагүй зайнаас QR код уншуулан төлөх боломжийг бүрдүүлсэн.

2021.09.22 өдөр

MONGOLIAN STOCK EXCHANGE  
MONGOLIAN STOCK EXCHANGE

Цахим төлбөрийн баримтын систем буюу E-barimt системтэй холбогдон Monpay-р худалдан авалт хийсэн баримт бүрийг автоматаар бүртгэх боломжтой.

Monpay аппликейшнд зөвхөн автомашиныхаа улсын дугаарыг бүртгүүлснээр хот хоорондын дамжин өнгөрөх авто зам ашигласны хураамж авдаг цэгүүдээр ямар нэгэн хүндрэл чирэгдэлгүй дамжин өнгөрөх Monpay данснаас нь автоматаар суутгадаг олон улсад хэрэглэдэг орчин үеийн технологийн шийдлийг нэвтрүүлж чадсан. Цаашид ч Мобифинанс ББСБ нь Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бүх нийтийг цахимжуулах бүхий л төсөл хөтөлбөрийг байнга дэмжин хамтран ажиллах болно.



Зураг 17. Monpay төрийн үйлчилгээний төлбөрийн систем

### Хувь хүн болон байгууллагад чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээ

#### Мини апп үйлчилгээ

Monpay аппликейшинд байрлах Миний апп цэсэнд хүн бүрийн амьдралын хэв маяг, өдөр тутмын хэрэглээ болох хоол хүнс, хувцас, ном, кино жүжиг үзвэрийн тасалбар, галт тэрэгний тасалбар захиалга, олон улсын тоглоом зэрэг олон төрлийн онлайн бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг багтаасан үйлчилгээ юм.



Зураг 18. Мини апп цэс

#### Monpay маркет

Вэб хуудасгүй мерчантуудад зориулсан бараа бүтээгдэхүүний зураг, үнийн мэдээллээ оруулан, онлайн дэлгүүртэй болох боломжийг бүрдүүлсэн шийдэл юм. Зочил ХХК-ийн платформтой интеграци хийн ажилладаг бөгөөд үүгээр дамжуулан худалдаа, үйлчилгээ эрхлэгчид нь Monpay-н мерчантын вэбээр нэвтрэн, онлайн дэлгүүрээ бүрэн удирдах боломжтой. Төлбөр төлөлт зөвхөн Monpay-р төлөгддөг. Энэхүү бэлэн платформд нэгдсэнээр Monpay-н экосистем дахь 1,4 сая гаруй хэрэглэгчдэд өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан борлуулах, боруулалтын сувгаа нэмэгдүүлэх боломжтой. Үүний зэрэгцээ хамгийн орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан И-Коммерс бизнесийн талбарт нэр хүндээ өсгөж өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх бүрэн боломжтой юм.

mobi finance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 5373271

mobi.com  
УЛААНБААТАР ХОТ  
36  
9021101075 5373271

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЦК  
ХТ  
6103855  
90211031195 CTC2420

2021.09.22 өдөр

Хүн бүр өдөр тутмын амьдралдаа санхүүгийн үйлчилгээг зогсолтгүй ашигладаг ба илүү аюулгүй, хялбар, хурдан шийдлийг сонгон хэрэглэгч хамтрагч байгуулагууддаа санал болгон ажиллаж байна.

МОНГОЛЫН ХАМГААГАХ БАНК  
MONGOLIAN STATE BANK  
БҮРГЭДСЭЭС



Зураг 19. Monpay маркет

### MonPay бичил зээлийн үйлчилгээ

Monpay зээлийн үйлчилгээ нь хэрэглэгчийн гар утасны хэрэглээнд суурилсан ямарч барьцаагүй, нэмэлт бичиг баримт бүрдүүлэх шаардлагагүйгээр ердөө ганцхан товч дараад л зээлийн шалгуураа шалгаж, тохирсон үнийн дүнгээр зээл авах боломжтой үйлчилгээ юм. Зээлийн үнийн дүнгийн хувьд 100'000 – 1'000'000₮-н хооронд, хүүний хувьд сарын 1,9% - 3,4%-н хүүтэй зээлийг санал болгодог. Monpay зээлийн үйлчилгээний давуу тал нь зээлдэгч авсан зээлийг 1-30 хоногийн дотор эргүүлэн төлөх боломжтой бөгөөд зээлийн зөвхөн хэрэглэсэн өдрийн хүүг төлдгөөрөө бусад зээл олгогчдоос давуу талтай ба зээлдэгчид ирэх дарамт бага байдаг.



Орчин үеийн технологийг хиймэл оюун ухаан, хэрэглэгчийн хувийн нууцлалгүйгээр төсөөлшгүй болсон. Тиймээс ч зээлийн үйлчилгээндээ дэлхийд салбартаа тэргүүлэгч Беларус улсын Gini machine компанитай хамтран хамгийн сүүлийн үеийн хиймэл оюун ухааныг ашиглаж эхэлсэн юм. Ингэснээр хэрэглэгчдийн зээлийн шалгуурыг илүү уян хатан болгож зээлийн үнэлгээг хамгийн бодитоор тогтоосноор зээлдэгчдийн төлбөрийн чадварт тохирсон зээлийн үнийн дүнг санал болгож байна.

Зураг 20. Monpay бичил зээлийн үйлчилгээ

Мобифинанс ББСБ-ын бичил зээлийн үйлчилгээний гол онцлог нь шимтгэлгүй бөгөөд хамгийн бага хүүтэй зээл олгодог. Тэр дундаа богино хугацаанд зайлшгүй шаардлагатай хэрэгцээг хангах боломжийг олгох дээр

mobifinance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9921101075-д, 5373271

37

ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ УШК  
8103055  
9921031155-д, 702429

2021.09.22  
БҮРГЭВ

төвлөрдөгөөрөө иргэдийн санхүүгийн хариуцлагатай байдал бол үр өгөөжийг тэнцвэржүүлж байдгаараа онцлог юм.

МОНГОЛЫН УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛЫН УЛААНБААТАР ХОТ  
2021-09-21  
БҮРГЭВ-03



Tridumkey | **MobiCom**

## ГАРЫН ҮСГЭЭ ГАР УТАГНААСАА

Банк, Төрийн үйлчилгээ, Финтек, ERP системд ашиглах боломжтой боллоо.


[www.tridumkey.mn](http://www.tridumkey.mn) | 7012-0722

Зураг 21. Цахим гарын үсэг

Түүнчлэн бичил зээлийн үйлчилгээг аппликейшнаар дамжуулан олгохдоо нууцлал аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ хэрэглэгчээ таних KYC (know your customer)-ийг хууль, дүрэм журамд нийцүүлэн орон даяар тархсан 80 гаруй салбар нэгжүүдээрээ хийж, баталгаажуулж байгаа ба гарын үсгийг мөн mPKI буюу нийтийн түлхүүрийн дэд бүтцийн технологийг ашиглан цахимаар хуулиар баталгаажуулсан гарын үсэг зурах боломжтой болгоод байна. Шинэ үеийн дижитал бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхэд хамгийн түрүүнд хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх, тэднийг санхүүгийн боловсролд сургах, шинэ үйлчилгээ ашиглахад нь туслахад оршино. Үүний тулд хэрэглэгчдэд зориулсан дараах үйлчилгээнүүдийг Мобикомын өргөн тархсан үйлчилгээний цэгүүдээр дамжуулан хүргэж байна.

### Хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх, түгээх үйлчилгээ

Аливаа бизнесийн байгууллагуудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ хэрэглэгчдэдээ оновчтой, зөв сувгаар хүргэх нь хамгийн чухал зорилгуудын нэг байдаг. Харамсалтай нь зөвхөн сошиал сувгаараа мэдээлэл хүргэх нь тэр бүр үр дүнтэй биш, телевизийн реклам хийлгэж цацахад хэт үнэтэй гэх мэт асуудал тулгарах нь элбэг. Тэгвэл Monpaу нь хамтрагч байгууллагууддаа илүү хүртээмжтэй, чанартай сувгаар хэрэглэгчдэдээ бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэх боломжийг олгодог. Нэг дор 100-200 мянган хэрэглэгчдэд мессэж болон и-мэйлээр дамжуулан мэдээлэл хүргэдгээрээ энэхүү үйлчилгээ нь давуу талтай. Ихэнх тохиолдолд эдгээр суваг нь сошиал хэрэгсэл болон телевизийн рекламаас илүү хэрэглэгчдэд хүрч чаддаг.



**mobi finance**  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 | 5373271

**mobi com**  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ КОМПОРАЦИ ХХК  
38 | 9021101075 | 5373272

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД КӨ  
КАПИТАЛ ҮЦК  
ХХК  
8123555  
9021031165 | 6702420

## Хэрэглэгч халамжлах, харилцах төвийн үйлчилгээ



Зураг 22. Харилцах төвийн үйлчилгээ

Хэрэглэгчдээ сонсох тэдний санал гомдлыг хүлээн авч богино хугацаанд шийдвэрлэж хэрэглэгчдээ халамжлах нь одоогийн бүх төрлийн бизнес үйлчилгээний хамгийн чухал салшгүй үйл хэсэг болсон билээ. Мonday 24/7 байнгын ажиллагаатай хэрэглэгч халамжлах, харилцах төвөөр дамжуулан хамтрагч байгууллагуудтай холбоотой гарсан бүх төрлийн санал гомдол зэргийг хоцрогдолгүй хүлээн авч, богино хугацаанд шийдвэрлэхээр ажилладаг. Энэ нь өөрсдийн гэсэн хэрэглэгч халамжлах, харилцах үйлчилгээгүй байгууллагуудад маш том давуу тал юм. Ихэнх тохиолдолд эдгээр суваг нь сошиал хэрэгсэл болон телевизийн рекламаас илүү хэрэглэгчдэд хүрч чаддаг.

## Цахим мөнгөний үйлчилгээний систем

Цахим мөнгөний үйлчилгээний систем нь 2018 оны 5-р сарын 28-аас 6-р сарын 5-ны өдрүүдэд олон улсын стандартын сертификат олгогч TUV Rheinland байгууллагаар аудит хийлгэж баталгаажуулсан. Зээлийн үйлчилгээний систем нь:


- Хэрэглэгчдэд зээл олгох, эргэн төлөлт хийх, зээлийн хүүний тооцоолол хийх, зээлийн гэрээ байгуулах, хиймэл оюун ухаанд суурилсан хэрэглэгчийн үнэлгээг хийх;
- Хиймэл оюун ухаанд суурилсан хэрэглэгчийн түүхэн дата дээр үндэслэн хэрэглэгчийн үнэлгээг бий болгож хэрэглэгчдэд зээл олгох эрхийн хэмжээг тодорхойлох;
- Цахим мөнгөний системийн нийт оролцогчид болох хэрэглэгч (бүртгэлтэй, бүртгэлгүй), төлөөлөгчийн бүртгэл, бүртгэлд үндэслэн оролцогчдын нэрээр нээгдэх цахим мөнгөний данс, дансууд хоорондын гүйлгээ, төлбөр тооцоо, шимтгэл хураамж, дансдын төлөв зэрэг цогц мэдээлэл бүхий хэрэглэгчийн мэдээллийг бааз, санхүүгийн бүртгэл, тайлагнал, бизнес процессыг удирдах;



## 1.3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

## 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй

Мобифинанс ББСБ ХХК-ийн 2020 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаарх Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд "PWC (ПрайсуотерхаусКуперс)" ХХК болон "Мэдээлэл аудит" ХХК Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, 2021 оны 03 сарын 30-ны өдөр "Бидний дүгнэлтээр Мобифинанс ББСБ ХХК ("Компани" гэх)-ийн санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн



2021.09.22 ТӨР

үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна" хэмээн дүгнэсэн байна.<sup>1</sup>

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

БҮРТГЭВ-03

## Санхүү байдлын аудитын хураангуй тайлан

Хөрөнгө (мянган төгрөг)	2020	2019	2018
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,881,305	2,255,436	1,404,963
Банкуудад байршуулсан хөрөнгө	6,108,886	3,041,299	3,067,638
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,221,498	5,728,626	3,460,802
Бусад санхүүгийн хөрөнгө	122,378	14,206	42,248
Бусад хөрөнгө	24,101	10,343	28,103
Хойшлогдсон татварын хөрөнгө	3,944	1,033	1,462
Биет бус хөрөнгө	60,272	88,662	117,052
Үндсэн хөрөнгө	16,036	15,013	35,518
Ашиглах эрхтэй хөрөнгө	118,237	132,045	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>13,556,657</b>	<b>11,286,663</b>	<b>8,157,786</b>
Өр төлбөр	2020	2019	2018
Хэрэглэгчийн барьцаа	5,653,022	4,401,018	3,513,346
Дансны болон бусад өглөг	223,701	105,619	41,475
Урьдчилж орсон орлого	7,400	309,208	-
Түрээсийн өр төлбөр	128,753	135,393	-
Орлогын албан татварын өглөг	13,370	57,639	26,717
<b>Нийт өр төлбөр</b>	<b>6,026,246</b>	<b>5,008,877</b>	<b>3,581,538</b>
Эзэмшигчдийн өмч	2020	2019	2018
Хувьцаат капитал	5,019,860	5,019,860	5,019,860
Хуримтлагдсан ашиг	2,510,551	1,257,926	(443,612)
Нийт эздийн өмч	7,530,411	6,277,786	4,576,248
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<b>13,556,657</b>	<b>11,286,663</b>	<b>8,157,786</b>

Хүснэгт 4. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлан  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

<sup>1</sup> ПрайсюотерхаусКуперс ХХН ("PwC") болон "Мэдээлэл Аудит" ХХК нь Мобифинанс ББСБ-ын 2020 оны 12 сарын 31-ний өдрийн болон тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэсэн бөгөөд ПрайсюотерхаусКуперс Аудит ХХК ("PwC") нь Мобифинанс ББСБ-ын 2019 болон 2018 оны 12 сарын 31-ний өдрийн болон тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн. PwC нь Үнэт цаасны танилцуулгын зорилгоор эдгээр аудитыг хийгээгүй бөгөөд PwC нь Монгол Улсын Үнэт цаасны тухай хуулийн 10.6 -р зүйлд заасан аудитор биш юм. Тиймээс, PwC нь энэхүү Үнэт цаасны танилцуулгыг уншаагүй тул Танилцуулгад тусгагдсан мэдээлэлд үндэслэн гаргасан шийдвэр, үйлдлээс болж гуравдагч этгээд хохирсон бол учирсан алдагдал, хохирлын хариуцлагыг хүлээхгүй болно.





2021.09.22

## Орлого үр дүнгийн аудитын хураангуй тайлан

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ  
МОНГОЛЫН ӨРГӨН

2021-08-31

Орлого (мянган төгрөг)	2020	2019	2018
Хүүгийн орлого	2,225,200	2,315,478	1,406,188
Хүүгийн зардал	(20,655)	(232,840)	-
Хүүгийн цэвэр орлого	2,204,545	2,082,638	1,406,188
Зээлийн алдагдлын сангийн зардал	(258,085)	(374,425)	(137,193)
Зээлийн алдагдлын дараах хүүгийн цэвэр орлого	1,946,460	1,708,213	1,268,995
Хураамж, шимтгэлийн орлого	1,707,803	1,615,977	807,978
Хураамж, шимтгэлийн зардал	(318,800)	(225,685)	(187,988)
Бусад үйл ажиллагааны орлого	23,164	370	8,327
Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал	(1,948,345)	1,184,585	(925,013)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>1,410,282</b>	<b>1,914,290</b>	<b>972,299</b>
Орлогын албан татварын зардал	(157,657)	(212,752)	(101,256)
<b>Тайлант жилийн ашиг</b>	<b>1,252,625</b>	<b>1,701,538</b>	<b>871,043</b>

Хүснэгт 5. Үнэт цаас гаргагчийн орлого үр дүнгийн тайлан  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

## Зээлийн багцын чанарын үзүүлэлт



График 5. Зээлийн багцын чанарын үзүүлэлт

Зээлийн багцын чанарын үзүүлэлт нь 2020 оны цар тахалын нөлөөллөөр хэвийн зээл 35.5 хувиар буурч, чанаргүй зээлийн хэмжээ 56.5 хувиар өссөн үзүүлэлттэй байсан. 2021 оны эхний хагас жилд эдийн засгийн нөхцөл сайжирснаар зээлийн багцын чанарын үзүүлэлт эргэн сэргэх төлөвтэй байна.





2020 онд олгосон зээлийн дүн 30.2 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ нь цар тахлын үеийн эрсдэлийн менежментийг хэрэгжүүлж зээл олголтын тоо буурсантай холбоотой юм. 2021 он гарснаар эдийн засаг сэргэх төлөвтэй байгаа тул зээл олголтын тоо өсөх хандлагатай байна.

График 6. Олгосон зээлийн дүн  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ дүн



График 8. Цэвэр зээлийн багцын хэмжээ  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ




График 7. Олгосон зээлийн тоо  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ





График 9. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн өсөлт  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

2020 онд үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн хэмжээ 2019 оноос 2.3 тэрбум төгрөг буюу 10.3 хувийн өсөлтийг үзүүлж 13.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх жилээс 1.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 19.9 хувийн өсөлт үзүүлэн 7.5 тэрбум төгрөгт хүрчээ.





График 10. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн харьцуулалт  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ



График 11. Үнэт цаас гаргагчийн ROE, ROA харьцаа  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

2020 онд цар тахлын нөлөөгөөр харилцагчдад олгох зээлийн хэмжээг бууруулсан бөгөөд үүнийг дагаад цэвэр ашгийн хэмжээ мөн адил буурсан үзүүлэлттэй байна. Харин 2021 он гарснаар эдийн засаг сэргэх төлөвтэй болж буй тул харилцагчдад олгох зээлийн хэмжээ нэмэгдэж байна.

Өөрийн хөрөнгийн өгөөж болон нийт хөрөнгийн өгөөж зохистой төвшинд Монголын Хөрөнгийн Бирж-д бүртгэлтэй томоохон хувьцаат компаниудын санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдтэй харьцуулахад жишиг харьцаа үзүүлэлт сайн байна.

Нэр	Симбол	Нийт хөрөнгийн өгөөж	Эздийн өмчийн өгөөж	Өр төлбөрийн харьцаа	Эздийн өмчийн харьцаа
	Ticker	ROA	ROE	D/A ratio	E/A ratio
"Таван Толгой" ХК	TTL	22.4%	41.2%	45.7%	54.3%
"АПУ" ХК	APU	16.0%	19.5%	17.0%	83.0%
"Түмэн шувуут" ХК	TUM	11.8%	15.8%	25.3%	74.7%
"Мандал даатгал" ХК	MNDL	9.7%	20.2%	52.0%	48.0%
"Мобифинанс ББСБ"	MONPAY	9.2%	16.6%	44.5%	55.5%
"Сүү" ХК	SUU	9.0%	19.6%	54.3%	45.7%
"ЛэндМН ББСБ" ХК	LEND	6.0%	13.7%	56.5%	43.5%
"Бодь Даатгал" ХК	BODI	5.9%	14.3%	59.0%	41.0%
"Монос Хүнс" ХК	MFC	5.3%	7.6%	30.9%	69.1%
"Мах Импекс" ХК	MMX	2.6%	15.4%	83.4%	16.6%

Хүснэгт 6. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтүүдийг нээлттэй ХК-уудтай харьцуулсан үзүүлэлт

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж





### Санхүүгийн хөшүүрэг




График 12. Санхүүгийн хөшүүрэг

Санхүүгийн хөшүүрэг буюу өр төлбөрийг эздийн өмчид харьцуулсан харьцаа нь 0.7-1.0 харьцаатай байгаа нь компанийн өр төлбөр, өөрийн хөрөнгийн харьцаа тогтвортой төвшинд хадгалагдаж байгааг илтгэж байна. Уг харьцаа нь 2.0 бүхлээс бага байх тохиолдолд тухайн компанийг санхүүгийн хувьд боломжит харьцаатай үйл ажиллагаа явуулж байна гэж үздэг бөгөөд үнэт цаас

гаргагчийн хувьд хөшүүрэг нь 2.0-с бага байгаа нь санхүүгийн бүтцийг үйл ажиллагаа явуулахад тогтвортой байгааг илтгэж байна.

### Санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хууль эрх зүйн орчин

Мобифинанс ББСБ нь Монголбанк болон Санхүүгийн Зохицуулах Хороотой нягт хамтран ажилладаг бөгөөд тус байгууллагуудаас гаргасан хууль, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажилладаг.

Дээрх байгууллагуудаас гаргасан хууль, дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт тавьж хэрэгжүүлэх, холбогдох дүрэм журмын хүрээнд өөрсдийн үйл ажиллагаатай уялдуулж журам болон ажлыг зааврыг тухай бүр батлуулах, мөрдлөг болгох ажлуудыг хийж байна. Үүнд:

Монголбанкнаас гаргасан хуулиуд:

- Үндэсний төлбөрийн системийн тухай хууль
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль

Монголбанкнаас гаргасан дүрэм журмууд:

- Цахим мөнгөний журам
- Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх болон систем ажиллуулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагааг хяналт тавих журам
- Мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам

Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан гаргасан хуулиуд:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан дүрэм журмууд:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам



2021.09.22  
 Доорх хүснэгтээс Мобифинанс ББСБ-н 2019-2021 онуудад Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилдасныг харж болно.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	2019	2020	2021 I	Хангасан эсэх
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа>10%	79.7%	90.8%	84.1%	Хангасан
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активийн харьцаа>20%	79.7%	90.8%	84.1%	Хангасан
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт>8%	104.4%	146.9%	131.2%	Хангасан
Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгох зээл, актив, баталгаа <30%	0.00%	0.00%	0.00%	Хангасан
ББСБ-ийн холбогдох этгээдэд олгох зээл, актив, баталгаа <10%	0.00%	0.00%	0.00%	Хангасан
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)<±40%	0.00%	11.5%	11.1%	Хангасан

Хүснэгт 7. СЗХ-ны Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд  
 Эх сурвалж: Мобифинанс ББСБ



### 1.3.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Мобифинанс ББСБ нь салбартаа орчин үеийн шинэлэг дэлхийн тренд болж буй инновациудыг нэвтрүүлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулдаг ба анх байгуулагдсан цагаасаа хойш өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээг тэлэх мөн бизнесийн орчинд тэсрэлт авчирсан цөөнгүй олон төслүүдийг хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж ирсэн. Цаашид ч энэхүү зорилгын хүрээнд шинэ технологиудыг судлан нэвтрүүлэхээр тасралтгүй ажиллаж байна. Өмнө нь хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийг он цагийн дагуу хураангуйлбал:

Он	Хөтөлбөр	Дэлгэрэнгүй
	<p>УЛААНБААТАР ХОТ                  МОБИФИНАНС ББСБ ХХК                  9021101075 д. 5373271</p>	<p>УЛААНБААТАР ХОТ                  МОБИФИНАНС ББСБ ХХК                  9021101075 д. 5373271</p>
		<p>УЛААНБААТАР ХОТ                  ӨЛЗНИЙ ЭНД КО                  КАПИТАЛ ҮЙСК                  ХХК                  9021031105 д. 070200</p>

2014 он	Candy loyalty хөтөлбөр
2017 он	Мессэж зээлийн үйлчилгээ NFC Candy card
2018 он	Хамгийн анхны цахим мөнгө E-barimt автомат бүртгэл ТҮЦ машин Candy төлбөрийн карт Тоон гарын үсэг
2019 он	Ухаалаг QR ПОС-ын шийдэл QRay QR кодыг унших Олон улсын төлбөр тооцооны глобал хамтрагчид ACH системд холбогдсон
2020 он	Candy to Monpay rebranding

Мобиком Корпорацийн түүхэн дахь хамгийн анхны лоаялти урамшууллын хөтөлбөр

Хамгийн анхны мессэж дээр суурилсан бичил зээлийн үйлчилгээ

Хамгийн анхны NFC стандартын карт

Монгол банкаар баталгаажсан Монголын хамгийн анхны цахим мөнгөний тусгай зөвшөөрөл  
Хэрэглэгч E-barimt-аа бүртгүүлсэн тохиолдолд Candy-р худалдан авсан бүтээгдэхүүн бүр автоматаар E-barimt системд бүртгэгдэх боломжтой болсон.

Төрийн үйлчилгээний ТҮЦ машины төлбөр тооцоог Candy-р хийх боломжтой болсон.

Хас банкттай хамтран Candy Cobrand карт төлбөрийн карт

mPKI технологийг ашиглан, хуулиар баталгаажсан гарын утсыг аппликейшн дээр зураг боломжийг бүрдүүлэв.

Худалдаа үйлчилгээний газруудад нэвтрүүлэв.

QRay QR кодыг унших интеграци хийж, экосистемээ өргөжүүлэв

Интеграци хийж, олон улсын эрхтэй төлбөрийн карт ашиглахгүйгээр төлбөр тооцоо хийх боломжийг бүрдүүлэв.

ACH системд холбогдсон анхны Финтек компани. Бүх банкны данс хооронд бодит цагийн горимд Монгол банкаар давхар баталгаажсан шилжүүлэг хийх боломжтой болсон.

Өмнө нь хэрэглэж байсан нэр болон логог бүрэн сольж цоо шинэ өнгө төрхтэйгөөр ребрандинг хийж Monpay Үндэсний төлбөрийн шийдэл болон шинэчлэгдэв

2021.08.22 өдөр  
ГЭВ

МУНГОЛЫН АРСАВАН ТӨСӨГ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2021-08-31

mobi  
finance  
УЛСАН БААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075-4, 5373271

mobi.com  
УЛСАН БААТАР ХОТ  
МОНГОЛЫН АРСАВАН ТӨСӨГ  
46

УЛСАН БААТАР ХОТ  
ӨЛЭГЭЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЙЦ  
5188405  
9021031165-3 СТС2420

СЗХ  
2021 Аар 22 өдөр  
БҮРТГЭВ

2021-08-31

2021 он	Хиймэл оюун ухаан зээлийн системд нэвтрүүлэв	Дэлхийд салбартаа тэргүүлэгч Беларус улсын Gini machine компанитай хамтран зээлийн системдээ хиймэл оюун ухаанд суурилсан технологи хэрэглэж эхлэв
	E-Mongolia app	Төрийн үйлчилгээ болон лавлагааг цахимаар аван төлбөрөө Monpay-р төлөх боломжтой болсон
	CAM систем	Монгол банкны нэгдсэн бүртгэлийн системд нэвтрэн хэрэглэгч өөрийн Сошиал хаягаар шилжүүлэг хийх боломжтой болсон
	Замын хураамж үйлчилгээ	Тээврийн хэрэгслийн дугаараа Monpay app-д бүртгүүлэн зам ашигласны хураамжийг бэлнээр болон банкны картаар төлөх шаардлагагүйгээр Monpay данснаасаа автоматаар төлөх боломжтой болсон.
	E-barimt буцаан олголт	E-barimt буцаан олголтыг Monpay аппликейшнээр дамжуулан авах үүд хаалгыг нээж байна.
Monpay бонд	Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийнхээ үргэлжлэл болгон хамгийн орчин үеийн технологийн шийдэл бүхий Блокчейнд суурилсан Monpay бонд төслийг хэрэгжүүлэхэд бэлэн болоод байна. Дээр дурьдсаж амжилттай хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдээс гадна цаашид хэрэгжүүлэх бизнесийн болон технологийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хөгжүүлэлт болон төлөвлөлтийн шатандаа явж байгааг дуулгахад таатай байна.	

  
mobifinance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 5373271

  
УЛААНБААТАР ХОТ  
47  
©21090559 2021.07.27

  
УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД НО  
КАПИТАЛ УШК  
ХХК  
5183855  
8021031155 070420

2021.09.27 дөр  
БҮГДГЭВ

УЛААНБААТАР ХОТ  
ОЛЗИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЙС  
ХХК  
9021031195 СТСМ30



Зураг 23. Төлбөр тооцооны дижитал шийдлүүд

### 1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАЙГУУЛСАН ГЭРЭЭ ХЭЛЦЭЛ

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3-н жилийн дотор хийсэн их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх талаарх хуулийн зөвлөх компанийн хураангуй дүгнэлтийг дор дурдаж байна.

	Их хэмжээний хэлцэл	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	ХНХ-н тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний хэлцэл
Нийт хийгдсэн хэлцлийн тоо	0	3	0
Хэрэгжиж дууссан хэлцэл	0	0	0
Одоо хэрэгжиж буй хэлцэл	0	3	0

Хүснэгт 9. Гэрээ хэлцэл

mobi finance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 5373271

УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 5373271  
48

УЛААНБААТАР ХОТ  
ОЛЗИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЙС  
ХХК  
9021031195 СТСМ30



2021.09.22-төр  
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-08-31

БҮРТГЭВ-03

## II. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ



2021.09.22

## 2.1 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА



Дижитал санхүүгийн зах зээлд гарч буй технологийн дэвшил

Хамгийн амжилттай нэвтэрч эдийн засаг, иргэдийн аж амьдралд мэдэгдэхүйц эерэг нөлөөг үзүүлж байгаа нэг төрлийн бүтээгдэхүүн бол технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ юм. Технологийн дэвшлийг зээлийн үйл ажиллагаанд ашигласнаар санхүүгийн байгууллагуудын зардал буурах, санхүүгийн үйлчилгээний хүртээмж сайжрах, уламжлалт банкны зээлийн үйлчилгээнээс хасагдсан иргэд, аж ахуйн нэгжүүдэд санхүүжилтийн олон төрлийн боломж нээгдэх зэрэг олон давуу тал үүсэж байна.

Статистик дүнгээс харахад технологид суурилсан зээлийн үйлчилгээ хамгийн өргөн хүрээнд нэвтэрсэн улс нь Хятад, үүний дараагаар АНУ, Их Британи зэрэг улсууд байна. Эдгээр улсуудын хувьд нэг хүнд ногдох финтек зээлийн дүн нь 60-110 ам.доллар байна. Мөн АНУ, Герман, Солонгос, Шинэ Зеланд зэрэг улсуудын хувьд технологид суурилсан зээлийн үйлчилгээний дийлэнх буюу 80 гаруй хувийг иргэдэд олгосон зээл бүрдүүлж байгаа бол Австрали, Япон, Нидерланд улсуудын хувьд аж ахуйн нэгжүүд нь технологид суурилсан зээлийн үйлчилгээг бусад улс орнуудаас илүү их ашиглаж байна.

Пэйтек /PayTech/ нь төлбөр, тооцооны үйл ажиллагаанд ашиглагддаг технологид суурилсан санхүүгийн үйлчилгээний нэг хэлбэр юм. Одоогоор дэлхийн томоохон төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулагч байгууллагууд гар утасны аппликейшн, электрон түрийвч зэрэг пэйтекийн шийдлүүдийг ашиглаж байна. 2018 онд дэлхийн нийт пэйтек компаниудад оруулсан хөрөнгө оруулалт хамгийн их хэмжээндээ буюу 18.0 тэрбум ам.доллар хүрсэн байна. Энэхүү хөрөнгө оруулалтын 77.8 хувь буюу 14.0 тэрбум нь зөвхөн БНХАУ-ын "Айнт Фаянэйншл" /Ant Financial/ финтекийн нэгдэлд оруулсан хөрөнгө оруулалт байсан бөгөөд тус байгууллага нь одоогоор дэлхийн хамгийн том гар утасны болон цахим төлбөр тооцооны систем болох Алипэй /Alipay/-г эзэмшдэг. Харин Сиэ /Sea/ группийн хувьцаагаа анхдагч зах зээлд олон нийтэд санал болгож (IPO) татан төвлөрүүлсэн 575.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт нь 2018 оны хоёр дахь том хөрөнгө оруулалт нь байв. Тус компанийн эзэмшдэг Эйрпэй /AirPay/ нь Индонез, Тайван, Тайланд, Малайз зэрэг Зүүн өмнөд Азийн улсуудын хэрэглэгчдийн ашигладаг электрон түрийвчийн платформ юм.

Финтекийг том зах зээлийнх нь хувьд авч үзвэл дараах салбар болон дэд үйлчилгээнүүдэд хуваагддаг бөгөөд банкууд, финтек старт аппликейшнүүд өөрийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл, үйл ажиллагаатайгаа уялдуулан төрөл бүрийн үйлчилгээг хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцүүлэн хүргэж байна.

Монгол Улсад хамгийн түгээмэл дэлгэрээд байгаа нь бичил зээл болон дижитал төлбөр тооцоо ба цаашлаад дижитал хөрөнгийн зах зээл мөн хөгжих хандлагатай байна.



Дэлхий дахинд нүүрлэсэн Ковид-19 цар тахал нь иргэд, бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд эерэг сөрөг бүхий л нөлөөг үзүүлсэн хэдий ч дижитал санхүүгийн зах зээлийн хувьд иргэдийн хэрэглээ илүү тухайн үйлчилгээ рүү шилжиж, глобал хэмжээнд 10-20%-ийн өсөлттэй гарсан байна.

	Финтек босоо бизнес модел	Бизнесийн загварууд
Жижиглэн худалдаа (Хэрэглэгчид, өрх ба ЖДҮ)	Дижитал зээл	P2P/ зах зээл дэх хэрэглэгчдэд зээлэх, P2P/зах зээл дэх бизнесүүд, P2P/зах зээл дэх ҮХ, Баланс хэрэглэгчдэд зээлэх, Өрөнд суурилсан секүрити, инвойс траднинг, крауд микрофинанс, хэрэглэгчдийн худалдан авалт, хэрэглэгчдийн мөнгөн урьдчилгаа, дижитал худалдан авалт, мөнгөн урьдчилгааны шийдэл
	Дижитал капитал босгох/ үүсгэх	Үнэт цаасанд суурилсан бусдаас хөрөнгө босгох, ҮХ, Орлого, ашгийн ногдол, шагналд суурилсан, хандивд суурилсан бусдаас мөнгө босгох
	Дижитал банк	Бүрэн дижитал банк/жижиглэн, микро, ждү/ зах зээл дэх банк /жижиглэн, микро, ждү/ Baas-banking as a service, агент үйлчилгээ мөнгө хийх болон гаргах
	Дижитал хадгаламж	Дижитал мөнгөний зах зээл/Фонд, дижитал микро хадгаламжийн шийдэл, Дижитал хадгаламж нийлүүлсэн пүүл хадгаламж (Savings as a Service /SaaS)
	Дижитал төлбөр	Дижитал гүйлгээ, /улс хооронд р2р, дотоод р2р/ мөнгөн гүйлгээ/P2P P2B B2P B2B/ е-мөнгө олгогч, хөдөлгөөнт мөнгө, мерчантад зориулсан үйлчилгээ олгогчдыг авах, ПОС, бөөнөөр төлөгч агрегаторууд, төлбөрт зориулсан API, тооцоо болон клиринг үйлчилгээг олгогчид Дижитал хөрөнгө солилцох
	Дижитал хөрөнгийн солилцох	Захиалгын хуудас, нэр дийлэрт платформ,/ ОТС худалдаа, худалдааны ботууд, брокерын үйлчилгээ, БТМ биткойн АТМ, P2P зах зээл, клиринг
	Дижитал халамж анхаарал	Софтвейр түрүүвч/мобайл хэтэвч, таблет хэтэвч, десктоп хэтэвч/вэб хэтэвч, ваулт үйлчилгээ, түлхүүр үгийн менежментийн үйлчилгээ, хардвейр хэтэвч
	Даатгалын технологи	Хэрэглээнд суурилсан, параметрт суурилсан, эрэлтэг зүйлсийн даатгал, P2P даатгал, Техникийн үйлчилгээ олгогч TSP, дижитал брокер болон агент, харьцуулалтын портал, хэрэглэгчийн менежмент, IoT
	Баялгийн технологи	Дижитал баялагийн менежмент, нийгмийн худалдаа, Робо зөвлөх, Робо тэтгэвэрт гаргалт, төлөвлөлт, санхүүгийн харьцуулалтын сайтууд
Зах зээлийн хангамж	Зохицуулалтын технологи	Профайлинг болон магадлан шалгалт, блокчейн форензик, динамик комплайнс, хууль дүрэм мэдээлэх, зах зээлийн хянах, Альтернатив кредит болон Дата аналитик Альтернатив кредитийг рэйтинг хийх агент, кредит оноо, сэтгэцийн байдлыг анализ хийх, нийгмийн байдлыг анализ хийх, био мэдээллийн анализ хийх
	Альтернатив зээл ба мэдээллийн анализ	Альтернатив зээлийн үнэлгээний агентлаг, зээлийн оноо, психометрийн анализ, социометрийн шинжилгээ, биометрийн анализ
	Дижитал таних тэмдэг	Аюулгүй байдал ба биометрик, KYC шийдэл, залилангаас урьдчилан сэргийлэх, эрсдлийн менежмент
	Аж ахуйн нэгжийн технологийн хангамж	API менежмент, үүлэн технологи, AI / ML / NLP, Enterprise Blockchain, Санхүүгийн менежмент ба бизнесийн оюун ухаан, Дижитал нягтлан бодох бүртгэл, Цахим нэхэмжлэл


Хүснэгт 10. Финтек бизнес модел  
Эх сурвалж: WEF, The Global Covid-19 FinTech Market Rapid Assessment Study.



## Монгол улсын салбарын хэрэглээний зээлийн үзүүлэлт

Монгол улсын санхүүгийн сектор дотор Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын салбар нь хамгийн өсөлттэй яваа салбар юм. Сүүлийн 5 жилийн дотор ББСБ-ын салбарын нийт актив 3.2 дахин өссөн бол банкны салбар энэ хугацаанд 2 дахин, даатгалын салбар 2.2 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2021 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт активын хэмжээ 2020 оной харьцуулхад 18% өссөн байгаа нь банкны салбарын 5.6%-тай тэнцэж байна.

Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкнуудын хувь нийлүүлсэн хөрөнгөөс 1.3 дахин их байгаа нь ББСБ-ууд нь банктai харьцуулахад хадгаламж татдаггүй буюу зөвхөн өөрийн хөрөнгөндөө



тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотой. Нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 17.6% буюу 312.4 тэрбум төгрөгөөр өсөж 2.1 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 36.6% мөнгөн хөрөнгийн өсөлт, 39% цэвэр зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 62% өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Зээлийн багц, чанар. 2021 оны I улирлын байдлаар нийт зээлийн хэмжээ 2020 оны мөн үеэс 11.8% буюу 150.2 тэрбум төгрөгөөр өсөж 1,422.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 112.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1,309.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарчээ.

### Зээлийн багц



График 13: нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хэмжээ  
Эх сурвалж: СЗХ

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2017 оны мөн үед 798.3 тэрбум төгрөг байсан бол 2021 оны I улирлын байдлаар 2.6 дахин өсөж 2.1 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 2.9 дахин өссөнтэй холбоотой.

### Нийт хөрөнгө | Нийт зээл | ББСБ тоо




График 14. Нийт хөрөнгө, нийт зээл болон ББСБ тоо  
Эх сурвалж: СЗХ



ББСБ-ын актив болон зээлийн өсөлт банкны өсөлтийг давж байна.

2020 онд үйлдвэрлэл буурч, бизнесийн үйл ажиллагаа хэсэг хугацаанд зогсонги байдалд орсон тул зээл гаргалт үүнийг даган буурсан ба арилжааны банкны зээл 4.18% буурч 17.2 их наяд төгрөгт хүрсэн бол ББСБ-ын зээлийн үлдэгдэл 1.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 7.6% өссөн байна. Банкны нийт актив энэ онд 13%-иар өссөн бол ББСБ-ын хувьд 16% өсөлттэй байна. Сүүлийн 10 жилийн дунджаас харахад ББСБ-ын зээлийн өсөлт болон нийт активын өсөлт харгалзан 32.5%, 31.4% байгаа нь банкны зээл, активын өсөлтийг давсан үр дүнг бий болгоод байна.



График 15. Банк болон ББСБ-н харьцуулсан үзүүлэлтүүд  
Эх сурвалж: СЗХ

Өнгөрсөн оны байдлаар ББСБ-ын салбарын нийт олгосон зээлийн хэмжээ банкны нийт зээлийн үлдэгдлийн 7.5 хувийг эзэлж байгаа ба нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 47%-г тус тус эзэлж байна. Энэ нь өмнөх оны тухайн үзүүлэлтээс харгалзан 0.8 %, 5.4% дээшилсэн үзүүлэлт юм.

ББСБ-ын үйл ажиллагааны төрөлжилтийн тоо, үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын статистикийн хувьд факторингийн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо 17.2%-иар, гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо 5.77%-иар буурч бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг ББСБ-ын тоо өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс итгэлцлийн үйлчилгээ 26.5%, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ эрхэлдэг ББСБ-ын тоо 8.8%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь ББСБ-ын салбарын үйл ажиллагаа тэлж буйг илэрхийлнэ.

Финтек зээлдэгчийн тоо ББСБ-ын нийт зээлдэгчийн 73.0%-ийг эзэлж байна. ББСБ-ын салбарын нийт олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 11.8% буюу 150.2 тэрбум төгрөг болж өссөн бол нийт ББСБ-ын тоо 530 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.9%-иар буурсан ба техник технологийн дэвшилт ашиглаж

УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЦЭГ  
МОНГОЛЫН СУУЧИЙН БҮСГЭЭ

УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЦЭГ  
МОНГОЛЫН СУУЧИЙН БҮСГЭЭ

УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЦЭГ  
МОНГОЛЫН СУУЧИЙН БҮСГЭЭ

53

хэрэглээний зээл олгож эхэлснээр харилцагчийн тоо огцом өссөн байна. СЗХ-ны ББСБ-ын 2021 оны тайланд дурдсанаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэг давхардсан тоогоор 3,481,431 харилцагч, 610,068 зээлдэгчид үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс финтек үйлчилгээ авч байгаа харилцагчийн тоо давхардсан тоогоор 3,241,570, зээлдэгч 428,002 буюу нийт давхардсан харилцагчийн 93.1%, зээлдэгчийн 70.2%-ийг финтек ББСБ эзэлж байна. Үүнээс Мобифинанс ББСБ ХХК-ийн зээлдэгчийн тоо 2021 оны эхний улирлын байдлаар 194.0 мянга байна.

ББСБ-ын зээлийн үлдэгдэл




График 16. ББСБ-н зээлийн үлдэгдэл  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

ББСБ-ын харилцагчид



График 17. ББСБ-н харилцагчид  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

ББСБ-ын зээлийн үлдэгдэлд эзлэх дүнгээр финтек ББСБ-ын 2020 онтой харьцуулахад буурсан байгааг харж болохоор байна. Энд дурдаж байгаа бусад финтек ББСБ нь цэвэр технологид суурилсан барьцаагүй зээл олгодоггүй гэдгийг онцлох нь зүйтэй.

Монгол улсад финтек хэлбэрээр хэрэглээний зээл олгох үйл ажиллагаа явуулж буй голлох дараах 15 ББСБ байна.

Финтек ББСБ	App
Ашид капитал	Simple
Ард Кредит	Ard app
Говь финанс	Cash One
Жи Эс Би Капитал	GSB capital
Зээл Эм Эн Платформ	Zeel.mn
Инвескор хэтэвч	Pocket.mn
ЛэндМН	LendMN
<b>Мобифинанс</b>	<b>Monpay</b>
Монголиа импакт финанс	Qmoni
Нөмөр кредит	Numur
Смарткапитал фонд	Mycredit.mn
Соно финтек	Sono mongolia
Ти финанс	T-finance



2021.09.22  
Хатан суудал инвест  
Централ капитал

МОНГОЛЫН ХАГГАМГААНЫ БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
Zeely  
Kmobi -08-31  
Хүснэгт 11. Финтек ББСБ  
БҮРТГЭЭГЭЭ

Монгол улсын хэмжээнд иргэдийн дунд хамгийн түгээмэл зээлийн бүтээгдэхүүнүүд буюу банкны хэрэглээний зээл, цалингийн зээл, кредит карт, ББСБ-ын уламжлалт зээл, финтек ББСБ-ын бичил хэрэглээний зээл зэргийг харьцуулан судалж үзэхэд чанарын хувьд 2020 оны байдлаар банкны өрхийн хэрэглээний зээл хамгийн өндөр буюу 18.3% нь чанаргүй байгаа бол цалингийн зээл, банкны кредит карт зэрэг зээлийн бүтээгдэхүүнүүд өрхийн хэрэглээний зээлтэй харьцуулахад харьцангуй бага буюу харгалзан 5.6%, 12.1% нь чанаргүйжсэн байна.

ББСБ-ын салбарын хувьд уламжлалт болон финтек хэлбэрээр ангилан дээрх үзүүлэлтээр харьцуулахад уламжлалт ББСБ-ын чанаргүй зээлийн төвшин 10.9%, финтек ББСБ дунджаар 6.4% байгаа нь бусад үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй бага байна.



График 18. Банк болон ББСБ салбарын зээлийн үзүүлэлт  
Эх сурвалж: СЗХ

Хэрэглээний зээлийн хүү буурч байна. Монгол банкнаас зарладаг бодлогын хүү он гарснаас хойш нийт 2 пунктээр буурч 6% болсон ба энэ нь банк болон ББСБ-ын зээлийн хүү буурахад нөлөөлөх ба нөгөө талаас COVID-19 вирусийн нөлөөллөөс болж зээлийн бүтээгдэхүүн тасрах улмаар санхүүгийн хүртээмж буурахаас сэргийлэх зорилготой авч хэрэгжүүлж буй арга хэмжээ гэж харж байна.

Мобифинанс ББСБ ХХК-ын хувь зээлийн дундаж хүү 2.6% байна. Тайлант улиралд ББСБ-ууд 483.2 тэрбум төгрөгийн зээлийг 2.9%-ийн жигнэсэн дундаж хүүтэй байгаа нь Мобифинанс ББСБ ХХК дундаж хүү салбарын дунджаас 0.3 пунктээр бага байна.

Мобифинанс ББСБ ХХК-ын хувь зээлийн дундаж хүү 2.6% байна. Тайлант улиралд ББСБ-ууд 483.2 тэрбум төгрөгийн зээлийг 2.9%-ийн жигнэсэн дундаж хүүтэй байгаа нь Мобифинанс ББСБ ХХК дундаж хүү салбарын дунджаас 0.3 пунктээр бага байна.



Зээлийн жигнэсэн дундаж хүү  
2021 - I улирал




График 19. Зээлийн жигнэсэн дундаж хүү  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

2021 оны I улиралд ББСБ-ууд 483.2 тэрбум төгрөгийн зээлийг 2.9% жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 387.2 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2021 оны I улирлын байдлаар 610,068 зээлдэгчийн 1.4 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлийн үлдэгдлийн 85.5% хэвийн зээл, 4.1% хугацаа хэтэрсэн зээл, 10.3% чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Цар тахал дэгдэж, бэлэн байдлын зэрэгт шилжснээс хойш “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, үйлчлэлийн хугацааг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл сунгасан. Өөрөөр хэлбэл, зээлийн хугацааг 90 хоног хүртэлх хугацаанд хэвийн ангилалд ангилах, зээлийн гэрээг 2 болон түүнээс дээш сунгасан тохиолдолд ангилал бууруулахгүй байхаар шийдвэрлэсэн.



Цахим санхүү, төлбөр тооцооны үзүүлэлт

Мобайл болон дата хэрэглээ нь финтек зах зээлийн үндсэн дэд бүтэц болохын хувьд зайлшгүй харах шаардлагатай үзүүлэлтийн нэг юм. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны /ХХЗХ/ тайланд дурдсанаар 2016-2020 оны хооронд дата хэрэглэгчийн тоо жилийн өсөлтийн хувиар /CAGR/ 1%, смарт утасны хэрэглэгчийн тоо 7% буюу жилийн өсөлтөөр 3.4 сая болж өсөх төлөвтэй байна.









График 20. Ухаалаг утас болон дата хэрэглэгчид  
Эх сурвалж: Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны /ХХЗХ/ тайлан


Монгол Банкнаас гаргадаг хөдөлгөөнт банкны тайлангаас харахад 2015-2020 оны хооронд идэвхтэй ашиглаж буй картын тоо тасралтгүй өссөн байхад нийт картын тоо дунджаар 4% буурсан байна. Мөн картын тоо буурахтай зэрэгцэн Интернет банкны идэвхтэй хэрэглэгчийн тоо болон мобайл банкны идэвхтэй хэрэглэгчийн тоо тус тус дунджаар 21% болон 16.4% -р өссөн байна.

Монрау аппликейшн нь нийт 700 мянга гаруй татан авалттай бөгөөд Монгол улсын топ татан авалттай аппликейшнуудын жагсаалтад дээгүүр байр эзэлж байна.

	Андройд /мянган таталт/	IOS МУ-ын топ таталттай аппликейшн /Жагсаалт/
И-баримт	1000	8
Хаан банк	1000	2
<b>Монрау</b>	<b>700</b>	<b>23</b>
ЛэндМН	500	50
Төрийн банк	500	-
Голомт банк	500	17
Ard	500	42
Хас bank	100	-
U point	100	-
TDB	100	-
Social pay	100	1
Most money	100	-
Pocket	100	22

Хүснэгт 12. Санхүүгийн салбарын аппликейшнүүдийн татан авалтын тоо  
Эх сурвалж: Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны тайлан





	2015	2016	2017	2018	2019	2020
Картын тоо	4.059	3.953	3.845	4.291	3.748	4.077
Идэвхтэй ашиглаж буй картын тоо	2.290	1.468	1.716	1.586	1.899	1.863
Интернет банкны идэвхтэй хэрэглэгч /Интернет болон аппликейшн//мян.хүн/	875	1.054	1.389	1.805	2.133	2.635
Мобайл идэвхтэй хэрэглэгчийн тоо /мян.хүн/	875	1.348	1.637	2.012	1.222	1.389

Хүснэгт 13. Интернет болон мобайл банкны идэвхтэй хэрэглэгчдийн тоо

Төлбөрийн уламжлал ойлголтыг өөрчилж илүү хялбар хүртээмжтэй болгохоор олон төрлийн цахим үйлчилгээнүүд нэвтрээд байгаа ба Монгол Банкнаас гаргадаг Хөдөлгөөнт банкны тайланд дурдсанаар 2020 оны байдлаар 107.6 сая ширхэг гүйлгээгээр 35.1 их наяд төгрөгийн төлбөр тооцоо хөдөлгөөнт банкаар хийсэн байна.

Интернэт хандалтаар нийт 32.5 их наяд төгрөгийн 74.4 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны IV улирлаас дүнгийн хувьд 2.1 их наяд төгрөгөөр буюу 6.8 хувиар, гүйлгээний тооны хувьд 24.0 сая ширхэг гүйлгээгээр буюу 47.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тус гүйлгээг үйлчилгээний төрлөөр ангилбал:

- Цахим хуудас – 16.3 их наяд төгрөгийн 8.1 сая ширхэг;
- Гар утасны аппликейшн – 16.2 их наяд төгрөгийн 66.4 сая ширхэг гүйлгээ тус тус хийгдсэн байна

Монгол улсын хэмжээнд финтекийн салбарт өрсөлдөхүйц хэмжээний үйл ажиллагаа явуулж буй дараах төлбөр тооцооны аппликейшнүүдтэй харьцуулахад татан авалтын тоогоор өндөр үзүүлэлттэй бөгөөд анхдагч юм.

	Mon Pay	Social Pay	SuperUp	TDB Pay	U Point	Store Pay
Нэвтэрсэн он	2010.08	2017.04	2020.02	2019.05	2018.12	2019.09
Үүсгэн байгуулагч	Мобиком Корпораци	Голомт банк	ЛэндМН	ХХБ	Юнивишн	Сторпэй
Систем хөгжүүлэгч	Мобиком	Хязгааргүй шийдэл ХХК	АНД Системс тех	Хязгааргүй шийдэл ХХК	Юнивишн	Сторпэй
Харилцагчийн тоо /апп татаж авсан тоо/	700,000	100,000+	100,000+	100,000+	100,000+	50,000+
Төлбөр тооцооны онцлог	Өөрийн эко орчинтой	Банкны үйлчилгээ	Өөрийн эко орчинтой	Банкны үйлчилгээ	Бонус оноо цуглуулдаг	Төлбөрөө 4 хувааж төлдөг

Хүснэгт 14. Үйл ажиллагаа явуулж буй төлбөр тооцооны аппликейшнүүдийн мэдээлэл  
Эх сурвалж: Компаниудын бүтээгдэхүүнүүдийн мэдээлэл


Татан авалт өндөртэй ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг аппликейшнүүдтэй харьцуулахад үйлчилгээний цар хүрээгээр өөрийн эко орчныг бий болгож харилцагчдад нэг дор цогцлоосон олон үйлчилгээг хүргэж



УЛААНБААТАР ХОТ  
МОБИФНАНС ББСБ ХХК  
9021101075-5373271



58



КАПИТАЛ ҮНД  
ХХК  
513255  
9021031155-5373271

ажилладагаараа давуу талтай билээ. Мөн харилцагчдын худалдан авалт тутамд олгодог урамшуулал нь харилцагчидаа цаашид идэвхжүүлэх, тогтмол ашиглах суурь болж өгдөг билээ.

Үйлчилгээ	Monpay	SuperUp	Simple	Ard	Pocket
Барьцаагүй зээл	✓	✓	✓	✓	✓
Шилжүүлэг	✓	✓	✗	✓	✓
Төлбөр тооцоо	✓	✓	✗	✓	✓
Цахим худалдаа	✓	✓	✗	✓	✗
Эко орчин	✓	✓	✗	✓	✗
Купон урамшуулал	✓	✓	✗	✓	✗

Хүснэгт 15. Ижил төрлийн аппликейшнүүдтэй харьцуулсан харьцуулалт  
Эх сурвалж: Компаниудын бүтээгдэхүүнүүдийн мэдээлэл



## 2.1.1 ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ТӨЛВИЙН СУДАЛГАА

Мобифинанс компанийн хувьд хэрэглэгчээ сонсож тэдний хүсэл сонирхол эрх ашиг дээр тулгуурлан өөрсдийн үнэт зүйл, алсын хараагаа тодорхойлдог онцлогтой. Тиймээс ч хэрэглэгчээс тогтмол судалгаа авч, тэднийг сонсон өөрсдийн бизнесийн хүрээгээ тэлэх, ойрын болон урт хугацааны стратеги бодлогоо тодорхойлоход судалгааны үр дүнгүүдийг ашигладаг.

Өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээн дээрх тогтмол судалгаа шинжилгээг Мобиком корпорацийн Маркетинг бүтээгдэхүүн судалгаа шинжилгээний албаар дамжуулан судалгааны олон төрлийн арга ашиглан, өргөн хэмжээнд буюу монгол орон даяарх хэрэглэгч үйлчлүүлэгчдээсээ авдаг юм. Жишээ нь: Өнгөрсөн хагас жилийн хугацаанд онлайн байдлаар Monpay брендингийн талаар – 1, Monpay хэрэглэгчдэд чиглэсэн урамшууллын талаар – 2, зээлийн бүтээгдэхүүний талаар – 1, нийт 4 удаагийн судалгааг нийт Monpay хэрэглэгчид болон бусад Monpay үйлчилгээг ашигладаггүй хэрэглэгчдийг оролцуулан авсан байна.

Судалгаа бүр өөрийн гэсэн зорилготой бөгөөд хэрэглэгч харилцагчиддаа хэр ойр байж тэднийг ойлгож байгаа, бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл хүртээмжтэй байдал хэр ойлгомжтой хялбар байна вэ гэдгийг бодитоор үнэлэх боломжийг үргэлж олгож байдаг. Судалгаа бүрийн гарсан үр дүнгээс хамаарч тухай бүрт нь хэрэглэгч, хамтрагчиддаа аль болох хялбар ойлгомжтой байх нөхцөл боломжийг бүрдүүлж өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээндээ нэвтрүүлэн ажилладаг.


mobi  
finance  
УЛААНБААТАР ХОТ  
МӨБИФИНАНС БӨСӨ ХХК  
9021101075-5373271

mobicom  
УЛААНБААТАР ХОТ  
МӨБИКОМ КОРПОРАЦИЙН ХЭМЖЭЭН  
59  
9021101075-5373272

ӨЛЗИЙ ЭНД КО  
КАПИТАЛ УНД  
ХХК  
УЛААНБААТАР ХОТ  
9021101075-5373271

Өмнөх судалгааны зарим үр дүнгүүдээс хуваалцвал:

2021.05 сард хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд Финтек салбарын хамгийн ойрын боломжит зах зээл гэж Улаанбаатар хотын 15-60 насны иргэдийг үзвэл тэдгээрийн 94% нь ухаалаг гар утастай буюу 884 мян. хэрэглэгч байна. Эдгээр 884 мян. хэрэглэгчдийн 29% нь буюу 265 мян. хэрэглэгч өдөр тутмын төлбөр тооцооны хэрэгсэлдээ интернэт банк болон ямар нэгэн дижитал хэрэгсэл хэрэглэдэг бөгөөд одоогийн Ковид-19 нөхцөл байдал, зах зээлийн хандлага, дижитал төлбөр тооцооны хэрэгсэл ашиглах шаардлага, экосистемийн тэлэлт зэргээс хамааран хурдацтай өсөн нэмэгдэх боломжтой нь харагдаж байна.



Зураг 24. Зах зээлийн багтаамж


Түүвэр судалгааны аргаар Улаанбаатар хотын иргэдээс авсан судалгааны үр дүнд Monpay брэндийн танигдсан байдлын талаарх асуултад Улаанбаатар хотын нийт иргэдийн 49% (тал хувь) нь Monpay үйлчилгээний талаар сонсож байсан гэж хариулсан ба тэдгээрийн 40%-д нь цахим хэтэвч, санхүүгийн үйлчилгээ гэдэг талаасаа танигдсан байна. Судалгаанд оролцогчдын дундаж нас 28, дундаж орлого 811,000₮, ажил эрхлэлтийн байдал өндөр байсан бөгөөд эдгээр судалгаанд оролцогчдын хувьд Монпэй аппликейшний төлбөрийн хялбар шийдэл, зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг илүүтэйгээр сонирхдог болох нь судалгааны үр дүнгээр харагдсан.



10 Хүний 4 нь  
Monpay гэж мэддэг

Зураг 25. Monpay үйлчилгээ танигдсан байдал

Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх ойлголтын хувьд лояалти буюу урамшуулалт онооны үйлчилгээ гэж ойлгох хандлага өмнө нь байсан бол Monpay болж ребрэндинг хийснээр энэхүү ойлголт бүрэн арилж бие даасан төлбөр тооцооны шийдэл, зээлийн үйлчилгээ болон олон төрлийн онлайн үйлчилгээг нэг дороос авах боломжтой цахим хэтэвч болж хэрэглэгчдэд аль хэдийнээ танигдсан нь судалгааны үр дүнгүүдээс харагдаж байна.




Урамшуулалт хөтөлбөрийн хувьд Монрау үндсэн урамшуулал болох худалдан авалтын үнийн дүн нэмэгдэх тусам дата болон хөнгөлөлтийн эрхээр урамшуулдаг Level up урамшууллын талаар 10 хүний 4 нь мэддэг ба мэддэг 4 хүний 2 нь тогтмол хэрэглэдэг гэсэн үр дүн гарсан. Урамшууллын нөхцөл болон урамшууллыг хэрэглэх хялбар байдлыг оноогоор үнэлүүлэхэд 5 онооноос 4.1 оноог авсан нь хэрэглэгчдэд зориулсан урамшуулалт хөтөлбөрүүдийг зах зээлд нэвтрүүлэхдээ илүү хэрэглэгчдэд ойлгомжтой хялбар байдлыг чухалчилдагийг илтгэж байна.

Нийт Монрау хэрэглэгчдийн 65% нь зээлийн үйлчилгээний талаар хангалттай мэддэг бөгөөд 10 хүний 1 нь зөвхөн зээлийн үйлчилгээнд үндэслэж Монрау аппликейшныг хэрэглэдэг гэжээ. Судалгаанд оролцогчдын 40% нь зээл авах болон эргэн төлөхөд маш хялбар, 74% нь цаашид үргэлжлүүлэн ашиглана гэж хариулсан байна. Мөн Энэ бүгдээс харахад Монрау зээлийн уян хатан нөхцөл, хүү, хялбар байдал зэрэг нь давуу тал болж байна. Монрау үйлчилгээний талаар сонсож байсан хэрэглэгчдийн 80% нь цаашид Монрау-г ашиглана гэжээ. Мөн 18% нь Ард, Лэнд.мн зэргийг давхар ашиглахаар төлөвлөж байгаагаа илэрхийлсэн байна.

## 2.2 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА

Монгол улсын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд:

Үзүүлэлт	нэгж	2017	2018	2019	2020	2021 I
Үндэсний тооцоо						
ДНБ, оны үнээр	тэрбум төг	27,876	32,411	36,898	36,958	8,803
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр	тэрбум төг	16,892	18,116	19,040	18,034	3,830
ДНБ-ний өсөлт бодит	хувь	5.3%	7.2%	5.1%	-5.3%	15.5%
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр	сая төг	9.0	10.3	11.6	11.4	2.6
Мөнгө санхүү						
Мөнгө M1	тэрбум төг	2,826	4,031	3,904	4,197	4,328
Мөнгө M2	тэрбум төг	15,861	19,475	20,834	24,220	25,136
Нэгдсэн төсвийн орлого	тэрбум төг	7,958	10,054	11,937	10,402	2,876
Нэгдсэн төсвийн тэнцэл	тэрбум төг	(1,059)	831	508	-96,272	151
Гадаад валютын албан нөөц	сая ам.дол	3,008	3,549	4,349	4,534.2	4,774




Засгийн газрын гадаад өр	сая ам.дол	7,321	7,184	7,702	8,653	8,450
Экспорт	сая ам.дол	6,201	7,012	7,620	7,576	3,974
Импорт	сая ам.дол	4,337	5,875	6,127	5,293	2,904
Төлбөрийн тэнцэл	сая ам.дол	1,460	(142)	453	2,282	1,070
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	сая ам.дол	2,086	2,729	2,900	2,620	
Хүүгийн төвшин						
Бодлогын хүү	%	11.0%	11.0%	11.0%	6.0%	6.0%
Инфляцийн төвшин	%	6.4%	8.1%	5.2%	2.3%	3.1%
Хадгаламжийн хүү, жилээр	%	13.0%	11.2%	10.6%	8.3%	7.9%
Зээлийн хүү, жилээр	%	19.0%	16.9%	16.9%	15.8%	15.2%
Төгрөг ам.долларын албан ханш	төг	2,427	2,644	2,734	2,849	2,849
Банкны салбар						
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төг	13,615	17,226	18,096	17,683	17,636
Хугацаа хэтэрсэн зээл	%	6.0%	4.9%	4.6%	7.1%	7.4%
Чанаргүй зээл	%	8.5%	10.4%	10.1%	11.2%	11.5%
Зээлийн хүү, сараар	%	1.5%	1.3%	1.3%	1.3%	1.2%

Хүснэгт 16. Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд  
Эх сурвалж: Монгол банк. Үндэсний статистикийн хороо

Сүүлийн нэг жил гаруйн хугацаанд хүмүүсийн амьдрал, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа цаашлаад дэлхийн эдийн засагт хүчтэй нөлөөлсөн олон үйл явдлууд болж өнгөрлөө. Тухайлбал Ковид 19-н дэгдэлтээс шалтгаалсан дэлхийн хөрөнгийн зах зээлийн томоохон уналт, хөдөлмөрийн зах зээлд өмнө нь гарч байгаагүй их хямрал, түүхэн дэх хамгийн огцом, хурдан эдийн засгийн бууралт өнгөрсөн онд тохиож өнгөрсөн билээ. Олон улсын валютын сан 2020 оны 6 дугаар сард үүсээд байсан нөхцөл байдлыг “Юутай ч зүйрлэшгүй хямрал” хэмээн нэрлэж байв.

Гэсэн ч Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор хөгжингүй орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын дэмжлэг, дэлхий нийтээр эрчимжиж буй вакцинжуулалтын аян зэрэг чухал үйл ажиллагаануудын үр дүнд 2020 оны 2-р хагасаас эхлэн глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд сэргэлт гарч эерэг



дүр зургууд Э ижиглагдаж эхлээд байна. Олон улсын санхүүгийн байгууллагуудын зүгээс 2021 онд Америкийн Нэгдсэн Улс 6.1%, Франц 5.0%, Герман 3.0%, Хятад 8.5%, дэлхийн нийт эдийн засаг 6.1% орчим өсөлттэй байх төсөөллийг гаргажээ.

### Дотоодын нийт бүтээгдэхүүн:

Монгол улсын эдийн засаг ч мөн “Ковид-19”-ийн хүчтэй нөлөөлөл дор байна. Өнгөрсөн оны нэгдүгээр сараас эхлэн дотоодод хорио цээрийн дэглэм тогтоосноор эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа алдагдан олон салбарт бизнесийн үйл ажиллагаа хязгаарлагдаж, ажлын байр, өрхийн хэрэглээ, хөрөнгө оруулалт хумигдсанаар 2020 оны ДНБ бодит дүнгээр -5.3% гарлаа. ДНБ 2020 оны эхний улиралд -10.7% агшилттай гарсан ч үүнээс хойш эдийн засагт “V” хэлбэрийн сэргэлт гарч оны эцэст жилийн дүнгээр -5.3% болж эдийн засгийн агшилт саарсан байна.

Оны үнээрх ДНБ-ийн өсөлт  
(жилээр)





График 21. Монгол Улсын ДНБ-ийн өсөлт  
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



ДНБ-ий агшилтыг задлан харвал 2.0%-ийг уул уурхайн салбар, 3.0%-ийг Үйлчилгээний салбар, 0.3%-ийг тээвэр холбоо болон бусад салбар бүрдүүлсэн байна.

2021 оны I дүгээр улиралд эдийн засаг өмнөх оны мөн үеэс 15.7 орчим хувиар өсжээ. Эдийн засаг ийнхүү сэргэхэд экспортын эрдэс түүхий эдийн гадаад эрэлт, үнийн өсөлт, түүнийг дагасан уул уурхайн олборлолт, тээвэр, боловсруулах үйлдвэрийн салбарын идэвхжил, цар тахлын үед эдийн засгийг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээ гол нөлөө үзүүлж байна.

Цаашид эдийн засгийн гадаад орчны таатай байдал үргэлжилж, Ковид-19 цар тахлын нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн төсөв, мөнгө болон макро зохистой бодлогын арга хэмжээний эерэг нөлөө үргэлжлэн гарч, зээлийн үйл ажиллагаа сэргэснээр 2021 оны туршид эдийн засаг сэргэлттэй, 5.0-7.0 хувийн өсөлттэй байна гэсэн урьдчилсан төсөөллийг Монгол банк гаргаад байна.

Төсөв:





Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2020 оны гүйцэтгэлээр 4.5 их наяд төгрөг буюу нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний 12.2 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай байв. Төсвийн тодотголтой харьцуулахад тэнцвэржүүлсэн орлого 300 тэрбум төгрөгөөр тасарсан бол нийт зардал 600 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байв.

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл




График 22. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл  
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Тэнцвэржүүлсэн орлого:**

Цар тахлын улмаас 2020 оны ихэнх саруудад орон даяар хөл хорионы дэглэм тогтоож, эдийн засгийн идэвхжил суларсан нөлөөгөөр тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 1.5 их наяд төгрөгөөр хумигджээ.

**Нийт зардал, цэвэр зээл:**

Цар тахлын үед төрөөс хэрэгжүүлсэн багц арга хэмжээний нөлөөгөөр төсвийн зардал 2020 онд өмнөх оноос 2.3 их наяд төгрөг буюу 19.7 хувиар тэлэв.





2021.09.22 14P

2021-08-31  
БҮРТГЭД-03

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр:

Засгийн газрын өр ДНБ-д эзлэх хувиар




График 23. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь  
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Энэ онд Засгийн газар “Мазаалай” бондын болон “Кредит свисс” банкнаас авсан зээлийн үлдэгдэл төлбөрийг төлсөн, богино хугацааны том дүнтэй гадаад өр төлбөр байхгүй, гадаад өрийн дарамт цаашид буурахаар байгааг харгалзан “Мүүдис” агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг -В3 төлөвтэй байсныг В3 тогтвортой болгож сайжруулав. “Century” төслийн хүрээнд хугацаа тулаад байсан Чингис болон Гэрэгэ бондын 1.0 тэрбум ам.долларын өр төлбөрийг түүхэндээ хамгийн бага төвшний хүүтэйгээр дахин санхүүжилт хийж өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Мөн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь 2021 онд 61.9 хувь байхаар батлагдсан нь хуульд заасан хязгаарыг хангаж байна.

Хүү:

Зээл, хадгаламжийн дундаж хүү болон бодлогын хүүгийн харьцуулалт



График 24. Хүүгийн харьцуулалт  
Эх сурвалж: Монгол банкны 6-р сарын Инфляцийн тайлан

Монгол банк өнгөрсөн онд хорио цээрийн дэглэмийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор бодлогын хүүг 11.0-ээс 6.0 хувь хүргэж бууруулаад байна. Энэ 3 дугаар сарын ээлжит хурлаар бодлогын хүүг дахин 6.0

mobifinance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 5373271

65

УЛААНБААТАР ХОТ  
КАПИТАЛ ҮЙС  
ХХК  
5103855  
9021031103 070310

2021.09.22

хувьд хэвээр үлдээх шийдвэр гаргалаа. Энэ оны 1 дүгээр улиралд банкуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 2.69 нэгж хувиар буурч 7.9 хувьд хүрсэн бол шинээр олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү 1.6 нэгж хувиар буурч 15.2 хувьд хүрлээ. Улмаар зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 1.08 нэгж хувиар өсч 7.3 хувьд хүрэв.

### Гадаад валютын албан нөөц:

2020 оны эцэст ГВАН өмнөх оноос 185.6 сая ам.доллараар өсөж 4534.2 сая ам.долларт хүрэв. Төлбөрийн тэнцэл 2020 онд 787 сая ам.долларын ашигтай байсан бол нөгөө талдаа мөнгөжсөн алтны нөөцөөс алт экспортолсон нөлөөгөөр алтны нөөц 624 сая ам.доллараар буурч ийнхүү ГВАН-ийн өөрчлөлт өмнөх оноос 185.6 сая ам.доллараар өслөө. 2020 онд 23 тонн алт худалдан авч, валютын нөөцөө өсгөж чадсан байна.

Гадаад валютын улсын нийт албан нөөц



График 25. Гадаад валютын албан нөөц

Эх сурвалж: Монгол банкны гадаад валютын албан нөөцийн статистик мэдээлэл

Гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оны 5 дугаар сараас хойш, төлбөрийн тэнцэл 10 дугаар сараас хойш ашигтай гарснаар гадаад валютын албан нөөц 2021 оны 4 дүгээр сарын байдлаар 4.9 тэрбум ам.долларт хүрч нэмэгдлээ. Үүний үр дүнд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш өнгөрсөн оны 6 дугаар сараас хойш өнөөг хүртэл маш тогтвортой байна.

### Валютын ханш:

Валютын ханш



График 26. Голлох валютуудын төгрөгтэй харьцах ханш

Эх сурвалж: Монгол банкны Инфляцийн статистик мэдээлэл



2021 оны 22-р сар

Ковид 19-ын хямралын үед хөгжиж буй орнуудаас хөрөнгийн урсгал гадагшилж, ханш савлах үзэгдэл нийтлэг ажиглагдсан хэдий ч Монгол төгрөгт савлагаа үүсээгүй. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сүүлийн 7 сар гаруйн хугацаанд 2,850 төгрөгийн орчимд тогтвортой байлаа. Сүүлийн саруудад зах зээлийн хүлээлт тогтвортой байсны дээр экспортын үнэ, эрэлтийг даган гадаад валютын орох урсгал сайжирснаар төгрөгийн ханш сулрах дарамт бага байлаа. Түүнчлэн, хөл хорионы хязгаарлалттай холбоотойгоор эдийн засгийн үйл ажиллагаа хумигдаж, валютын эрэлт буурсан байна.

Ам.долларын ханш 2021 оны 6-р сарын 15-ны байдлаар 2,849.81 төгрөгт хүрсэн нь оны эхнээс 0.01 хувиар чангарсан, өмнөх оны мөн үеэс 1.56 хувиар суларсан үзүүлэлт байна.

Төгрөгийн юаньтай харьцах ханш 2021 оны 6-р сарын 15-ны байдлаар 445.05 төгрөгт хүрсэн нь оны эхнээс 2.02 хувиар, өмнөх оны мөн үеэс 12.05 хувиар тус тус суларсан үзүүлэлт юм.

### Инфляци:



График 27. Инфляцийн жилийн төвшин

2020 оны 4 дүгээр улиралд халдвар хамгааллын дэглэм чангарч эрэлт багассантай холбоотойгоор буурах чиглэлд хөдөлж байсан үнийн өсөлт 2021 оны 2-р улирлаас эхлэн өсөх хандлагатай боллоо 2020 оны эцэст улсын хэмжээнд жилийн 2.3 хувь, Улаанбаатарт 1.9 хувь байсан инфляц 2021 оны 5 дугаар сарын байдлаар харгалзан 6.3 хувь, 6.7 хувь болсон байна.

Инфляци ийнхүү өсхөд сайжруулсан түлшний үнийн хөнгөлөлтийг зогсоосон, эдийн засгийн идэвхжиж эхэлсэн зэрэг нөлөөлжээ. Цаашид цахилгаан, дулааны үнийг төрөөс даах хугацаа 7 сарын 1-ээр дуусгавар болох, гадаад зах зээл дэх нефтийн үнээс шалтгаалан шатахууны үнэ өөрчлөгдөх зэрэг нөлөөгөөр инфляц өсөх дарамттай байх хэдий ч 2021 онд зорилт төвшин буюу  $6.0\% \pm 2.0\%$  орчимд хадгалагдах төсөөлөлтэй байна.



Топ 20 индекс



График 28. Хөрөнгийн зах зээлийн ТОП 20 индекс  
 Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж. Топ 20 Индекс

2020 оны эхэнд болон дунд үед захын идэвх сул байсан бол оны сүүл хэсгээс хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд хурдацтай өссөөр 2021 оны 4 сарын 23-нд ТОП 20 индекс бүх цаг үеийн дээд хэмжээ 37,973 нэгжид хүрсэн байна. 2021 оны 6-р сарын 16-ны байдлаар топ 20 индекс 32,249 нэгж байна. Зах зээлийн үнэлгээ 2021 оны эхний улирлын байдлаар 3,691.94 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Банкууд:

Эдийн засгийн сэргэлт, цар тахлын үед орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлсөн, цахилгаан, дулаан, усны төлбөрт хөнгөлөлт үзүүлсэн, хүүхдийг мөнгийг 100 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн, иргэн бүрт 300 мянган төгрөг олгосон зэрэг арга хэмжээний нөлөөгөөр банкны салбар дахь иргэд, аж ахуйн нэгжийн нийт хадгаламж 4-р сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.4 хувиар нэмэгдсэн байна.

Хадгаламжийн өсөлтийг ялгаатай бүлгүүдээр авч үзвэл, 1-5 сая төгрөгийн дүнтэй хадгаламж 51.0 хувиар, 5-20 сая төгрөгийн дүнтэй хадгаламж 30.0 хувиар, 20-100 сая төгрөгийн дүнтэй хадгаламж 25.4 хувиар, 100-500 сая төгрөгийн дүнтэй хадгаламж 24.7 хувиар, 500 сая төгрөгөөс дээш дүнтэй хадгаламж 30.8 хувиар тус тус өссөн байна. Энэ нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд бүх бүлгүүдийн хувьд хадгаламж жигд өндөр өсөлттэй байсныг илтгэж байна.

Хадгаламжийн өсөлтийн хувь  
 (мөнгөн хэмжээгээр)



График 29. Сүүлийн нэг жилийн хугацаанд хадгаламжийн өсөлтийн хувь  
 Эх сурвалж: Монгол банкны 6-р сарын Инфляцийн тайлан

Үүний зэрэгцээ банкны салбарын зээлийн хүү буурч, зээл олголт идэвхжиж эхэллээ. Мөнгөний бодлогын хүрээнд 2020 оны туршид бодлогын хүүг 5.0 нэгж хувиар бууруулан 6.0 хувьд хүргэж, банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулах замаар эх үүсвэр чөлөөлж, урт хугацаатай, зорилтот репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлж ашигласнаар зээлийн хүү буурах суурь нөхцлийг бүрдүүлэв. Ингэснээр шинээр олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү 2020 оны 9 дүгээр сараас хойш тасралтгүй буурсаар энэ оны 4 дүгээр сард жилийн 15.2 хувь болов.

Арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэл 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өсөж 17.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Тодруулбал хувийн байгууллагын зээл 8.1 их наяд төгрөг, иргэдийн зээл 8.9 их наяд төгрөг байна. Нийт зээлийн үлдэгдлийн 1.6 их наяд төгрөг буюу 9.2 хувь нь гадаад валютаар олгосон зээл эзэлж байна.

Зээлийн өсөлтийн хувь  
(мөнгөн хэмжээгээр)





График 30. Сүүлийн нэг жилийн хугацаан дахь зээлийн өсөлтийн хувь  
Эх сурвалж: Монгол банкны 6-р сарын Инфляцийн тайлан

Зээлийн өсөлтийг ялгаатай бүлгүүдээр авч үзвэл, 50-100 сая төгрөгийн зээл 20.5 хувиар, 100-500 сая төгрөгийн зээл 29.2 хувиар, 2-3 тэрбум төгрөгийн зээл 21.1 хувиар, 4-5 тэрбум төгрөгийн зээл 11.7 хувиар өсжээ.

Чанаргүй зээл:

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ



2021 оны 1-р улирлын байдлаар нийт чанаргүй зээлийн үлдэгдэл 2,013.4 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт чанаргүй зээлийн 73.8 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 78.0 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлж байна. Үүнийг салбараар авч үзвэл 20.6 хувийг уул уурхай, 19.3 хувийг боловсруулах, 13.5 хувийг барилга, 10.7 хувийг үл хөдлөх, 7.5 хувийг худалдааны салбарын зээл тус тус эзэлж байна.

График 31. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ  
Эх сурвалж: Монгол банкны 6-р сарын Инфляцийн тайлан

**mobifinance**  
 УЛААНБААТАР ХОТ  
 МОБИФИНАНС ББСБ ХХК  
 9021101075 ☎ 5373271

**mobicom**  
 УЛААНБААТАР ХОТ  
 МОНГОЛЫН ИРГЭДИЙН БАНК  
 69

ӨЛЗНИЙ ЭМД НЭГ  
 КАПИТАЛ ҮЙН  
 ХХК  
 6100855  
 9021031105 ☎ 0702100

**Ажил эрхлэлт:**

2021 оны 06 сарын 30-ны байдлаар  
**БҮРТГЭВ**

2021 оны 06 сарын байдлаар Монгол улсын нийт хүн ам 3.32 сая бөгөөд хүйсийн харьцаа 50.9% эмэгтэй 49.1% эрэгтэй байна. Нийт ажиллах хүчний хэмжээ 1.15 сая бөгөөд 47.0% эмэгтэй, 53.0% эрэгтэй байна. Үжиллагчдын тоо 1.05 сая байна. 2021 оны 1-р улирлын байдлаар ажилгүйдлийн төвшин 8.8% байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.2% нэмэгдсэн үзүүлэлт болжээ.



График 32. Нийт ажиллах хүч болон ажилгүйдлийн хувь  
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

**Цаашдын төлөв:**

Монгол улсын эдийн засгийн өсөлт (төсөөлөл)




График 33. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төсөөлөл  
Эх сурвалж: Сангийн яам

Энэ жилийн хувьд дэлхий дахиныг нөмөрсөн цар тахлын аюул холдож, эдийн засагт өсөлт бий болно гэсэн хүлээлт давамгайлж байна. АНУ, БНХАУ, Евро бүс зэрэг томоохон эдийн засгууд хүлээлтээс давсан эдийн засгийн өсөлтүүдийг үзүүлсэн, эрдэс бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэн зэрэг гадаад орчны зэрэг өөрчлөлтүүд, хөл хорионы дэглэм суларсан, засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогын

арга хэмжээний нөлөө гарч эхэлсэн зэрэг дотоод хүчин зүйлүүд эдийн засгийг аажмаар сэргэх төлөвт чиглүүлж байна.



Монгол улсын талаар Азийн Хөгжлийн Банкны тайланд дурдсанаар "Худалдааны таатай нөхцөлүүд, экспортын эрэлт нэмэгдсэнээр Монгол улсын

Саяхан үйлдсэн үйлдэлүүд

УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075-т. 5373271

70

ЕЛЭНЭ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЦК  
5183655  
9021031155-т. СТС2420



эдийн засгийн өсөлт 2021 онд аажмаар сэргэж, цаашлаад цар тахлын эрсдэл буурч, дэлхийн эдийн засгийн нөхцөл сайжирснаар 2022 онд хурдацтай өсөх төлөвт орно” гэжээ. Сангийн яамнаас 2021 онд Монгол улсын эдийн засаг 6.5% өсөх төсөөлөл гаргаад байна.

Ковидын дараа улс орнуудын эдийн засаг хурдтай сэргэж байгаа болон ногоон хувьсгалтай холбоотойгоор манай орны экспортын гол бүтээгдэхүүнүүд болох зэс, алт, коксжих нүүрсний үнэ өсөж байна. Түүний дотор зэсийн ханш хамгийн өндөр өсөлт үзүүлж буй. Нүүрс, төмрийн хүдэр, алтны ханш ч ойрын жилүүдэд байгаагүй хэмжээнд нэмэгдээд байна. Мөн зарим шинжээчид дараагийн супер цикл эхэлсэн гэж үзэж байгаа зэргээс экспортын түүхий эдүүдийн үнэ цаашид ч өндөр төвшинд хадгалагдана гэсэн хүлээлт үүсээд байна. Эдгээр хүчин зүйлүүдэд үндэслэн Монгол банкнаас төлбөрийн тэнцэл 2021 онд 500 орчим сая ам.долларын ашигтай байна гэсэн төсөөлөл гаргажээ.

Гэсэн хэдий ч цар тахлын дотоод тархалттай холбоотойгоор тодорхой бус байдал улам нэмэгдсэнийг тэмдэглэх нь зүйтэй. Өрхийн хэрэглээ сүүлийн хоёр улирал дараалан агшсан, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа хязгаарлагдсан, ажил эрхлэлт, өрхийн орлого хумигдсан зэрэг сөрөг нөлөөллүүд их байна. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв КОВИД-19-ын дотоод тархалтын нөхцөл байдлаас ихээхэн хамаарахаар байна.

### ББСБ САЛБАРЫН СУДАЛГАА

2021 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 17,339 хувь нийлүүлэгчдийн 530 ББСБ, 298 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 3,517 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3,481,431 харилцагч, 610,068 зээлдэгчид хүрч үйлчилж байна.




График 34. ББСБ тоо болон харилцагчдын тоон харьцаа  
Эх сурвалж: СЗХ зах зээлийн мэдээллийн судалгаа

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 58.0 хувиар өсөж 3,481,431-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 43,3 хувиар өсөж 610,068-д хүрлээ. Энэ

УЛСАНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 ☎ 5373271

УЛСАНБААТАР ХОТ  
МОБИКОРПОРЭЦТ ХХК  
9021000000 ☎ 2070372

ӨЛӨГЭЙ ЭНД КО  
ОЛИГО БАНК ХХК  
5100065  
9021031105 ☎ СТО2400



нь 1 ББСБ-ийн харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 4.4 дахин, оны эхнээс 6.4 дахин огцом өссөнтэй холбоотой.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2021 оны I улирлын байдлаар 20 ББСБ үзүүлж байна.

Нийт харилцагчдын 93.1% буюу 3,241,570 нь, зээлдэгчдийн 70.2% буюу 428,002 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 6.9% буюу 239,861, зээлдэгчдийн 29.8% буюу 182,066 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна.

### Зээлийн жигнэсэн дундаж хүү /сар/





График 35. ББСБ салбарын зээлийн дундаж хүү болон банкны зээлийн дундаж хүү  
Эх сурвалж: СЗХ зах зээлийн мэдээллийн судалгаа

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 11.8% буюу 150.2 тэрбум төгрөгөөр өсөж 2021 оны I улирлын байдлаар 1,422.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 112.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1,309.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Тайлант улиралд ББСБ-ууд 483.2 тэрбум төгрөгийн зээлийг 2.9 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 387.2 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2021 оны I улирлын байдлаар 610,068 зээлдэгчийн 1.4 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.



Handwritten signatures and initials in black ink over the stamps.





Нийт хөрөнгө | Нийт зээл




График 36. ББСБ салбарын нийт хөрөнгө болон нийт зээлийн харьцаа  
Эх сурвалж: СЗХ зах зээлийн мэдээллийн судалгаа

2007-2021 оны эхний улирлын хооронд ББСБ-ын нийт хөрөнгө 66.4 тэрбум төгрөгөөс 2,089.1 тэрбум төгрөгт хүрч, 30.4 дахин нэмэгдсэн байна.


2021 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 2.1 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх

оны мөн үетэй харьцуулахад 17.6 хувиар буюу 312.4 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 39.0 хувийг цэвэр зээлийн өсөлт, 36.6 хувийг мөнгөн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Салбарын нийт хөрөнгийн 76.8% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 182 ББСБ, 10.6% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 102 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 12.6 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 246 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт хөрөнгийн дүн (тэрбум төгрөг)	Нийт хөрөнгөөр салбарт эзлэх хувь
5.0 тэрбумаас дээш	67	1216.8	58.2%
2.5-5.0 тэрбум	115	388.5	18.6%
1.9-2.5 тэрбум	102	220.7	10.6%
1.4-1.9 тэрбум	123	199.7	9.6%
0.6-1.4 тэрбум	38	41.3	2.0%
0.6 тэрбум хүртэлх	85	22.2	1.1%
<b>Нийт</b>	<b>530</b>	<b>2089.1</b>	<b>100%</b>

Хүснэгт 17. ББСБ салбарт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын хөрөнгийн хэмжээ  
Эх сурвалж: СЗХ зах зээлийн мэдээллийн судалгаа



**СЗХ**  
 2021 оны 2 дөр  
**БҮРТГЭВ**

УЛААНБААТАР ХОТ  
 УЛСЫН ОРГАНЫ БИРЭГЭЙН  
 2021.01.22

Нийт зээлийн үлдэгдлийн 85.5 хувийг буюу 1,216.3 тэрбум төгрөгийг хэвийн зээл, 4.1 хувийг буюу 59.0 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 10.3 хувийг буюу 146.7 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

### Нийт зээлийн хуваарилалт




График 37. ББСБ-ын салбарын хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хувь  
 Эх сурвалж: СЗХ зах зээлийн мэдээллийн судалгаа

### Эх үүсвэр

#### Эх үүсвэрийн бүтэц



График 38. ББСБ-ын салбарын санхүүжилтийн бүтэц  
 Эх сурвалж: СЗХ зах зээлийн мэдээллийн судалгаа


Салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар өссөн ба энэхүү өсөлтийн 62.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Нийт хөрөнгийн 29.1 хувийг өр төлбөр, 70.9 хувийг эздийн өмч бүрдүүлж байна.

дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 162.7 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2021 оны I улирлын байдлаар 32 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 938 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 70.4 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

2021 оны I улирлын байдлаар 74 ББСБ

Three red official stamps and handwritten signatures are visible at the bottom of the page. The stamps include the logo of 'mobi finance' and '74 УЛААНБААТАР ХОТ МОБИФИНАНС ББСБ ХХК'.



Ашигт ажиллагаа




График 39. ББСБ-ын салбарын нийт орлого, цэвэр ашиг  
Эх сурвалж: СЗХ зах зээлийн мэдээллийн судалгаа

2021 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 109.1 тэрбум төгрөгийн орлого олж, 67.6 тэрбум төгрөгийн зардал гаргаж 41.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 7.2% буюу 7.3 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 12.1% буюу 7.3 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 0.1% буюу 54.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд хүүгийн бус үйл ажиллагааны орлого 26.1% буюу 4.3 тэрбум төгрөгөөр өсжээ. Энэхүү өсөлтийн 43.1% буюу 1.9 тэрбум төгрөгийг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлогын өсөлт, 39.9% буюу 1.7 тэрбум төгрөгийг санхүүгийн үйлчилгээний орлогын өсөлт бүрдүүлж байна. Итгэлцлийн үйлчилгээний орлого 6.3 дахин буюу 2.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

**2.3 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Үнэт цаас гаргагч нь барьцаагүй бичил зээлийн үйлчилгээ болон төлбөрийн системийн шийдлийн талаарх үйлчилгээг үзүүлдэг билээ. Барьцаагүй бичил зээлийг илүү хурдан шуурхай, мөн өөрийн санхүүгийн сахилга батаа нотлон зээл авч болдгийг олон харилцагчдад мэдрүүлж чадсанаар сүүлийн 2 жилийн хугацаанд маш олон идэвхтэй харилцагчтай болсноос гадна, бусад санхүүгийн байгууллагын зээлийн бүрэлдэхүүнд инноваци, технологийн шийдэл шаардлагатай болохыг үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш тасралтгүй харуулсаар байна.

Мобифинанс ББСБ нь Monpra брэндээрээ дамжуулж дараах зорилгыг эрхэм болгон үйл ажиллагаагаа тэлнэ:



**Партнеруудын бизнесийн өсөлтийг дэмжих**



Жижиг дунд бизнес эрхлэгчдийг **Монпэй маркетараа** дамжуулан хэрэглэгчидтэй холбож, өсөлтийг дэмжих

**Шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх**



Амар хялбар, ашиглахад хүртээмжтэй дижитал бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх

**Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх**



Дижитал технологиор хамгийн хүртээмжтэй үйлчилгээг хэрэглэгч, нийгэмд бий болгох

Групп компанийнхаа эрхэм зорилго, үнэт зүйлийг даган, өөрийн экосистем дэх хамгийн итгэлт тунш нь байх болно.


Зураг 26. Мобифинанс ББСБ-ын зорилт

Энэхүү зорилгынхоо хүрээнд дараах гурван гол чиглэлд илүү үнэ цэнэ нэмсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгож ажиллана.



ҮЯЛДАА ХОЛБООТОЙ САЛБААР ДАМЖУУЛАН ЭКОСИСТЕМЭЭ ОРГОЖУУЛАХ

Зураг 27. Экосистемийн хөгжүүлэлт



УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075, 5373271

УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075, 5373271

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛСНИЙ ЭМЛЭГ КОМПАНИЙН ХХК  
6103855  
6021031153, СТС2420

## 2.4 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 2.4.1 ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Мобифинанс ББСБ-ын зээлийн үйлчилгээний хүртээмж жил тутам өсөн нэмэгдсээр байна. Бичил зээлийн үйлчилгээ буюу тэр бүр банкны үйлчилгээ авах боломжгүй эсвэл банкны хэт нүсэр шат дамжлагаас зайлсхийсэн хэрэглэгчдэд уян хатан нөхцөлтэйгөөр зээл тогтмол олгодог бөгөөд цаашид нэмэлт боломжуудыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Мобифинанс ББСБ нь финтекийн салбарын зах зээлд тэргүүлэх байр суурь эзлэх, байр сууриа тэлэх, зээлийн багцын хэмжээг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд илүү сонирхолтой худалдан авалтын шийдлүүдийг санал болгож, үнэнч хэрэглэгчдийн хэрэглээг дэмжих зорилготойгоор ирэх жилүүдэд зээлийн үйл ажиллагаатай холбоотой дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:


- Кредит скоринг буюу хэрэглэгчийн зээлжих шалгуурыг уян хатан, хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцэхүйц төвшинд хүргэх;
- Жижиг дунд бизнес эрхлэгчдэд бизнесийн эргэлтийн хөрөнгийг сайжруулах зорилгоор шаардлагад нийцсэн зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх;
- Олон төрлийн сонголттой буюу шууд зээл авах, эсвэл ямарваа нэгэн бүтээгдэхүүн үйлчилгээ авах үедээ зөвхөн тухайн бүтээгдэхүүний төлбөрийг зээлээр төлөх, тухайн 2 үйлчилгээг хослуулсан өөрийн зээлийн шугамыг бүрдүүлэх;

Зээлийн дэлгэрэнгүй	2020	2021	2022F	2023F
Нийт харилцагчийн тоо /мян.хүн/	102	141	192	259
Зээл олголтын тоо /мян.төг/	213.4	282.8	469.8	586.6
Олгосон зээлийн хэмжээ /сая.төг/	48.343	79.627	135.702	169.294
Зээлийн багц /сая.төг/	4.861	9.708	15.039	19.634

Хүснэгт 18. Зээлийн дэлгэрэнгүй мэдээлэл  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

- Харилцагчийн тоо:** Мобифинанс ББСБ-ийн зээлийн харилцагчийн тоо 2021 оны II улирлын байдлаар 17 хувиар өсч 119,8 мянгад хүрлээ. Энэхүү үзүүлэлт цаашид нэмэгдэн 2021-2023 оны хооронд жилд дунджаар 35%-ийн өсөлт үзүүлж 259 мянгад хүрэх төсөөлөлтэй байна.
- Зээл олголтын тоо, хэмжээ:** 2020 онд зээл олголтын тоо 213 мянга, зээлийн хэмжээ 48.3 тэрбум төгрөгт хүрсэн ба цаашид жилд дунджаар 41% өсөлттэй байхаар тооцоолж байна.
- Зээлийн багц:** 2020 оны зээлийн багцын хэмжээ 4.8 тэрбум төгрөг, 2021 оны II улирлын байдлаар 6.2 тэрбум төгрөгт хүрлээ. Санхүүгийн таамаглалд дурдсанаар зээлийн багц ирэх жилүүдэд 43%-иар өсөх тооцоо байна.





## 2.4.2 МАРКЕТПЛЕЙС БУЮУ ОНЛАЙН ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

Онлайн худалдааны платформын боломжуудыг нэмэгдүүлэх, хэрэглэгчид нэг платформоос бүх үйлчилгээг авах, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх төлөвлөгөөний хүрээнд:

- Бүх төрлийн биет болон биет бус бүтээгдэхүүн үйлчилгээг платформд нэгтгэх
- Хэрэглэгч сонголтоо хийхээс эхлэн төлбөр төлж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ гар дээрээ хүлээн авах хүртэлх бүрэн шат дамжлагыг цогцоор бүрдүүлэх
- Зах зээлд илүү эрэлттэй байгаа үйлчилгээ, жишээлбэл цахим спорт, гар утасны тоглоомуудын цэнэглэлт хийх боломжуудыг олон сонголттой болгох, нэмэлтээр олон төрлийн цахим спортуудын төлбөр төлөх, цэнэглэх сонголтуудыг нэмэх
- Хэрэглэгч, мерчантуудыг холбосон дундын экосистемийг бүрдүүлэх



Дээрх үйлчилгээнүүдийг өмнө нь олон үйлдэлтэй байсан санхүүгийн үйлчилгээнүүдийг хэдхэн хоромд авах, гүйцэтгэх боломж олгосон нь тун дэвшилтэт шийдлүүд юм.

## 2.4.3 ЦАХИМ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭГ ТЭЛЭХ, ХЭРЭГЛЭГЧДИЙГ СУРГАХ ЧИГЛЭЛ

Мобифинанс нь хэрэглэгчдээ цахим үйлчилгээнд сургах, санхүүгийн боловсролыг нь сайжруулах, цахим гэмт хэрэг болон бусад эрсдэлээс хамгаалах, мөн хэрэглэгч нарынхаа хүсэл сонирхолд тулгуурлан, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, урамшуулалт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, Monpay аппликейшндаа шинэ функц нэмэх гэх мэт үйл ажиллагааг тасралтгүй явуулснаар экосистемээ улам өргөжүүлж, хөгжүүлэхээр төлөвлөж байна.

Monpay хэрэглэгчдээ сургах зорилгоор хэрхэн урамшуулал авах, шинэ үйлчилгээг хэрхэн ашиглах талаар цуврал мэдээлэл, зураг, алхам бүрээр нь нарийвчлан харуулсан видео контентыг сошиал сувгуудаараа дамжуулан хүргэдэг.

**МОНПЭЙ АППЛИКЕЙШН АШИГЛАН ТӨЛБӨР ТӨЛӨХ**

**Алхам 1**  
МИИ ИАГП-г хэсгүүрү шалгах

**Алхам 2**  
Замын хураажих хэсгийг сонгоно

**Алхам 3**  
Тээврийн хэрэгслийн улсын дугаараа бүртгүүлнэ

**Алхам 4**  
Гүйлгээний кодыг оруулна

**УЛААНБААТАР ХОТ**

**mobifinance**

УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 ф. 5373271

Зураг 28. Monpay аппликейшнээр төлбөр төлөх загвар

78

**УЛААНБААТАР ХОТ**

**ӨЛСНИЙ ЭНД КО**  
**КАПИТАЛ ЦАХ**

УЛААНБААТАР ХОТ  
ИИХИЙН ХОМ КОРПОРАЦИ ХХК  
6021101075 ф. 2070572

5103055  
УЛ. 9021031101 ГТЦ2420

Түүнчлэн хэрэглэгчдийнхээ цахим санхүүгийн аюулгүй байдалд үргэлж онцгой анхаарал хандуулдаг бөгөөд зөвлөгөө бүхий контентуудыг бэлтгэн хүргэсээр байна. Цаашид сошиал нөлөөлөгчдөөр дамжуулан, хэрэглэгчдийн санхүүгийн боловсролд чиглэсэн контентуудыг сонирхолтой концепц бүхий агуулгатайгаар хүргэхээр төлөвлөж байна.



Зураг 29. Хэрэглэгчийн хувийн мэдээллийн хамгаалалт

QR код бол төлбөрийн системийн хамгийн орчин үеийн шийдлийн нэг. Тиймээс ч Monpay хэрэглэгчид хамтрагчиддаа хамгийн Хялбар байхаар өөрсдийн системийн хөгжүүлэлтийг цаг алдалгүй хамгийн хурдан шуурхай хийсээр ирсэн. Цаашдаа мөн бүх банк болон төлбөрийн системийн QR кодыг хамгийн хурдан хугацаанд, ямарч саадгүй уншиж таньдаг болохоор ажиллаж байна. Үндэсний төлбөрийн шийдэл Monpay нь бүх төрлийн QR код уншдаг болсноор хэрэглэгчдэд сэтгэл ханамжтай үйлчилгээ авах боломжийг илүү бүрдүүлэх болно. Үүний нэгэн жишээ болгон төрийн үйлчилгээний ТҮЦ машины төлбөрийг Monpay апп-р дамжуулан зөвхөн QR код уншуулснаар 2-3 сек-н хугацаанд төлөх боломжтой болсон. Мөн автозамын хураамжаа машиныхаа улсын дугаарыг бүртгүүлснээр замын цэгүүдэд зогсох шаардлагагүйгээр автоматаар төлдөг болсон гэх мэт орчин үеийн технологийн шийдлүүдийг нэвтрүүлсэн бөгөөд төрийн байгууллагын нэгдсэн системтэй холбогдох, татварын систем, НӨАТ-н буцаан олголтыг Monpay-р авах гэх мэт томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



СЗХ  
2021 оогд 22 өдөр  
БҮРТГЭЭ-03

МОНГОЛЫН ХАМГИЙН ХЯЛБАР АР  
2021-08-31  
БҮРТГЭЭ-03



Зураг 30. ТҮЦ машины төлбөр төлөх үйлчилгээ

Monpay хэрэглэгчээс авсан судалгаанд үндэслэн, ирээдүйд аль болох удаан хугацаанд оршин тогтнох, мөн хамгийн сүүлийн үеийн тренд болж буй бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхийг зорьдог. Тухайлбал, хүүхэд залуучуудын дунд гар утасны тоглоом, видео тоглоомын соёл эрчимтэй тархаж, энэ төрлийн зах зээл маш хурдацтай өсөж хөгжиж байна. Мобифинанс ББСБ нь энэ трендээс хоцролгүй, Зүүн өмнөд Азид №1-т бичигддэг, тоглоом цэнэглэлтийн Coda pay компанитай хамтран, залуу хэрэглэгчдэдээ үйлчилгээгээ үзүүлж эхлээд байна. Энэхүү зах зээл нь жилээс жилд дэлхий дахинд маш хурдацтай хөгжиж байгаа тул цаашид ч ижил төрлийн компаниудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Хэрэглэгчийн нууцлал, төлбөр төлөлт болон мөнгөн шилжүүлгийн аюулгүй байдал нь дэлхийн бүх финтек компаниудын хамгийн гол цөм нь байдаг. Ийм учраас мэдээллийн болон технологийн өндөр нууцлалтайгаар төлбөр мөнгө шилжүүлгийг олон улсын стандартад бүрэн нийцсэн өөрсдийн Tier III түвшний дата төвөөр дамжуулан хийдэг нь хэрэглэгч үйлчлүүлэгч болон хамтрагч нарт хамгийн найдвартай, аюулгүй гэсэн итгэлцэл төрүүлдэг бөгөөд, мөн адил өөрсдийн аюулгүй найдвартай байдалдаа бүрэн итгэлтэй байдаг.





Хялбар байдал: Ямарваа нэгэн үйлчилгээ, бүтээгдэхүүний төлбөрийг зөвхөн QR код уншуулан хамгийн хялбараар төлөх, бүх төрлийн QR кодуудыг унших, үйлчлүүлэгчид цаг хугацааны

mobifinance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 5373271

80  
УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛЫН КОРПОРАЦН ХХК  
6001050032 7972073

ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЦК  
ХХК  
6183855  
572-031185 СТС2420





алдагдалгүй, сэтгэл ханамжтай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх



**Аюулгүй байдал:** Зөвхөн хэрэглэгч өөрийн төхөөрөмжөөс өөрийн үүсгэсэн нууц үгийг ашиглан, мэдээллийн нууцлалтайгаар төлбөр шилжүүлэх, үйлчилгээ, бүтээгдэхүүний төлбөрийг төлөх, ОУ-н стандартыг хангасан Tier III төвшний дата төвүүдийг ашиглан мэдээллийг хадгалах



**Хурдтай байх:** Банк хооронд, хэрэглэгч хооронд Монгол банкны АСН системийн тусламжтайгаар хугацааны хоцрогдолгүй шууд шилжүүлэх, нэг зэрэг олон төлбөр төлөх



**Хэрэглэгчдийг сургах:** Өргөн хүртээмжтэйгээр хэрэглээнд нэвтрүүлэхийн тулд цахим төлбөрийн хэрэгслийн талаарх хэрэглэгчийн мэдлэг боловсролыг сайжруулах шаардлагатай бөгөөд үүний хүрээнд хэрэглэгчдэд чиглэсэн зурган болон дүрст контентыг өөрсдийн сувгаар тогтмол сурталчлах, сургалтыг тодорхой давтамжтайгаар зохион байгуулах, онлайн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулна.

### 2.4.4 САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Компанийн хөрөнгө 2020 оны эцэс 13.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны үзүүлэлтээс 20.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Дараагийн 4 жилд нийт хөрөнгийн хэмжээ дунджаар 24.0 хувиар өсч 2024 онд 31.7 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Нийт хөрөнгөнд эзлэх харилцагчдад олгосон зээл болон цахим мөнгөний хэрэглэгчдийн дансны үлдэгдэл дунджаар 83.0 хувьтай байх бөгөөд тус үзүүлэлтийн төвшин жил бүр өсч 2024 онд нийт хөрөнгийн 88.0 хувьтай тэнцэж 27.9 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөл байна. Компанийн уг үзүүлэлтээс харахад дараагийн 4 жилд зээлийн үйлчилгээгээр дэмжин, цахим мөнгөний хэрэглээг нэмэгдүүлэхийг чиглэн ажиллаж байна.

ХӨРӨНГӨ /мян.төг/	2020	2021Т	2022Т	2023Т	2024Т
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,881,305	4,443,639	6,001,328	5,353,664	7,576,504
Банкуудад байршуулсан хөрөнгө	6,108,886	4,482,714	4,482,714	4,482,714	4,482,714
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,221,498	10,495,362	11,884,435	15,099,889	19,155,673
Бусад санхүүгийн хөрөнгө	122,378	241,350	241,350	241,350	241,350
Бусад хөрөнгө	24,101	6,668	30,168	30,168	30,168
Хойшлогдсон татварын хөрөнгө	3,944	6,081	6,081	6,081	6,081
Биет бус хөрөнгө	60,272	31,881	12,024	9,166	6,307
Үндсэн хөрөнгө	16,036	22,697	5,014	4,663	4,312
Ашиглах эрхтэй хөрөнгө	118,237	1,161,463	889,872	722,860	555,849
Нийт хөрөнгө	13,556,657	20,891,854	23,552,985	25,950,554	32,058,958

2021 оны 09 22 өдөр

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

ӨР ТӨЛБӨР	2020	2021Т	2022Т	2023Т	2024Т
Хэрэглэгчийн барьцаа	5,653,022	6,773,861	7,757,923	8,409,967	8,823,678
Дансны болон бусад өглөг	223,701	621,463	778,643	778,643	778,643
Бондын өглөг		4,000,000	4,000,000	3,000,000	4,000,000
Урьдчилж орсон орлого	7,400	0	1,040	1,040	1,040
Түрээсийн өр төлбөр	128,753	1,241,362	1,211,735	1,211,735	1,211,735
Орлогын албан татварын өглөг	13,370	163,333	163,333	151,667	210,000
Нийт өр төлбөр	6,026,246	12,800,019	13,912,674	13,553,052	15,025,096
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2020	2021Т	2022Т	2023Т	2024Т
Хувьцаат капитал	5,019,860	5,019,860	5,019,860	5,019,860	5,019,860
Хуримтлагдсан ашиг	2,510,551	3,071,975	4,620,451	7,377,642	12,014,002
Нийт эздийн өмч	7,530,411	8,091,835	9,640,311	12,397,502	17,033,862
Нийт өр төлбөр болон эздийн өмч	13,556,657	20,891,854	23,552,985	25,950,554	32,058,958

Хүснэгт 19. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл (мянган төгрөг)  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ


Компани нь ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажилладаг бөгөөд санхүүгийн мөнгөн урсгалаа тогтмол төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавих болон санхүүгийн байгууллагад зээлийн эрх нээлгэх замаар хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлэн ажилладаг.



#### Орлогын тайлангийн төсөөлөл

/мян.төг/	2020	2021Т	2022Т	2023Т	2024Т
Хүүгийн орлого	2,225,200	2,671,713	4,248,347	4,614,401	5,523,945
Хүүгийн зардал	(20,655)	(163,333)	(723,333)	(548,333)	(478,333)
Хүүгийн цэвэр орлого	2,204,545	2,508,379	3,525,014	4,066,068	5,045,612
Зээлийн алдагдлын сангийн зардал	(258,085)	(154,709)	(384,665)	(406,923)	(430,148)
Зээлийн алдагдлын дараах хүүгийн цэвэр орлого	1,946,460	2,353,671	3,140,349	3,659,145	4,615,463
Хураамж, шимтгэлийн орлого	1,707,803	2,455,928	3,277,448	4,315,566	5,727,089
Хураамж, шимтгэлийн зардал	(318,800)	(662,290)	(835,336)	(963,473)	(1,145,863)
Бусад үйл ажиллагааны орлого	23,164	7,902	19,061	19,061	19,061
Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал	(1,948,345)	(3,436,720)	(3,835,344)	(3,966,754)	(4,064,239)
Татварын өмнөх ашиг	1,410,282	718,491	1,766,177	3,063,545	5,151,511
Орлогын албан татварын зардал	(157,657)	(118,922)	(194,559)	(306,355)	(515,151)
Тайлант жилийн ашиг	1,252,625	599,569	1,571,618	2,757,191	4,636,360

Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл (мянган төгрөг)  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

Компанийн нийт хүүгийн орлого 2020 онд 3.9 тэрбум төгрөг хүрч өмнөх оны үзүүлэлтээс 1 хувийн өсөлт гаргаж чадсан байна. Дэлхий нийтээр тархаж буй Covid-19 цар тахлын үед үйл ажиллагаагаа тогтвортой явуулж ажлын байраа





хадгалан үлдэж орлогоо бууруулахгүй ажиллаж чадсан билээ. Дараагийн 4 жилд зээлийн хүүгийн орлогоо тогтмол өсгөж жилийн дундаж өсөлт 30 хувьд хүргэж 2024 гэхэд 5.5 тэрбумын зээлийн хүүгийн орлогыг олохоор төсөөлж байна. Цахим мөнгөний үйлчилгээний хэрэглээг бий болгож хэрэглэгчдэдээ олон олон шинэ бүтээгдэхүүнийг санал болгож үйлчилгээний шимтгэлийн орлого 5.7 тэрбумд хүргэхээр ажиллаж байна.

## СВОТ ШИЖИЛГЭЭ

- Давуу тал  
Орчин үеийн технологийн шийдэлд тулгуурлан үйлчилгээгээ явуулж буй цөөн ББСБ-н нэг бөгөөд хүн бүрийн хэрэглээнд нийцсэн гар утсанд суурилсан санхүүгийн бүхий л үйлчилгээг үзүүлж өндөр эрэлттэй зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгож байна.
- Сул тал  
Банкууд финтект суурилсан үйлчилгээг өргөн хүрээнд нэвтрүүлж, хөгжүүлэхэд өрсөлдөөн хүчтэй нэмэгдэнэ.
- Боломж  
Цаашлаад илүү хөгжиж, инновацийн шийдэлд нийцэж тэлэх асар их боломжтой.
- Эрсдэл  
Банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд бизнесийн үндсэн эрсдэл нь зээлийн эрсдэл байдаг. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь эсвэл хэсэгчлэн биелүүлэхгүй байх, зээлийн үндсэн төлбөр, хүү, алданги болон холбогдох бусад зардлыг тогтоосон хугацаанд төлөхгүй байх тохиолдолд зээлийн эрсдэл үүсдэг.

## 2.5 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

### Салбарын эрсдэл

ББСБ-ын эрсдэл, тогтворгүй байдлыг чанаргүй зээлийн харьцаа ба Z индекс гэсэн хоёр аргаар голчлон тооцдог.

ББСБ нь олгосон зээлийг хугацаа, чанар, эргэж төлөгдөх магадлалыг нь харгалзан ангилах замаар зээлийн эрсдэлийн санг тооцож байгуулдаг. Санхүүгийн зохицуулах хорооноос зээлийн эрсдэлийн санг байгуулах хувь хэмжээг зээлийн ангилал тус бүр дээр тогтоож өгсөн байдаг. Тухайн ББСБ байгуулбал зохих эрсдэлийн сангаа байгуулсан эсэхээс нь хамааран ББСБ чанаргүй зээлээ нөхөх, эрсдэлээс хамгаалах чадвартай эсэхийг нь тодорхойлдог.

2021 оны I улиралд уг харьцаа 102.2 хувь гарч байгуулбал зохих эрсдэлийн санг бүрдүүлж чадсан бөгөөд эрсдэлийг 102.2 хувиар нөхөх чадамжтайг харуулжээ.

Handwritten signatures and red stamps. One stamp says "mobi finance" and another "ОЛЗНИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮНД". There is also a stamp with "83" and another with "5182855" and "9921031195".

Банк бус санхүүгийн байгууллагууд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцдог харьцаа болох зардал, орлогын харьцаа тайлант улиралд 45.4 хувь гарсан буюу өмнөх оны мөн үеэс 1.0 нэгжээр өсжээ. Өөрөөр хэлбэл банк бус санхүүгийн байгууллагууд 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 45.4 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм.



График 40. ББСБ салбарын Z индекс  
Эх сурвалж: СЗХ ББСБ салбарын тойм

Z индекс нь банк бус санхүүгийн байгууллагын дампуурах магадлалыг харуулдаг ба активын өгөөж болон өөрийн хөрөнгийн харьцааны нийлбэрийг активын өгөөжийн хэлбэлзэлд харьцуулж тооцдог. Z индексийн утга ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хөшүүрэг өндөр байх үед их гарах ба өгөөжийн хэлбэлзэл ихтэй үед буюу орлогын тодорхойгүй байдал

их үед бага гарна. Өөрөөр хэлбэл индексийн их утга нь эрсдэл багатай, тогтвортой байдлыг илэрхийлдэг. 2021 оны I дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын Z индекс өмнөх оны мөн үеэс 1.7 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

### Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэл


Цахим халдлага болон дайралт нь ББСБ-уудын мэдээллийн бааз, сүлжээнд тохиолдож болзошгүй томоохон эрсдэлүүдийн нэг юм. Үүний үр дүнд ББСБ-уудын болон харилцагчийн мэдээлэл алдагдах, устах, солигдох, сүлжээ болон программ хангамжид алдаа гарах, цахилгаан тасрах зэрэг эрсдэлүүд бий болдог. Энэхүү эрсдэлийг ББСБ-ууд байнгын хяналтад авч ажиллаж байна.

### Дотоод эрсдэлийн удирдлага

Мобифинанс ББСБ нь эрсдэлийн удирдлагын дараах бодлогыг боловсруулж, эдгээрийг жил бүр шинэчлэн хэрэгжүүлж байна.

- Хэрэгжилт хариуцсан ажилтан эрсдэлийн илрүүлэг, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө бүхий эрсдэлийн үнэлгээг хийнэ.
- Эрсдэлийн үнэлгээний загварыг удирдлага болгон жилд нэг удаа хийх бөгөөд тухайн үнэлгээгээр хийгдсэн эрсдэлийг бууруулах ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг дараа жилийн үнэлгээг хийх үед дүгнэнэ.
- Эрсдэлийн үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлсийн дагуу үнэлнэ. Үүнд:
  - Харилцагчаас хамаарах эрсдэлийн хүчин зүйлс
    - Харилцагч өөрийн биеэр ирэлгүй, зайнаас харилцаа үүсгэсэн;






- Харилцагч нь гадаадын иргэн;
- Харилцагч нь хуулийн этгээд эсхүл хэн нэгнийг төлөөлсөн тохиолдолд;
- Хууль хяналтын байгууллагаас эцсийн өмчлөгчтэй холбоотой мэдэгдэл ирсэн, тухайн эрх бүхий байгууллагад бүртгэлтэй харилцагч;
- Газар зүйн эрсдэлийн хүчин зүйлс
  - МУТСТ тогтолцооны төвшин сул улс орнууд /Монгол хамаарахгүй/;
  - Санхүүгийн болон бусад хориг эсхүл ижил төрлийн арга хэмжээнд хамрагдсан, авилга хээл, хахууль, гэмт хэргийн үзүүлэлт өндөр улс орнууд;
  - Терроризм, террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхэд, дэмжихэд тохиромжтой гэж үзсэн улс орон, бүс нутаг;
  - Бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлс
  - Зайнаас үйлчилгээ үзүүлдэг эсэх (Тухайлбал аппликейшн ашигладаг эсэх)
  - Бусад нэмэлт хүчин зүйлс
- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх саналыг Бүтээгдэхүүн Удирдлагын Хороонд танилцуулах үедээ тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлийн үнэлгээг дараах үнэлгээний хуудаст заасны дагуу хийж танилцуулна.
- Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, түүний үр дүнд Гүйцэтгэх захирал хяналт тавьж ажиллана.

**Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдлийн үнэлгээний хуудас**

№	Хүчин зүйлс	Үнэлгээ	Жин	Үнэлгээ	
1	Харилцагчийн эрсдэл	1	20%	1	Low
	Иргэншил	1	10%		
	Өндөр эрсдэлтэй хэрэглэгч	1	30%		
	Улс төрд нөлөө бүхий этгээд	1	60%		
2	Бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл	1	20%	1	Low
	Зээлийн үйлчилгээний эрсдэл	1	50%		
	Цахим мөнгөний үйлчилгээний эрсдэл	1	50%		
3	Гүйлгээний эрсдэл	1	40%	1	Low
	Нэг удаагийн зарлагын гүйлгээний хэмжээ 20 саяаас их	1	20%		
	Нэг удаагийн орлогын гүйлгээний хэмжээ 20 саяаас их	1	40%		
	Нэг өдөрт 5-с дээш удаагийн давматжаар гүйлгээ хийх	1	20%		
	Нэг сарын дотор 500,000-с дээш дүнгээр 10-с дээш удаа гүйлгээ хийх	1	20%		
4	Газарзүйн эрсдэл	1	20%	1	Low
	Иран	1	25%		
	Хойд солонгос	1	25%		
	Саудын Араб	1	25%		



inob.com

Улаанбаатар хотын захиралын газар 85

ГЭХ  
2021-09-22 өдөр  
Орос  
БҮРТГЭВ

1 25%

БОНГАЛЫН ГЭМЭГ  
КОМПАНИЙН ЭГЭЭГТ  
2021-08-31  
БҮРТГЭВ

1 бол бага, 2 бол дунд, 3 бол их эрсдэлтэй

№	Хүчин зүйлс	Үнэлгээ	Жин	Нийт оноо	Эрсдлийн түвшин
1	Харилцагчийн эрсдэл	1	20%	1	Low
2	Бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл	1	20%		
3	Гүйлгээний эрсдэл	1	40%		
4	Газарзүйн эрсдэл	1	20%		

Хүснэгт 21. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлийн үнэлгээний хуудас

**ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ**

1. Эрсдлийн үнэлгээг дараах загварыг удирдлага болгон хийнэ

№	1. Defined risks (Тодорхойлогдсон эрсдэл)			2. Risk evaluation (Эрсдлийн үнэлгээ)				3. Score (Оноо)		4. Rating (Эрсдлийн түвшин)			5. Mitigation action (Эрсдлийг бууруулах ажлын төлөвлөгөө)
	Inherent Risk (Тодорхойлсон эрсдэл)	Risk control (Эсдлийн хяналт)	Residual Risk (Үлдэгдэл эрсдэл)	Likelihood of risk (Эрсдлийн давтамж)	Давтамжийн үнэлгээ	Consequence (Үр нөлөө)	Үр нөлөөний үнэлгээ	Давтамж	Үр нөлөө	Risk rating	Risk level	Responsibility of risk	
<b>1 Харилцагчийн эрсдэл</b>													
1.1					Rare		Negligible	1	1	1	LOW	Manager	
1.2													
1.3													
<b>2 Бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл</b>													
2.1					Rare		Negligible	1	1	1	LOW	Manager	
2.2													
<b>3 Цахим сувгийн эрсдэл</b>													
3.1					Rare		Negligible	1	1	1	LOW	Manager	
3.2													
<b>4 Газарзүйн эрсдэл</b>													
4.1					Rare		Negligible	1	1	1	LOW	Manager	
4.2					Rare		Negligible	1	1	1	LOW	Manager	
<b>5 Зохицуулах байгууллагын эрсдэл гэх мэт</b>													
5.1					Rare		Negligible	1	1	1	LOW	Manager	

Хүснэгт 22. Эрсдэлийн үнэлгээ хийх загвар

Эх сурвалж: Мобифинанс ББСБ

**mobi**  
финанс  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 ᠙. 5373271

**mobicom**  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ ИНТЕРНАЦИОНАЛ ХХК  
86 9021101075 ᠙. 2701072

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД КО  
МПАНИЙН ЭГЭЭГТ  
5183855  
9021001105 ᠙. СГЦ2420

2. Эрсдэл тохиолдох магадлалыг дараах хүснэгтийн дагуу үнэлнэ

Оноо	Үнэлгээ		Тайлбар	
	Монгол	English	Financial	Non-financial
1	Маш бага	Negligible	Санхүүгийн алдагдал байхгүй	- Negligible impact on customer churn - Negligible impact, brief loss of service
2	Бага	Minor	Санхүүгийн алдагдал 3% болон түүнээс бага	- Customer churn up 3% to percent - Local only services down of less than control time - Local media attention quickly remedied - Reportable incident to regulator, no follow up
3	Дунд	Moderate	Санхүүгийн алдагдал 5% буюу түүнээс их	- Report to regulator requiring major project for corrective action - Customer churn 3% to 5% percent - Any of critical [any of voice, data, vas] services down exceeded control time
4	Их	Major	Санхүүгийн алдагдал 10% буюу түүнээс их	- Customer churn 5% to 10% percent - Any of critical [any of voice, data, vas] services down more than 30 minutes - National short-term negative media coverage; significant loss of market share
5	Маш их	Catastrophic	Санхүүгийн алдагдал 10%-с их	Customer monthly churn rate 10% percent or more Critical services down more than 30 minutes National long-term negative media coverage; game-changing loss of market share

Хүснэгт 23. Эрсдэл тохиолдох магадлалыг үнэлэх  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

3. Эрсдлийн үр нөлөөг дараах хүснэгтийн дагуу үнэлнэ


Давтамжийн оноо	Үнэлгээ		Магадлал үнэлэх шалгуур (History based)
	Монгол	English	
1	Маш бага	Rare	Сүүлийн 3 жилд тохиогоогүй (Онцгой тохиолдолд түүнээс олон жилийн өмнөх тохиолдлыг тооцож болно) Эсвэл одоогоор тохиолдсон түүх байхгүй
2	Бага	Unlikely	Сүүлийн 3 жилд 2 хүртэл удаа тохиолдсон. Тохиолдоно гэсэн хүлээлтгүй байсан боловч тохиолдсон
3	Тохиолдолд болзошгүй	Possible	Сүүлийн 3 жилд 2-с олон удаа тохиолдсон
4	Тохиолдоно	Likely	Сүүлийн 1 жилд 2 хүртэл удаа тохиолдсон
5	Байнга тохиолдоно	Almost certain	Сүүлийн 1 жилд 2-с олон удаа тохиолдсон



ХХК  
2021.08.22 өдөр  
БҮГДЭВ  
№: 11

2021-08-31  
БҮГДЭВ


### 3. Эрсдлийн үнэлгээний матриц



Схем 5. Эрсдэлийн үнэлгээний матриц  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

### Систем бүтэц, аюулгүй, найдвартай ажиллагаа

Цахим мөнгөний систем нь өөрсдийн үүрэг бүхий олон дэд системийн бүрдэл бөгөөд шаталсан байдлаар загварчлагдсан систем юм. Цахим гүйлгээг шаталсан бүтцийн хамгийн хамгаалалт өндөртэй хэсэгт боловсруулдаг. Сүлжээ болон системийн шат давхарга бүрд тохирсон хамгаалалтын системүүд ажилладаг. Эдгээр системийн бүрэлдэхүүнд багтаж байгаа системүүд сүлжээ, тоног төхөөрөмж болон газарзүйн төвшинд нөөц холболтыг хангаж байхаар зохион байгуулагдсан. Түүнчлэн дэд систем бүрд хамгаалалтын системүүдийг хэрэгжүүлсэн тул системийн аль нэг хэсэгт гарсан доголдол бусад хэсгүүдэд нөлөөлдөггүй.




Схем 6. Системийн бүтэц  
Эх сурвалж: Мобифинанс ББСБ

**mobi finance**  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 д. 5373271

МобиКом  
УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛЫН КОРПОРАЦИ ХХК  
88

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЙС  
ХХК  
602 011195 д. 0702420





	Дэд системийн нэр	Тайлбар
1	Emoney API	Бизнесийн логик хариуцсан дэд систем
2	Transaction API	Гүйлгээний логик хариуцсан дэд систем
3	Account management system	Хэрэглэгчийн удирдагын систем
4	Monpay Online Shop	Онлайн дэлгүүрийн дэд систем
5	Customer SMS App	Хэрэглэгчид зориулсан мессеж мэдэгдлийн аппликейшн
6	Partner SMS App	Байгууллагын зориулсан мессеж мэдэгдлийн аппликейшн
7	Emoney OPEN API	Гуравдагч байгууллагын систем интеграци
8	Report Module	Тайлан боловсруулах хэсэг
9	Branch Web	Цахим мөнгөөр гүйлгээ хийх веб интерфэйс
10	Partner Merchant Web	ЦМХА – д данс удирдах тайлан татах зориулалт бүхий интерфэйс
11.	Messenger	Монпра ухаалаг аппликейшн хэрэглэгчид текстээр хоорондоо харилцах зориулалт бүхий мессенжер аппликейшн
12	Billing hub	Байгууллагын биллийг цуглуулах зориулалт бүхий дэд систем
13	Developer web	Гуравдагч байгууллага систем интеграци, техникийн холболт хийх заавар бүхий вэб

Хүснэгт 25. Системийн нэршил



16)



CSX  
2021.08.22 өдөр  
БҮРТГЭВ  
85001

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2021-08-31  
БҮРТГЭВ-03

# III. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

  
mobi  
finance  
*Signature*  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 дт. 5373271

  
mobicom  
*Signature*  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК  
9021090652 дт. 2072672

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗИЙ ЭНД КО  
КАПИТАЛ УЦК  
ХХК  
*Signature*  
5183855  
9021031195 дт. СТС2420

### 3.1 ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА


Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 41, 42, 43 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5, 6, 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн доорх нөхцөлтэй өрийн бичгийг хөрөнгө оруулагчдад санал болгож байна.

### Монрау бонд

Нэр	Нөхцөл
Үнэт цаас гаргагч:	"Мобифинанс ББСБ" ХХК
Үнэт цаасны төрөл:	Компанийн урамшуулалтай бонд
Бондын арилжаа:	Нээлттэй хүрээнд
Санал болгож буй бондын тоо ширхэг:	10,000 ширхэг
Нэгж бондын нэрлэсэн үнэ:	100,000 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн:	1,000,000,000 төгрөг
Бондын хугацаа:	12 сар /365 хоног/
Бондын хүүгийн төвшин:	14 хувь /жилийн/
Бондын эргэн төлөлт хийгдэх:	Бондын хоёрдогч зах зээл нээгдсэн өдрөөс хойш нэг жилийн дараа буюу 2022 оны мөн сарын мөн өдөр (амралтын өдөр бол дараагийн ажлын өдөр)
Хүү төлөх хугацаа:	Хугацааны эцэст
Бондын баталгаа:	"Мобиком Корпораци"-ийн 100% төлбөрийн баталгаа
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт:	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт
Анхдагч зах зээлийн арилжаа	Монрау аппликейшнээр дамжуулан оролцох

### 3.2 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

"МобиФинанс ББСБ" нь нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,000 ширхэг, нийт 1,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй бондыг олон нийтэд санал болгож байна. Бондоор татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үндсэн үйл ажиллагаа болох барьцаагүй бичил зээлийн үйлчилгээг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



2021.09.22


УЛААНБААТАР ХОТ  
 МОНГОЛ УЛААНБААТАР ХОТ  
 2021.09.22

Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ: 1,000,000,000 (Нэг тэрбум)төгрөг.

Мобифинанс ББСБ-ийн зээлийн үйлчилгээний хүртээмж жил тутам өсөн нэмэгдсээр байна. Бичил зээлийн үйлчилгээ буюу тэр бүр банкны үйлчилгээ авах боломжгүй эсвэл банкны хэт нүсэр шат дамжлагаас зайлсхийсэн хэрэглэгчдэд уян хатан нөхцөлтэйгөөр зээл тогтмол олгодог бөгөөд цаашид нэмэлт боломжуудыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Мобифинанс ББСБ финтекийн салбарын зах зээлд тэргүүлэх байр суурь эзлэх, байр сууриа тэлэх, зээлийн багцын хэмжээг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд илүү сонирхолтой худалдан авалтын шийдлүүдийг санал болгож, үнэнч хэрэглэгчдийн хэрэглээг дэмжих зорилготойгоор ирэх жилүүдэд зээлийн үйл ажиллагаатай холбоотой дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд: Мобифинанс ББСБ ХХК нь нэг бүр нь 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 ширхэг, нийт 1,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй үнэт цаасны зах зээлд санал болгож байна. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг компанийн үндсэн бүтээгдэхүүн болох богино хугацаат зээлийн эх үүсвэрт зарцуулна. Үүнд:

- Кредит скоринг буюу хэрэглэгчийн зээлжих шалгуурыг уян хатан, хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцэхүйц төвшинд хүргэх
- Жижиг дунд бизнес эрхлэгчдэд бизнесийн эргэлтийн хөрөнгийг сайжруулах зорилгоор шаардлагад нийцсэн зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх
- Олон төрлийн сонголттой буюу шууд зээл авах, эсвэл ямарваа нэгэн бүтээгдэхүүн үйлчилгээ авах үедээ зөвхөн тухайн бүтээгдэхүүний төлбөрийг зээлээр төлөх, тухайн 2 үйлчилгээг хослуулсан өөрийн зээлийн шугамыг бүрдүүлэх
- Хэрэглэгчдэдээ санхүүгийн хэрэгсэл ашиглах боломжийг олгох

Зээл олголтын тоо



Компаний зээл олголтын тоо 2024 он гэхэд жилийн дундаж өсөлт 2020 онтой харьцуулбал 25 хувь байхаар байна.


График 41. Зээл олголтын тоо  
 Эх сурвалж: Мобифинанс ББСБ

MNT (МЯНГАН ТӨГРӨГ)	2020	2021F	2022F	2023F	2024F
ЗЭЭЛИЙН БАГЦ	4,861,600	10,843,520	12,495,540	15,984,376	20,307,389
ЗЭЭЛИЙН ОЛГОЛТЫН ДҮН	48,343,861	85,097,617	146,672,414	164,584,677	200,810,875
ХҮҮГИЙН ОРЛОГО	1,617,966	2,057,370	3,708,347	4,134,401	5,043,945


**mobi finance**  
 УЛААНБААТАР ХОТ  
 МОНГОЛ УЛААНБААТАР ХОТ  
 2021.09.22

УЛААНБААТАР ХОТ  
 МОНГОЛ УЛААНБААТАР ХОТ  
 2021.09.22

УЛААНБААТАР ХОТ  
 МОНГОЛ УЛААНБААТАР ХОТ  
 2021.09.22



Хүснэгт 26. Үнэт цаас гаргагчийн зээлийн үзүүлэлтийн төсөөлөл



Компанийн бизнес төлөвлөгөөний дагуу зээл олголтын дүн 2020 онтой харьцуулахад жилийн дундаж өсөлт нь 33.0 хувиар 200.0 тэрбум төгрөгийн бичил зээлийг олгохоор төлөвлөж байна. Харин одоогийн зээлийн хүүний орлогыг 3 дахин өсгөж 5.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олохоор төсөөлж байна.

### 3.3 ҮНЭТ ЦААСНЫ ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН БАТАЛГАА

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох “Мобиком Корпораци” ХХК баталгаа гаргаж байгаа нь эргэн төлөгдөх чадварыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулж байна.




Мобиком Корпораци ХХК нь Монгол Улсын Ньюком ХХК, Япон Улсын Сумитомо болон KDDI Корпорациудын хамтарсан хөрөнгө оруулалттай компани бөгөөд Монголын Топ-10 аж ахуйн нэгжийн нэг бөгөөд сүүлийн 8 жилд Топ-5 татвар төлөгчид багтаж ирсэн улсын тэргүүлэх зэргийн компани юм. Өдгөө 1996 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаагаа 25 дахь жилдээ явуулж байна.

**Баталгаа гаргагч нь дараах үүргийг хүлээнэ:**

“Бонд гаргагч нь нийтэд санал болгосон бондыг хугацаанд нь төлөөгүй бол Андеррайтерийн зүгээс баталгаа гаргагч Мобиком корпораци ХХК-д бичгээр тавьсан шаардлага болон холбогдох бүхий л шаардлагатай нотлох бичиг баримт буюу тухайн үнэт цаас гаргагчийн хүлээх үүргийн хэмжээг тодорхойлсон ҮЦТХТ-ийн бичиг хүргүүлнэ. Шаардлага хүлээн авсанаас хойш ажлын 10 хоног дотор баталгаа гаргагч нийтэд санал болгох бондын нөхцөлийн дагуу Бонд гаргагчийн эргэн төлөлттэй холбоотой бүх өр төлбөрийг төлж барагдуулах үүрэгтэй”





**МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК**

14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Юнескийн гудамж - 28, МПМ Цогцолбор, Утас: 75759944,  
Факс: +976-11-310411, <http://www.mobicom.mn>

2021.06.24 № 1/4613-1

төрийн гүйцэтгэлийн хэлбэр -ийн № -т

Мобифинанс ББСБ ХХК-аас нийтэд санал болгох бонд гаргах болсонтой холбогдуулан баталгаа гаргах ("Баталгаа") тухай

**"ӨЛЗИЙ Энд Ко Капитал ҮЦК" ХХК ("Андеррайтер") -т**

Бид Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Компанийн охин компани болох Мобифинанс ББСБ ХХК (Улсын бүртгэлийн дугаар 5373271)-ийн гаргах 2'000'000'000 (хоёр тэрбум төгрөг) төгрөгийн үнийн дүнгтэй бондын танилцуулгал ("Танилцуулга")-д хамаагуулан уг баталгааг гаргаж байна.

Танилцуулгын дагуу нийтэд санал болгох бонд нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:

- (1) Санал болгож буй дүн: 2'000'000'000 (хоёр тэрбум төгрөг) хүртэлх төгрөг
- (2) Хугацаа: Бондыг нийтэд санал болгосноос хойш 1 жил
- (3) Гаргах огноо: 2021 оны 9 дүгээр сар

ИЙМД, "Мобифинанс ББСБ" ХХК-ийн хувьцааны 100%-ийг эзэмшиж байгаа эцсийн өмчлөгчийн хувьнаар Компани нь (бонд эзэмшигчийн алиг тусын тулд) Андеррайтерын өмнө дараах үүргийг үүсгэр хүлээж байна:

**1. ҮҮРЭГ**

Хэрэв Мобифинанс ББСБ нийтэд санал болгосон бондыг хугацаанд нь төлөхгүй бол Компани нь (бонд эзэмшигчийн ашиг тусын тулд) Андеррайтераас бичгээр тавьсан шаардлага болох холбогдох бүхий л шаардлагатай нотлох баримтуудыг хүлээн авснаас хойш ажлын 10 (арван) хоногийн дотор нийтэд санал болгох бондын нөхцөлийн дагуу Мобифинанс ББСБ-ын бондын эргэн төлөлттэй холбоотой бүх ор толбор ("Барьцаагаар хангагдах үүрэг")-ийг толж барагдуулах үүргийг Андеррайтерын өмнө үүсгэр хүлээж байна. Барьцаагаар хангагдах үүрэг нь нийтэд санал болгох бондын үнийн дүн (хоёр тэрбум төгрөг), хамаарах хуримтлагдсан хүү болон алдаглыг (өдөрт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1%-ийн нийлбэр дүнгээс хэтрэхгүй).



**2. ХУГАЦАА**

Энэхүү баталгааны хүчинтэй хугацаа баталгаа хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 жил байна.

**3. ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ**

Энэхүү Баталгаа болон үүнийг үндсэн агуулга, бүтцээс үүдэн эсвэл холбоотой гарах альянс маргаан, нэхэмжлэл (гэрээний бус маргаан, нэхэмжлэл орно)-ийг Монгол Улсын хуулиар тайлбарлаж,





**МАРГААНЫГ ХАРЬАЛАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХ**

Талууд Монгол улсын шүүх нь засхүү гэрээ, үүний үндсэн агуулга эсвэл бүтэцс үүдэн эсвэл холбоотой гэрэх аливаа маргаан нэхэмжлэл (гэрээний бус маргаан, нэхэмжлэл орно) нийг харьяалан шийдвэрлэх эрхтэй байхыг эргэлт буцалтгүйгээр зөвшөөрөв.

**Хүндэтгэсэн,**

Мобиком Корпораци ХХК-г төлөөлөн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

\_\_ гарын үсэг зурсан

**ООТАНИ** овогтой **ТОМОЮУКИ**



Мобиком Корпораци нь:



Зураг 31. Мобиком корпорацийн үйлчилгээний цар хүрээ

- ▶ Монгол орон даяар үйл ажиллагаа явуулж буй өөрийн 64 салбар нэгж, 2200 гэрээт борлуулагч болон 10,000 гаруй хөдөлгөөнт борлуулагчдаараа дамжуулан, Монгол Улсын хүн амын тал хувийн харилцаа холбооны хэрэгцээ шаардлагыг бүрэн ханган ажиллаж байна.
- ▶ Мобиком Корпораци ХХК нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг явуулахдаа Францын Alcatel, Шведийн Ericsson, Японы NEC, NTT, Норвегийн Нокиа, БНХАУ-ын Huawei, ZTE, АНУ-ын AT&T, Apple Inc, БНСУ-ын Самсунг мобайл, Швейцарийн Comfone, Данийн MACH зэрэг дэлхийн нэр хүндтэй компаниудтай нягт уялдаа холбоотой хамтран ажилладаг.
- ▶ Мобиком корпораци ХХК нь өнөөдрийн байдлаар Монгол улсын нийт 599 сум суурин газар өөрийн үйлчилгээгээ хүргээд байгаа бөгөөд нийт 1.5 сая гаруй хэрэглэгчдэд үйлчилгээгээ хүргэж байна. Үүнээс хөдөө орон нутагт 800 мянга гаруй хэрэглэгч тус корпорацийн сүлжээнд хамрагдсан байна.

### 3.4 ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮГИЙН ТӨВШИН ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Бондын жилийн хүүг банкны хадгаламжийн болон ЗГҮЦ-ны хүүгээс өндөр байхаар тогтоосон. Зах зээлийн нөхцөл байдал, банкны хадгаламжийн хүү, ижил төрлийн өрийн хэрэгслийн хүү зэргийг харгалзан Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад жилийн 14.0%-ийн хүү, татварын дараа 13.3%-ийн хүүг санал болгож байна.

#### Бодлогын хүү, ТБҮЦ-ны хүү, хадгаламжийн ЖДХ

Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагддаг ЗГҮЦ-ны хүү нь компанийн бондын жишиг хүү болдог хэдий ч Засгийн газрын өрийн удирдлагын бодлогын хүрээнд ЗГҮЦ-ыг 2017 оны 10-р сарын 24-ны өдрөөс хойш арилжаалахыг зогсоосон. Хамгийн сүүлд арилжаалагдсан 6 сарын хугацаатай ЗГҮЦ-ны хүү 11.805% байсан.



2021.09.22

Монгол банкнаас бодлогын хүүг 2018 оноос 2020 оныг хүртэл 11.0 хувьд хадгалсаар ирсэн бөгөөд 2020 оны 3 сарын 24-ний өдөр бодлогын хүүг 6.0% хувьд хүргэж түүхэн доод төвшинд хүргээд байна. Энэ нь Ковид 19 цар тархалттай холбоотой тодорхой бус байдал нэмэгдэж гадаад эрэлт, түүхий эдийн үнэ буурсан болон гадаад дотоод эдийн засгийн идэвхжил суларч, эдийн засгийн өсөлт саарах эрсдэл нэмэгдсэнтэй холбоотой.


### Банкнүүдын хадгаламж болон нээлттэй бондын хүүгийн харьцуулалт

Зах зээл дахь хүүгийн төвшин бодлогын хүүг дагаж буурснаар 2021 оны 7 сарын байдлаар арилжааны банкнүүдын 12 сарын хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 8.02%, дээд хүү 8.8%, доод хүү 7.2% байна. МХБ-д нээлттэй гарсан ЛэндМН ББСБ-ын бондын хүү жилийн 14% байсан. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад 14.0%-ийн хүүг санал болгож байна.

### Хүүгийн харьцуулалт



График 42. Банкнүүд болон нээлттэй бондүүдын хүүгийн харьцуулалт  
Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Банкнүүд






График 43. Татварын дараах хүүгийн харьцуулалт

	Хадгаламж	Хаалттай бонд	Моnрау бонд
Хүү /дундаж/	7.8%	16.0%***	14.0%
Татвар	10%	10%	5%
Татварын дараах хүүгийн орлого	7.0%	14.4%	13.3%
Хүү олгох давтамж	Жилд 1	Янз бүр	Жилд 1
Хүү буурахгүй байх магадлал	x	x	✓
Хугацааны дундуур зарах боломж	x	x	✓
Ханшийн зөрөөний ашиг олох боломж	x	x	✓
Баталгаа / Барьцаа	20* сая.төг	x даатгалтай байх боломжтой	"Мобиком корпораци" ХХК-ийн төлбөрийн баталгаа**
Санхүүгийн тайлангийн ил тод байдал	✓	x ХК-д хамаарахгүй	✓
Зохицуулагч байгууллагын зөвшөөрөлтэй эсэх	✓	x ХК-д хамаарахгүй	✓
Зохицуулагч байгууллагаас хяналт тавих эсэх	✓	x ХК-д хамаарахгүй	✓
Олон улсын Аудитын байгууллагаар хянагддаг эсэх	✓x	?	✓ Прайс уотер хаускуперс аудит /pwc/

Хүснэгт 29. Нээлттэй бондын давуу тал



**3.5 ӨРИЙН БИЧГЭЭР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ**

**Өрийн бичиг нь түүний эзэмшигчийн дараах эрхийг гэрчилнэ:**

1. Өрийн бичиг эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь компанийн санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгыг хөрөнгө оруулалтын зорилгоор судлан үзэж, бүрэн танилцсаны үндсэн дээр өрийн бичгийг худалдан авч, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах эрхтэй.
2. Үнэт цаасны үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой шимтгэл, хураамжийн үүргийг гүйцэтгэснээр Үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй.
3. Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тохиролцсон хугацаанд бүрэн төлөхийг шаардах эрхтэй.
4. Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны мэдээллийн ил тод байдлын журамд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн мэдээллийг авах эрхтэй.
5. Өрийн бичиг эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь өрийн бичгийн хоёрдогч зах зээлийн үнийн мэдээлэлтэй танилцах эрхтэй.
6. Өрийн бичгийг бирж дээрээс үнэт цаасны компаниараа дамжуулан чөлөөтэй худалдан авах, хоёрдогч зах зээл дээр худалдах;
7. Өрийн бичиг эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь хугацааны эцэст өрийн бичгийг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, хуримтлагдсан хүүг төлөхийг шаардах эрхтэй ба хэрэв үнэт цаас гаргагч нь энэ үүргээ биелүүлэхгүй бол баталгааны гэрээнд заасны дагуу хийхийг шаардах болон Монгол Улсын хуулиар олгогдсон бусад эрхийг эдэлнэ ( КтХ-ийн 41.1, 41.5);
8. Өрийн бичиг гаргагч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол өрийн бичиг эзэмшигч нь тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах ( Иргэний хуулийн 208.6).
9. Хэрэв бонд гаргагч гуравдагч этгээд баталгаа, батлан даалт гаргасан бол тухайн этгээдийн талаарх мэдээлэлтэй танилцах (Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам)
10. Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад эрх.


**Өрийн бичиг нь түүний эзэмшигчийн дараах үүргийг гэрчилнэ:**

1. Мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулах нөхцөлөөр өөрийн захиалсан өрийн бичгийн төлбөрийг төлөх, тийнхүү төлөөгүй бол захиалсан өрийн бичгийг ҮЦК худалдах эрхтэйг хүлээн зөвшөөрөх;
2. Өрийн бичиг гаргах шийдвэрт заасан бөгөөд Үнэт цаас гаргагч өөрийн гаргасан өрийн бичгээ төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдан авах эрхээ хэрэгжүүлэхэд саад болохгүй байх (КтХ-ийн 41.6);
3. Өрийн бичиг эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн өрийн бичгийн төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас

MOBI  
finance  
МОНГОЛЫН ХОТ  
МОНГОЛЫН БЭСӨБ ХАК  
9021101015-5373271

МОНГОЛЫН ХОТ  
МОНГОЛЫН БЭСӨБ ХАК  
101  
9021101015-5373271

МОНГОЛЫН ХОТ  
МОНГОЛЫН БЭСӨБ ХАК  
ӨЛЭНИЙ ЭНД БО  
КАПИТАЛ ҮЦК  
ХАК  
5183855  
9021031195-5373271




олсон орлого бөгөөд “Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль”-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй мөнгөн хөрөнгө болохыг бүрэн баталж, эрсдэл болон өгөөжийг бүрэн тооцоолж хөрөнгө оруулалтын шийдвэрийг бие даан гаргасан талаар баталгаа гаргаж ҮЦК-аас гаргасан анхан шатны маягтыг үнэн зөв мэдээлэх болон түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

4. Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Өрийн хэрэгслийн хүүгийн орлогоос татвар төлөх үүрэгтэй.
5. Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

### Үнэт цаас гаргагчийн үүрэг

Үнэт цаас гаргагчийн Өрийн бичиг гаргахтай холбоотой үйл ажиллагаа нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Хорооны Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам, Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам, Биржийн Үнэт цаасны бүртгэлийн болон Арилжааны журам, ҮЦТХТ-ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журмаар тус тус зохицуулагдана.

1. Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй;
2. Өрийн бичгийн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд үнэт цаасны барьцааны гэрээний дагуу зохих арга хэмжээг авч өрийн бичиг эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах;
3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу үр ашигтай захиран зарцуулах;
4. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хугацаанд хүүгийн төлбөрийг төлөх, хугацааны эцэст үндсэн төлбөрийг төлөх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах;
5. Өрийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд Баталгааны гэрээнд заасан зохих арга хэмжээг авч Өрийн бичиг эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах үүрэгтэй.
6. Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээнүүд дээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас өрийн бичиг эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах үүрэгтэй;
7. Үнэт цаас гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр хийгдэх өдрөөс ажлын 3 хоногийн өмнө ҮЦТХТ-д байрших өөрийн дансанд шилжүүлнэ. Шилжүүлсэн дүнг ҮЦТХТ нь хөрөнгө оруулагчийн үнэт цаасны данс руу үндсэн болон хүүгийн төлбөр хийгдэх өдөр татна;



УЛААНБААТАР ХОТ  
2020 ОУР 22  
СЭРГЭГЭВ

8. Холбогдох хууль тогтоомж болон журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;
9. Хэрэв Үнэт цаас гаргагчид гуравдагч этгээд баталгаа, батлан даалт гаргасан бол бондын танилцуулгад уг этгээдийн тодорхой үнэн зөв мэдээллийг тусгах;
10. Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар хүргэх;
11. Үнэт цаас гаргагч нь бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын мэдээллийг нэн даруй олон нийт, Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.
12. Үнэт цаас гаргагч буюу нээлттэй бонд гаргагч нь дараах тохиолдолд зохих мэдээллийг Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийтэд тухайн үйл явдал болсноос хойш ажлын гурван өдрийн дотор мэдээлнэ.
  - Бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны чиглэл, төсөл болон төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орсон;
  - Бусад санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчаас зээл авсан, тэдний өмнө хүлээсэн нэмэлт үүрэг үүссэн;
  - Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон;
  - Хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт орсон;
  - Эрх бүхий байгууллагын шийдвэрээр бонд гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан;
  - Бонд гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, хугацааг сунгуулсан, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;
  - Бонд гаргагч нь гуравдагч этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргасан;

  
mobi  
finance  
УЛААНБААТАР ХОТ  
МОНГОЛЫН ИТЭНДС БҮСЭСЭ ЖИЖ  
Уул 1075-4, 53792711

  
mobi  
УЛААНБААТАР ХОТ  
ЭНХЭМ КОРПОРАЦИ ЖИЖ  
Уул 1075-4, 53792711  
103

  
УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЭГЭЙ ЭНД КО  
КАПИТАЛ УЙН  
ХХК  
5103855  
Уул 1031195, СТС2429

### 3.6 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ



Схем 7. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах дараалал

Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс үнэт цаас гаргагчийн гаргаж буй өрийн хэрэгслийг нээлттэй хүрээнд нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрч үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тохиолдолд Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-д заасны дагуу Үнэт цаас гаргагч болон Андеррайтер компаниуд өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах дэлгэрэнгүй төлөвлөгөөг танилцуулах болно.

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчийн хурлын 2021 оны 06 сарын 24 өдрийн #АН-SHM 06/21 тоот тогтоолын дагуу анхдагч зах зээлд нийт 20,000 /хорин мянга/ ширхэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий компанийн өрийн хэрэгслийг олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалах бөгөөд хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжааны тогтоосон үнийн аргыг ашиглан олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн. Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй өрийн хэрэгслийн худалдан авах захиалгын хугацааг Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл гарсны дараа үнэт цаас гаргагч болон андеррайтерийн компаниуд харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.



Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд хэрхэн оролцох вэ?

СЗХ-н 2021 оны 6 сарын 11 өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан шинэ үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу анхдагч зах зээлийн үйл ажиллагааг андеррайтер төвтэй зохион байгуулна.

Үнэт цаас худалдан авах үйл ажиллагаа Monpra аппликейшнээр хийгдэнэ.

1. **Данс нээлгэх** (Хэрэв үнэт цаасны дансгүй бол Monpra аппликейшнээр дамжуулан данс нээлгэх)
2. **Мөнгөө байршуулах** (Бонд худалдан авах мөнгийг Monpra аппликейшны дансандаа байршуулна)
3. **Бонд худалдан авах захиалга өгөх** (Monpra аппликейшнээр дамжуулан бонд худалдан авах захиалгыг өгч захиалгаа баталгаажуулна)
4. **Арилжаа хаагдах** (Анхдагч зах зээлийн нийт арилжаа 1.0 тэрбум төгрөгт хүрсэнээр хаагдана)






### Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга

Монголын Хөрөнгийн биржийн 2018 оны 10 сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-д заасны дагуу тогтоосон үнэ/өгөөж/-ээр цаг хугацааны ахлах дарааллаар санал болгон арилжих арга юм.

### Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд хэрхэн оролцох вэ?



Схем 8: Анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар



2021 оны 08 сарын 31  
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2021-08-31

БҮРТГЭВ-03

# IV. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

  
mobi  
finance  
*[Signature]*  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 ☎ 5373271

  
mobicom  
*[Signature]*  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК  
9021090352 ☎ 2072572

*[Signature]*  
УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗИЙН АЖИРА  
КАПИТАЛ ҮЙС  
ХХК  
5183855  
9021031195 ☎ CTC2420



#### 4.1 АНДЕРРАЙТЕР КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ


Андеррайтер компани	Мэдээлэл
Байгууллагын нэр	Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011125147
Регистрийн дугаар	5183855
Үйл ажиллагааны чиглэл	Андеррайтер, Брокер, Дилер
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар 14200 Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Сити центр, 10 давхар, 1003 тоот
Утас	+976-7777-6377
Цахим шуудан	info@ucc.mn

Хүснэгт 30. Андеррайтерийн компанийн мэдээлэл

#### “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-ийн танилцуулга

“Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан. Компани нь СЗХ-оос үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, МХБ болон МҮЦАЭХ-ийн гишүүн байгууллага юм.

“Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК нь дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Монголд анх удаа НКЕХ, LSE, ASX and NYSE зэрэг гадаадын биржийн арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлж, энэхүү үйлчилгээгээр дотооддоо тэргүүлсээр байна. “Сүү” ХК-ийн 6.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд хамтрагч андеррайтераар ажилласан. 2018 онд Үндэсний өв соёлыг эрхэмлэгч, НААД брэндийн эрхийг эзэмшигч “Талын Эзэн” ХХК-ийн 420.0 сая төгрөгийн бондыг хаалттай хүрээнд амжилттай арилжаалж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв-д бүртгүүлж хөрөнгө оруулагчдын эзэмшлийг баталгаажуулсан нь Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анхны тохиолдол байв. Мөн оны 6 сард Урбан брэндийн 600.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий “Урбан бонд”, 8 сард 1.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий “Бэрс бонд” хаалттай бондуудын санхүүжилт босгох үйл ажиллагаанд хамтрагч андеррайтераар, 2019 оны 4 сард “АБТС ББСБ” ХХК-д зээлийн санхүүжилт зуучлагч андеррайтераар тус тус ажиллаад байна. Мөн 2019 онд банк бус санхүүгийн байгууллагын хоёрдогч IPO болох “Ард Кредит ББСБ” ХХК-ийн IPO-д үндсэн андеррайтер, 2020 онд ББСБ-ын анхны нээлттэй бонд болох ЛэндМН ББСБ ХК-ийн олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл санал болгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер, 2021 онд мөн ЛэндМН ББСБ-ын



2021-09-22

дахин нээлттэй бонд гаргах үйл ажиллагаанд үндсэн андеррайтераар амжилттай ажиллаад байна.

“Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК нь үнэт цаасны гадаад, дотоод арилжаа, андеррайтерийн ажил үйлчилгээнээс гадна байгууллагын санхүүжилт, M&A болон бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд 2015-2018 онуудад Япон Улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх, “Зэс Эрдэнийн Хувь” ХХК, “Түшиг Уул” ХК, “Eurofeu” ХХК зэрэг компаниудад санхүүгийн зөвлөхийн үүрэг гүйцэтгэсэн. “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-ийн Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд оруулж буй манай компанийн хувь нэмрийг үнэлж Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн холбооноос 2011 онд “Шилдэг Брокерийн компани”-аар, 2013 онд Монголын хөрөнгийн зэх зээлийн дээд шагнал GRAND BULL AWARDS “Шилдэг Шинийг Санаачлагч” байгууллагаар тус тус шалгарч байсан бөгөөд 2018 онд Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зэх зээлийн дээд шагнал GRAND BULL AWARDS “Шилдэг Мэргэжилтэн”, 2020 оны Монголын үндэсний олон нийтийв телевизийн “Цагийн хүрдийн баатар”-аар тодорсон билээ.

Бидний ажилласан төслүүдийг дурдвал:

- 2021 онд “Микро Кредит ББСБ” ХХК-ийн хаалттай бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд андеррайтер
- 2021 онд “ЛэндМН ББСБ” ХК-ийн 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Монголын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдах бондын хоёр дахь удаагийн санхүүжилт босгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер
- 2021 онд “Соно финтек ББСБ” ХХК-ийн хаалттай бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд андеррайтер
- 2021 онд “Говь Экуйпмент Рентал Флийт” ХХК -ийн хаалттай бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд андеррайтер
- 2021 онд Сингапур улсад бүртгэлтэй “Гарнетон” ХХК-ийн хаалттай хүрээнд долларын санхүүжилт босгох үйл ажиллагаанд хамтрагч андеррайтер
- 2021 онд “Монголиан Мючүал Финанс Групп” ХХК-ийн хаалттай бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд андеррайтер
- 2021 онд “Чоно финанс ББСБ” ХХК-ийн хаалттай бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд андеррайтер
- 2020 онд Финтек салбарын томоохон төлөөлөл болох “Анд системс” ХХК-д хаалттай хүрээнд бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер,
- 2020 онд 24 га газрыг хамарсан томоохон бүтээн байгуулалтын төсөл болох “Мишээл сити” төслийн санхүүжилтэд зориулж хаалттай хүрээнд санхүүжилт босгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер,
- 2020 онд “ЛэндМН ББСБ ХК-ийн 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Монголын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдах бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер
- Япон улсаас дотоодын IT үйлчилгээ үзүүлдэг компанид хаалттай хүрээнд долларын санхүүжилт босгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер
- 2020 онд “БИД” санхүүгийн нэгдлийн хаалттай хүрээнд бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер
- 2020 онд “Бэрс финанс ББСБ ХХК-ийн бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер

mobi  
finance

УЛААНБААТАР ХОТ  
ДИНАНС ББСБ ХХК  
Уулзварын 5373271

108

УЛААНБААТАР ХОТ

ӨЛЗИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЦК  
ХХК

5133855  
9921031195 СТС2420

- 2020 онд "АБТС ББСБ" ХХК-ийн зээлийн санхүүжилт зуучлах үйл ажиллагаанд зуучлагч
- 2020 онд "Микро Кредит ББСБ" ХХК-ийн хаалттай бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер
- 2019 онд "БИД" санхүүгийн нэгдлийн хаалттай хүрээнд бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер
- 2019 онд "Бэрс финанс" ББСБ ХХК-ийн хаалттай хүрээнд бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд үндсэн андеррайтер
- 2019 онд "АБТС ББСБ" ХХК-ийн зээлийн санхүүжилт зуучлах үйл ажиллагаанд зуучлагч
- 2019 оны эцсийн байдлаар Монголын хөрөнгийн биржийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүнгээр ТОП 5-д багтсан
- Дотоодын агаарын тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагад зөвлөх
- 2019 онд гадаадын хөрөнгө оруулалттай компанийн нэгтгэх үйл ажиллагаанд зөвлөх
- 2019 онд "Шарын гол" ХК-ийн өрийг хувьцаагаар солих үйл ажиллагаанд андеррайтер
- 2019 онд банк бус санхүүгийн байгууллагын хоёрдогч IPO болох "Ард Кредит ББСБ" ХХК-ийн олон нийтээс 5.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан Төвлөрүүлэх үйл ажиллагаанд үндсэн андеррайтер,
- 2018 онд "Бэрс финанс ББСБ"-ын хаалттай хүрээнд бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд хамтрагч андеррайтер.
- 2018 онд "Урбан" брэндийн хаалттай хүрээнд бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд хамтрагч андеррайтер
- 2018 оны НААД брэндийн эрхийг эзэмшигч "Талын Эзэн" ХХК-ийн бондыг хаалттай хүрээнд амжилттай арилжаалж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв-д бүртгүүлж хөрөнгө оруулагчдын эзэмшлийг баталгаажуулсан анхны тохиолдол байв. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анхны
- 2017 онд "Сүү" ХК-ийн 6.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй бондын санхүүжилт босгох үйл ажиллагаанд хамтрагч андеррайтер,
- 2017 онд "Зэс Эрдэнийн Хувь ХХК, компанид санхүүгийн зөвлөх,
- 2016 онд "Түшиг Уул" ХК санхүүгийн зөвлөх, 2015 онд "Eurofeu" ХХК компанид санхүүгийн зөвлөх,
- 2015-2018 онуудад Япон Улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх,
- 2013-2017 онд ЗГҮЦ ны арилжаанд идэвхтэй, голлох байр суурьтай оролцсон.

Бид дотоодын компаниудад андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн нийт 68.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлээд байна.



## Андеррайтерийн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг

Энэхүү гэрээгээр андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нээлттэй хүрээнд санхүүжилт татах үйл ажиллагаатай холбоотой Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу үнэт цаас гаргах төлөвлөгөөг боловсруулах, үнэт цаасны танилцуулга материалыг бэлтгэх, хөрөнгө оруулагчдад санал болгох, хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, мөн энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан СЗХ болон МХБ-тэй үнэт цаас гаргагчийг төлөөлөн харилцах гэх мэт талуудын хоорондын харилцааг зохицуулна.

- Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3 дугаарт заасны дагуу Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр зохион байгуулна.
- Андеррайтер тус бүр нь энэхүү гэрээ болон ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй бөгөөд андеррайтер тус бүр төлөвлөгөөнд заасан ажлыг заасан хугацаанд гүйцэтгэх үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий этгээд нь нийтэд санал болгох үнэт цаасны үнийг үндэслэлгүйгээр тогтоосон эсхүл тус үнэ нь үнэт цаас гаргах үйл ажиллагааг амжилтгүй болгоход хүргэнэ гэж андеррайтер үзсэн тохиолдолд андеррайтер нь үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь андеррайтерийг шаардлагатай бүхий л мэдээ мэдээллээр үнэн зөв, түргэн шуурхай хангаж ажиллах үүрэгтэй.
- Андеррайтер нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол Үнэт цаас гаргагч нь гэрээг түдгэлзүүлэх мэдэгдлийг бичгээр үйлдэж, түүнд төлбөл зохих төлбөрийг түдгэлзүүлж болох бөгөөд энэхүү мэдэгдэлд биелүүлээгүй үүргийн шинж чанарыг тодорхойлох ба энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг андеррайтераас шаардах эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь тогтоосон хугацаанд аливаа дотоод мэдээллийг андеррайтертай зөвшилцөлгүйгээр олон нийтэд мэдээлсэн, үүний улмаас үнэт цаас гаргагчийн үнэт цаасны үнэлгээнд эрс өөрчлөлт гарсан, хөрөнгө оруулалт, санхүүжилт татах ажиллагаанд саад учруулсан, хөрөнгө оруулагчдад буруу мэдээлэл хүргэсэн болон бусад байдлаар андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан бол Үнэт цаас гаргагч учирсан хохирлыг өөрөө хариуцна.



## АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

“Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК нь Монгол улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, СЗХ-ны “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон МХБ ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам” -ын холбогдох заалтуудын дагуу үнэт цаас гаргагч “Мобифинанс ББСБ” ХХК (РД:5373271)-тай 2021 оны 6 сарын 24-ний өдөр МР/Л тоот “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулан “Мобиком Корпораци” ХХК-ийн 100% төлбөрийн баталгаатай “Монпрау” бондыг олон нийтэд санал болгохоор хамтран ажиллаж байгаа.

Андеррайтер нь гэрээний дагуу Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаас гаргах төлөвлөгөө, санхүүгийн үзүүлэлтийн төсөөллийн хэрэгжих магадлал, татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, эдийн засгийн үр ашгийн тооцоо болон олон нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгыг боловсруулахад шаардлагатай зөвлөмжөөр ханган ажиллалаа.

2020 он Ковид-19 цар тахлын улмаас эдийн засаг агшиж, бизнесийн үйл ажиллагаа хумигдан, иргэдийн хэрэглээ буурч, эдийн засгийн эргэлт буурснаас санхүүгийн байгууллагын зээл гаргалт хумигдан, эргэн төлөлтийн чадавх буурсан амаргүй жил байлаа.

Энэхүү цар тахалаас үүдэлтэй эдийн засгийн уналтыг “Мобифинанс ББСБ” ХХК-ийн хувьд эрсдэлийн менежментийн удирдлагыг сайн хэрэгжүүлж, цахимд суурилсан үйлчилгээгээр хэрэглэгчдэд тасралтгүй үйлчилж, эх үүсвэрийн дутагдалгүй, зээлийн эргэн төлөлтийн чанарыг сайжруулж чадсан зэрэг амжилттайгаар даван гарсан гэж дүгнэж байна.

Андеррайтер Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох дүрэм журам болон үнэт цаас гаргахтай холбоотой хөндлөнгийн үнэлгээний байгууллагуудын хараат бус дүгнэлтэд үндэслэн энэхүү Мобиком корпораци ХХК-ийн баталгаатай Мобифинанс ББСБ-н олон нийтэд нээлттэй санал болгож буй бондын “Үнэт цаасны танилцуулга”-ыг бэлтгэж, мэргэжлийн дүгнэлтийг танилцуулж байна.

Андеррайтерийн дүгнэлтийн агуулга:

1. Үнэт цаас гаргагч компанийн тухай
2. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа
3. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл
4. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт
5. Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө
6. Хөрөнгө оруулалтын өгөөж
7. Хөрөнгө оруулалтын эрсдэл



## 1. Үнэт цаас гаргагчийн тухай

“Үнэт цаас гаргагч” Мобифинанс ББСБ ХХК нь гар утсанд суурилсан цахим төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор Монгол Улсын үүрэн холбооны тэргүүлэгч оператор Мобиком Корпораци ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар 2010 оны 4 дүгээр сард үүсгэн байгуулагдсан. Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга”-ын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг авснаар Монгол Улсад анх удаа цахим мөнгөний “Мост Мони үйлчилгээ”-г 2010 оны 10 дугаар сарын 10-ны өдөр зах зээлд нэвтрүүлсэн. Түүнчлэн Мобифинанс нь 2018 онд Монголбанкнаас Монголын хамгийн анхны Цахим мөнгөний тусгай зөвшөөрлийг “Candy”-гээрээ авсан юм. Зөвшөөрөл авахтай зэрэгцэн Монголд анх удаа ухаалаг утсан дээр суурилсан, цахим мөнгөний албан ёсны төлбөрийн хэрэгсэл болох Candy Pay аппликейшныг танилцуулсан билээ. Гэвч “Candy нь зөвхөн Мобикомын хэрэглэгчдэд зориулагдсан уламжлалт Лояалти хөтөлбөр” гэсэн ойлголт хүчтэй хэвээр байсан тул 2020 онд “Candy Pay”-ийн брэнд имижийг өөрчлөх шийдвэр гаргаж, “MonPay” болгон шинэчилсэн.

Үнэт цаас гаргагчийн хувьцааны багцыг Мобиком корпораци ХХК 100% эзэмшдэг. Харин Мобиком корпораци ХХК-ийн хувьцааны багцыг Монгол Улсын Ньюком ХХК, Япон Улсын Сумитомо болон KDDI корпорациуд эзэмшдэг байна.

Мобиком корпораци ХХК 1995 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн цагаас өнөөг хүртэл Ньютел ХХК /2000 он/, Монгол Контент ХХК /2005 он/, Улуснет ХХК /2005 он/, Мобинет ХХК /2009 он/, Мобифинанс ББСБ /2010 он/ зэрэг охин компаниудыг байгуулан бизнесийн хүрээгээ тэлэн амжилттай ажиллаж байна. Монголын **Топ-10** компаниудын нэг бөгөөд сүүлийн 8 жилд **Топ-5** татвар төлөгчид багтаж ирсэн монгол улсын тэргүүний компаниудын нэг юм.

Өнөөдрийн байдлаар Мобиком Корпораци ХХК нь үүрэн холбоо, улс хоорондын холбоо, интернэт, сансрын холбоо болон сүлжээний дэд бүтэц гэсэн үндсэн үйлчилгээг байгууллага болон хувь хэрэглэгчдэд тасралтгүй, найдвартай байдлаар хүргэн ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан бөгөөд тухайн салбартаа олон жил ажилласан туршлагатай, мэргэшсэн, хоорондоо нэгдмэл сонирхолгүй, бие даан шийдвэр гаргах бүрэн чадвартай буюу компанийн сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэн компанийн тогтвортой хөгжлийг ханган ажиллах бүрэн боломжтой хүмүүс гэж үзэж байна.



## 2. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагааны тухай

2018 оны 10 дугаар сард Мобифинанс ББСБ Монгол Улсын мөнгөн тэмдэгт- төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий бэлэн бус төлбөрийн хэрэгслээр тооцогдох “Цахим мөнгө гаргах” тусгай зөвшөөрлийн гэрчилгээг Монголбанкнаас албан ёсоор хүлээн авсан анхдагч байгууллага юм.

Монгол Улсад одоогоор “Мобифинанс ББСБ”-тай ижилхэн цахим мөнгөний лиценз эзэмшигч зургаан компани байдаг бөгөөд зөвхөн эдгээр компаниуд л цахим мөнгө ашиглан, веб хуудас болон гар утасны аппликейшн дээр суурилсан санхүүгийн бизнес эрхлэх зөвшөөрөлтэй юм.

Мобифинанс ББСБ нь Монгол орон даяар хэрэглэгчдэд “Үндэсний төлбөрийн шийдэл” Monpay брэндийн цахим санхүүгийн үйлчилгээнүүдийг ашиглах боломжийг бүрдүүлж, холбогдох тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд Финтекийн боломжийг өргөн цар хүрээтэйгээр түгээсээр байна. Monpay цахим мөнгөний үйлчилгээ нь хэрэглэгчид гар утасныхаа дугаарт холбогдсон цахим данснаасаа төлбөр тооцоо, худалдан авалт, мөнгөн шилжүүлгийг маш хялбараар, түргэн шуурхай хямд хийж гүйцэтгэх боломжийг олгож байна. Monpay зээлийн үйлчилгээ нь хэрэглэгчийн гар утасны хэрэглээнд суурилсан ямарч барьцаагүй, нэмэлт бичиг баримт бүрдүүлэх шаардлагагүйгээр зээл олгох үйлчилгээ юм. Зээлийн үнийн дүнгийн хувьд 100'000 – 1'000'000₮-н хооронд, хүүний хувьд сарын 1,9 - 3,4%-н хүүтэй зээлийг санал болгодог.

Мөн E-Token үйлчилгээ буюу хэрэглэгч бүх төрлийн банкны картыг Monpay аппликейшндээ бүртгүүлснээр Monpay дансаа ямар нэгэн шимтгэлгүйгээр хормын дотор цэнэглэх боломжтой нь бүх төрлийн мөнгөн шилжүүлэг хийхэд хялбар болгож байна.


Монгол Улсын төрийн бүх үйлчилгээг цахимжуулах, цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор E-Mongolia төслийг Монгол Улсын Засгийн газар үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор Мобифинанс ББСБ энэхүү төслийг дэмжин E-Mongolia, төрийн үйлчилгээний ТҮЦ машины төлбөрийн систем, татварын E-barimt систем, хот хоорондын авто замын хураамж төлөх дамжин өнгөрөх цэгүүдийн төлбөрийн системүүдэд амжилттай холбогдоод байна.

## 3. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээллийн тухай


ХӨРӨНГӨ /мян.төг/	2020	2021Т	2022Т	2023Т	2024Т
Мөнгө ба түүнтэй	2,881,305	4,443,639	6,001,328	5,353,664	7,576,504



УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075-5, 5373271




Мобифинанс ББСБ ХХК



ӨЛЭГЧИЙН ЭНД КО  
КАПИТАЛ ҮЙС  
ХХК

адилгах хөрөнгө					
Банкуудад байршуулсан хөрөнгө	6,108,886	4,482,714	4,482,714	4,482,714	4,482,714
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,221,498	10,495,362	11,884,435	15,099,889	19,155,673
Бусад санхүүгийн хөрөнгө	122,378	241,350	241,350	241,350	241,350
Бусад хөрөнгө	24,101	6,668	30,168	30,168	30,168
Хойшлогдсон татварын хөрөнгө	3,944	6,081	6,081	6,081	6,081
Биет бус хөрөнгө	60,272	31,881	12,024	9,166	6,307
Үндсэн хөрөнгө	16,036	22,697	5,014	4,663	4,312
Ашиглах эрхтэй хөрөнгө	118,237	1,161,463	889,872	722,860	555,849
Нийт хөрөнгө	13,556,657	20,891,854	23,552,985	25,950,554	32,058,958
<b>ӨР ТӨЛБӨР</b>					
Хэрэглэгчийн барьцаа	5,653,022	6,773,861	7,757,923	8,409,967	8,823,678
Дансны болон бусад өглөг	223,701	621,463	778,643	778,643	778,643
Бондын өглөг		4,000,000	4,000,000	3,000,000	4,000,000
Урьдчилж орсон орлого	7,400	0	1,040	1,040	1,040
Түрээсийн өр төлбөр	128,753	1,241,362	1,211,735	1,211,735	1,211,735
Орлогын албан татварын өглөг	13,370	163,333	163,333	151,667	210,000
Нийт өр төлбөр	6,026,246	12,800,019	13,912,674	13,553,052	15,025,096
<b>ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>					
Хувьцаат капитал	5,019,860	5,019,860	5,019,860	5,019,860	5,019,860
Хуримтлагдсан ашиг	2,510,551	3,071,975	4,620,451	7,377,642	12,014,002
Нийт эздийн өмч	7,530,411	8,091,835	9,640,311	12,397,502	17,033,862
Нийт өр төлбөр болон эздийн өмч	13,556,657	20,891,854	23,552,985	25,950,554	32,058,958

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл






/мян.төг/	2020	2021Т	2022Т	2023Т	2024Т
Хүүгийн орлого	2,225,200	2,671,713	4,248,347	4,614,401	5,523,945
Хүүгийн зардал	(20,655)	(163,333)	(723,333)	(548,333)	(478,333)
Хүүгийн цэвэр орлого	2,204,545	2,508,379	3,525,014	4,066,068	5,045,612
Зээлийн алдагдлын сангийн зардал	(258,085)	(154,709)	(384,665)	(406,923)	(430,148)
Зээлийн алдагдлын дараах хүүгийн цэвэр орлого	1,946,460	2,353,671	3,140,349	3,659,145	4,615,463
Хураамж, шимтгэлийн орлого	1,707,803	2,455,928	3,277,448	4,315,566	5,727,089
Хураамж, шимтгэлийн зардал	(318,800)	(662,290)	(835,336)	(963,473)	(1,145,863)
Бусад үйл ажиллагааны орлого	23,164	7,902	19,061	19,061	19,061
Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал	(1,948,345)	(3,436,720)	(3,835,344)	(3,966,754)	(4,064,239)
Татварын өмнөх ашиг	1,410,282	718,491	1,766,177	3,063,545	5,151,511
Орлогын албан татварын зардал	(157,657)	(118,922)	(194,559)	(306,355)	(515,151)
Тайлант жилийн ашиг	1,252,625	599,569	1,571,618	2,757,191	4,636,360

Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн орлого үр дүнгийн тайлангийн төсөөлөл

Компаний хөрөнгө 2020 оны эцэс 13.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны үзүүлэлтээс 20.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Дараагийн 4 жилд нийт хөрөнгийн хэмжээ дунджаар 24.0 хувиар өсч 2024 онд 31.7 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Нийт хөрөнгөнд эзлэх харилцагчдад олгосон зээл болон цахим мөнгөний хэрэглэгчдийн дансны үлдэгдэл дунджаар 83.0 хувьтай байх бөгөөд тус үзүүлэлтийн төвшин жил бүр өсч 2024 онд нийт хөрөнгийн 88.0 хувьтай тэнцэж 27.9 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөл байна. Компаний уг үзүүлэлтээс харахад дараагийн 4 жилд Мобифинанс ББСБ ХХК нь зээлийн үйлчилгээгээр дэмжин, цахим мөнгөний хэрэглээг нэмэгдүүлэн

  
 УЛААНБААТАР ХОТ  
 МОБИФИНАНС ББСБ ХХК  
 9021101075 ᠮ. 5373271

  
 УЛААНБААТАР ХОТ  
 ӨЛЗИЙ ЭНД КО  
 КАПИТАЛ ҮЦК  
 ХХК  
 8143885  
 9021031195 ᠮ. 070210\_5

бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулан санхүүгийн үзүүлэлтээ хангах бүрэн боломжтой хэмээн дүгнэж байна. хийг чиглэн ажиллаж байна

Мобифинанс ББСБ ХХК-ийн 2021 оны 6 сарын 24-ний өдрийн #АН-SHM 06/21 тоот тогтоолоор нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,000 ширхэг, нийт 1,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй бондыг олон нийтэд санал болгож байна. 1'000'000'000 (нэг тэрбум) төгрөгийг өрийн бичиг гаргах замаар олон нийтээс татан төвлөрүүлж бичил хэрэглээний зээлийн санхүүжилтэд зарцуулахаар шийдвэрлэжээ.

### Зээл олголтын тоо



Компаний зээл олголтын тоо нь 2020 онтой харьцуулахад 2024 он гэхэд зээл олголтын тооны жилийн дундаж өсөлт нь 25 хувь байхаар байна.

График 1. Зээл олголтын тоо

MNT (Мянган төгрөг)	2020	2021F	2022F	2023F	2024F
Зээлийн багц	4,861,600	10,843,520	12,495,540	15,984,376	20,307,389
Зээлийн олголтын дүн	48,343,861	85,097,617	146,672,414	164,584,677	200,810,875
Хүүгийн орлого	1,617,966	2,057,370	3,708,347	4,134,401	5,043,945

Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн зээлийн үзүүлэлтийн төсөөлөл

Мобифинанс ББСБ нь бизнес төлөвлөгөөний дагуу ирэх дөрвөн зээл олголтын дүн 2020 онтой харьцуулахад жилийн дундаж өсөлт нь 33.0 хувиар 200.0 тэрбум төгрөгийн бичил зээлийг олгохоор төлөвлөж байна. Харин одоогийн зээлийн хүүний орлогыг 3 дахин өсгөж 5.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олохоор төсөөлж байна.



#### 4. Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

##### 2.1 МХБ ТӨХК бүртгэлийн шалгуур:

Үнэт цаас гаргагч нь МХБ ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018.01.25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 14 дүгээр зүйлд заасны дагуу Өрийн хэрэгслийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа гэж үзэж байна.

##### 2.2 Санал болгох үнэ:

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,000 ширхэг өрийн хэрэгслийг 1 жилийн хугацаатай 14.0 хувийн өгөөжтэйгөөр анхдагч зах зээлд байршуулахаар төлөвлөж байна.

Энэ нь бодлогын хүү буурахтай зэрэгцэн хадгаламжийн хүү буурч буй өнөө үед бонд эзэмшигчдэд 1 жилийн хугацаанд, харьцангуй өндөр өгөөжтэй тогтвортой хүү эзэмших боломжийг олгож буйгаараа онцлогтой юм.


СЗХ-ны 2021/06/11 өдөр 225 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн тухай журам" болон "Компанийн өрийн хэрэгслэлийн бүртгэлийн журам"-ын зохицуулалтаар


2.5 Андеррайтер нь гэрээний дагуу үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах хувьцааг Хорооны бүртгэл болон арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах ажиллагааг зохион байгуулна.

2.6. Андеррайтер нь үнэт цаас гаргагчтай тохиролцсоны үндсэн дээр нийтэд санал болгон гаргах хувьцааг үнэт цаасны анхдагч зах зээлд байршуулах, хувьцааны захиалгыг бүрдүүлэх аргачлалын талаар үнэт цаасны танилцуулгад дэлгэрэнгүй тусгасан байна.

Журмын дагуу андагч зах зээлийн арилжаа андеррайтер төвтэй явагдах бөгөөд үнэт цаас худалдан авах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй Монрау аппликейшнээр дамжуулан зохион байгуулна.

Урд өмнө нь олон нийтэд санал болгож байсан компанийн өрийн хэрэгслэлийн бүтээгдэхүүний анхдагч зах зээлийн захиалгын байдлыг харахад дийлэнх тохиолдолд захиалга давж биелсэн байдаг бөгөөд үүний үр дүнд хувь тэнцүүлэх хувааж хөрөнгө оруулагч нарын захиалгыг 100% биелүүлэх боломжгүй болох, илүүдэл хөрөнгийг буцаагаад харилцагч





нарын данс руу мөнгө хүсэх өргөдлөөр буцаах олгох зэрэг түвэг, бэрхшээлүүд учирч байсан.

Тиймээс энэ удаа “Monpay” бондын анхдагч зах зээлийн захиалгыг цаг хугацааны дарааллаар зохион байгуулахаар төлөвлөж байна. Өөрөөр хэлбэл, нийт 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татах бөгөөд цаг хугацааны дарааллаар зохион байгуулж худалдан авах захиалгын үнийн дүн 1.0 тэрбум төгрөгт хүрмэгц захиалгыг хаах болно.

“Monpay” бондыг олон нийтэд санал болгож байгаа зорилго нь бичил зээлийн санхүүжилт хэдий ч Monpay аппликейшнийг олон нийтэд таниулах, сурталчлах явдал билээ. Бидний хийсэн тооцооллоор 1.0 тэрбум төгрөгийн захиалгыг Monpay аппликейшнээр 300 гаруй харилцагчдаас бүрдүүлэх боломжтой бөгөөд үүгээрээ хөрөнгийн зах зээлийн тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна гэж дүгнэж байна.

#### 5. Хөрөнгө оруулалтын өгөөж

Татварын хөнгөлөлт

Компанийн нээлттэй бондын хувьд 5%-ийн хүүгийн татвар төлөх зохицуулалттай байгаа тул бонд эзэмшигчдийн хувьд өгөөжөө нэмэгдүүлэх давуу талтай юм.

Өндөр өгөөж

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад 14.0 хувь, татварын дараах 13.3 хувийн хүүг санал болгож байгаа нь зах зээл дээр арилжаалагдаж буй нээлттэй бондуудаас хамгийн боломжит өндөр хүүтэй байна. Өнгөрсөн оны мөн үеэс бодлогын хүү 3%, хадгаламжийн хүү 3%-6% буурсантай харьцуулахад Мобифинанс ББСБ ХХК-ийн санал болгож буй бондын татварын дараах өгөөж нь хадгаламжийн хүүгээс 5.3% өндөр байна. Түүнчлэн өнөөдөр зах зээл дээр арилжаалагдаж буй жишиг бонд буюу 2021 оны 4 сард гарсан ЭТТ бондын татварын дараах өгөөжөөс 3.8 хувиар өндөр байгаа нь бонд эзэмшигчдэд хөрөнгөө илүү өгөөжтэй удирдах таатай боломжийг бий болгож байна.



### Хүүгийн харьцуулалт



График 2. Өгөөж /татварын дараа/  
\* Инвексор Актив ТЗК-ын гаргасан ХБҮЦ-ны хувьд үндсэн төлбөр нь 3 сар тутам буюу 24 сарын хугацаанд нийт 8 хуваагдаж эргэн төлөгдөх нөхцөлтэй тул бодит өгөөж нь анх оруулсан дүнгээс тооцогдохгүй юм.

#### Хугацааны дундуур зарах боломж

Нээлттэй бондыг худалдан авснаар бонд эзэмшигч нь хэрэгцээтэй үедээ эзэмшсэн бондоо хэсэгчилэн болон бүхэлд нь зарах боломжтой байдаг.

#### Ханшийн зөрүүний ашиг хүртэх боломж

Нээлттэй бондыг эзэмшиж байх хугацаанд зах зээл дээр хадгаламжийн хүү буурах юм уу эсвэл бондын эргэн төлөлтийн хугацаа дөхөх тусам бондын үнэ өссөнөөр бонд эзэмшигч нарын хувьд арилжааны зөрөөний ашиг олох боломж бий болдог.

#### 6. Хөрөнгө оруулалтын эрсдэлийн тухай

Аливаа санхүүгийн бүтээгдэхүүн нь тодорхой төвшний эрсдэлтэй байдаг тул хөрөнгө оруулагч та шийдвэр гаргах бүртээ сайн судлах шаардлагатай юм. Хөрөнгө оруулалтын эрсдэлийн талаар анхааруулж буй агуулга нь бүх боломжит эрсдэлийг дурдаагүй байж болох бөгөөд Ковид-19 цар тахал ч үүний нэгэн жишээ болсон билээ.



## Бизнесийн эрсдэл

### Эргэн төлөлт муудах

Аливаа санхүүгийн харилцаанд орохдоо жишээ нь мөнгөө хадгалуулах, бонд эзэмших, мөнгө зээлэх үедээ харилцагчид тухайн банк, ББСБ-ын эргэн төлөлтийн чадавх, санхүүгийн тайлангийн байдлыг судлах боломж тэр бүр байдаггүй нь эрсдэх нөхцөлийг бий болгодог.



Ковид-19 цар тахалтай холбоотой санхүүгийн хэрэглэгчдийн эргэн төлбөрийн чадвар муудсанаар том үнийн дүнтэй зээл гаргагч санхүүгийн байгууллагуудын эргэн төлөлт удаашрах, хойшлох, сунгагдах хандлагатай байна. Түүнчлэн хөл хорио тогтоосонтой холбоотойгоор технологийн хөгжүүлэлтгүй санхүүгийн байгууллагуудын хувьд эрсдэлийн төвшин өндөр байх магадлалтай юм.


Харин Мобифинанс ББСБ ХХК-ийн хувьд бизнесийн загвар нь зах зээл дээр тогтворжсон, эрсдэлийн удирдлага чадавхижсан зэрэг нь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагуудтай харьцангуй чанаргүй зээлийн хэмжээ бага байх нөхцөлийг олгох боломжтой гэж харж байна. Өөрөөр хэлбэл оновчтой бизнес загвар, чадавхижсан эрсдэлийн удирдлага нь тус компанийн зах зээл дээр эзлэх байр сууриа хадгалах үндсэн суурь болж өгч байна. Үүнд:

1. Харьцангуй урт хугацааны эх үүсвэрээр богино хугацаат зээл гаргаж буй тул хөрвөх чадварын эрсдэл харьцангуй бага
2. Зах зээл дээр харилцагчдын тооны хувьд тогтворжих мөчлөгтөө орон, харьцангуй чанартай харилцагчдыг бий болгосон
3. Нэг хүнд олгох зээлийн дүн бага
4. Өөрсдийн хөгжүүлсэн хиймэл оюун ухааны тусламжтайгаар харилцагчийн зээлжих чадварын үнэлгээг цаг алдалгүй шинэчилж байгаа
5. Бизнес эрсдэх магадлалтай урт хугацаат уламжлалт зээл рүү зах зээлээ тэлээгүй

### Эх үүсвэр

Санхүүгийн байгууллагуудын хувьд гадаад эх үүсвэрийн дутагдлаас үүдэн эх үүсвэрийн дийлэнх нь богино буюу 1 жил дотор эргэн төлөгдөхөөр байдаг. Энэ нь нөгөө талаас санхүүгийн байгууллагуудын урт хугацаат зээл гаргах боломжийг хязгаарлаж, эх үүсвэрээ дахин санхүүжүүлэх шаардлагыг бий болгодог. Өөрөөр хэлбэл богино хугацаат эх үүсвэрээр урт хугацаат





зээл олгон эх үүсвэрийн байнгын дутагдалтай байдаг санхүүгийн байгууллагуудын хувьд ирэх жилүүдэд хямрах магадлалтай байдаг. Харин үнэт цаас гаргагчийн хувьд үндсэн зээл олголтын төрөл нь 7-30 хоногтой байхад эх үүсвэрийн дийлэнх нь 1 жил хүртэл хугацаатай байдаг нь эх үүсвэрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлснээр мөнгөн урсгалаа зохицуулах боломжийг олгох онцлогтой.

### Эрсдэлийн менежментийн бодлого

Санхүүгийн байгууллага нь зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, багцын эрсдэл, ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл зэрэг олон эрсдэлийг үүрдэг. Ялангуяа санхүүгийн байгууллага нь өндөр хүү амлах тусам эрсдэл өндөр байх магадлалтай байдаг гэдгийг иргэд анхаарч байх нь зүйтэй юм.

### Бизнес төлөвлөгөөний биелэлт

2020 оны цар тахлын эдийн засгийн хүнд үеийн дараагаар эдийн засаг хэвийн байдалд ороход иргэдийн эдийн засгийн хэрэглээ нэмэгдэх магадлалтай байгаа нь бизнес төлөвлөгөөг биелүүлэхэд эерэгээр нөлөөлнө гэж харж байна. Гэвч санхүүгийн байгууллагуудын хувьд эх үүсвэрийн дутмагшил, эргэн төлөлтийн чадавх муудах зэрэг нь хамгийн том бэрхшээл хэвээр байх төсөөлөлтэй байна. Үнэт цаас гаргагчийн хувьд харьцангуй богино хугацааны зээл гаргаж байгаа тул эрсдэх магадлалтай зээлийг маш хурдан илрүүлэх боломжтой бөгөөд, өөрсдийн технологийг ашиглан хэрэглэгчдийн дахин үнэлгээ хийх замаар зээлийн чанараа сайжруулах боломжтой гэж харж байна.

### Технологийн эрсдэл

Санхүүгийн байгууллагын хувьд технологио өөрөө хөгжүүлэх боломжгүй хараат байх нь техникийн алдаа гарах, үйл ажиллагааны эрсдэлд орох зэрэг эрсдэлүүдийг нэмэгдүүлэх боломжтой.

## 7. ДҮГНЭЛТ

Мобифинанс ББСБ ХХК нь Монгол улсад анхны “Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга”-н үйлчилгээ, “Цахим мөнгө”-ний тусгай зөвшөөрлийг авч зах зээлд танилцуулсан, толгой компани болох Мобиком корпорац нь 1995 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулан зөвхөн



өөрийн салбарт тэргүүлэгч байсаар ирсэн төдийгүй мөн бизнесийн цар хүрээ, нийгэмд оруулж байгаа хувь нэмрээрээ Монгол Улсын шилдэг компаниудын эхний эгнээнд шалгарсаар байна.


Зээл олгодог байгууллагын хувьд харилцагчаа танин мэдэх технологи байгаа эсэх, нэг хэрэглэгчдэд олгосон зээлийн дүн өндөр эсэх, зээлийн төвлөрөл өндөр эсэх, эх үүсвэрээ татах чадвар зэрэг үзүүлэлт нь чухал үзүүлэлт байдаг.

Харин Мобифинанс ББСБ нь хэрэглэгч бүрийн төлбөрийн чадварт тохирсон зээлийн үнэлгээг тооцоолох, эрсдэлээ удирдах чадвар зэрэг нь 2020 оны цар тахлыг давж гарсан үзүүлэлтээс харагдаж байна. Андеррайтерийн зүгээс цар тахлын хүнд үеийг оновчтой даван гарсан үзүүлэлтийг дараах хүчин зүйлстэй холбоотой хэмээн үзэж байна.

- Эх үүсвэрийн оновчтой удирдлага
- Эрсдэлийн удирдлага
- Технологийн давуу тал дээр түшиглэн чанартай хэрэглэгчдээ авч үлдэх боломж
- 1 харилцагчид олгосон зээлийн дүн бага
- Байгууллагын хэрэглэгчдэд зээл олголт төвлөрөөгүй тул зээлийн эдийн засагч, зээл олгогчоос хамааралтай буюу зээл олголтонд хүний хүчин зүйл бага байсан

Андеррайтер нь “Нээлттэй бонд”-ыг олон нийтэд санал болгох үр ашгийг дараах байдлаар дүгнэж байна.

1. Олон нийтэд хуримтлалаа төрөлжүүлэн удирдах боломжийг олгох.
2. Олон нийтийн бондын хөрөнгө оруулалтын тухай мэдлэгийг нэмэгдүүлэх.
3. Бондын хөрвөх чадварыг нэмэгдүүлснээр хөрөнгө оруулагчдад өгөөжийн зөрөөний ашиг хүртэх боломж олгох.
4. Нээлттэй арилжаалагдах өрийн бичгийн хүүгийн орлогод ногдох татвар 5 хувь байдаг тул хөрөнгө оруулагчдын хүртэх өгөөж нэмэгдэх.
5. Нээлттэй бонд гаргах сонирхолтой компаниудыг нэмэгдүүлэн, эх үүсвэрийн удирдлагыг хөрөнгийн зах зээл рүү чиглүүлэх.
6. Үнэт цаас гаргагчийн толгой компани болох Топ-10 компаниудын нэг “Мобиком корпораци” ХХК баталгаа гаргаж байгаа нь эргэн төлөгдөх






чадварыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бүрэн хааж байгаа бүтээгдэхүүн.

7. СЗХ-ны шинэчлэн 2021/06/11 өдөр 225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн тухай журам" болон "Компанийн ерийн хэрэгслэлийн тухай журам"-ын зохицуулалтаар анх удаа олон нийтэд санал болгож байгаа.
8. Анхдагч арилжааны захиалга анх удаа андеррайтер төвтэй явах бөгөөд арилжаанд гар утас дээр суурилсан Monpay аппликейшнээр хялбар оролцох боломжийг олгосон.





**4.2 АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ**

Аудитын байгууллагын нэр	Прайс Уотерхаус Куперс Аудит" ХХК
Үйл ажиллагааны чиглэл	Аудитын үйлчилгээ
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Сэнтрал Тауэр, 6 давхар, 601 тоот
Утас	+976-11-314032
Факс	+976-11-312042
Веб хуудас	www.pwc.com

Прайс Уотерхаус Куперс Аудит (PwC) нь дэлхийн 158 улсад салбатай, 284,000 гаруй ажилчидтай, дэлхийн тэргүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч компанийн нэг юм. Тус компани нь 2010 оны 9 сарын 7 өдрөөс эхлээд Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Өдгөө 3 салбар, 90 гаруй ажилтантайгаар эдийн засгийн бүхий л салбарт, гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн аудит, баталгаажуулах үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ, татварын болон хууль эрх зүйн үйлчилгээ, хүний нөөцийн үйлчилгээний цогц шийдлийг санал болгон ажиллаж байна.

PwC нь өөрсдийн хуримтлуулсан мэдлэг, туршлага, шинэлэг арга барилынхаа хүрээнд бизнес эрхлэгчдэд шинэ боломж, зөвлөгөөг өгсөөр ирсэн билээ.

**Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага**


Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.


АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар



124 積田






үгсэн тохиох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.

- Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компани нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Компанийн үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүс болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Аудитын дүгнэлт:






**МОБИФИНАНС ББСБ ХХК**  
(Монгол Улсад бүртгэлтэй)

**Санхүүгийн Тайлагналын Олон Улсын  
Стандартын дагуу бэлтгэсэн  
Санхүүгийн Тайлангууд ба  
Хараат бус Аудиторын Дүгнэлт**

**2020 оны 12 дугаар сарын 31**





**Агуулга**

КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ.....	3
ЗАХИРАЛ БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ.....	4
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН.....	5
<b>САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД</b>	
Санхүүгийн байдлын тайлан .....	8
Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан .....	9
Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
Мөнгөн гүйлгээний тайлан .....	11
<b>САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД</b>	
1. Мобифинанс ба түүний үйл ажиллагаа.....	12
2. Компанийн үйл ажиллагаа явуулж буй орчин .....	12
3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд .....	13
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан үндсэн тооцоолол ба үнэлэлт .....	23
5. Шинэ ба нэмэлт өөрчлөлт орсон стандартууд болон тайлбарууд.....	24
6. Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн мэдэгдлүүд .....	25
7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	26
8. Банкуудад байршуулсан хөрөнгө.....	26
9. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа.....	28
10. Бусад санхүүгийн хөрөнгө.....	31
11. Бусад хөрөнгө .....	32
12. Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөр .....	33
13. Биет бус хөрөнгө .....	33
14. Үндсэн хөрөнгө .....	34
15. Хэрэглэгчдийн барьцаа .....	34
16. Дансны болон бусад өглөг .....	35
17. Урьдчилж орсон орлого.....	35
18. Хувьцаат капитал.....	35
19. Хүүгийн орлого ба зардал.....	36
20. Хураамж, шимтгэлийн орлого ба зардал .....	37
21. Бусад үйл ажиллагааны орлого.....	37
22. Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал.....	37
23. Орлогын албан татварын зардал.....	38
24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага .....	38
25. Капиталын удирдлага.....	44
26. Болзошгүй өр төлбөр ба үүрэг .....	44
27. Бодит үнэ цэнийн тодруулга.....	45
28. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансдын үлдэгдэл .....	47
29. Тайлант хугацааны дараах үйл явдлууд.....	49
30. Монгол хэл дээрх орчуулга.....	49





**КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

**АЛБАН ЁСНЫ ХАЯГ:**

Мобифинанс ББСБ ХХК  
МГМ цогцолбор, ЮНЕСКО-ийн гудамж-28,  
1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 15141, Монгол Улс

**ХУУЛЬЧ:**


Эрдэнэбатын Эрдэнэсүрэн


**ХАРИЛЦАГЧ БАНКУУД:**

Худалдаа Хөгжлийн Банк  
Голомт Банк  
Хаан Банк  
Төрийн банк  
Хас Банк

**АУДИТОРУУД:**

ПрайсуотерхаусКуперс ХХН, Мэдээлэл Аудит ХХК  
Мэргэшсэн нягтлан бодогчид





**ЗАХИРАЛ БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ**

Мобифинанс ББСБ ХХК (цаашид "Компани" гэх)-ийн Гүйцэтгэх захирал ПҮРЭВЦЭРЭНГИЙН ЦЭН-ОЙДОВ болон Санхүүгийн асуудал эрхэлсэн дэд захирал БААТАРЫН ҮНЭНБАТ бид өөрсдийн дүгнэлтээр энэхүү тайлангийн 8-52 дугаар хуудсанд тусгагдсан санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу зөв бодитойгоор илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



**ПҮРЭВЦЭРЭНГИЙН ЦЭН-ОЙДОВ**  
Гүйцэтгэх Захирал

**БААТАРЫН ҮНЭНБАТ**  
Санхүүгийн Асуудал Эрхэлсэн  
Дэд Захирал





**pwc**



## Хараат бус аудиторын тайлан

Мобифинанс ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчид

### Бидний дүгнэлт

Бидний дүгнэлтээр, Мобифинанс ББСБ ХХК ("Компани" гэх)-ийн санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

### Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Компанийн санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангуудын тодруулга.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

### Хараат бус байдал


Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу Компаниас бид хараат бус болно. Бид НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

### ПрайсуотерхаусКуперс ХХН

34 Аль-Фарабийн өргөн чөлөө, А барилга,  
4<sup>th</sup> давхар, 050059, Алматы,  
Казахстан  
Утас: +7 (727) 3303201 Факс: +7 (727) 2446868  
www.pwc.kz

### Мэдээлэл аудит ХХК

505-JDS Барилга, Амарсанаагийн гудамж,  
Баянгол дүүрэг, 17-р хороо,  
Улаанбаатар, Монгол улс  
Утас: +(976) 11 369511 Факс: +(976) 11 369511  
www.monicpa.mn







**pwc**

МЭДЭЭЛЭЛ АУДИТ

**Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангууд бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Компанийн үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Компанийн үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Компанийн засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.


**Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компани нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа





**Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)**

тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Компанийн үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.

- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.



2021 оны 3 дугаар сарын 30  
Алматы, Казахстан



2021 оны 3 дугаар сарын 30  
Улаанбаатар, Монгол



Мянган төгрөгөөр	Тодруулга	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7	2,881,305	2,255,436
Банкуудад байршуулсан хөрөнгө	8	6,108,886	3,041,299
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	9	4,221,498	5,728,626
Бусад санхүүгийн хөрөнгө	10	122,378	14,206
Бусад хөрөнгө	11	24,101	10,343
Хойшлогдсон татварын хөрөнгө		3,944	1,033
Биет бус хөрөнгө	13	60,272	88,662
Үндсэн хөрөнгө	14	16,036	15,013
Ашиглах эрхтэй хөрөнгө	12	118,237	132,045
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>13,556,657</b>	<b>11,286,663</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Хэрэглэгчдийн барьцаа	15	5,653,022	4,401,018
Дансны болон бусад өглөг	16	223,701	105,619
Урьдчилж орсон орлого	17	7,400	309,208
Түрээсийн өр төлбөр	12	128,753	135,393
Орлогын албан татварын өглөг	23	13,370	57,639
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>6,026,246</b>	<b>5,008,877</b>
<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>			
Хувьцаат капитал	18	5,019,860	5,019,860
Хуримтлагдсан ашиг		2,510,551	1,257,926
<b>НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		<b>7,530,411</b>	<b>6,277,786</b>
<b>НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>		<b>13,556,657</b>	<b>11,286,663</b>

Компанийн удирдлагыг төлөөлөн 2021 оны 3 сарын 30-ны өдөр энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав.

УЛААНБААТАР ХОТ  
**МОБИФИНАНС**  
**ББСБ ХХК**  
 Гүйцэтгэх Захирал

**ПҮРЭВЦЭРЭНГИЙН ЦЭЭН-ОЙДОВ**

Гүйцэтгэх Захирал

*(Signature)*

**БААТАРЫН ҮНЭНБАТ**

Санхүүгийн Асуудал Эрхэлсэн  
 Дэд Захирал

Хуудас 12-оос 52-т хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**mobi**  
**finance**  
 УЛААНБААТАР ХОТ  
 МОБИФИНАНС ББСБ ХХК  
 5021101075 ул. 5373271

**mobi**  
 УЛААНБААТАР ХОТ  
 133  
 5021101075 ул. 5373271

УЛААНБААТАР ХОТ 8  
 ӨЛЭНИЙ ЭНД КО  
 КАПИТАЛ ҮЙС  
 ХХК  
 6103055  
 0021031195 ул. СГСМ430


СЭХ  
2021.09.22 өдөр  
БҮРТГЭВ

**Мобифинанс ББСБ ХХК**  
**Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан**

2021-08-31  
БҮРТГЭВ

Мянгаан төгрөгөөр	Тодруулга	2020	2019
Хүүгийн орлого	19	2,225,200	2,315,478
Хүүгийн зардал	19	(20,655)	(232,840)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>		<b>2,204,545</b>	<b>2,082,638</b>
Зээлийн алдагдлын сангийн зардал	9,8,7,10	(258,085)	(374,425)
<b>Зээлийн алдагдлын дараах хүүгийн цэвэр орлого</b>		<b>1,946,460</b>	<b>1,708,213</b>
Хураамж, шимтгэлийн орлого	20	1,707,803	1,615,977
Хураамж, шимтгэлийн зардал	20	(318,800)	(225,685)
Бусад үйл ажиллагааны орлого	21	23,164	370
Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал	22	(1,948,345)	(1,184,585)
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>1,410,282</b>	<b>1,914,290</b>
Орлогын албан татварын зардал	23	(157,657)	(212,752)
<b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН АШИГ</b>		<b>1,252,625</b>	<b>1,701,538</b>
<b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО</b>		<b>1,252,625</b>	<b>1,701,538</b>

Компанийн удирдлагыг төлөөлөн 2020 оны 3 сарын 30-ны өдөр энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав.



ПҮРЭВЦЭРЭНГИЙН ЦЭЭН-ОЙДОВ

Гүйцэтгэх Захирал

БААТАРЫН ҮНЭНБАТ  
Санхүүгийн Асуудал Эрхэлсэн  
Дэд Захирал

Хуудас 12-оос 52-т хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

9







**Мобифинанс ББСБ ХХК  
Өмчийн өөрчлөлтийн тайлан**

Мянган төгрөгөөр	Хувьцаат капитал	ББСБ-ын эздэд хамаарах	
		Хуримтлагдсан ашиг/ (Хуримтлагдсан алдагдал)	Нийт эзэмшигчдийн өмч
2019 оны 1 сарын 1-нээрх үлдэгдэл	5,019,860	(443,612)	4,576,248
Тайлант жилийн ашиг	-	1,701,538	1,701,538
Гаргасан хувьцаа	-	-	-
2019 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	5,019,860	1,257,926	6,277,786
Тайлант жилийн ашиг	-	1,252,625	1,252,625
2020 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	5,019,860	2,510,551	7,530,411

Хуудас 12-оос 49-т хавсаргасан тодруулууд нь энэхүү санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Мөнгөн гүйлгээний тайлан**

Мянаан төгрөгөөр	Тодруулга	2020	2019
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Татварын өмнөх ашиг		1,410,282	1,914,290
<b>Залруулгууд:</b>			
Үндсэн хөрөнгийн элэгдэл ба үнэ цэнийн бууралт	14	13,584	20,318
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	12	13,808	5,772
Биет бус хөрөнгийн хорогдуулалт ба үнэ цэнийн бууралт	13	28,390	28,390
Харилцагчдад олгосон зээлийн хүүгийн орлого	19	(2,165,172)	-
Хүүгийн орлого - бусад орлого	19	(60,028)	-
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	19	20,655	8,950
Зээлийн эрсдэлийн сан	9	256,535	374,425
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	21	(74)	(353)
Валютын ханшийн зөрүү		(20,618)	-
<b>Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		<b>(502,838)</b>	<b>2,351,792</b>
Зээл болон бусад авлагын бууралт/(өсөлт)		1,204,794	(4,432,435)
Бусад санхүүгийн хөрөнгийн (өсөлт)/бууралт		(89,763)	25,500
Бусад хөрөнгийн бууралт/(өсөлт)		(13,758)	17,545
Банкуудад байршуулсан богино хугацаат хадгаламжийн өсөлт		(2,999,992)	(457,643)
Дансны болон бусад өглөгийн бууралт/(өсөлт)		(186,098)	138,089
Хэрэглэгчдийн барьцааны өсөлт		1,252,004	887,671
<b>Ажлын капиталын өөрчлөлт</b>		<b>(1,335,451)</b>	<b>(1,469,266)</b>
Хүлээн авсан хүүгийн орлого		2,203,404	2,276,858
Төлсөн хүүгийн зардал		-	223,890
Төлсөн орлогын албан татвар		(202,465)	(181,401)
<b>Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>665,488</b>	<b>849,888</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Худалдан авсан үндсэн хөрөнгө	14	(14,607)	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		74	540
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(14,533)</b>	<b>540</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Түрээсийн өр төлбөрийн эргэн төлөлт - үндсэн		(27,295)	-
<b>Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(27,295)</b>	<b>-</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд нөлөөлсөн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		2,209	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7	2,255,651	1,405,030
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7	4,381,305	2,255,436

Хуудас 12-оос 49-т хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

11





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулагууд – 2020 оны 12 сарын 31**

**1. Мобифинанс ба түүний үйл ажиллагаа**

Мобифинанс ББСБ ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны санхүүгийн тайлангууд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын ("СТОУС") дагуу бэлтгэгдсэн.

**Үндсэн үйл ажиллагаа.** Компани нь Мобиком Корпораци ХХК (цаашид "Мобиком" гэх)-ийн хэрэглэгчдэд гар утсанд суурилсан цахим мөнгөн гүйлгээний болон зээлийн үйлчилгээг үзүүлдэг. 2010 оны 8 дугаар сард Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийн дагуу Компани үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд зөвшөөрөл хугацаагүй олгогдсон. 2018 оны 9 дүгээр сард Компани нь Монголбанкнаас цахим мөнгө гаргах тусгай зөвшөөрөл авсан. Монголбанкны тусгай зөвшөөрлийн дагуу Компани бусад харилцаа холбооны компаниудын хэрэглэгчдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн. "Кэнди" нь Монгол банкнаас зөвшөөрөгдсөн, тусгай зөвшөөрөлтэй анхны үндэсний цахим төлбөрийн хэрэглүүр юм. 2020 оны 9 дүгээр сард "Кэнди" брэнд нэрээ өөрчлөн "Монпэй" болсон.

**Бүртгэлтэй хаяг болон бизнесийн үйл ажиллагаагаа явуулж буй байршил.** Компани нь Монгол Улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2010 оны 4 сарын 8-ны өдөр байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Компанийн албан ёсны хаяг ба үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг газар нь Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-ийн гудамж-28, МПМ цогцолбор болно. Компанийн цор ганц хувьцаа эзэмшигч нь Мобиком Корпораци ХХК бөгөөд Компанийн толгой компани болно. Мобикомын хувьцаа эзэмшигчид:

- КДДИ Оверсис Холдинг БВ, Нидерланд улсад байгуулагдсан компани (99%);
- Ньюком ХХК, Монгол улсад байгуулагдсан компани (1%).

**Тайлагналын мөнгөн тэмдэгт.** Эдгээр санхүүгийн тайлангууд нь өөрөөр заагаагүй бол мянган Монгол төгрөг ("ТӨГ")-өөр илэрхийлэгдсэн.

**2. Компанийн үйл ажиллагаа явуулж буй орчин**

Монгол улсын инфляци болон хүүгийн түвшний өндөр өсөлт зэрэг нь хөгжиж буй орны эдийн засгийн шинж чанарыг илтгэдэг. Монгол улсын эдийн засаг 2017-2019 оны хооронд дунджаар 6 орчим хувиар өссөн дараа КОВИД-19 цар цахлын сөрөг үр дагавар, өмнө байсан макро эдийн засгийн сул талууд болон тус улс руу орох хөрөнгө оруулалт багассаны улмаас Монгол улсын эдийн засгийн өсөлт хумигдсан байна. Монгол улсын эдийн засаг 2021-2022 онуудад дотоодын хэрэглээ, уул уурхай болон үйлдвэрлэлийн салбарын хөрөнгө оруулалтад илүү хүчтэй түлхэц үзүүлэх замаар 4-өөс дээш хувь хүртэл өсөх хандлагатай байна.


Стандарт энд Пуурс зэрэглэл тогтоогч агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2020 оны 7 сарын 09-ны өдөр "В" буюу тогтвортой зэрэглэлд үнэлсэн. Мөн Мүүди-с олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагын зүгээс Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2020 оны 12 сарын 18-ны өдөр "В" зэрэглэлд ангилсан. "В" зээлжих зэрэглэлийн үнэлгээнд дараах гол хүчин зүйлс нөлөөлж байна: Монгол улсын эдийн засгийн тогтвортой өсөлт, Засгийн газраас удирдаж буй төсвийн сахилга батын сайжруулалт, бараа бүтээгдэхүүний үнэ гэх мэт.

Улмаар, 2020 оны 3-р сарын 12-ны өдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас КОВИД-19 вирусн тархалтыг далхий нийтийн цар тахал гэж зарласан. Цах тахлын хариу арга хэмжээний хүрээнд Монгол Улсын эрх баригчид аялалын хориг, хязгаарлалтууд, хорио цээр тогтоолт, тусгаарлах байрны захиалга, бизнесийн үйл ажиллагааны хязгаарлалт, хилийн хаалт гэх зэрэг КОВИД-19-ийн тархалт, үр нөлөөг хязгаарлахыг зорьсон олон арга хэмжээг авч байна. Эдгээр арга хэмжээ нь Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагааг эрс хязгаарлаж, Монгол Улсын түүхий эд, ашигт малтмалын экспортод сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд цаашид бизнес эрхлэгчид, зах зээлд оролцогчид, Компанийн үйлчлүүлэгчид мөн Монгол Улсын болон дэлхийн эдийн засагт тодорхойгүй хугацаагаар сөргөөр нөлөөлж болзошгүй. КОВИД-19 нь Компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц их хэмжээний нөлөө үзүүлээгүй болно.

Компанийн үйл ажиллагааг тогтвортой байлгах үүднээс удирдлага зардлаа бууруулах, ажилтнуудаа дэмжих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын ирээдүйн үр нөлөөг урьдчилан таамаглахад хэцүү бөгөөд удирдлагын одоогийн хүлээлт, үнэлэлт нь бодит үр дүнгээс ялгаатай байж болох юм.

12





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулууд – 2020 оны 12 сарын 31**

**3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)**

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - хэмжилтийн ангилал.** Компани нь санхүүгийн хөрөнгийг хэмжилтээр нь дараах төрлүүдэд ангилна: Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ ("ААБҮЦ"), Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ ("БДОБУЦ") болон Хорогдуулсан өртөг ("ХӨ"). Санхүүгийн өрийн хэрэглүүрүүдийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) холбогдох хөрөнгүүдийн багцыг удирдах Компанийн бизнесийн загвар (ii) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлогоос хамаарна.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - бизнес загвар.** Бизнес загвар нь Компани санхүүгийн хөрөнгийг мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл Компанийн зорилго нь (i) зөвхөн тухайн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших) эсвэл (ii) хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авахаас болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авахын аль нь вэ гэдгээс хамаарах (гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба худалдах зорилгоор эзэмших) бөгөөд хэрэв (i) ба (ii)-ын аль нь ч биш тохиолдол бол санхүүгийн хөрөнгийг нь "бусад" гэсэн бизнес загварт хамааруулан ангилах ба ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ.


Бизнес загварыг үнэлгээ хийсэн өдрийн байдлаар бэлэн байгаа багцын хувьд тодорхойлсон зорилгод хүрэхийн тулд Компанийн хийж буй үйл ажиллагаанд хамааралтай бүхий л нотолгоонд үндэслэн бүлэг хөрөнгүүдийн (багцын түвшинд) хувьд тодорхойлно. Бизнес загварыг тодорхойлоход Компанийн авч үзсэн хүчин зүйлүүдэд багцын бүрэлдэхүүн болон зорилго, холбогдох хөрөнгүүдийн мөнгөн урсгал хэрхэн цуглуулагдаж байсан талаарх өнгөрсөн үеийн туршлагауд, эрсдэлээ хэрхэн үнэлж удирдаж байгаа, тухайн хөрөнгийн гүйцэтгэлд хэрхэн үнэлгээ хийж, удирдаж байгаа мөн удирдлагыг хэрхэн урамшуулж байгаа зэргийг авч үздэг.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - мөнгөн урсгалын онцлог.** Бизнес загвар нь хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулж, хөрөнгийг эзэмших эсвэл хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөрөөс бүрдэж буй ("ЗҮХТ") эсэхэд Компани үнэлгээ өгдөг. Гэрээт мөнгөн урсгал нь ЗҮХТ-ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуугдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ гэрээт мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд нийцтэй эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг авч үздэг.

Гэрээний нөхцөлүүд нь эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх өөрчлөлтийг харуулж байвал санхүүгийн хөрөнгө нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэж ангилагдана. ЗҮХТ үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа үед дахин хийгдэхгүй.

**Санхүүгийн хөрөнгө – дахин ангилал.** Багцыг удирдаж байгаа бизнес загвар бүхэлдээ өөрчлөгдсөн бол санхүүгийн хэрэглүүрийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес загвар өөрчлөгдсөний дараах хамгийн эхний тайлант үеийн эхнээс хэрэгжинэ. Компани тайлант болон харьцуулах өмнөх хугацаанд бизнесийн загвараа өөрчлөөгүй бөгөөд дахин ангилал хийгээгүй болно.

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт - Хүлээгдэж буй зээлийн алдагдал (ХЗА)–д зориулсан зээлийн алдагдлын сан.** Компани ирээдүйд болох нөхцөл байдлыг авч үзсэний үндсэн дээр хорогдуулсан өртгөөр болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэгддэг өрийн хэрэглүүрүүдийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолдог. Компани тайлагналын өдөр бүр хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжиж зээлийн алдагдлын зардлыг хүлээн зөвшөөрдөг. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжигдэхүүнд: (i) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлогдсон зохистой, магадлалын үндсэнд жинлэсэн дундаж дүнг, (ii) мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, (iii) өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээллүүд зэрэг багтана.







**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)**

Хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн өрийн хэрэглүүрүүд нь санхүүгийн байдлын тайланд хүлээгдэж буй зээлийн алдагдлын (ХЗА) сан хасагдсан цэвэр дүнгээр тусгагддаг. БДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн хувьд ХЗА-ын хасагдуулгыг хассан хорогдуулсан өртгийн өөрчлөлтийн дүн нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд дансны үнийн бусад өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод БДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн гарзыг хассан дүнгээр олз гэж тайлагнагдана.

Компани анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах зээлийн чанарын өөрчлөлтөд үндэслэсэн үнэ цэнийн бууралтын "3 шатлал" бүхий загварыг ашигладаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед ямар нэг үнэ цэнийн бууралтгүй санхүүгийн хэрэглүүр нь "1-р шатлал"-д ангилагдана. 1-р шатлалын санхүүгийн хэрэглүүрийн ХЗА нь ашиглалтын хугацааны хүлээгдэж буй алдагдлын тухайн ногдох хэсэгт, тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл (12 сарын ХЗА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ. Хэрэв Компани анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн ("ЗЭМӨ") гэдгийг тогтоовол хөрөнгийг "2-р шатлал"-д ангилах бөгөөд ХЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх ба энэ нь гэрээ дуусах хүртэл боловч хэрэв байгаа бол хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг авч үзнэ (Ашиглалтын хугацааны ХЗА).

Тодруулга 24-д Компани нь зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг хэрхэн тодорхойлдог талаар тайлбарласан. Хэрэв Компани санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурсан гэж тодорхойлсон бол хөрөнгийг "3-р шатлал" руу шилжүүлэх ба ХЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэнэ. Компанийн зээлийн үнэ цэнэ буурсан хөрөнгийн тодорхойлолт болон үүргээ биелүүлээгүйн тодорхойлолтыг Тодруулга 24-д тайлбарласан. Худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХЗА нь үргэлж хөрөнгийн ашиглалтын хугацааны турш дах ХЗА-тай ижил хэмжигдэнэ. ХЗА-ын загварыг хэмжихэд ашиглагдсан мэдээллүүд, таамаглал болон тооцооллын аргуудыг мөн ХЗА-ын загварт ирээдүйд чиглэсэн мэдээллүүдийг Компани хэрхэн ашигласан талаарх дэлгэрэнгүйг Тодруулга 24-өөс харна уу.

**Санхүүгийн хөрөнгө - данснаас хасах.** Компани санхүүгийн хөрөнгийн нөхөн төлөгдөх үйл ажиллагаа дуусгавар болсон, дахин нөхөн сэргээх үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь данснаас хасдаг. Данснаас хасах нь үл хүлээн зөвшөөрөх үйл явдлыг илэрхийлнэ. Компани гэрээний дагуу төлөгдөх дүнг шаардан авах эрхтэй боловч буцаан олгох магадлал бага үед хууль сахиулах үйл ажиллагаа дуусаагүй зарим санхүүгийн хөрөнгүүдийг данснаас хасдаг.

**Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах.** Компани санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг. (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй. Холбогдох тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

**Санхүүгийн хөрөнгө - өөрчлөлт.** Компани зарим тохиолдолд санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу дахин тохиролцох тохиолдол гардаг. Компани гэрээт мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг дараах зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ; хөрөнгийн эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр гэрээний шинэ зүйл заалт байгаа эсэх, хүүгийн түвшний мэдэгдэхүйц өөрчлөлт, валютын ханшийн өөрчлөлт, шинэ барьцаа эсвэл хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөөлөх зээлийн өсөлт, мөн зээлдэгчийн санхүүгийн хүндрэлд ороогүй байх үе дэх зээлийн сунгалт гэх мэт.





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)**

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгалыг хүчингүй болгож Компани анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бодит үнэ цэнээр нь шинэ хөрөнгөнд хүлээн зөвшөөрнө. Дахин тохиролцоо хийсэн өдөр нь дараа үеийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр болно. Мөн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг харгалзан үзнэ. Мөн Компани шинэ зээл буюу өрийн хэрэглүүр нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөрийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үл хүлээн зөвшөөрөгдсөн анхны хөрөнгийн дансны үнэ болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Дахин тохиролцоо нь нөгөө талын санхүүгийн хүндрэлтэй байдал болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй болсон үед хийгдэж байгаа тохиолдолд Компани хөрөнгийн одоогийн шинэчлэгдсэн мөнгөн гүйлгээ болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж гэрээний өөрчлөлтөөс үүдэлтэй мэдэгдэхүйц өөрчлөгдсөн хөрөнгөнд эрсдэл болон өгөөж байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон өгөөж өөрчлөгдөөгүй бол өөрчилсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөлтгүй гэх ба өөрчлөлтөөс үүдэн үл хүлээн зөвшөөрөлт гарахгүй. Компани нь анхны үр ашигт хүүгийн түвшин (эсвэл худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшин)-г ашиглан өөрчлөгдсөн гэрээт мөнгөн урсгалыг хорогдуулах замаар нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтийн олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн өр төлбөр - хэмжилтийн ангилал.** Санхүүгийн өр төлбөрүүдийг дараахаас бусад тохиолдолд дараа үеийн хорогдуулсан өртгөөр хэмжиж ангилна, үүнд (i) ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн өр төлбөр: энэхүү ангилал нь дериватив, борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (үүнд богино хугацаат үнэт цаас), бизнесийн нэгдэл дэх нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй зүйлс болон анхны хүлээн зөвшөөрөлтөөрөө илэрхийлэгдсэн санхүүгийн өр төлбөр, (ii) мөн санхүүгийн баталгааны гэрээ болон зээлийн амлалтууд хамаарна.

**Санхүүгийн өр төлбөр – бүртгэлээс хасах.** Санхүүгийн өр төлбөр хүчингүй болох үед (өөрөөр хэлбэл гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгэж дууссан, цуцлагдсан эсвэл хугацаа дууссан) бүртгэлээс хасагдана.

Компани болон түүний анхны зээлдэгчдийн мэдэгдэхүйц өөр нөхцөл бүхий өрийн хэрэглүүр болон одоо буй санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт нь анхны санхүүгийн өр төлбөрийг данснаас хасаж, шинэ санхүүгийн өр төлбөр бүртгэх үндэслэл болно. Аливаа төлсөн төлбөр хураамж болон хүлээн авсан төлбөр хураамжийн цэвэр дүнг багтаасан шинэ нөхцөлөөрх мөнгөн гүйлгээний хорогдуулсан өнөөгийн үнэ цэнэ нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх хугацааны мөнгөн гүйлгээний хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээс хамгийн багадаа 10% зөрүүтэй бол мэдэгдэхүйц өөр нөхцөлтэй гэж үзнэ. Өрийн хэрэглүүрийн нөхцөл хугацаа өөрчлөгдсөнөөр хэрэв өрийн хэрэглүүр хүчингүй болсон гэж үзвэл төлсөн төлбөр хураамж болон аливаа зардал нь өрийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөгдсөнөөс үүдсэн олз, гарзаар бүртгэдэг. Харин эсрэг тохиолдолд төлсөн төлбөр хураамжийн зардлын дүнгээр өр төлбөрийн дансны үнийг нэмэгдүүлэх бөгөөд өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдэх хугацааны туршид хорогдуулна.

Дансны үнийн өөрчлөлтийн эдийн засгийн шинж чанар нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд барагдуулаагүй байгаа өр төлбөрийн өөрчлөлтийг хуримтлуулан тооцох аргыг ашиглан тооцоолоход гарсан өөрчлөлт гэж тооцон бүртгэдэг. Үүссэн аливаа олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.** Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө гэдэг нь тодорхой мөнгөний дүнд түргэн хөрвөх чадвартай бөгөөд үнэ цэнийн өөрчлөлтөнд орох мэдэгдэхүйц эрсдэлгүй хөрөнгийг хэлнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд гурван сараас бага хугацаатай банкинд байршуулсан хөрөнгө хамаарна. Санхүүгийн байдлын тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор гурван сараас илүү хугацаагаар хязгаарласан санг мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Учир нь (i) тэдгээр нь гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор байршуулсан бөгөөд энэхүү мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн

17



140





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)**

болон хүүгийн төлбөрийн аргачлалыг (ЗҮХТ) илэрхийлж буй болон (ii) тэдгээр нь Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдоогүй.

Мөнгөн гүйлгээний тайланд толилуулсан мөнгөн орлого зарлага нь Компанийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн шилжилтийг харуулж байгаа бөгөөд үүнд Компанийн хамтрагч талын харилцах данс руу шилжүүлсэн эсвэл хүлээн авсан гүйлгээг багтаасан. Жишээлбэл, хэрэглэгчийн харилцах данснаас суутгасан зээлийн хүүгийн орлого болон үндсэн төлбөр, хэрэглэгчийн харилцах дансанд шилжүүлсэн зээл олголт гэх мэт.

Баталгааны дансны үлдэгдлийг Монголбанкинд тайлагнах зорилгоор Компани нь банкинд байршуулсан хөрөнгийг мөнгөн хөрөнгөнд оруулдаг.

**Банкинд байршуулсан хөрөнгө.** Компани нь харилцагч банкуудад мөнгө шилжүүлэх үед банкинд байршуулсан хөрөнгөөр бүртгэдэг. Банкинд байршуулсан хөрөнгийн хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Учир нь (i) тэдгээр нь гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор байршуулсан бөгөөд энэхүү мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөр (ЗҮХТ)-ийн аргачлалыг илэрхийлж буй болон (ii) тэдгээр нь Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдоогүй.

**Хэрэглэгчдэд олгосон зээл.** Компани нь хэрэглэгчдэд зээл олгосон тохиолдолд хэрэглэгчдэд олгосон зээлийг бүртгэдэг. Бизнесийн загвар болон мөнгөн урсгалын шинж чанарт үндэслэн Компани нь хэрэглэгчдэд олгосон зээлийг дараах хэмжилтийн ангиллуудын аль нэгэнд ангилдаг: (i) гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшдэг бөгөөд энэхүү мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөр (ЗҮХТ)-ийн аргачлалыг илэрхийлж буй ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэхээр заагдаагүй бол хорогдуулсан өртгөөр (ii) ЗҮХТ-ийн шалгуур болон хорогдуулсан өртөг, бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнийн бусад шалгуурыг хангаагүй бол ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр ангилна.

Үнэ цэнийн бууралтын нөөцийг ирээдүйн нөхцөл байдлын таамаглал бүхий ХЗА загварт үндэслэн тодорхойлдог. Тодруулга 24-т ХЗА-ийг хэмжихэд ашигласан мэдээлэл, таамаглал, тооцоолох аргууд болон ирээдүйн нөхцөл байдлын таамаглалыг хэрхэн хэрэглэснийг тайлбарласан.

**Бусад санхүүгийн хөрөнгө.** Бусад санхүүгийн хөрөнгүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх ба дараа нь үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.


**Үндсэн хөрөнгө.** Үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр тооцож тусгана. Урсгал засвар үйлчилгээний өртгийг тухайн үед нь зардал болгож бүртгэнэ.

Бага хэмжээний засвар, өдөр тутмын засвар үйлчилгээний зардлыг гарсан үед зардлаар бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн гол эд ангийг солиход гарсан өртгийг капиталжуулж, хуучин эд ангийг данснаас хасна.

Тайлант хугацааны эцэс бүрт удирдлага нь үнэ цэнэ буурсан шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлдог. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл, удирдлага уг хөрөнгийн нөхөгдөх өртгийг хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулахад гарах зардлыг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь тодорхойлдог. Дансны дүнг нөхөгдөх өртөг хүртэл бууруулж, холбогдох үнэ цэнийн гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэдэг. Хэрэв үндсэн хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс зарахад гарах зардлыг хассан дүнг тооцоолоход ашигласан таамаглалд өөрчлөлт орсноос шалтгаалан үнэ цэнийн бууралт багассан тохиолдолд урд жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцааж болно.

Үндсэн хөрөнгө борлуулсны олз, гарзыг тухайн үеийн бүртгэлийн дүнтэй харьцуулан тооцож тухайн жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.





**Мобифинанс ББСБ ХХК**

**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)**

**Элэгдэл.** Баригдаж буй хөрөнгөнд элэгдэл тооцдоггүй. Үндсэн хөрөнгийн бусад хэсгүүдийн элэгдлийг тооцоходоо хөрөнгийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь доорх ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан хуваарилна:

	<u>Ашиглалтын хугацаа жилээр</u>
Тавилга, эд хогшил, тээврийн хэрэгсэл	10
Компьютер	2 - 3

Компанийн тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны эцэст хэрэв уг хөрөнгө аль хэдийн ашиглагдаж дууссан бол хөрөнгийн борлуулах үнээс холбогдох тооцоолсон зардлуудыг хасч тооцсон дүнг хөрөнгийн үлдэх өртөг гэдэг. Тайлант хугацаа бүрийн эцэст хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг хянаж үзэх ба шаардлагатай бол залруулдаг.

**Ашиглах эрхтэй хөрөнгө.** Компани оффисын барилгыг түрээслэдэг. Гэрээний бүрэлдэхүүнд түрээсийн болон түрээсийн бус гэсэн 2 агуулгыг хамруулан авч үзэж болно. Түрээсийн гэрээний нийт үнийг түрээсийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт үнийн дүнгээс хамааруулан хуваарилдаг. Харин үл хөдлөх хөрөнгийн түрээсийн хувьд түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг салгахгүйгээр түрээсийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгон тооцдог.

Түрээсийн хөрөнгийг анхлан өнөөгийн үнэ цэнийг үндэслэн хэмждэг. Ашиглах эрхтэй хөрөнгийг дараах өртгөөр хэмжинэ:

Ашиглах эрхтэй хөрөнгийг дараах өртгөөр хэмжинэ:

- түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилтийн дүн,
- түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх өдөр болон түүнээс өмнө төлсөн түрээсийн төлбөрүүд (хүлээн авсан аливаа түрээсийн урамшууллыг хассан дүнгээр),
- анхдагч шууд зардал; болон
- түрээсийн гэрээнд заасан нөхцөлд хөрөнгийг нөхөн сэргээх зардал.

Ашиглах эрхтэй хөрөнгийг ихэнхдээ хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль багаар нь шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Хэрэв Компани түрээсийн хөрөнгийг худалдан авах сонголтыг хэрэгжүүлэх үндэслэлтэй байгаа бол ашиглах эрхтэй хөрөнгийг бэлтгэл шаардагдах хөрөнгийн ашиглагдах хугацааг үндэслэн элэгдүүлнэ. Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийг дараах хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан тооцоолдог.

Оффис

Ашиглалтын хугацаа жилээр  
1 - 10

**Биет бус хөрөнгө.** Компанийн биет бус хөрөнгүүдийн ашиглах хугацаа нь тодорхой ба үүнд ихэвчлэн тусгай зөвшөөрөл болон компьютерийн программ хангамж ордог. Бүх биет бус хөрөнгийг тодорхой хугацаагаар ашиглахаар худалдан авсан бөгөөд түүнийг олж авахад зарцуулсан зардал болон ашиглахаар авчрах үед гарсан зардлын дүнгээр хүлээн зөвшөөрдөг.

Биет бус хөрөнгийг ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулна.

Компьютерийн программ хангамж болон бусад биет бус хөрөнгө  
Тусгай зөвшөөрөл

Ашиглалтын хугацаа жилээр  
3-10  
4

Хэрэв үнэ цэнэ буурсан бол биет бус хөрөнгийн дансны өртгийг ашиглалтын үнэ ба бодит үнэ цэнээс хөрөнгийг хасахтай холбоотой зардлыг хассан дүнгийн хамгийн их дүнгээр нь бууруулан бүртгэнэ.

**Хэрэглэгчдийн барьцаа.** Хэрэглэгчдийн барьцаа нь хувь хүн болон аж ахуйн нэгжүүдэд төлөх үүсмэл бус өр төлбөр бөгөөд хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Компани нь Монголбанкнаас олгосон лицензийн дагуу цахим мөнгө гаргах эрхтэй. Хэрэглэгчдийн барьцаа нь цахим мөнгө авахын тулд хэрэглэгчдийн хадгалуулсан бэлэн мөнгө бөгөөд Компаниас гаргасан цахим мөнгө гэж үзэж болно.

19





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)**

- баталгаат үлдэх өртгийн дагуу Компанийн төлөхөөр тооцоолж буй дүн;
- худалдан авах сонголтгоо Компани хэрэгжүүлэх нь ул үндэслэлтэй тодорхой бол тэрхүү сонголтыг хэрэгжүүлэх; болон
- түрээсийн гэрээнд Компани түрээсийн хугацааг цуцлах эрхтэй үед түрээсийн гэрээг цуцлахад үүсэх торгууль.

Компанийн хэмжээнд ихэнх хөрөнгө болон тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээнүүдэд түрээсийн хугацааг сунгах, дуусгавар болгох эрхийг багтаасан байдаг. Эдгээр нь компанийн үйл ажиллагаанд ашиглах хөрөнгийг удирдахад үйл ажиллагааны уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд хэрэглэгддэг. Ихэнх тохиолдолд түрээслүүлэгч бус Компани түрээслэж буй хөрөнгийн хугацааг сунгах болон цуцлах сонголтыг хийх боломжтой. Гэрээ сунгах сонголтыг (эсвэл түрээсийн хугацаа дууссаны дараа) түрээс нь сунгагдах (эсвэл цуцлагдахгүй тохиолдолд) нь бодитойгоор хэрэгжих боломжтой тохиолдолд гэрээний нөхцөлд оруулна.

Түрээсийн өр төлбөрийн хэмжихдээ түрээсийн төлбөрт тодорхой үндэслэлтэй сунгах сонголтуудыг мөн багтаасан болно.

Түрээсийн төлбөрүүдийг түрээсийн нуугдмал хүүгийн түвшинг ашиглан хорогдуулах ба хэрвээ энэ түвшинг хялбархан тогтоох боломжгүй бөгөөд энэ нь ихэнхдээ Компанийн түрээст тохиолддог бол компанийн өсөн нэмэгдэх зээлийн хүүний түвшинг ашиглана. Энэ нь Компани эдийн засгийн ижил төстэй нөхцөл байдалд (хугацаа, барьцаа хөрөнгө болон нөхцөл) ашиглах эрхтэй хөрөнгөтэй ижил төстэй өөр хөрөнгийг худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг ижил төстэй нөхцөлөөр зээлэх үед төлөх зээлийн хүүгийн түвшинг хэлнэ. Өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн түвшинг тодорхойлохын тулд Компани:

- боломжтой бол гуравдагч талын санхүүжилт хүлээн авснаас хойш санхүүгийн нөхцөлд гарсан өөрчлөлтийг тусгаж тохируулсан эхлэл болгон хувь хүн түрээслэгчээс хүлээн авсан санхүүжилтийг ашиглана.
- зээлийн эрсдэлд тохируулсан, эрсдэлгүй хүүгийн түвшний аргыг ашиглах;
- түрээсийн талаарх зарим зохицуулалт хийх, ж.нь. хугацаа, улс орон, валют, барьцаа хөрөнгө г.м

Компани нь түрээсийн төлбөр хүчин төгөлдөр болоход тухайн түрээсэлж байгаа хөрөнгө нь бие даасан шинжтэй гэж үзэн түрээсийн гэрээг түрээсийн гэрээний эхний өдөр ирээдүйд төлөгдөх индекс болон түрээсийн үе тутмын төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн хөрөнгө болон өр төлбөр үүсгэн бүртгэнэ. Индекс эсвэл хувь дээр суурилсан түрээсийн төлбөрт хийсэн өөрчлөлтүүд нь түрээсийн төлбөрийг дахин ашиглах, ашиглах эрхийн хөрөнгөөр тохируулна.

Түрээсийн төлбөрийг өр төлбөрийн үндсэн дүн ба санхүүгийн зардлын хооронд хуваарилдаг. Санхүүгийн зардал нь түрээсийн хугацааны туршид ашиг алдагдлаар тусгагдах бөгөөд тайлант хугацаа бүрд үе тутмын хүүгийн зардлаар түрээсийн өр төлбөрийн үлдэгдэлд тусгагдана.

Богино хугацаатай түрээсийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл болон бага өртөг бүхий бүх төрлийн хөрөнгийн түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар хуваарилан ашиг алдагдалд зардлаар хүлээн зөвшөөрнө. Түрээсийн хугацаа нь 12 сар ба түүнээс бага бол богино хугацааны түрээс байдаг. Бага өртөгтэй хөрөнгөд МТ-ийн төхөөрөмжүүд, таван мянган ам.доллар ба түүнээс доош үнэтэй оффисын тавилга, эд хогшил гэх мэт хөрөнгүүд багтдаг.

Гэрээний хугацаанд түрээсийн зардлыг оновчтой болгохын тулд Компани тоног төхөөрөмжийн түрээсийн түрээстэй холбоотой үлдэгдлийн үнийн баталгааг гаргаж өгдөг. Компани түрээсийн өр төлбөрийн хэсэг болох баталгааны үлдэх өртөгт хамаарах төлөхөөр хүлээгдэж буй дүнг анхлан тооцоолж, хүлээн зөвшөөрдөг. Ихэвчлэн түрээсийн эхлэх үед хүлээгдэж буй үлдэгдэл үнэ нь баталгааны дүнтэй тэнцүү эсвэл түүнээс их байдаг тул Компани баталгааны дагуу ямар нэгэн төлбөр төлөхгүй. Тайлангийн хугацааны эцэст хүлээгдэж буй үлдэгдлийн утгыг харьцуулж үзэх хөрөнгө болон ирээдүйн үнийн талаарх хүлээлтэд хүрч бодит үлдэгдэл дүнг тусгахын тулд хянаж, шаардлагатай бол тохируулна.

21





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулууд – 2020 оны 12 сарын 31**

**3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)**

**Хувьцаат капитал.** Энгийн хувьцааг эзэмшигчдийн өмчид тусгана. Шинээр энгийн хувьцаа гаргахтай шууд холбогдон гарсан нэмэгдэл зардлыг өөрийн хөрөнгийн хэсгийн энгийн хувьцааны сөрөг тохируулах данс байдлаар, татварын дараах цэвэр дүнгээр харуулна. Гаргасан хувьцааны нэрлэсэн үнээс хүлээн авсан төлбөр болох бодит үнэ цэнээс илүү гарсан дүнг нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэдэг.

**Ногдол ашиг.** Ногдол ашгийг өр төлбөр гэж бүртгэх ба ногдол ашиг зарлагдсан буюу батлагдсан тайлант хугацаанд өөрийн хөрөнгөнөөс хасаж бүртгэнэ. Тайлант хугацаа дуусгавар болсны дараа санхүүгийн тайлан батлагдахаас өмнө зарлагдсан ногдол ашгийг "тайлант хугацааны дараа болсон үйл явдал" гэсэн тодруулгад тусгадаг.

**Хүүгийн орлого ба зардлын хүлээн зөвшөөрөлт.** Хүүгийн орлого, зардлыг бүх өрийн хэрэглүүрийн хувьд аккруэл сууриар үр ашигт хүүгийн аргаар бүртгэнэ. Энэ аргаар үр ашигт хүүний салшгүй хэсэг болох гэрээний талуудын хооронд төлсөн буюу хүлээн авсан бүх төлбөрийг хүүний орлого, зардлын нэг хэсэг гэж үзэж хойшлуулна.

Санхүүгийн хөрөнгө үүсгэх буюу олж авах, санхүүгийн өр төлбөр гаргахтай холбоотой төлөгдсөн эсвэл хүлээн авсан төлбөр нь үр ашигт хүүгийн хувьтай холбоотой төлбөрт багтана, жишээ нь зээлжих чадварын үнэлгээний төлбөр, үнэлгээний болон бүртгэлийн хураамж гэх мэт.

Худалдан авсан эсвэл анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнэ буурсан хөрөнгийн хувьд, үр ашигт хүүгийн түвшин нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг (анхны хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулаад) анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэ (худалдан авах үнээр илэрхийлэгддэг) рүү дискантчилсан хүүний түвшин байна. Улмаар үр ашигт хүүгийн түвшин нь зээлийн эрсдэлд тохируулагддаг.

Хүүгийн орлогыг дараахаас бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгийн дансны нийт үнээс үр ашигт хүүний түвшингээр тооцоолно: (i) санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтанд орсон (3-р шатлал) бол хүүгийн орлогыг тооцохдоо хорогдуулсан өртгийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хассан цэвэр дүнгээс үр ашигт хүүний түвшингээр тооцоолно, (ii) худалдан авсан эсвэл анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд хорогдуулсан өртгөөс тохируулсан үр ашигт хүүний түвшингээр тооцоолно.

**Хураамж, шимтгэлийн орлого.** Шимтгэл хураамжийн орлогыг ихэвчлэн үндсэн ажил гүйлгээг гүйцэтгэх үед буюу Компани нь үүргээ биелүүлэх үед тухайн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Хүлээн авсан шимтгэл хураамжийн үнийн дүн эсвэл авлага нь гүйцэтгэлийн үүргийн хувьд ялгаатай үйлчилгээнүүдийн үнийг илэрхийлнэ.


Компани нь Монпэй цахим мөнгөний үйлчилгээгээр дамжуулан Мобиком компанийн хэрэглэгчдийн хийсэн гүйлгээнээс шимтгэлийн орлого олдог. Бусад олон байгууллагуудын өмнөөс Компани энэхүү үйлчилгээг үзүүлдэг.

**Идэвхтэй харилцагчийн орлого.** Компани нь Мобикомын Монпэй идэвхтэй хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлснийхээ төлөө сар бүр 500 төгрөгийн шимтгэлийн орлого олдог. Энэхүү орлогыг тухайн хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

**Шимтгэлийн орлого.** Монпэй үйлчилгээний хэрэглэгчид бэлэн мөнгөө цахим мөнгө рүү хөрвүүлэх, цахим мөнгөө бэлэн мөнгө рүү хөрвүүлэх, цахим мөнгөний шилжүүлэг, цахим мөнгөний гүйлгээний хуулга авах, цахим мөнгөний дансны үлдэгдэл шалгах, дансны тодорхойлолт авах зэрэг үйлчилгээ авдаг. Компани дээрх гүйлгээ бүрээс шимтгэлийн орлого олдог. Энэхүү орлогыг тухайн хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

Монпэй үйлчилгээний хэрэглэгчид Мобикомын GSM утасны дугаарыг сүүлийн 6 сар дараалан ашиглаагүй тохиолдолд идэвхгүй хэрэглэгчийн төлөвт шилждэг. Компани нь долоо дах сараас эхлэн тэдгээр идэвхгүй хэрэглэгчдээс сар бүр 500 төгрөгийн (дансны үлдэгдэл 500 төгрөгөөс бага болсон тохиолдолд тухайн үлдэгдлийн дүнгээр) шимтгэлийн орлого олдог.





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулагууд – 2020 оны 12 сарын 31**

**3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (Үргэлжлэл)**

**Хураамж, шимтгэлийн зардал.** Хураамж, шимтгэлийн орлогын дагуу гарсан зардал нь Хураамж, шимтгэлийн зардалаар хүлээн зөвшөөрөгдөнө.

**Мерчант, агенттай холбоотой зардал.** Мобиком Корпораци ХХК-аас цахим худалдаатай холбоотой аутсорсингийн зардал (цахим мөнгө болон зээлийн үйлчилгээтэй холбоотой харилцагчийн болон дуудлагын төвийн үйлчилгээ) -ыг мерчант, агенттай холбоотой зардлаар хүлээн зөвшөөрнө.

**Бусад банкны шимтгэл.** Хэрэглэгч нь цахим мөнгөө бэлэн мөнгө рүү хөрвүүлэхдээ банкны гүйлгээгээр дамжуулан өөрийн банкны данс руу цахим мөнгөө шилжүүлсэн тохиолдолд гүйлгээний хураамж төлдөг. Банкны данснаасаа цахим мөнгө рүү хөрвүүлэх банкны гүйлгээ бүрт Компани нь арилжааны банкуудад шимтгэл төлдөг бөгөөд бусад банкинд төлсөн шимтгэл гэж хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

**Санхүүгийн хэрэглүүрүүдийг хооронд нь хаах.** Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэх нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө. Энэхүү хооронд нь хаах эрх нь (а) ирээдүйд болох үйл явдлын болзошгүй төлбөр

биш байх, (б) дараах тохиолдол бүрийг хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжтой байх ёстой. Үүнд: (i) бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед (ii) төлбөр төлөгдөхгүй болох үед (iii) төлбөрийн чадваргүй болж дампуурсан үед бий болдог.

**Ажиллагсадын зардал ба тэтгэмж.** Цалин хөлс, Монгол улсын тэтгэврийн сан ба нийгмийн даатгалын санд шилжүүлэх шимтгэл, зэлжийн амралт, өвчтэй байсан хугацааны тэтгэмж, шагнал, түүнчлэн мөнгөн бус хөнгөлөлтүүдийг Компанийн албан хаагчдад тухайн холбогдох үйлчилгээг үзүүлсэн тайлант хугацаанд тооцож, хүлээн зөвшөөрдөг. Компанийн хуулинд зааснаас өөр ижил төрлийн тэтгэвэр болон тэтгэмжийн төлбөр төлөх ямар нэгэн эрх зүйн эсвэл үүсмэл үүрэг хүлээгээгүй болно.

**Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг хөрвөх чадварын байдлаар нь толилуулах.** Компани нь тодорхой зааглагдсан үйл ажиллагааны мөчлөг байхгүй учраас эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд тусад нь тусгадаггүй. Харин хөрөнгө ба өр төлбөрийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулдаг. Санхүүгийн хэрэглүүрүүдийг дуусгавар болох хугацаагаар нь ангилсан шинжилгээг Тодруулга 24-өөс харна уу.


**4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан үндсэн тооцоолол ба үнэлэлт**

Компани нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүд болон дараагийн санхүүгийн тайлант жилийн хөрөнгө болон өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд нөлөө үзүүлэх үнэлэлт болон тооцооллыг хийдэг. Тооцоолол болон үнэлэлтүүд нь үргэлж хянагддаг бөгөөд удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдэд суурилдаг.

Удирдлага нь тооцоололд үнэлэлт хийхийн зэрэгцээ нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцыг мөн үнэлдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд хамгийн мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд мэдэгдэхүйц залруулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлс хамаарна:

**Тасралтгүй байх зарчим.** Удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг үл тасалдах зарчимд тулгуурлан бэлтгэсэн. Энэ үнэлэлтийг хийхдээ удирдлага нь Компанийн санхүүгийн байдал, одоогийн хандлага, үйл ажиллагааны ашигтай байдал болон санхүүгийн эх үүсвэрүүдэд нэвтрэх, Компанийн үйл ажиллагаанд санхүүгийн зах зээлийн нөхцөлийн нөлөөллийг авч үзсэн.

23





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө	874	874
Банкин дахь харилцах данс	2,883,848	1,754,777
3 сар хүртэлх хугацаатай хадгаламж	-	500,000
Хасах нь: эрсдэлийн сан	(3,417)	(215)
<b>Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>2,881,305</b>	<b>2,255,436</b>

ХЗА хэмжих зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг 1-р шатлалд хамруулсан. Эдгээр дансны үлдэгдэл дүнд тооцсон ХЗА нь бага хэмжээний үл нөлөөлөхүйц дүнтэй болно.

Дараах хүснэгтэд 2020 болон 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн хөндлөнгийн үнэлгээний байгууллагын (Мүүдийн) эрсдэлийн зэрэглэлд үндэслэсэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийн зээлжилтийн чанарыг харуулав:

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Хугацаа хэтрээгүй буюу үнэ цэнэ буураагүй		
- ВЗ	2,883,848	2,254,777
<b>Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, бэлэн мөнгийг хассан дүн</b>	<b>2,883,848</b>	<b>2,254,777</b>


**8. Банкуудад байршуулсан хөрөнгө**

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
3-аас дээш сарын хугацаатай хадгаламж	6,136,368	3,068,773
Хасах нь: эрсдэлийн сан	(27,482)	(27,474)
<b>Нийт бусад банкуудад байршуулсан хөрөнгө</b>	<b>6,108,886</b>	<b>3,041,299</b>

Компани нь банкны зах зээлд идэвхтэй оролцдог тул бусад санхүүгийн байгууллагуудтай эрсдэлийн томоохон төвлөрөлтэй байдаг. Нийт санхүүгийн байгууллагууд дах учирч болзошгүй эрсдэл 6,136,368 мянган төгрөг (2019: 3,068,773 мянган төгрөг) ба энэ нь банкинд байршуулсан бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хадгаламж болон бусад дүнгээс бүрдэнэ гэж тооцоолсон.







**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**8. Банкуудад байршуулсан хөрөнгө (Үргэлжлэл)**

Дараах хүснэгтэд 2020 болон 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн хөндлөнгийн үнэлгээний байгууллагын (Мүүдийг) эрсдэлийн зэрэглэлд үндэслэн банкуудад байршуулсан хөрөнгийн үлдэгдлийн зээлжилтийн чанарын шинжилгээг харууллаа. Эдгээр дансдын үлдэгдэл нь тухайн хөрөнгүүдийн хувьд зээлийн эрсдэлд хамгийн их өртөх дүнг илэрхийлнэ.

	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр	Шатлал 1 (12-сарын ХЗА)	Шатлал 1 (12-сарын ХЗА)
<b>Банкинд байршуулсан хөрөнгө</b>		
- ВЗ	6,136,368	3,068,773
Хасах нь: эрсдэлийн сан	(27,482)	(27,474)
<b>Банкуудад байршуулсан хөрөнгийн нийт дүн</b>	<b>6,108,886</b>	<b>3,041,299</b>


Дараах хүснэгтэнд банкинд байршуулсан хөрөнгийн дансны нийт дүн болон эрсдэлийн сангийн жилийн эхнээс жилийн эцсийн хоорондох өөрчлөлтийг тайлбарласан болно.

Мянган төгрөгөөр	Эрсдэлийн сан	Дансны нийт дүн
	1-р шатлал (12-сарын ХЗА)	1-р шатлал (12-сарын ХЗА)
2020 оны 1 сарын 1-нд	27,474	3,068,773
Эрсдэлийн санд нөлөөлөх шилжилт хөдөлгөөн:		
Шинээр үүссэн эсвэл худалдан авсан ХЗА-ын өөрчлөлт	-	3,000,000
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	8	-
	-	67,595
<b>Тайлант хугацааны нийт эрсдэлийн санд нөлөөлөх шилжилт хөдөлгөөн</b>	<b>8</b>	<b>3,067,595</b>
Эрсдэлийн санд нөлөөлөхгүй шилжилт хөдөлгөөн:		
Данснаас хассан	-	-
<b>2020 оны 12 сарын 31-нд</b>	<b>27,482</b>	<b>6,136,368</b>



*Handwritten signature*





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**8. Банкуудад байршуулсан хөрөнгө (Үргэлжлэл)**

Мянган төгрөгөөр	Эрсдэлийн сан	Дансны нийт дүн
	1-р шатлал (12-сарын ХЗА)	1-р шатлал (12-сарын ХЗА)
2019 оны 1 сарын 1-нд	480	3,068,118
Эрсдэлийн санд нөлөөлөх шилжилт хөдөлгөөн:		
Шинээр үүссэн эсвэл худалдан авсан ХЗА-ын өөрчлөлт	26,994	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	-	655
<b>Тайлант хугацааны нийт эрсдэлийн санд нөлөөлөх шилжилт хөдөлгөөн</b>	<b>26,994</b>	<b>655</b>
Эрсдэлийн санд нөлөөлөхгүй шилжилт хөдөлгөөн:		
Данснаас хассан	-	-
<b>2019 оны 12 сарын 31-нд</b>	<b>27,474</b>	<b>3,068,773</b>

**9. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа**

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Харилцагчдад олгосон хорогдуулсан өртгөөрх зээл болон урьдчилгааны дансны нийт дүн	4,913,865	6,237,228
Хасах нь: зээлийн алдагдлын сан	(692,367)	(508,602)
<b>Харилцагчдад олгосон хорогдуулсан өртгөөрх зээл болон урьдчилгааны нийт дүн</b>	<b>4,221,498</b>	<b>5,728,626</b>

Компани гар утсанд суурилсан зээлийг хэрэглэгчдэд мессежээр ("SMS") дамжуулан олгодог. SMS зээлийг бас Монпэй зээл гэж нэрлэдэг ба нэг ба 2 сарын хугацаатай, зээлийн үндсэн дүнгээс хамааран сарын 1.9 – 3.4 хүртэлх хувийн хүүтэй.

2019 болон 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх зээлийн зээлжилтийн чанарын шинжилгээг доор харуулав:

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
<b>Хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ буураагүй</b>	<b>3,964,949</b>	<b>5,389,538</b>
<b>Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнэ буураагүй:</b>		
- 30 хүртэлх хоногоор хэтэрсэн	71,638	171,632
- 30 аас 90 хоногоор хэтэрсэн	51,979	148,452
<b>Хугацаа хэтэрсэн, үнэ цэнэ буурсан:</b>		
- 91 ээс 180 хоногоор хэтэрсэн	185,479	140,172
- 181 ээс 360 хоногоор хэтэрсэн	201,046	221,355
- 360 хоногоос дээш хэтэрсэн	438,781	166,079
<b>Дансны нийт дүн</b>	<b>4,913,865</b>	<b>6,237,228</b>
<b>Хасах нь: Зээлийн алдагдлын сан</b>	<b>(692,367)</b>	<b>(508,602)</b>
<b>Нийт дүн</b>	<b>4,221,498</b>	<b>5,728,626</b>





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**9. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа (Үргэлжлэл)**


Дараах хүснэгтэд ХЗА-ын хасагдуулгыг Компанийн дотоодын зээлийн үнэлгээний журмын дагуу хүлээн зөвшөөрч бүртгэсэн ХӨ-өөр хэмжсэн, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны зээлийн эрсдэлд өртөх байдлын шинжилгээг харуулав. Дотоодын зээлийн үнэлгээний шалгуурыг дотооддоо тодорхойлсон зээлийн эрсдэлийн үндсэн хэмжүүрт тохируулсныг Тодруулга 24-өөс харна уу. Мөн доорх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны дансны дүн нь Компанийн зээлийн эрсдэлд хамгийн их өртөхг хэмжээг илэрхийлнэ. 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх хорогдуулсан өртгөөр хэмжсэн, харилцагчдад олгосон зээлийн зээлжилтийн чанарыг харуулбал:

Мянган төгрөгөөр	1-р шатлал (12 сарын ХЗА)	2-р шатлал (ЗЭМӨ ашиглалтын хугацааны ХЗА)	3-р шатлал (үнэ цэнэ буурсан ашиглалтын хугацааны ХЗА)	Нийт дүн
<b>Мессеж зээл:</b>				
Маш онцгой	206,568	4,028	-	210,596
Онцгой	2,357,906	54,517	510,269	2,922,692
Маш сайн	1,036,334	40,051	220,847	1,297,232
Сайн	364,141	25,021	59,221	448,383
Сул	-	-	34,600	34,600
<b>Мобиекспресс зээл:</b>				
Сул	-	-	362	362
<b>Дансны нийт дүн</b>	<b>3,964,949</b>	<b>123,617</b>	<b>825,299</b>	<b>4,913,865</b>
<b>Зээлийн алдагдлын хасагдуулга</b>	<b>25,532</b>	<b>18,686</b>	<b>648,149</b>	<b>692,367</b>
<b>Дансны дүн</b>	<b>3,939,417</b>	<b>104,931</b>	<b>177,150</b>	<b>4,221,498</b>

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх хорогдуулсан өртгөөр хэмжсэн, харилцагчдад олгосон зээлийн зээлжилтийн чанарыг харуулбал:

Мянган төгрөгөөр	1-р шатлал (12 сарын ХЗА)	2-р шатлал (ЗЭМӨ ашиглалтын хугацааны ХЗА)	3-р шатлал (үнэ цэнэ буурсан ашиглалтын хугацааны ХЗА)	Нийт
<b>Мессеж зээл:</b>				
Маш онцгой	173,199	3,428,189	300,487	3,901,875
Онцгой	98,743	1,276,509	155,211	1,530,463
Маш сайн	26,992	442,214	40,007	509,213
Сайн	17,489	212,585	27,395	257,469
Сул	3,661	30,041	4,044	37,746
<b>Мобиекспресс зээл:</b>				
Сул	-	-	462	462
<b>Дансны нийт дүн</b>	<b>320,084</b>	<b>5,389,538</b>	<b>527,608</b>	<b>6,237,228</b>
<b>Зээлийн алдагдлын хасагдуулга</b>	<b>17,861</b>	<b>51,222</b>	<b>439,519</b>	<b>508,602</b>
<b>Дансны дүн</b>	<b>302,223</b>	<b>5,338,316</b>	<b>88,087</b>	<b>5,728,626</b>





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**9. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа (Үргэлжлэл)**

Компани нь барьцаа хөрөнгө авахгүйгээр зээл олгодог. 2020 оны 12 сарын 31 болон 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн, харилцагчдад олгосон зээлийн мэдээллийг дараах хүснэгтэнд үзүүлэв:


Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Барьцаагүй зээл	4,913,865	6,237,228
Нийт ХӨ-өөрх харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны дансны нийт дүн (ХӨ-өөрх зээлийн ангилал тус бүрээрх эрсдэлд өртөх магадлалын дүн)	4,913,865	6,237,228

Харилцагч зээлээ эргэн төлөхгүй тохиолдолд харилцагчийн Монпэй дансандаа байршуулсан бэлэн мөнгө (Монпэй цахим мөнгө)-ийг харилцагчийн зээлийн үлдэгдэл дүнд хаадаг.

**10. Бусад санхүүгийн хөрөнгө**

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
<i>Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад санхүүгийн хөрөнгө</i>			
Гуравдагч талын харилцагчтай байгуулсан гэрээнээс үүссэн дансны авлага		107,146	10,367
Холбоотой талын харилцагчтай байгуулсан гэрээнээс үүссэн дансны авлага	28	16,194	6,459
Хасах нь: алдагдлын сан хасагдуулга		(962)	(2,620)
<b>ХӨ-өөр хэмжигдэх бусад санхүүгийн хөрөнгийн нийт дүн</b>		<b>122,378</b>	<b>14,206</b>





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулагууд – 2020 оны 12 сарын 31**

**10. Бусад санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)**


2019 болон 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх бусад санхүүгийн хөрөнгийн чанарын шинжилгээг доор харуулав:

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2020 оны 12 сарын 31
Хуацаа хэтрээгүй, үнэ цэнэ буураагүй	112,781	66
Хуацаа хэтэрсэн боловч үнэ цэнэ буураагүй:		
- 30 хүртэлх хоногоор хэтэрсэн	1,285	7,348
- 30 аас 90 хоногоор хэтэрсэн	294	175
Хуацаа хэтэрсэн, үнэ цэнэ буурсан:		
- 91 ээс 180 хоногоор хэтэрсэн	2,010	6,106
- 181 ээс 360 хоногоор хэтэрсэн	1,930	1,653
- 360 хоногоос дээш хэтэрсэн	5,040	1,478
<b>Дансны нийт дүн</b>	<b>123,340</b>	<b>16,826</b>
Хасах нь: Алдагдлын сан хасагдуулга	(962)	(2,620)
<b>Нийт дүн</b>	<b>122,378</b>	<b>14,206</b>

**11. Бусад хөрөнгө**

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Урьдчилгаа төлбөр	23,684	8,160
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа	417	2,183
<b>Бусад эргэлтийн хөрөнгийн нийт дүн</b>	<b>24,101</b>	<b>10,343</b>





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**12. Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөр**

Компани оффис түрээсэлдэг. Түрээсийн гэрээг ихэвчлэн 12 сараас 10 жилийн тогтмол хугацаатайгаар байгуулдаг.

Ашиглах эрхтэй хөрөнгийг доорх байдлаар ангилан харуулав:

Мянган төгрөгөөр	Оффис	Нийт
<b>ӨРТӨГ</b>		
<b>2019 оны 1 сарын 1</b>	-	-
Нэмэгдсэн	137,817	137,817
<b>2019 оны 12 сарын 31</b>	137,817	137,817
Нэмэгдсэн	-	-
<b>2020 оны 12 сарын 31</b>	137,817	137,817
<b>ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ</b>		
<b>2019 оны 1 сарын 1</b>	-	-
Элэгдлийн зардал	(5,772)	(5,772)
<b>2019 оны 12 сарын 31</b>	(5,772)	(5,772)
Элэгдлийн зардал	(13,808)	(13,808)
<b>2020 оны 12 сарын 31</b>	(19,580)	(19,580)
<b>2019 оны 12 сарын 31-нээрх дүн</b>	132,045	132,045
<b>2020 оны 12 сарын 31-нээрх дүн</b>	118,237	118,237

2020 оны санхүүгийн зардалд 20,655 мянган төгрөгийн хүүгийн зардал, Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардалд 13,808 мянган төгрөгийн элэгдлийн зардал тус тус бүртгэсэн.

Компани түрээсийн өр төлбөрийг доорх байдлаар хүлээн зөвшөөрсөн:

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Богино хугацаат түрээсийн өр төлбөр	7,096	6,074
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	121,657	129,319
<b>Нийт түрээсийн өр төлбөр</b>	<b>128,753</b>	<b>135,393</b>

**13. Биет бус хөрөнгө**

Мянган төгрөгөөр	2020	2019
<b>ӨРТӨГ</b>		
<b>1 сарын 1-нээр</b>	<b>154,587</b>	<b>154,587</b>
Нэмэгдсэн	-	-
<b>12 сарын 31-нээр</b>	<b>154,587</b>	<b>154,587</b>
<b>ХУРИМТЛАГДСАН ХОРОГДУУЛАЛТ</b>		
<b>1 сарын 1-нээр</b>	<b>65,925</b>	<b>37,635</b>
Тайлант жилийн хорогдуулалт	28,390	28,390
<b>12 сарын 31-нээр</b>	<b>94,315</b>	<b>66,025</b>
<b>ДАНСНЫ ЦЭВЭР ҮНЭ</b>	<b>60,272</b>	<b>88,662</b>





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулууд – 2020 оны 12 сарын 31**

**14. Үндсэн хөрөнгө**

Мянган төгрөгөөр	Тавилга эд хогшил	Компьютер	Нийт
<b>ӨРТӨГ</b>			
2019 оны 1 сарын 1	14,317	99,095	113,412
Нэмэгдсэн	-	-	-
Хасагдсан	(5,017)	(21,490)	(26,507)
2019 оны 12 сарын 31	9,300	77,605	86,905
Нэмэгдсэн	-	14,607	14,607
Хасагдсан	(1,476)	(1,089)	(2,565)
2020 оны 12 сарын 31	7,824	91,123	98,947
<b>ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ</b>			
2019 оны 1 сарын 1	10,284	67,610	77,894
Тайлант хугацааны элэгдлийн зардал	982	19,336	20,318
Хасагдсан	(4,924)	(21,396)	(26,320)
2019 оны 12 сарын 31	6,342	65,550	71,892
Тайлант хугацааны элэгдлийн зардал	759	12,825	13,584
Хасагдсан	(1,476)	(1,089)	(2,565)
2020 оны 12 сарын 31	5,625	77,286	82,911
<b>ДАНСНЫ ЦЭВЭР ҮНЭ</b>			
2019 оны 12 сарын 31	2,958	12,055	15,013
2020 оны 12 сарын 31	2,199	13,837	16,036

**15. Хэрэглэгчдийн барьцаа**

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Хуулийн этгээд - Харилцах данс	1,160,810	560,610
Хувь хүн - Харилцах данс	4,492,212	3,840,408
<b>Нийт хэрэглэгчдийн барьцаа</b>	<b>5,653,022</b>	<b>4,401,018</b>

Хэрэглэгчдийн барьцаа гэдэг нь Монпэй платформ систем дэх Мобифинанс ББСБ ХХК-ийн гаргасан нийт цахим мөнгө юм. Монпэй үйлчилгээнд бүртгүүлсэн хэрэглэгчдийн ихэнх нь Мобикомын хэрэглэгчид юм. 1 Монпэй оноо нь 1 төгрөгтэй тэнцүү.

СЗХ-ны шаардлагын дагуу Компани нь санхүүгийн байдлын тайлан дах хэрэглэгчдийн барьцаа дансны үлдэгдлийн 20% (2019: 20%) буюу 1,130,604 мянган төгрөг (2019: 880,203 мянган төгрөг)-ийг түргэн хөрвөх эргэлтийн хөрөнгө хэлбэрээр (банкинд хадгалуулсан мөнгө, засгийн газрын бондоорх хөрөнгө оруулалт гэх мэт) хэрэглээнд ашиглахгүйгээр хязгаарлах ёстой.

Монгол Банкны шаардлагын дагуу Компани нь хэрэглэгчдийн барьцааг байршуулах банкны баталгааны данстай байх шаардлагатай. Мөн нийт гаргасан цахим мөнгө болох хэрэглэгчдийн нийт барьцаа нь баталгааны дансны үлдэгдлээс хэтрэх ёсгүй (Тодруулга 24).





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулууд – 2020 оны 12 сарын 31**

**16. Дансны болон бусад өглөг**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>2020 оны 12 сарын 31</b>	<b>2019 оны 12 сарын 31</b>
Гуравдагч талд өгөх дансны өглөг	171,835	64,840
Тооцоолсон зардал	29,245	5,382
Бусад татварын өглөг	22,615	4,665
Холбоотой талд өгөх дансны өглөг	6	30,732
<b>Дансны болон бусад өглөгийн нийт дүн</b>	<b>223,701</b>	<b>105,619</b>

Дансны болон бусад өглөгүүд нь хүүгүй, ерөнхийдөө 15-30 хоногийн хугацаатай төлөгддөг.

Монпэй үйлчилгээний хэрэглэгчдийн тоо өссөн тул 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар гуравдагч талд өгөх дансны болон бусад өглөгийн дүн мэдэгдэхүйц өссөн.

Үйлчлүүлэгчдийн буруу хүсэлтээс (жишээлбэл, банкны данс буруу) болж хийгдээгүй бэлэн мөнгөний гүйлгээ тухайн харилцагчийн барьцаа данснаас (Монпэй) хасагдан, хэрэглэгчийн банкны дансруу шилжүүлэгдэхээсээ өмнө өглөгт бүртгэгддэг.

**17. Урьдчилж орсон орлого**

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 7,400 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого нь Мобиком Корпораци ХХК-аас хэрэглэгчдэдээ Монпэй цахим мөнгө шилжүүлэх урамшуулалтай холбоотойгоор урьдчилж хүлээн авсан мөнгө болно.


**18. Хувьцаат капитал**

<i>Мянган төгрөгөөр</i>	<b>Одоо байгаа хувьцааны тоо</b>	<b>Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ (бүтэн дүнгээр)</b>	<b>Энгийн хувьцаа</b>
2019 оны 1 сарын 1-нээр	501,986	10,000	5,019,860
Гаргасан хувьцаа	-	-	-
2019 оны 12 сарын 31-нээр	501,986	10,000	5,019,860
Гаргасан хувьцаа	-	-	-
2020 оны 12 сарын 31-нээр	501,986	10,000	5,019,860

Тайлант жилд ногдол ашиг зарлаж төлөөгүй.







**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**19. Хүүгийн орлого ба зардал**


Мянган төгрөгөөр	2020	2019
<b>Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого</b>		
ХӨ-өөрх харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	1,586,312	1,831,048
ХӨ-өөрх бусад банкинд байршуулсан хөрөнгө	578,860	403,617
<b>Нийт үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого</b>	<b>2,165,172</b>	<b>2,234,665</b>
<b>Бусад ижил төстэй орлого</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	26,149	54,025
Бусад орлого	33,879	26,788
<b>Нийт бусад ижил төстэй орлого</b>	<b>60,028</b>	<b>80,813</b>
<b>Нийт хүүгийн орлого</b>	<b>2,225,200</b>	<b>2,315,478</b>
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>2,225,200</b>	<b>2,315,478</b>
<b>Хүүгийн болон бусад ижил төстэй зардал</b>		
Бондын өглөг	-	223,890
Түрээсийн өр төлбөр	20,655	8,950
<b>Нийт хүүгийн болон бусад ижил төстэй зардал</b>	<b>20,655</b>	<b>232,840</b>
<b>Нийт хүүгийн зардал</b>	<b>20,655</b>	<b>232,840</b>
<b>Хүүгийн болон бусад ижил төстэй цэвэр орлого</b>	<b>2,204,545</b>	<b>2,082,638</b>

2017 оны 5 дугаар сараас Компани нь Монпэй хэрэглэгчдэд зориулж нэг сарын хугацаатай зээл олгож эхэлсэн. Нэг хэрэглэгчид олгох зээлийг 10,000 төгрөгөөс 1,000,000 хүртэл төгрөгөөр тогтоосон. Компани зээлийн үндсэн дүнгээс хамааран жилийн 23%-аас 41%-ийн хүү тооцдог.

Компани 3 сараас 12 сар хүртэлх дуусах хугацаатай бусад банкуудад байршуулсан хөрөнгөтэй. Уг хөрөнгийн үр ашигт хүүгийн хэмжээ нь хугацаанаас хамааран жилийн 8.5%-аас 12.1%-ийн хооронд хэлбэлздэг.

Хүүгийн орлогод ойролцоогоор 17,736 мянган төгрөг (2019: 8,642 мянган төгрөг)-ийн харилцагчдын үнэ цэнэ буурсан зээлийн хүүгийн орлого багтсан. Эргэн төлөгдөхгүй хүүгийн орлогыг СТОУС-ын шаардлагын дагуу 2019 болон 2020 оны ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхгүй, мөн ихэнхи нь цахим мөнгөний үлдэгдэлтэй (барьцаатай) Монпэй хэрэглэгчид тул тухайн дүнг бүрэн нөхөх боломжтой гэж удирдлагын зүгээс үзэж байгаа.





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**20. Хураамж, шимтгэлийн орлого ба зардал**

Мянган төгрөгөөр	2020	2019
<b>Хураамж, шимтгэлийн орлого</b>		
Идэвхтэй хэрэглэгчийн орлого	1,075,253	1,078,439
Шимтгэлийн орлого	632,550	537,538
<b>Нийт хураамж, шимтгэлийн орлого</b>	<b>1,707,803</b>	<b>1,615,977</b>
<b>Хураамж, шимтгэлийн зардал</b>		
Мерчант, агенттай холбоотой зардал	(199,602)	(138,846)
Бусад банкны шимтгэл	(99,725)	(86,836)
Бусад	(19,473)	(3)
<b>Нийт хураамж, шимтгэлийн зардал</b>	<b>(318,800)</b>	<b>(225,685)</b>
<b>Хураамж, шимтгэлийн орлогын цэвэр дүн</b>	<b>1,389,003</b>	<b>1,390,292</b>

Идэвхтэй хэрэглэгчийн орлого нь Монлэй идэвхтэй хэрэглэгчийн шимтгэлтэй холбоотой.

**21. Бусад үйл ажиллагааны орлого**

Мянган төгрөгөөр	2020	2019
Валютын ханшийн бодит бус цэвэр олз	15,871	17
Бусад орлого	7,293	353
<b>Нийт бусад үйл ажиллагааны орлого</b>	<b>23,164</b>	<b>370</b>

**22. Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал**

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020	2019
Цалин хөлс		464,387	388,205
Зар сурталчилгааны зардал		820,385	340,914
Мэргэжлийн үйлчилгээний зардал		441,797	264,510
Үндсэн хөрөнгийн элэгдэл	12;14	27,392	26,090
Биет бус хөрөнгийн хорогдуулалт	13	28,390	28,390
Бусад зардал		165,994	136,476
<b>Нийт удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал</b>		<b>1,948,345</b>	<b>1,184,585</b>





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**23. Орлогын албан татварын зардал**

Орлогын албан татварын зардал нь дараахаас бүрдэнэ:

Мянаан төгрөгөөр	2020	2019
Орлогын албан татвар	160,569	212,323
Хойшлогдсон татвар	(2,812)	429
<b>Тайлант жилийн орлогын албан татварын зардал</b>	<b>157,657</b>	<b>212,752</b>

Компани нь орлогын албан татварын зорилгоор татвар ногдохгүй, хасагдахгүй зүйлсийг залруулан санхүүгийн тайлагналын зорилгоорх орлогод үндэслэн орлогын албан татварыг тооцоолдог. Ашигт ногдуулах татварын хувь нь эхний 6 тэрбум төгрөг (2019: 3 тэрбум төгрөг)-ийн орлогод 10% байх ба 6 тэрбум төгрөгнөөс дээш хэтэрсэн (2019: 3 тэрбум төгрөг) орлогын дүнд 25% (2019: 25%)–аар татвар ногдуулдаг. Хүүгийн орлогоос татварын тусгай хувь хэмжээгээр 10% (2019 онд 10%)–ийн татвар төлдөг.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Компанийн үр ашигт татварын хувиар тооцож гаргасан орлогын албан татварын зардалд 2020 оны 12 сарын 31 болон 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:


Мянаан төгрөгөөр	2020	2019
Татварын өмнөх ашиг	1,410,282	1,914,290
Хуулиар тогтоосон хувь хэмжээгээр (2020: 10%, 2019: 10%)	141,028	191,429
Татварын зорилгоор татвар ногдохгүй, татвараас хасагдахгүй зүйлсийн нөлөө:		
- Хасагдахгүй зардал	16,629	20,894
- Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгө	-	429
<b>Нийт орлогын албан татварын зардал</b>	<b>157,657</b>	<b>212,752</b>

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага**

Компанийн эрсдэлийн удирдлагын чиг үүрэг нь санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, хууль эрхзүйн эрсдэлтэй холбоотой. Санхүүгийн эрсдэл нь зах зээлийн эрсдэл (валютын эрсдэл, хүүний түвшний эрсдэл болон бусад үнийн эрсдэл), зээлийн эрсдэл ба төлбөрийн чадварын эрсдэлээс бүрдэнэ. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн үүрэг нь эрсдэлийн хязгаарыг тогтоох, эрсдэлд өртөх магадлалыг эдгээр хязгаарт барих явдал юм. Үйл ажиллагааны болон хууль эрхзүйн эрсдэлийн удирдлагын чиг үүрэг нь эдгээр эрсдэлийг багасгахын тулд дотоод бодлого, үйл ажиллагааны зохистой ажиллагааг хангахад чиглэгдсэн.

Эрсдэлийн удирдлагын хороо нь маркетинг, санхүү, хэрэглэгчийн үйлчилгээ, борлуулалт, мэдээллийн технологи ба хууль эрхзүйн хэлтсийн удирдлагуудаас бүрдэнэ. Хорооны зорилго нь дээр дурдсан болзошгүй эрсдэлийг багасгах явдал юм. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зөв зохистой явуулахад зориулсан санхүүгийн эрсдэл тус бүрийн эрсдэлийг удирдах бодлого, журам байдаг.





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодрууллагууд – 2020 оны 12 сарын 31**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**

**Зээлийн эрсдэл.** Зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн нэг тал нь нөгөө талын өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдэн санхүүгийн алдагдал хүлээх эрсдэл ба Компани ийм эрсдэлд өртөмтгий байдаг.

Харилцагч тагуудтай хийсэн зээлийн болон бусад ажил гүйлгээний үр дүнд Компанийн зээлийн эрсдэлд өртөх магадлал нэмэгдэж байдаг бөгөөд санхүүгийн хөрөнгө болон зээлтэй холбоотой балансын гадуурх үүрэг амлалтыг бий болгож байдаг.

Компанийн зээлийн эрсдэлд өртөх хамгийн их хэмжээ нь санхүүгийн байдлын тайлан дах санхүүгийн хөрөнгийн дансны үнээр тодорхойлогдоно.

**Зээлийн эрсдэлийн удирдлага.** Зээлийн эрсдэл нь Компанийн бизнесийн хамгийн том эрсдэл юм. Тиймээс удирдлага нь зээлийн эрсдэлд өртөх магадлалыг болгоомжтойгоор удирддаг.

Эрсдэлийн удирдлагын зорилгоор зээлийн эрсдэлийг тооцоолох нь нарийн төвөгтэй бөгөөд зах зээлийн нөхцөл байдал, хүлээгдэж буй мөнгөн урсгал, цаг хугацаа зэргээс хамааран өөр өөр байдаг. Хөрөнгийн багцын зээлийн эрсдэлийн үнэлгээ нь тохиолдох магадлал, хохирлын хувь хэмжээ болон харилцагч талуудын хоорондын уялдаа холбоог тооцоолохыг шаарддаг.

**Хязгаарлалт.** Компани нь нэг зээлдэгчийн хувьд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг хязгаарлах замаар зээлийн эрсдэлийн түвшинг тогтоодог. Зээлдэгч нь одоогийн зээлээ төлөөгүй тохиолдолд шинэ зээл авах боломжгүй. Зээлдэгчдэд зориулсан хязгаарлалтыг зээлийн эрсдэлийн зэрэглэл тогтоох дотоод системээр тодорхойлдог.

**Зээлийн эрсдэлийн зэрэглэл тогтоох систем.** Зээлийн эрсдэлийг хэмжих, зээлийн эрсдэлийн хэмжээгээр санхүүгийн хэрэглүүрийг ангилахын тулд Компани нь хоёр аргыг хэрэглэдэг - Дотоодын Эрсдэлд Суурилсан үнэлгээний систем эсвэл олон улсын зэрэглэл тогтоодог агентлагууд (Стандарт энд Пүүрс - " S&P", Фитч, Мүүди'с)-ын үнэлгээнд тулгуурлах арга юм.

Компани нь Хиймэл оюун ухаан дээр суурилсан Жини Машин зээлийн үнэлгээний системийг 2020 оны 9-р сараас эхлэн ашиглаж эхэлсэн болно. Үйлчлүүлэгчийг газарзүйн байршил, хүн ам зүйн шинж чанар, зээлийн түүх, гар утасны хэрэглээ, гар утасны түрээс зэрэг түүхэн өгөгдлүүд дээр нь үндэслэн үнэлдэг.

Зээлийн дотоод үнэлгээг зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүрт тохируулсныг доорх хүснэгтэнд харуулав:

<u>Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр</u>	<u>Харгалзах дотоод үнэлгээний оноо</u>
Маш онцгой	0.99500-1.0
Онцгой	0.95500-0.99499
Маш сайн	0.85500-0.95499
Сайн	0.75-0.85499
Сул	0-0.74999

Зээлийн эрсдэлийн үнэлгээний ангилал бүр нь зээл төлөх чадварын тодорхой шалгууртай:

- Маш онцгой – зээлдэгч дараах нөхцөлийг хангаж байвал 1,000,000 төгрөгийн зээл авах эрхтэй: зээлдэгч нь 0.99500 болон түүнээс дээш оноотой байх;
- Онцгой – зээлдэгч дараах нөхцөлийг хангаж байвал 500,000 төгрөгийн зээл авах эрхтэй: зээлдэгч нь 0.95500 болон түүнээс дээш оноотой байх;
- Маш сайн – зээлдэгч дараах нөхцөлийг хангаж байвал 200,000 төгрөгийн зээл авах эрхтэй: зээлдэгч нь 0.85500 болон түүнээс дээш оноотой байх;
- Сайн – зээлдэгч дараах нөхцөлийг хангаж байвал 100,000 төгрөгийн зээл авах эрхтэй: зээлдэгч нь 0.75 болон түүнээс дээш оноотой байх;
- Сул – Зээл авах эрхгүй (2020 оноос өмнө зээлдэгч 10,000 болон 50,000 төгрөгийн зээл авах боломжтой байсан)





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулауд – 2020 оны 12 сарын 31**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**

Зээлийн эрсдэлийн үнэлгээ тооцох онооны системийг дотооддоо боловсруулсан бөгөөд удирдлагаас үнэлгээг нь тогтоосон. Энэхүү системд ашиглагдах чанарын болон тоон үзүүлэлт нь шинжээчийн дүгнэлтэнд тулгуурласан. Компани нь мессэж зээлийн эрсдэлийг хэмжихдээ энэ системийг ашигладаг.

Үнэлгээний загварыг Зээлийн эрсдэлийн хэлтэс байнга хянаж, бодит гүйцэтгэлийн мэдээллийг шалгаж, шаардлагатай бол шинэчилдэг. Компани үнэлгээний тооцооллын үнэн зөвийг байнга шалгаж, загваруудын урьдчилан таамаглах боломжийг үнэлдэг.

Мүүдийз олон улсын хөндлөнгийн үнэлгээний агентлаг нь харилцагчдыг үнэлсэн байдаг. Энэхүү үнэлгээ нь олон нийтэд нээлттэй байдаг. Энэхүү үнэлгээ буюу үүргээ биелүүлээгүй байх магадлалыг ("ҮББМ") банкинд байршуулсан хөрөнгийн хувьд хэрэглэсэн.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт. ХЗА нь ирээдүйд хүлээж болзошгүй мөнгөний алдагдлын өнөөгийн үнэ цэнийг магадлалын үндсэн дээр жинлэсэн тооцоолол (өөрөөр хэлбэл: зээлийн үргэлжлэх хугацаанд зээл төлөгдөхгүй болоход эрсдэлээр жинлэсэн дундаж алдагдал) юм. ХЗА нь нэг хүчин зүйлээс шууд хамааралтай бус хэд хэдэн боломжит хувилбаруудаас хамаарч тооцоологддог. Компанийн ХЗА-ын тооцоолол дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: үүргээ биелүүлээгүй байх магадлал (ҮББМ), үүргээ биелүүлээгүй байх үеийн үлдэгдэл (ҮББҮҮ), үүргээ биелүүлээгүй байх үеийн алдагдлын хэмжээ (ҮББҮАХ) болон дискаунтын хувь орно.

ҮББҮҮ гэдэг нь тайлант хугацааны дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлтийг авч үзэн зээлдэгчийн ирээдүйд төлөх төлбөр төлөгдөхгүй болох үед хэдий хэмжээний өртэй байхыг харуулдаг таамаглал юм. ҮББМ гэдэг нь зээлдэгч өгөгдсөн хугацаанд үүргээ биелүүлээгүй байх магадлалыг тооцоолдог. ҮББҮАХ нь үүргээ биелүүлээгүйгээс үүссэн алдагдлын тооцоолол. Үүнийг төлөх ёстой гэрээний мөнгөн урсгал болон зээлдэгчийн барьцаа хөрөнгөөс гарах мөнгийг оролцуулан хүлээж буй мөнгөн дүн хоёрын зөрүүнд үндэслэнэ. Ихэвчлэн ҮББҮҮ-ийг хувиар илэрхийлдэг. Хүлээгдэж буй алдагдал нь тайлант хугацааны эцэст дискаунтчиллагдан өнөөгийн үнэ цэнээр бүртгэгддэг. Санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшингээр дискаунтын хувь тодорхойлогдоно.

Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь хэрэглүүрийн хугацааны туршид загварчлагдсан. Хугацааны турш гэдэг нь гэрээний үлдсэн хугацаа буюу өрийн хэрэглүүрийн дуусгавар болох өдөр хүртэл үргэлжилнэ.

Удирдлага нь хугацааны турш ХЗА-ыг загварчилдаг ба энэ нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын үлдэх хугацааны туршид үүсч болзошгүй бүх тохиолдлоос үүсэх алдагдал юм. 12 сарын ХЗА нь тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор санхүүгийн хэрэглүүрт тохиолдох болзошгүй үйл явдлаас үүсэх ба ашиглалтын хугацааны ХЗА-ын нэг хэсгийг илэрхийлнэ.

Энэхүү санхүүгийн тайлангийн зорилгоор удирдлагын тооцоолсон ХЗА нь захиргааны зорилгоор голдуу ашиглагддаг үйл ажиллагааны эргэлтийн явцад тооцоолох тооцооллоос илүүтэйгээр тухайн цаг хугацааны тооцоолол байна. Тооцоолол нь ирээдүйд чиглэсэн мэдээллийг авч үздэг бөгөөд үүнд ХЗА нь зээлийн эрсдэлд нөлөө үзүүлэх макро эдийн засгийн гол хувьсагчуудын магадлалыг тусгадаг.

ҮББМ-ыг хэмжих зорилгоор харилцагч тал гэрээний төлбөрөө 90 хоногоос дээш хугацаагаар төлөөгүй нөхцөл байдал үүсэхийг Компани нь үүргээ биелүүлээгүй байх нөхцөл гэж тодорхойлсон.

Тодруулгын зорилгоор Компани нь үүргээ биелүүлээгүй байх тодорхойлолтыг үнэ цэнэ буурсан хөрөнгийн тодорхойлолттой бүрэн нийцүүлсэн. Дээр дурдсан үүргээ биелүүлээгүй байх тодорхойлолт нь Компанийн бүх төрлийн санхүүгийн хөрөнгийн хувьд ашиглагдана.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (ЗЭМӨ) байгаа эсэх үнэлгээг дангаар нь болон багцын түвшинд хийнэ. Зээл болон бусад санхүүгийн хөрөнгийн хувьд ЗЭМӨ-ийг үнэлгээний загвараас хамааран багцад үндэслэн эсвэл бие даасан байдлаар үнэлнэ. ЗЭМӨ-ийг тодорхойлоход ашиглах шалгуурийн зохистой байдлыг Компанийн Зээлийн эрсдэлийн хэлтэс тодорхой давтамжтайгаар хянаж байдаг. 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулууд – 2020 оны 12 сарын 31**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**

санхүүгийн хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн томоохон өөрчлөлт байсан гэсэн таамаглалыг няцаагаагүй байна.

Энэхүү санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ХЗА-ын түвшин нь анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлдэгчийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн эсэхээс хамаарна. Энэ нь ХЗА хэмжилтийн гурван үе шаттай загвар юм. Анхны хүлээн зөвшөөрөлтөөр зээлийн үнэ цэнэ буураагүй мөн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд томоохон өсөлт гараагүй санхүүгийн хэрэглүүрийг 12 сарын ХЗА (1-р шатлал)-д үндэслэн эрсдэлийн алдагдлын хасагдуулгыг хүлээн зөвшөөрдөг. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт гарсан бол санхүүгийн хэрэглүүрийг 2-р шатлал руу шилжүүлэх боловч зээлийн үнэ цэнэ буурсан гэж үзэхгүй бөгөөд алдагдлын санг ХЗА-ын хугацаанд үндэслэн байгуулна. Хэрэв санхүүгийн хэрэглүүрийн зээлийн үнэ цэнэ буурсан бол санхүүгийн хэрэглүүрийг 3-р шатлалд шилжүүлэх бөгөөд алдагдлын санг ХЗА-ын хугацаанд үндэслэн байгуулна. Хөрөнгө 3-р шатлалд байснаар нийт дансны үнэнд суурилсан хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөхөө зогсоох бөгөөд хүүгийн орлогыг ХЗА-ыг хассан дансны үнээс хөрөнгийн үр ашигт хүүгийн түвшингээр тооцоолно.

Хэрэв зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн шалгуур хангагдахаа больсон гэдэг нь нотлогдсон бол хэрэглүүрийг 1-р шатлал руу буцааж шилжүүлнэ.

Компани нь ХЗА хэмжилтийн гурван аргатай: (i) мессеж зээлийн хувьд багцын үнэлгээ, (ii) банкуудад байршуулсан хөрөнгийн хувьд гадаад эх зүүвэрт суурилсан үнэлгээ (iii) бусад санхүүгийн хөрөнгийн хувьд бие даасан ганцаарчилсан үнэлгээ.

Үнэлгээг багц дээр үндэслэн тооцоолохдоо Компани нь шилжүүлгийн матрицыг ашиглан эрсдэлд өртөх түвшинг тогтоон, алдагдлын санг хэмжинэ.

ХЗА-ыг тусгайлсан байдлаар үнэлэхдээ янз бүрийн боломжит үр дагавар тус бүрийн магадлалыг харгалзан зээлийн алдагдлыг тооцоолно. Компани үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд дор хаяж хоёр боломжит үр дагаврыг тодорхойлсон бөгөөд эдгээр хувилбарын магадлал нь магадгүй маш бага байсан ч зээлийн алдагдлыг бий болгодог. Бие даасан ганцаарчилсан үнэлгээ нь голчлон удирдлагын мэргэшсэн үнэлгээнд суурилагддаг.


ХЗА нь дараах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийн үржвэрүүдийн нийлбэр юм: дээр тайлбарласны дагуу тодорхойлогдсон ҮББҮҮ, ҮББМ ба ҮББҮАХ. ХЗА нь зээлийн эрсдэлийн параметруудийг (ҮББҮҮ, ҮББМ, ҮББҮАХ) ашиглалтын хугацааны туршид сар бүр урьдчилан тооцоолсноор тодорхойлогддог. Эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгүүдийг хооронд нь үржүүлж, оршин тогтнох магадлалыг тохируулна (жишээ нь өмнөх саруудад үүргээ биелүүлээгүй байх эсвэл үлдэгдэл төлөгдсөн байх). Энэ нь ирээдүйн ХЗА-ыг тооцоолж дараа нь нэгтгэх юм.

**Зээлийн эрсдэлийн параметрийг тооцоолох гол зарчмууд.** ҮББҮҮ-ийг бүтээгдэхүүний төрлөөс хамааран өөр өөр байдаг хүлээгдэж буй төлбөрийн байдалд үндэслэн тодорхойлно. ҮББҮҮ нь 12 сар эсвэл нийт ашиглалтын хугацаанд зээлдэгчийн төлөх ёстой гэрээний эргэн төлөлтөнд үндэслэнэ. Зээлийн богино хугацааны шинж чанараас шалтгаалан Компани ашиглалтын хугацааны ҮББМ-ыг тооцдог. Ашиглалтын хугацааны ҮББМ нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын үлдсэн хугацааны туршид үүргээ биелүүлээгүй байх магадлалыг харуулдаг бөгөөд энэ нь хэрэглүүрийн ашиглалтын хугацааны турш буюу 12 сарын хугацаандаа үүргээ биелүүлээгүй байх магадлалуудын нийлбэр юм. Компани нь ҮББМ-ын тооцоололд түүхэн мэдээлэлд үндэслэсэн шилжилтийн матрицыг ашигладаг.

ҮББҮАХ нь үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалан Компанийн хүлээх алдагдлын түвшинг илтгэнэ. 12 сар болон ашиглалтын хугацааны ҮББҮАХ нь үүргээ биелүүлэхгүй болсны дараа хүлээгдэж буй эргэн төлөлтөнд нөлөөлөх хүчин зүйлсэд үндэслэн тодорхойлогддог. ҮББҮАХ-ын үнэлгээний багцалсан аргачлал нь эргэн төлөлтийн статистик дээр суурилдаг.

**Хөндлөнгийн үнэлгээний зарчмууд.** Зарим авлагуудад хөндлөнгийн зээлийн эрсдэлийн үнэлгээ байдаг бөгөөд холбогдох Мүүдийгийн үнэлгээний агентлагаас гаргасан эргэн төлөгдөх статистик мэдээллээс зээлийн эрсдэлийн параметр ҮББМ ба ҮББҮАХ-г тооцоолоход ашиглагддаг. Энэ аргыг банкуудад байршуулсан хөрөнгийн хувьд ашигладаг.





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**

**ХЗА-ын загварт ирээдүйн нөхцөл байдлын таамаглалыг ашиглах нь.** Компани нь зээлийн эрсдэл болон ХЗА-тай харилцан хамаарал бүхий эдийн засгийн гол хувьсагчуудыг тодорхойлоогүй болно. Ирээдүйн нөхцөл байдлын таамаглалыг ашиглах нь шинжээчийн дүгнэлтэнд суурилдаг ба мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхүйц байгаагүй.

Эдийн засгийн аливаа таамаглалын нэгэн адил төсөөлөл, магадлал нь уламжлалт тодорхойгүй байдлын өндөр түвшинд хүргэдэг тул бодит үр дагавар нь төсөөлсөн төсөөллөөс үлэмж ялгаатай байж болно.

**Зах зээлийн эрсдэл.** Компани нь зах зээлийн эрсдэлийн нөлөөлөлд үйл ажиллагаагаа явуулдаг. Зах зээлийн эрсдэл нь (а) валютын ханш (б) хүүгийн түвшин болон (в) өмчийн хэрэглүүр гэх мэт зах зээлийн ерөнхий болон тусгай хувьсагчуудын хэлбэлзлийн улмаас үүсдэг. Компани хүлээн зөвшөөрөгдөж болох эрсдэлийн үнэлгээнд хязгаарыг тогтоох замаар өдөр тутам хяналт тавьдаг. Гэхдээ тухайн хязгаараас давсан, зах зээлийн мэдэгдэхүйц өөрчлөлт үүсвэл энэхүү арга нь алдагдал хүлээх эрсдэлээс хамгаалж чадахгүй.

**Гадаад валютын ханшийн эрсдэл.** Гадаад валютын ханшийн эрсдэл нь валютын ханшийн зөрүүгээс болж санхүүгийн хэрэглүүр болон ирээдүйн мөнгөн урсгалын бодит үнэ цэнэ хэлбэлзэх эрсдэлийг илэрхийлдэг. Гадаад валютаас үүсэх эрсдэл нь үндэсний мөнгөн тэмдэгтээс бусад мөнгөн тэмдэгт буюу ихэвчлэн ам.доллараар хийгдсэн гүйлгээтэй холбоотой. Компанийн гадаад валютын ажил гүйлгээ нь харьцангуй бага дүнтэй учир, ханшийн томоохон эрсдэл үүрэхгүй гэж үздэг бөгөөд гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах албан ёсны бодлого журам байхгүй байна.

Дараах хүснэгтэнд бусад бүх хувьсагч тогтмол байхад гадаад валютын ханш өөрчлөгдсөнөөр мөнгөөр солигдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг өөрчилбэл энэ нь Компанийн татварын дараах ашигт ямар нөлөө үзүүлж болохыг харуулсан:

**Татварын дараах ашигт үзүүлэх нөлөө**

Мянган төгрөгөөр	2020	2019
	Өсөлт/(Бууралт)	Өсөлт/(Бууралт)
Ам.доллар 10 хувиар чангарахад	86,242	-
Ам.доллар 10 хувиар сулрахад	(86,242)	-


**Хүүгийн түвшний эрсдэл.** Компани нь санхүүгийн байдал болон мөнгөн гүйлгээний хувьд зах зээлийн хүүний түвшний хэлбэлзлийн нөлөөнд өртдөг. Ийм өөрчлөлтийн үр дүнд хүүгийн орлого нэмэгдэх боловч гэнэтийн нөхцөл байдал үүссэнээс хамааран буурах эсвэл алдагдал үүсэх боломжтой. Компани зөвхөн хүүтэй, хугацаатай хадгаламжтай бөгөөд удирдлагын зүгээс Компанийн бизнест ихээхэн нөлөө үзүүлж болохуйц хүүгийн түвшний эрсдэл байхгүй гэж үзсэн ба энэхүү эрсдэлийн талаар тодорхой бодлого журам байдаггүй. Компанийн удирдлага хүүгийн түвшний өөрчлөлт нь Компанийн санхүүгийн үр дүнд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

Хүүгийн түвшний мэдрэмтгий байдлын шинжилгээг 12 сарын 31-ний өдрийн байдлаар доор харуулав.

Монпэй зээлийн хүүгийн түвшин 10%-аар (2019: 10% өндөр) өндөр байсан гэж үзвэл 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх тайлант жилийн ашиг 145,817 мянган төгрөг (2019: 167,205 мянган төгрөг)-өөр өндөр байх байсан.

**Төлбөрийн чадварын эрсдэл.** Төлбөрийн чадварын эрсдэл нь байгууллага санхүүгийн өр төлбөрөө барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэл үүсэх эрсдэлийг илэрхийлнэ. Компани нь өдөр тутам бэлэн мөнгөний нөөцийг харилцах данс болон зээлийн татан авалт зэргээр авах боломжтой. Компани нь эдгээр бүх хэрэгцээг хангахуйц бэлэн мөнгөний нөөцийг хадгалдаг бөгөөд хугацаа нь дуусч буй хөрөнгийн дахин хөрөнгө оруулалтын хамгийн бага түвшинг өндөр магадлалтайгаар урьдчилан таамаглаж болно гэж үздэг. Төлбөрийн чадварын эрсдэлийг өдөр тутамд Компанийн Цахим Мөнгөний хэлтсээс удирддаг. Компанийн төлбөрийн чадварын эрсдэлийн удирдлага нь хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай түргэн хөрвөх хөрөнгийн түвшинг харгалзан үзэж, төлбөрийн чадварын харьцааг хуулийн дагуу хянадаг. Компани нь Монголбанк болон СЗХ-ны шаардлагын дагуу төлбөрийн чадварын харьцааг өдөр бүр тооцдог.





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**

Монголбанкны зохицуулалтын дагуу Компани нь гаргасан цахим мөнгөний дүнтэй (хэрэглэгчдийн барьцаа) тэнцүү хэмжээний баталгааны данстай байх шаардлагатай. Баталгааны данс нь мөнгөн хөрөнгөнөөс бүрдэх ба бусад зориулалтаар болон барьцааны зорилгоор ашиглагдахыг хориглосон байдаг. Энэхүү шаардлагыг хангахын тулд Компани нь банкинд 3 сараас дээш хугацаатай хадгаламж болон тусдаа харилцах дансыг байршуулсан. Зохицуулалтын тайлагналын зорилгоор Компани эдгээр хадгаламжийг мөнгөн хөрөнгөтэй адилтгаж авч үздэг. Тиймээс удирдлага 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Компани зохицуулалтын шаардлагыг хангасан гэж үзэж байгаа болно.

Хөрвөх чадварын зөрүүг хянах. Бид төлбөрийн чадварын эрсдэлийн удирдлагаа хэрэгжүүлж, хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай түргэн хөрвөх хөрөнгийн түвшинг харгалзан үзэж байнга хянадаг ба шаардлагатай тохиолдолд үүнийг банкинд байршуулсан дуусгавар болж буй хугацаатай хадгаламжаас бүрэн нөхөх боломжтой гэж үзэж байна.

12 сарын 31-ний өдрийн байдлаар баталгааны данс ба хэрэглэгчдийн барьцааны үлдэгдлийг доор харуулав:

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020	2019
<b>Харилцах данс</b>	<b>7</b>		
Голомт банк		1,176,576	876,480
<b>Банкуудад байршуулсан хөрөнгө - 3 сараас дээш хугацаатай</b>	<b>8</b>		
Голомт банк		3,000,000	1,000,000
Хаан банк		500,000	1,000,000
Худагдаа хөгжлийн банк		1,500,000	500,000
Хас банк		1,000,000	1,000,000
<b>Нийт банкны баталгааны данс</b>		<b>7,176,576</b>	<b>4,376,480</b>
<b>Нийт хэрэглэгчдийн барьцаа</b>		<b>5,653,022</b>	<b>4,401,018</b>

Компани нь ажлын капиталын хэрэгцээг хангах хангалттай хэмжээний мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг бэлэн байлгадаг. Компанид төлбөрийн чадварын эрсдэлээс хамгаалах албан ёсны бодлого байдаггүй. Компани нь голчлон хувь нийлүүлэгчээс авсан хөрөнгө оруулалтаар санхүүждэг.


Дараах хүснэгтэнд Компанийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг тэдгээрийн гэрээнд заасан дуусгавар болох хугацаагаар нийт дүнгээр нь харуулсан. Компанийн дискаунтчлагдаагүй мөнгөн гүйлгээний дүнг гэрээнд заасан дуусгавар болох хугацаагаар үзүүлэв.

2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар:

Мянган төгрөгөөр	Тодруулга	Хугацаагүй	3 сараас доош хугацаатай	3-12 сарын хугацаатай	Нийт дүн
<b>Хөрөнгө</b>					
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө*	7	2,884,722	21,382	-	2,906,104
Банкуудад байршуулсан хөрөнгө*	8	136,368	-	6,153,618	6,289,986
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	9	-	4,221,498	-	4,221,498
Бусад санхүүгийн хөрөнгө	10	122,378	-	-	122,378
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>		<b>3,143,468</b>	<b>4,242,880</b>	<b>6,153,618</b>	<b>13,539,966</b>
<b>Өр төлбөр</b>					
Хэрэглэгчдийн барьцаа	15	5,652,902	-	120	5,653,022
Дансны болон бусад өглөг**	16	57,261	43,230	100,595	201,086
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>		<b>5,710,163</b>	<b>43,230</b>	<b>100,715</b>	<b>5,854,108</b>
<b>Цэвэр дүн</b>		<b>(2,566,695)</b>	<b>4,199,650</b>	<b>6,052,903</b>	<b>7,685,858</b>

\* алдаагийн сангийн хасаадуулыг оруулаагүй

\*\*татварын өглөгийг оруулаагүй







**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар:

Мянган төгрөгөөр	Тодруулга	Хугацаагүй	3 сараас доош хугацаатай	3-12 сарын хугацаатай	Нийт дүн
<b>Хөрөнгө</b>					
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө*	7	1,755,651	512,500	2,268,151
	Банкуудад байршуулсан хөрөнгө*	8	68,773	1,028,750	2,158,833
	Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	9	-	6,329,605	6,329,605
	Бусад санхүүгийн хөрөнгө	10	14,206	-	14,206
	<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>		<b>1,838,630</b>	<b>7,870,866</b>	<b>2,158,833</b>
<b>Өр төлбөр</b>					
	Хэрэглэгчдийн барьцаа	15	4,400,898	-	4,401,018
	Дансны болон бусад өглөг**	16	48,358	31,446	21,150
	<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>		<b>4,449,256</b>	<b>31,446</b>	<b>21,270</b>
	<b>Цэвэр дүн</b>		<b>(2,610,626)</b>	<b>7,839,409</b>	<b>2,137,563</b>
				<b>2,137,563</b>	<b>7,366,346</b>

\* алдагдлын сангийн хасаабуулыг оруулаагүй

\*\* татварын өглөгийг оруулаагүй

**25. Капиталын удирдлага**

Компанийн капиталын удирдлагын үндсэн зорилго нь хувьцаа эзэмшигчийг өгөөжтэй, бусад нөлөө бүхий талуудыг үр ашигтай байлгах, капиталын өртгийг бууруулахын тулд капиталын бүтцийг илүү тохиромжтой байдлаар зохион байгуулж Компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад оршино. Капиталын бүтцийг хэвийн хадгалах эсвэл өөрчлөхийн тулд Компани нь хувь нийлүүлэгчид төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулан тогтоох, хувь нийлүүлэгчийн хөрөнгийг буцаах, шинэ хувьцаа гаргах эсвэл өр төлбөрийг бууруулах зорилгоор хөрөнгө худалдах боломжтой.

Компани нь 2020 онд капиталын бүх гадаад шаардлагыг биелүүлсэн. 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн өөрийн хөрөнгө нь 7,530,411 мянган төгрөг (2019 онд 6,277,786 мянган төгрөг) байсан.


**26. Болзошгүй өр төлбөр ба үүрэг**

**Шүүхээр шийдүүлэх хэрэг.** Бизнесийн хэвийн нөхцөлд компани нь эсрэг нэхэмжлэл хүлээн авч болно. Өөрийн тооцоолол, дотоодын мэргэжлийн зөвлөгөөнд үндэслэн удирдлагын зүгээс нэхэмжлэлд хамаарах материаллаг хэмжээний хохирол гарахгүй гэж үзэж байгаа бөгөөд санхүүгийн тайланд үүнтэй холбоотой нөөц байгуулаагүй.

2019 оны 12 сарын 31 болон 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Компани нь ямар нэгэн шүүхийн үйл ажиллагаанд холбогдож оролцоогүй болно.

**Татварын болзошгүй өглөг.** 2020 онд батлагдсан Монгол Улсын татварын хууль тогтоомжийг Компанийн ажил гүйлгээ, үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд олон янзаар тайлбарлагдаж байгаа. Үүний үр дүнд удирдлагын авч хэрэгжүүлж буй татварын байр суурь болон татварын энэхүү байр суурийг дэмжих албан ёсны баримт бичгүүдээр татварын албанд сорилт тулгарч байна. Бизнесийн тодорхой зорилгогүйгээр хийсэн эсвэл татварын зөрчилтэй харилцагч талуудтай хамтран хийсэн татварын ажил гүйлгээнүүдийг хянан үзэх эрсдэл өндөр байгааг харгалзан Монголын татварын албаны хяналт аажмаар сайжирч байна. Татварын байгууллагууд шалгагдаж буй жилийн өмнөх таван жилийн татварыг эргэн сөхөж шалгах эрхтэй байдаг. Зарим тодорхой нөхцөл байдалд түүнээс өмнөх хугацааг хамран шалгах боломжтой.





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулууд – 2020 оны 12 сарын 31**

**26. Болзошгүй өр төлбөр ба үүрэг (Үргэлжлэл)**

Монгол Улсын үнэ шилжилт (ҮШ)-ийн тухай хууль тогтоомж нь онцлог шинж чанарыг агуулсан боловч Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас боловсруулсан олон улсын Үнэ шилжилтийн зарчимтай ерөнхийдөө нийцдэг. ҮШ-ийн тухай хууль тогтоомжоор хэрвээ ажил гүйлгээ нь сунгасан гарын зарчмын дагуу хийгдээгүй бол хянагдах ажил гүйлгээнд (харилцан хамааралтай талуудын хоорондын гүйлгээ ба холбоогүй талуудын хооронд хийгдэх тодорхой гүйлгээ) нэмэлт татвар ногдуулах боломжийг олгосон. Удирдлага одоогийн ҮШ-ийн тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөх дотоод хяналтыг хэрэгжүүлсэн.

Хянагдах ажил гүйлгээнээс үүсэх татварын өр төлбөрийг ажил гүйлгээний бодит үнээс нь хамаарч тогтоодог. Үнэ шилжилтийн дүрмийг тайлбарлах явцад ийм үнийг хэрэглэх сорилттой тулгарах боломжтой байдаг.

Ийм сорилтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй байна; гэхдээ энэ нь санхүүгийн байдал болон / эсвэл Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байж болох юм.

Монгол Улсын татварын хууль тогтоомж нь тодорхой чиглэлээр, ялангуяа нэмэгдсэн өртгийн албан татвар, суутганы албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үнэ шилжилтийн болон бусад чиглэлээр тодорхой удирдамж, зааварчилгаагаар хангадаггүй. Компани ийм тодорхойгүй хуулийн хэсгүүдийг заримдаа өөрсдийн үйл ажиллагаандаа тайлбарлан ашигладаг. Дээр дурдсанчлан захиргааны болон шүүх ажиллагааны сүүлийн үеийн өөрчлөлтийн үр дүнд татварын ийм байр суурийг өндөр хяналтанд авч магадгүй юм. Татварын байгууллагын аливаа сорилтын үр нөлөөг найдвартай үнэлэх боломжгүй; гэсэн хэдий ч энэ нь байгууллагын санхүүгийн байдал болон / эсвэл нийт үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байж болох юм.

Компанийн удирдлага нь холбогдох хууль тогтоомжийг тайлбарлан хэрэгжүүлсэн байдлаа зохистой бөгөөд Компанийн татварын болон бусад хууль тогтоомжийн талаарх байр суурь тогтвортой байна гэж үзэж байгаа. Татварын болон хууль эрх зүйн эрсдэлүүд одоогоор байхгүй гэж удирдлага үзэж байна. Удирдлага нь татварын эрсдэлийг тогтмол үнэлдэг бөгөөд ирээдүйд нөхцөл байдал өөрчлөгдөж болзошгүй тул одоогоор хангалттай урьдчилан таамаглах боломжгүй байна. 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар татварын тодорхой бус байдлыг бүртгэх нөөц санг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж удирдлага үнэлсэн.

**27. Бодит үнэ цэнийн тодруулга**

Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангилал тус бүрт тодорхойлох ба эдгээр нь (i) Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно (ii) Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ (iii) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Удирдлага нь санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэнийн түвшинг ашигладаг. Хэрэв бодит үнэ цэнийг тодорхойлоход ихээхэн тохируулга хийгдэх өгөгдлийг ашиглаж байгаа бол тухайн хэмжилт нь 3-р түвшинд хийгдэж байна гэсэн үг. Ашиглаж буй үнэлгээний өгөгдлийн ач холбогдлыг бодит үнэ цэнийн тодорхойлолттой бүхлээр нь харьцуулан тооцдог.

**Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүд.** Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүрийн тооцоолсон бодит үнэ цэнийг хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалыг ижил түвшний зээлийн эрсдэл, үлдэх хугацаатай шинэ хэрэглүүрийн одоогийн хүүгийн түвшнээр дискаунт хийж тооцоолно. Хөнгөлөлтийн хувь нь харилцагч талын зээлийн эрсдэлээс хамаарна.

**Дансны үнэ нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд.** Хэрвэх чадвар сайтай, 1 жилээс доош богино хугацаатай санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн дансны үнэ нь харгалзах бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байна.

45



**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулагууд – 2020 оны 12 сарын 31**

**27. Бодит үнэ цэнийн тодруулга (Үргэлжлэл)**

Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийн тодруулга. Бодит үнэ цэнийг 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй хөрөнгийн дансны үнэ болон бодит үнэ цэнийн ангиллаарх шатлалын дагуу дараах байдлаар харууллаа:

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Дансны дүн
<b>Санхүүгийн хөрөнгө</b>				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	874	-	-	874
- Бэлэн мөнгө	-	2,880,431	-	2,880,431
- Банкн дахь харилцах данс	-	-	-	-
- 3 сар хүртэлх хугацаатай хадгаламж	-	-	-	-
Банкуудад байршуулсан хөрөнгө				
- 3-аас дээш сарын хугацаатай хадгаламж	-	6,108,886	-	6,108,886
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-	4,221,498	4,221,498
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	122,378	122,378
<b>Санхүүгийн бус хөрөнгө</b>				
Бусад хөрөнгө	-	-	24,101	24,101
Биет бус хөрөнгө	-	-	60,272	60,272
Үндсэн хөрөнгө	-	-	16,036	16,036
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	118,237	-	118,237
<b>НИЙТ ДҮН</b>	<b>874</b>	<b>9,107,554</b>	<b>4,444,285</b>	<b>13,552,713</b>

Бодит үнэ цэнийг 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй хөрөнгийн дансны үнэ болон бодит үнэ цэнийн ангиллаарх шатлалын дагуу дараах байдлаар харууллаа:

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Дансны дүн
<b>Санхүүгийн хөрөнгө</b>				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	874	-	-	874
- Бэлэн мөнгө	-	1,754,574	-	1,754,574
- Банкн дахь харилцах данс	-	499,988	-	499,988
- 03 сар хүртэлх хугацаатай хадгаламж	-	-	-	-
Банкуудад байршуулсан хөрөнгө				
- 3-аас дээш сарын хугацаатай хадгаламж	-	3,041,299	-	3,041,299
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-	5,728,626	5,728,626
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	14,206	14,206
<b>Санхүүгийн бус хөрөнгө</b>				
Бусад хөрөнгө	-	-	10,343	10,343
Биет бус хөрөнгө	-	-	88,662	88,662
Үндсэн хөрөнгө	-	-	15,013	15,013
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	132,045	-	132,045
<b>НИЙТ ДҮН</b>	<b>874</b>	<b>5,427,906</b>	<b>5,858,850</b>	<b>11,285,630</b>





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**27. Бодит үнэ цэнийн тодруулга (Үргэлжлэл)**

Бодит үнэ цэнийг 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй өр төлбөрийн дансны үнэ болон бодит үнэ цэнийн ангиллаарх шатлалын дагуу дараах байдлаар харууллаа:

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Дансны дүн
<b>Санхүүгийн өр төлбөр</b>				
Хэрэглэгчдийн барьцаа				
- Хуулийн этгээд	-	1,160,810	-	1,160,810
- Хувь хүн	-	4,492,212	-	4,492,212
Дансны болон бусад өглөг				
- Гуравдагч талд өгөх дансны өглөг	-	171,835	-	171,835
- Холбоотой талуудын дансны өглөг	-	6	-	6
- Тооцолсон зардал	-	29,245	-	29,245
<b>Санхүүгийн бус өр төлбөр</b>				
Урьдчилж орсон орлого	-	-	7,400	7,400
Түрээсийн өр төлбөр	-	-	128,753	128,753
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>5,854,108</b>	<b>136,153</b>	<b>5,990,261</b>

Бодит үнэ цэнийг 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй өр төлбөрийн дансны үнэ болон бодит үнэ цэнийн ангиллаарх шатлалын дагуу дараах байдлаар харууллаа:

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31			
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Дансны дүн
<b>Санхүүгийн өр төлбөр</b>				
Хэрэглэгчдийн барьцаа				
- Хуулийн этгээд	-	560,610	-	560,610
- Хувь хүн	-	3,840,408	-	3,840,408
Дансны болон бусад өглөг				
- Гуравдагч талд өгөх дансны өглөг	-	64,840	-	64,840
- Холбоотой талуудын дансны өглөг	-	30,732	-	30,732
- Тооцолсон зардал	-	5,382	-	5,382
<b>Санхүүгийн бус өр төлбөр</b>				
Урьдчилж орсон орлого	-	-	309,208	309,208
Түрээсийн өр төлбөр	-	-	135,393	135,393
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>4,501,972</b>	<b>444,601</b>	<b>4,946,573</b>

**28. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансдын үлдэгдэл**

Хэрвээ компани нь нэг хяналтын дор эсвэл аль нэг тал нь нөгөө талынхаа хяналтан дор байвал эсвэл санхүүгийн болон үйл ажиллагааны шийдвэр гаргахад нөгөө талдаа мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байвал тухайн талуудыг харилцан холбоотой талууд гэнэ. Харилцан холбоотой талуудын холбоог тодорхойлох явцад тэдгээрийн хуулийн хэлбэрийг анхаарахаасаа илүү харилцаа холбооны мөн чанарыг чухалчилж үзэх хэрэгтэй.





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулгууд – 2020 оны 12 сарын 31**

**28. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансдын үлдэгдэл (Үргэлжлэл)**

Компани тайлант жилийн турш дараах гүйлгээнүүдийг хийсэн бөгөөд 12 сарын 31-ний өдрийн байдлаар толгой компанитай хийсэн ажил гүйлгээ болон дансдын үлдэгдлүүдийг дор үзүүлэв:

Мянаан төгрөгөөр	Он	Үзүүлсэн үйлчилгээ	Авсан үйлчилгээ	Дансны авлага	Дансны өглөг	Хэрэглэгчийн барьцаа
KDDI корпораци	2020	-	-	6,331	-	-
KDDI корпораци	2019	-	-	6,392	-	-
Мобиком корпораци ХХК	2020	1,074,411	619,493	9,864	-	256,077
Мобиком корпораци ХХК	2019	1,078,439	594,874	-	(338,834)	304,233

Тайлант хугацаанд бусад холбоотой талууд буюу нэг хяналттай/удирдлагатай компаниудтай хийсэн ажил гүйлгээнүүд болон дансдын үлдэгдлүүдийг дор үзүүлэв:

Мянаан төгрөгөөр	Он	Үзүүлсэн үйлчилгээ	Авсан үйлчилгээ	Дансны авлага	Дансны өглөг	Хэрэглэгчийн барьцаа
Ньютел ХХК	2020	-	28,717	-	-	-
Ньютел ХХК	2019	-	-	-	-	-
Мобинет ХХК	2020	842	19,419	-	6	4,651
Мобинет ХХК	2019	-	1,164	-	105	3,101
Монгол Контент ХХК	2020	-	1,210	-	-	-
Монгол Контент ХХК	2019	-	-	-	-	-
Ньюфонд ХХК	2020	-	6,600	-	-	-
Ньюфонд ХХК	2019	-	6,125	-	-	-

**Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээнд мөрдсөн нөхцөлүүд.** Жилийн эцсийн байдлаарх дансдын үлдэгдэл дүнгүүд нь барьцаагүй, хүүгүй, мөнгөөр төлөгдөх дүнгүүд байсан. Холбоотой талуудаас ямар нэг баталгаа аваагүй мөн өгөөгүй. Энэ үнэлгээ санхүүгийн тайлангийн хугацаа бүрт холбоотой талуудын санхүүгийн байдлыг болон холбоотой талуудын үйл ажиллагаа явуулж буй зах зээлийг үнэлсэнээр хийгддэг.

**Холбоотой талуудад үзүүлсэн үйлчилгээ.** Энэ нь цахим мөнгөний үйлчилгээний орлогоор илэрхийлэгдэх бөгөөд холбоотой талуудад байнгын хэрэглэгчдийн хөтөлбөрийг удирдлагаар хангаснаас ордог орлогоос бүрдэнэ. Эдгээр гүйлгээнүүдийн нөхцөлийг талууд харилцан тохиролцсон.

**Холбоотой талуудаас авсан үйлчилгээ.** Энэ нь Компанийн холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ буюу цалингийн тооцоолол, худалдан авалтын үйлчилгээ, захиргааны үйлчилгээ, хэрэглэгчийн үйлчилгээ болон программ хангамжийн үйлчилгээ зэргийг авснаас үүсдэг. Эдгээр зардлуудыг Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардалд бүртгэдэг. Эдгээр гүйлгээнүүдийн нөхцөлийг бүх талууд харилцан тохиролцсон болно (Тодруулга 22).


**Холбоотой талуудаас авах авлага ба өгөх өглөг.** Эдгээр авлага, өглөгийн гүйлгээнүүдийн нөхцөлийг бүх талууд харилцан тохиролцсон.

**Хэрэглэгчдийн барьцаа.** Эдгээр нь Мобикомын ихэнх хэрэглэгчдийн цахим мөнгөний үлдэгдэл болно.

Компанийн шууд толгой компани нь Мобиком корпораци ХХК бөгөөд Монгол улсад үүсгэн байгуулагдсан.

Компанийн хамгийн дээд толгой компани нь КДДИ Оверсис Холдинг БВ бөгөөд Нидерланд улсад үүсгэн байгуулагдсан.





**Мобифинанс ББСБ ХХК**  
**Санхүүгийн тайлангийн тодруулагууд – 2020 оны 12 сарын 31**

**28. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон дансдын үлдэгдэл (Үргэлжлэл)**

Удирдах гол ажилтнуудад олгосон цалин урамшуулал. Компани удирдах түвшний бүх ажилтныг голлох удирдлага гэж үздэг. Голлох удирдлагуудад олгосон цалин хөлс, урамшуулал дараах байдалтай байна:

Мянеан төгрөгөөр	2020	2019
Цалин хөлс	81,118	52,349
Тэтгэврийн болон нийгмийн даатгалын шимтгэл	5,673	11,956
Богино хугацааны урамшуулал	50,224	40,847
<b>Нийт дүн</b>	<b>137,015</b>	<b>105,152</b>


2020 онд удирдах гол албан тушаалтан 1 хүн байсан (2019: 1).

**29. Тайланг хугацааны дараах үйл явдлууд**

Эдгээр санхүүгийн тайланд нөлөөлөхүйц, тайлангийн хугацаа дууссанаас хойш аудитын тайланг гаргах өдөр буюу 2021 оны 3 сарын 30-ны өдөр хүртэл гарсан аливаа үйл явдлын талаарх мэдээлэл Удирдлагад байхгүй байна.

**30. Монгол хэл дээрх орчуулга**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг мөн Англи хэл дээр бэлтгэсэн болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд ялгаа эсвэл зөрчилдөх зүйл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.





#### 4.3 ХУУЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

Хуулийн фирмийн нэр	"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН
Үйл ажиллагааны чиглэл	Хуулийн зөвлөгөө
Хаяг	Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гудамж, Централ Тауэр, 13 давхар, 1301 тоот
Утас	+976-11-330048
Факс	+976-11-330049
Веб хуудас	www.mdsa.mn
Цахим шуудан	info@mdsa.mn



"Эм Ди Эс энд ХаанЛекс " ХХН нь Монгол Улсын томоохон хуулийн фирмүүдийн нэг бөгөөд "Илүү сайн үйлчилгээ үзүүлэх" зорилготойгоор 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудад дэлхийн стандартад нийцсэн хууль зүйн үйлчилгээг дотоодын туршлага, ур чадвартай хослуулан хүргэдэг.

"Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээ бүртгэгдсэн (Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 02-р сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолын дагуу), үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээл дээр хөрөнгө босгож буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай.

**Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:**

Энэхүү гэрээний зорилго нь Үнэт цаас гаргагч үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд хуулийн зөвлөх нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхтэй холбогдсон асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Хуулийн зөвлөх нь Зөвлөх үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай үнэн зөв мэдээ мэдээлэл, баримт материалыг үнэт цаас гаргагчаас шаардан авах эрхтэй.
- Хуулийн зөвлөх нь гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тодруулга өгөх, танилцуулга хийх үүрэгтэй.





- Хуулийн зөвлөх нь гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, дүгнэлт гаргах, үнэт цаас гаргагчийн нууцыг хадгалах үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч нь Хуулийн зөвлөхөд Зөвлөх үйлчилгээтэй холбоотой байж болох аливаа бүх мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөвөөр өгөх үүрэгтэй.


Хууль зүйн дүгнэлт



*Handwritten signature*



170 *Handwritten signature* (б)



*Handwritten signature*





**“МОБИФИНАНС ББСБ” ХХК-ААС ӨРИЙН БИЧИГ ГАРГАН НИЙТЭД САНАЛ  
БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ,  
ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААР**

**ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**


**ХААНА:** “МОБИФИНАНС ББСБ” ХХК-д  
**ХАЯГ:** МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, 1-Р ХОРОО,  
ЮНЕСКО ГУДАМЖ, МПМ ЦОГЦОЛБОР  
**УТАС/ФАКС:** (976-11) 75752255

**ХААНААС:** “ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН  
**ХАЯГ:** УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, СҮХБААТАРЫН ТАЛБАЙ 2  
СЭНТРАЛ ТАУЭР, 13 ДАВХАР, 1301 ТООТ  
**УТАС/ФАКС:** (976-11) 330048, (976-11) 330049



**ОГНОО:** 2021 ОНЫ 08 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР





Монгол Улс, Улаанбаатар хот 14300  
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2  
Сэнтрал Тэйор 13 дугаар 1301 тоот

Утас: +976 11 330049  
Факс: +976 11 330049  
Оффис: +976 90000001

**“МОБИФИНАНС ББСБ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ТАНАА**

2021.08.13 № 21/184

**“МОБИФИНАНС ББСБ” ХХК-ИЭС ӨРИЙН БИЧИГ ГАРГАН НИЙТЭД САНАЛ  
БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ,  
ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

Тус “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН нь (цаашид “МДСХ” гэх) нь “Мобифинанс ББСБ” ХХК (цаашид “Компани”, эсхүл “Үнэт цаас гаргагч” гэх)-ийн өрийн бичиг гарган нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр эсэх талаар энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид “Дүгнэлт” гэх)-ийг гаргаж байгаа болно. Энэхүү Дүгнэлт нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй. Энэхүү Дүгнэлт нь холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд энэ нь аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл, баталгаа өгөх зорилготой болно.

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахад ирүүлсэн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан лараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй ба Дүгнэлт гаргаагүй болно.

1. Энэхүү Дүгнэлт нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд аливаа санхүүгийн тоон мэдээллүүдийн талаар бид нарний мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Энэхүү Дүгнэлтэд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд бидний хийсэн ажил энэхүү Дүгнэлтийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх;
4. Бусад улсын хууль тогтоомж буюу бусад эрх зүйн харьяаллын хүрээнд хийгдсэн, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх талаар;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт “...санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу санхүүгийн мэдээлэл, андеррайтерын судалгаа, дүгнэлт, таамаглал болон нийтэд илэрхий мэдээллийн талаар;
6. Эд хорөнгө, эдийн бус баялгийн үнэлгээ, хувьцааны үнэ, ханшийн мэдээллийн талаар;
7. Энэхүү Дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон, эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
8. Компанийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү Дүгнэлттэй холбоотой бид гаргахгүй болно;
9. Дүгнэлт боловсруулах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд бид өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно.





Дор дурдсанаас бусад тохиолдолд бидний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү дүгнэлтийг ашиглах, ишлэл авах, бусад баримт бичигт оруулан дурдах, бусдад хувиран хүргүүлэхийг хориглоно. Үүнд:

1. Энэхүү өрийн бичиг гаргахтай холбогдуулан “Мобифинанс ББСБ” ХХК-ийн болон түүнтэй гэрээгээр ажиллаж буй нягтлан бодогч, хуульч болон мэргэжлийн зөвлөхүүд;
2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу та бүхний мэдээлэл, тайлан гаргаж хүргүүлэх ёстой төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллага.

Дүгнэлтийг дээрх хаягласан этгээдүүдэд хүргүүлсэн өдрөөс хойш хууль тогтоомжид өөрчлөлт орсон болон бусад үйл ажиллагаатай холбогдуулан бид нэмэлт хууль зүйн дүгнэлт хийх үүрэг хүлээхгүй болно.

Мөн Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхингдуулсан, Дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ харнуцлага хүлээхгүй.

Энэхүү албан бичиг нь Дүгнэлтийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

“ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН-ИЙН

ГЭНГЭЭНИЙ ХУУЛЬЧ



Д.ДҮГЭРЖАВ





### АГУУЛГА

Удиртгал	5
1.Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх	7
2.Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, гэдний Компанийг удирдах чадвар, дадлага туршлагын талаар	8
3.Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-оос баталсан “Компанийн засаглалын кодекс”-г нийцсэн эсэх	12
4.Бусадтай байгуулсан худалдах худалдан авах, бэлтгэл нийлүүлэх, зээлийн зэрг үүтг цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх	18
5.Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх	22
6.Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох ноцол байгаа эсэх	24
7.Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх	26
8.Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх	27
9.Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох	29
10.Тухайн Компанийн улсын бүртгэл, гатвар толөгчийн бүртгэлтэй холбоотой зорчил байгаа эсэх болон нэмэлт шилжилгээ, судалгаа	30
11.Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шилжилгээ	31
Гол дүгнэлт	32



Handwritten signature and initials (B)



“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН (цаашид “МДСХ”, эсхүл “Бид” гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэгт зааснаар Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх бүхий этгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор тус бүртгэлд өөрчлөлт оруулан шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (Хявралт 1.1)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох “Мобифинанс ББСБ” ХХК (Регистрийн дугаар: 5373271), (цаашид “Компани”, эсхүл “Үнэт цаас гаргагч” гэх) нь өрийн бичиг гаргаж шийтгэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг биднээс хүсч, улмаар бид 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр “Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ” (Хявралт 1.2) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид “Дүгнэлт” гэх)-ийг гаргаж байна.


Энэхүү Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн үндсэн дээр гаргаж байна. Тус Компани нь Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйл (Компанийн өрийн бичиг), 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох)-д заасны дагуу өрийн бичиг гарган СЗХ, Монголын хөрөнгийн бирж (цаашид “МХБ” гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

#### Хангагдсанд гооцох нөхцөл

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, үнэн зөв;
4. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
5. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;
6. Загвар хувилбарвар ирсэн баримт бичиг нь тухайн хувилбарыг үндэс болгон баталгааждаг;
7. Компани, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
8. Шүүх, төрийн эрх бүхий болон бусад байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;





10. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй.

Энэхүү өрийн бичгийн бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7 дахь хэсэг, СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан "МХБ-ийн "Арилжааны журам"-ын дагуу явагдана. Түүнчлэн СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болох "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын холбогдох зохицуулалтыг харгалзан үзсэн болно.

Бид Дүгнэлт гаргах зорилгоор Компаниас түүний Гэрчилгээ, Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтын хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн Компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн мэдээллийг гаргуулж судалсан болно.

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна:





“Мобифинанс ББСБ” ХХК нь Компанийн тухай хуулийн дагуу анх “Мобиком корпораци” ХХК гэх цор ганц хувьцаа эзэмшигчтэй (“Мобиком”)-гээр үүсгэн байгуулагдаж 2010 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн (Улсын бүртгэлийн дугаар: 9015002023, Регистрийн дугаар: 5373271) (Хавсралт 11.13).

“Мобифинанс” ХХК нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” болон “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн дагуу СЗХ-ны 2010 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 230 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 6.1) авсныг болон үүнтэй холбоотойгоор компанийн нэрийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан болохыг 2010.11.10-ны өдөр улсын бүртгэлд бүртгэснийг тус компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанд тэмдэглэсэн байна. (Хавсралт 11.13)

**Компанийн мэдээлэл:**

Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар: 000182924;

Улсын бүртгэлийн дугаар: 9015002025;

Регистрийн дугаар: 5373271;

Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр: “Мобифинанс ББСБ” Хязгаарлагдмал хариуцлагатай Компани;

Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл: Банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, зээлийн үйлчилгээ, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, гадаад валютын үйл ажиллагаа;

Хугацаа: Хугацаагүй;

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 1 (“Мобиком Корпораци” ХХК);

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр): 5,019,860.00;

Хуулийн этгээдийн албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Юнеско гудамж, МПМ цогцолбор;

Гэрчилгээ олгосон огноо: 2019.04.19;

Гүйцэтгэх захирал: Ш.Оюунчимэг.

Энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар 2010 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр улсын бүртгэлд бүртгэсэн тухай 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр олгогдсон Улсын бүртгэлийн гэрчилгээ (Гэрчилгээний дугаар 000182924, Улсын бүртгэлийн дугаар 9015002025, Регистрийн дугаар 5373271) (Хавсралт 13, Хавсралт 14) бүхий “Мобифинанс ББСБ” ХХК нь хууль зүйн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.





Компанийн Гүйцэтгэх захирлын эрх бүхий албан хаагчид тус тус болон  
Компанийн эрх бүхий албан тушаалтан тус тус болон  
Компанийн захирал чөлөөр эхлэхэд бүртгэгдсэн өдөр


Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Компанийн дүрэмд тус компанийн эрх бүхий албан тушаалтныг тусгайлан тодорхойлоогүй байна. Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.1 дэх заалтын дагуу Компанийн дүрэм зэрэг холбогдох байрмт бичигт үндэслэн тус компанийн Эрх бүхий албан тушаалтан гэдэгт “Мобифинанс ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Цахим мөнгөний хэлтсийн менежер, Дижитал бизнесийн хэлтсийн менежер болон энэхүү Дүгнэлтийн 4-д дурдсан “Ажил гүйцэтгэх гэрээ” (Компанийн тогтсон хэлтэсээр “аутсорсингийн гэрээ” гэх)-ний дагуу санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий тус компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч “Мобиком корпораци” ХХК-ийн Санхүүгийн асуудал эрхэлсэн дэд захирал, ахлах нягтлан бодогч, Мэдээллийн технологийн хэлтсийн менежер нарыг Компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээд гэдэг үүднээс хамруулан авч үзлээ.

Компанийн нөлөө бүхий цор ганц хувьцаа эзэмшигч “Мобиком корпораци” ХХК нь “Компанийн тухай” хуулийн дагуу хоёр хувьцаа эзэмшигч (Монгол Улсын хуулийн дагуу 2005.10.23-ны өдөр үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн “Ньюком” ХХК РД: 209596, болон Нидерланд Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Кэй Ди Ди Ай Оверсийз Холдингс Би Ви)-тэй, 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн (Улсын бүртгэлийн дугаар: 9019005111; РД: 2072572) Монгол Улсын хуулийн этгээд (Хавсралт 9.1, Хавсралт 9.2) юм.

“Мобифинанс ББСБ” ХХК-ийн дүрэм болон гүйцэтгэх захирлын албан бичгээс харахад тус Компани нь төлөөлөн удирдах зөвлөлгүй (Хавсралт 14.15) бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 75.2-т хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд орооор заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно гэж заасантай нийцсэн байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны журмын<sup>1</sup> 2.14.1-д заасны дагуу итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх банк бус санхүүгийн байгууллагад нэг буюу түүнээс дээш тооны хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байх нэмэлт шаардлага тавигддаг бөгөөд энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар Компанийн бүртгэлтэй үйл ажиллагааны чиглэлүүдэд итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагааны чиглэл байхгүй байна. Компанийн хувьцаа эзэмшигчийн 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн АН-SHM 03/21 тоот шийдвэр (Хавсралт 2.1)-ийн дагуу Компани нь итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар шийдвэрлэсэн боловч итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж авахаар эрх бүхий этгээдэд хандаж бүртгүүлээгүй байгаа тул төлөөлөн удирдах зөвлөлтэй байх нэмэлт шаардлага нь “Мобифинанс ББСБ” ХХК-ийн хувьд хамаарахгүй гэж дүгнэлээ. Хэрэв тус Компани нь итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж авах бол төлөөлөн удирдах зөвлөлтэй байх дээрх шаардлагыг хангах шаардлагатай бөгөөд энэ асуудлаар Компаниас тодруулахад Компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй болох зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалт явуулж байгаа тухай бидэнд мэдэгдсэн болно.

Компанийн эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал Ш.Оюунчимэг нь 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн АН-SHM 01/21 тоот хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хурлын тогтоол (Хавсралт 2.2)-оор, цахим мөнгөний хэлтсийн менежер М.Бүдбазар, дижитал бизнесийн хэлтсийн менежер А.Алтанбагана нар нь 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 21/15 тоот гүйцэтгэх захирлын тушаал (Хавсралт 2.3)-аар тус тус томилогдон ажиллаж байна. Тус эрх бүхий албан тушаалтнуудаас гадна тус Компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч “Мобиком корпораци” ХХК-ийн Санхүүгийн асуудал эрхэлсэн дэд захирал Б.Үнэнбат нь 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн АН-BoDM 30/17 тоот “Мобиком корпораци” ХХК-ийн ТУЗ-ийн хурлын тогтоол (Хавсралт 2.4)-оор, Дижитал бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хэлтсийн хэсгийн

<sup>1</sup> Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт







менежер Ж.Магнаашийрэв нь 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 750 тоот "Мобиком корпораци" ХХК-ийн ерөнхий захирлын тушаал (Хавсралт 2.5)-аар, Ахлах нягтлан бодогч Б.Бямбажаргал нь 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 780 тоот "Мобиком корпораци" ХХК-ийн ерөнхий захирлын тушаал (Хавсралт 2.6)-аар тус тус томилогдон ажиллаж байгаа бөгөөд дэр дурдсан Аутсорсингийн гэрээний дагуу Компанийн тухайн чиглэлээрх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилдаг байна. Гэхдээ Компанийн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлж байгаа толгой компанийн ажилтныг тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан Компанийн гүйцэтгэх захирал тушаал гаргасны үндсэн дээр ажил олгогч, ажилтны буюу хөдөлмөрийн харилцаа бодит утгаар үүснэ.

№	Нэр	Боловсрол	Ажлын туршлага
1.	Шагжжамбын Оюунчимэг (Гүйцэтгэх захирал) (Хавсралт 2.7)	2005 онд Шинжлэх ухаан техникийн их сургуулийн Компьютерийн техник менежментийн сургууль: Бизнесийн удирдлагын бакалавр (BBA); 2013 онд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улс, Кентийн Их Сургууль: Бизнесийн удирдлагын магистр (MBA);	2006/08-2010/08 онд Мобиком Корпораци ХХК: Төлөвлөлтийн албаны мэргэжилтэн; 2010/08-2012/05 онд Монгол Улсын Засгийн газар, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар: Системийн нэгтгэлийн албаны ахлах мэргэжилтэн; 2014/01-2015-01 онд Мобиком Корпораци ХХК: Бодлого, зохицуулалтын хэлтсийн менежер, ахлах; 2015/01-2016/01 онд Мобиком Корпораци ХХК: Стратегийн төслийн менежер; 2016/01-2019/10 онд Мобиком Корпораци ХХК: Стратеги, шинэ бизнес хөгжлийн албаны захирал; 2019/10-2021/04 онд Мобиком Корпораци ХХК: Дижитал бизнесийн албаны захирал; 2021/04 оноос Мобифинанс ББСБ ХХК: Гүйцэтгэх захирал.
2.	Мөнхбатын Бүдбазар (Цахим мөнгөний хэлтсийн менежер) (Хавсралт 2.8)	2004-2008 онд Мандах Бүртгэл Дээд Сургууль: Нягтлаг бодогч – хяналтын бакалавр.	2008-2010 онд Голомт банк: Ахлах теллер; 2010 оноос одоог хүртэл Мобифинанс ББСБ ХХК: Цахим мөнгөний хэлтсийн менежер
3.	Адьаагийн Алтанбагана (Дижитал бизнесийн хэлтсийн менежер)	2004-2008 онд Монгол Улсын Их Сургууль: Химийн факультет Хими технологийн инженер – Бакалавр;	2009/11-2011/11 онд Юнтел ХХК: Байгууллага хариуцсан ажилтан;





	(Хавсралт 2.9)	2018 онд Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль: Бизнесийн удирдлага – Магистр.	2011/11-2015/02 онд Юнител ХХК: Байгууллагын борлуулалтын мэргэжилтэн; 2015/02-2017/01 онд Юнител ХХК: Ахлах мэргэжилтэн; 2017/01-2019/02 онд Юнител ХХК: Хэлтсийн менежер; 2019/04-2021/03 онд Мобиком корпораци ХХК: Байгууллагын борлуулалтын хэлтсийн менежер; 2021/04 оноос Мобифинанс ББСБ ХХК: Дижитал бизнесийн хэлтсийн менежер.
4.	Баатарын Үнэнбат (Санхүүгийн асуудал эрхэлсэн дэд захирал) (Хавсралт 2.10)	1996-2000 онд Санхүү эдийн засгийн дээд сургууль: Нягтлан бодогч бакалавр.	2004-2014 онд Ньюком ХХК: Захирал; 2015-2017 онд Хувиараа бизнес эрхлэгч; 2017 оноос Мобиком корпораци ХХК: Санхүү эрхэлсэн дэд захирал.
5.	Жанчивын Магвааншийрэв (Дижитал бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хэлтсийн хэсгийн менежер) (Хавсралт 2.11)	2014 онд Турк улсын Истамбул хотын Истамбул Аядил Их Сургууль: Компьютерийн инженер бакалавр.	2014/10-2019/06 онд Мобиком корпораци ХХК: Програмист; 2019/06-2020/04 онд онд Мобиком корпораци ХХК: Төлөвлөлтийн инженер; 2020/04-2021/04 онд онд Мобиком корпораци ХХК: Ахлах инженер; 2021/04 оноос онд Мобиком корпораци ХХК: Менежер.
6.	Батсайханы Бямбажаргал (Ахлах нягтлан бодогч) (Хавсралт 2.12)	2011 онд Монгол Улсын Их Сургууль: Нягтлан бодох бүртгэл бакалавр; 2019 онд Шихихууг Их Сургууль: Эрх зүйч	2011/06-2021/06 онд Ньюфонд ББСБ ХХК: ахлах нягтлан бодогч.

Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекс заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

**КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**



*Handwritten signature*

*Handwritten signature*



№	Нэрс/Шаардлага	Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, ирээг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал ханцаг эсэх	Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (ЖТХ-ийн 84.3.2)*	Хувь хүн байх (ЖТХ-ийн 77.3, 83.2, 83.3)
1.	Шагжжамбын Оюунчимэг (Гүйцэтгэх захирал)	Үгүй	Үгүй*	Тийм
2.	Мөнхбатын Бүдбазар (Цахим мөнгөний хэлтсийн менежер)	Үгүй	Үгүй*	Тийм
3.	Адьяагийн Алтанбагана (Дижитал бизнесийн хэлтсийн менежер)	Үгүй	Үгүй*	Тийм
4.	Баатарын Үнэнбат (Санхүүгийн асуудал эрхэлсэн дэд захирал)	Үгүй	Үгүй*	Тийм
5.	Жаншвын Магваанширэв (Дижитал бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хэлтсийн хэсгийн менежер)	Үгүй	Үгүй*	Тийм
6.	Батсайханы Бямбажаргал (Ахлах нягтлан бодогч)	Үгүй	Үгүй*	Тийм

\*Монгол Улсын Хууль зүйн сайдын 2017 оны 07 сарын 21-ний өдрийн 4/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд тасна дагуу Ял шийтгэлтэй эсэх талаарх ажлын үндэстний нөхцөлд өгөгдөсгүй тул Компанийн тухай гүйцэтгэх зүйлийн 84.3.2-т заасан шийтгэл эдэлж байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнууд хангаж байгаа эсэхийг бидэнд гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үзэж авч үзэв.

Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекс заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.





Компанийн дүрэм ёсогт өөрчлөлт оруулсан нь хууль тогтоонож, ГЗХ-оос баталсан  
"Компанийн дотоод журмыг" гүйцэтгэн авч

**Мобифинанс ББСБ ХХК-ийн дүрэм.** Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн SHM 06/19 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Мобифинанс ББСБ" ХХК-ийн дүрэм (цаашид "Дүрэм" гэх)-ийг (Хавсралт 1.4) хүчин төгөлдөр мөрдөж байна. Дүрэм нь нийт 10 бүлэгтэй бөгөөд Компанийн оноосон нэр, хэлбэр, оршин байгаа хаяг, Үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, Компанийн хувьцаа, хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө, Компанийн удирдлага, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн хурал, гүйцэтгэх удирдлага, эрх хэмжээ, эрх хэмжээний хязгаарлалт, бүрэн эрхийн хугацааг тодорхойлох, Их хэмжээний ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, Нягтлан бодох бүртгэл, санхүү, татвар, аудит, ногдол ашиг хуваарилан олгох, Компанийн болон хувьцаа эзэмшигчийн хариуцлага, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Үнэт цаас гаргагчийн Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

**Хөдөлмөрийн дотоод журам.** "Мобифинанс ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 21/39 тоот тушаалаар Хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, ажил үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэхтэй холбогдсон хөдөлмөрийн харилцааг зохицуулах зорилгоор нийт 7 бүлэг, 5 хавсралтаас бүрдсэн Хөдөлмөрийн дотоод журам (Хавсралт 3.1)-ыг батлан мөрдүүлж байна. Энэ журмаар хөдөлмөрийн удирдлага зохион байгуулалт, компанийн дотоод үйл ажиллагаа, байгууллагын тамга тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх, хадгалах, хамгаалах, төлөвлөгөө тайлан гүйцэтгэлийн үнэлгээ урамшуулал, ажилд авах, ажлаас чөлөөлөх, цалин хөлс, ажил амралтын цаг, талуудын эрх үүрэг, хөдөлмөрийн сахилга, хариуцлага, бизнесийн ёс зүйн дүрмийн мөрдлөгө, хариуцлага, хөдөлмөрийн маргааны талаар зохицуулсан. Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5.1, 80.2, 130.1-т заасан шаардлагад нийцсэн байна.

**Дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааны журам.** Компанийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор бие даасан, хяраат бус байдлаар шалгалт, баталгаажуулалт хийж, зөвлөгөө өгөх үйл ажиллагааны харилцааг зохицуулах зорилгоор Компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 18/17 тоот тогтоолын хавсралтаар баталсан нийт 9 бүлгээс бүрдэх Дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааны журам (Хавсралт 3.2)-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааны журам нь зорилго, хамрах хүрээ, баримт бичгийн хариуцагч, баримт бичгийн хамаарах талууд, гүйцэтгэлийн хэмжүүр, нэр томъёо, товчлол, үйл явц буюу процессийн диаграм, процессийн алхмын тайлбар, ерөнхий зүйл, баримтлах зарчим, дотоод аудиторын үйл ажиллагаанд хориглох зүйлс, оролцогч талуудын үүрэг, оролцогч талуудын эрх, оролцогч талуудын хариуцлага, хамаарах баримт бичгүүдтэй холбоотой харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь холбогдох хууль тогтоомж, 2011 оны Засгийн газрын 311 тоот тогтоолд нийцсэн байна.

**Зээлийн үйлчилгээний журам.** Гүйцэтгэх захирлын 2020 оны 11 дугаар сарын 03-ны өдрийн тушаалын Хавсралтаар зээлийн эрх нээх гэрээний дагуу зээлийг онлайн аргаар олгох, эргүүлэн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах, зэрэг үйл ажиллагаатай холбогдон гарах харилцааг зохицуулах зорилгоор нийт 3 бүлгээс бүрдсэн УАЖ-3014:05 дугаартай Зээлийн үйлчилгээний журмыг (Хавсралт 3.3) батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар Мобифинансын эрх, үүрэг, зээл, зээлийн эрх нээх гэрээ байгуулах, зээлийн хэмжээ, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хяналт, зээлийн үйлчилгээний процессийн диаграм бүхий харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчим болон хууль тогтоомжид нийцэж байна.



16) *[Handwritten signature]*





**Цахим мөнгөний үйлчилгээний журам.** (Хавсралт 3.4) Гүйцэтгэх захирлын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 20/06 дугаар тушаалын хавсралт 1-ээр батлагдсан бөгөөд цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн дагуу төлбөр тооцооны үйл ажиллагаа, цахим мөнгөний үйлчилгээний хэрэглэгч, цахим мөнгөний үйлчилгээний хэрэглэгчийн хязгаарлалт, цахим мөнгөний үйлчилгээний төлөөлөгч, цахим мөнгөний хүлээн авагч, цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч, баталганы дансны холбоотой харилцааг зохицуулсан байна. Компани нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хүрээнд цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуула хийх болон төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхэлж байна. (Хавсралт 6.1) Дүгнэлт гаргах өдрийн байдлаар уг үйлчилгээг 2013 оны цахим төлбөр тооцоо, мөнгө гуйвуулгын үйлчилгээг СЗХ-ноос, 2018 онд цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээг Монголбанк (Хавсралт 6.2)-наас тус тус зөвшөөрөл авсан ба тусгай зөвшөөрөл нь хүчин тоголдор, түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй байна (Хавсралт 11.15)

**Цахим мөнгөний үйлчилгээний төлбөр тооцооны журам.** Гүйцэтгэх захирлын 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн тушаалын хавсралтаар цахим мөнгөний үйлчилгээний төлбөр тооцоог үлэн зов хотлох, бүртгэх, төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 5 бүлгээс бүрдсэн УАЖ-3017:05 дугаар Цахим мөнгөний үйлчилгээний төлбөр тооцооны журам (Хавсралт 3.5)-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчим болон хууль тогтоомжид нийцэж байна.


**Гадаад валют арилжааны журам.** Компанийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн тушаалын хавсралтаар хэрэглэгч гадаад валют худалдан авах, гадаад валютаа цахим мөнгөнд хөрвүүлэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 3 бүлэг, 3 хавсралтаас бүрдсэн УАЖ-3022:01 дугаартай Гадаад валют арилжааны журмыг батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.6). Энэ журмаар нийтлэг үндэслэл, хамрах хүрээ, баримт бичгийн хариуцах эгтээд, баримт бичгийн хамаарах тал, нэр томъёо болон товчлол, гүйцэтгэлийн хэмжүүр, гадаад валют арилжааны үйл ажиллагаа, хэрэглэгчийн арилжаа хийх үйл явц, гадаад валютын бэлэн байдлыг хангах, валютын эх үүсвэрийг бий болгох үйл ажиллагаа, компанийн эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан. Валютын арилжааны үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлөө авсан хэдий ч олон нийтийг хамарсан гадаад валют арилжааны үйл ажиллагаагаа эхлээгүй байгаа тухай Компани бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 11.15).


**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны журам.** Гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн тушаалаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй урьдчилан сэргийлэх, харилцаагаа таньж мэдэх, түүний ажил гүйцэтгэх хянах зорилго бүхий сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх, харилцаагчтай таньж мэдэх, мэдээллийг шалгах, гүйлгээнд хязгаар тавих, мэдээлэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 9 бүлгээс бүрдсэн журмыг (Хавсралт 3.7) батлан мөрдүүлж байна. Энэхүү журмын 7.3.5-д "... 20 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор Санхүүгийн мэдээллийн алба ("СМА")-д батлагдсан маягтын дагуу комплаенсын ажилтан Гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр мэдээлнэ" гэж заасан нь Монголбанкнаас баталсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмын 11.4.5-д "Мэдээлэх үүрэгтэй этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийн хэрэгжилтийг шалгадаг, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод бодлого, журам, хяналтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнтэй байдалд хяналт тавих чиг үүрэг бүхий гүйцэтгэх удирдлагаас хараат бус ... байна" гэж заасантай нийцэхгүй байгааг бид илрүүлсэн бөгөөд уг зорчлийг арилгахад чиглэсэн зохих оорчлолтийг журамд оруулах ажлыг эхлүүлсэн тухай Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн (Хавсралт 11.15).

Дээр дурдсан өөрчлөлтийг оруулсны үндсэн дээр энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монголбанкнаас баталсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны журам, Цахим мөнгөний журамд нийцэхээр байна.



(Б)





**Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналт болон эрдэлийн хөтөлбөр.** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай тухай хуулийн 14.1-д дотоод хяналтын болон эрдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна гэсний дагуу Гүйцэтгэх захирлын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 21/38 тоот тушаалын Хавсралт 1-ээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журмын биелэлтэд хяналт тавих, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх хууль бус үйл ажиллагаанаас үүсч болох эрдэлээс сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 10 бүлэг, 3 хавсралтаас бүрдсэн хөтөлбөр (Хавсралт 3.8) батлан мөрдүүлж байна.

2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 21/25 (Хавсралт 3.9) тоот гүйцэтгэх захирлын тушаалаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журмын хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих үүргийг нахим мөнгөний хэлтсийн Компианс ехлэх мэргэжилтэн Б.Алтанзул (хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн)-ын ажил үүрэгт нэмэлт, оорчлолт оруулж тусгасан ба тус ажилтан нь энэхүү Хөтөлбөрийн 1.2, 7 дугаар зүйл, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.4.11-д заасны дагуу Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг болно.


**Хэрэглэгчийн гомдол барагдуулах журам.** Компанийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 18/17 тоот тушаалын хавсралтаар УАЖ-3019/04 дугаартай Мобифинансын үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч, түргэн шуурхай барагдуулах, хэрэглэгчийн этгэл хангамжийг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах зорилготой нийт 9 бүлгээс бүрдсэн Хэрэглэгчийн гомдол барагдуулах журам (Хавсралт 3.10)-ыг батлан мөрдүүлж байна. Энэ журмаар нийтлэг үндэслэл, хамрах хүрээ, баримт бичгийн хариуцагч, баримт бичгийн хамаарах талууд, гүйцэтгэлийн хэмжүүр, үйлчилгээний нэр томьёо, ажил үүргийн ангилал, товчилсон буюу sandy/кэнди үйлчилгээ, мессеж зэрэг үйлчилгээний нэр томьёо, ажил үүргийн ангилал, товчилсон үг хэллэг, гомдол барагдуулах түвшин, үйл явц буюу гомдол барагдуулах процессын диаграм, процессын алхмын тайлбар, гомдол хүлээн авах суваг, гомдлыг шалган барагдуулах, хяналт, тайлан гаргах үйл ажиллагаа, гомдлын мэдээллийг тайлагнах, шинжлэх, арга хэмжээ авах, хамаарах баримт бичгүүдтэй холбоотой харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь Монголбанкнаас баталсан Цахим мөнгөний журмын 3 дугаар зүйлийн 3.3.6-д нийцэж байна.

**Мэдээллийн технологийн тасралтгүй найдвартай ажиллагааны журам.** Компанийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн тушаалын хавсралтаар мэдээллийн технологи, системийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түүнд ороллогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, тавигдах шаардлагуулыг тодорхойлох хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулах зорилгоор нийт 14 бүлгээс бүрдсэн УАЖ-3021:02 дугаартай Мэдээллийн технологийн тасралтгүй найдвартай ажиллагааны журмыг батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.11). Энэ журмаар баримт бичгийн хариуцах этгээд, хамаарах тал, гүйцэтгэлийн хэмжүүр, системийн хяналт аюулгүй байдал, системийн тасралтгүй ажиллагаа, төлөвлөгөөт зогсолт болон гэнэтийн саатлын үед ажиллах, өгөгдлийн сангийн үйл ажиллагаа, түүний нооцлох, програм хангамж, ашиглалт хөгжүүлэлттэй холбоотой харилцааг зохицуулсан.

**Залруулгын гүйлгээ хийх ажлын заавар.** Компанийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн АЗА-3113:02 дугаартай Залруулгын гүйлгээ хийх ажлын заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.12). Энэхүү заавар нь хэрэглэгчийн болон системийн алдаатай үйлдлийг гомдол, хэрэглэгчийн хүсэлтийн дагуу залруулж хэрэглэгчийг гомдолгүй болгохтой холбоотой харилцааг зохицуулсан.

**Зээл олголтын ажлын заавар.** (Хавсралт 3.13) Компанийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн АЗА-3087:02 дугаартай Зээл олголтын ажлын заавар батлан мөрдүүлж байна. Энэхүү заавар нь хэрэглэгч зээлтэй холбоотой мэдээлэл нөхцөл, шалгуурыг хангасан эсэх, системээр дамжуулан зээл олгохтой холбоотой харилцааг зохицуулсан.





**Монпэй зээл үйлчилгээний авлагатай ажиллах ажлын заавар.** Компанийн Хэрэглэгчийн үйлчилгээний газрын захирал 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн АЗА-3099:03 дугаартай Монпэй зээл үйлчилгээний авлагатай ажиллах ажлын заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.14). Энэхүү заавар нь Монпэй зээл үйлчилгээний зээлийн хугацаа хэтэрсэн хэрэглэгчийн авлагыг барагдуулах, авлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажиллагааг алдаагүй үр дүнтэй зохион байгуулах, холбогдох алба, хялсгийн хамтын ажиллагааг зохицуулсан.

**Санхүүгийн SAP програмд банкны үйл ажиллагааны клиринг дансыг бүртгэх заавар.** Компанийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн АЗА-3105:02 дугаартай Санхүүгийн SAP програмд банкны үйл ажиллагааны клиринг дансыг бүртгэх заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.15). Энэхүү заавар нь ажлын зааврыг мөрдөх ажлын байрны нэр, холбогдох дүрэм, журам, процессийн нэр, тэдгээрийн бүртгэлийн дугаар, үйл явц, урсгалын диаграмм, процессын тайлбарын талаар зохицуулсан байна.


**Санхүүгийн програмд гүйлгээ бүртгэх заавар.** Компанийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн АЗА-3114:03 дугаартай Санхүүгийн програмд гүйлгээ бүртгэх заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.16). Энэхүү заавар нь цахим мөнгөний системд анхан шатны баримтын дагуу хийгдсэн гүйлгээг санхүүгийн програмд бүртгэх, гүйлгээний тайлан бэлдэх, баримтыг архивт хүлээлгэн өгөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.


**Blacklist бүртгэх, хасах заавар.** Компанийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн АЗА-4117:01 дугаартай Blacklist бүртгэх, хасах заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.17). Энэхүү заавар нь үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс авлага үүсгэсэн болон авлага үүсгэх эрсдэлтэй хэрэглэгчдийг авлагын төрлөөр нь ангилж жагсаалт үүсгэх, үүссэн жагсаалтын дагуу мэдээллийг програмд оруулах, хянах, хэрэглэгч авлагаа барагдуулах үед тус жагсаалтаас хасах үйл ажиллагаагай холбоотой харилцааг зохицуулсан байна.

**Зээлийн тайлан гаргах, эсрдлийн сан байгуулах ажлын заавар.** Компанийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн АЗА-3129:02 дугаартай Зээлийн тайлан гаргах, эсрдлийн сан байгуулах ажлын заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.18). Энэхүү заавар нь сар бүр гаргах зээлийн болон эсрдлийн сангийн тайлан бэлтгэх, түүний загвар, үйл ажиллагааг ангилж жагсаалт үүсгэх, үүссэн жагсаалтын дагуу мэдээллийг програмд оруулах, хянах, хэрэглэгч авлагаа барагдуулах үед тус жагсаалтаас хасах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

**Sandy зээлийн гэрээ байгуулсан хэрэглэгчийг зээлийн мэдээллийн санд шалгах, зээлдэгчийн мэдээллийг нийлүүлэх ажлын заавар.** Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн АЗА-3096:02 дугаартай Sandy зээлийн гэрээ байгуулсан хэрэглэгчийг зээлийн мэдээллийн санд шалгах, зээлдэгчийн мэдээллийг нийлүүлэх ажлын заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.19). Энэхүү заавар нь sandy зээлийн эрх нээх, хэрэглэгчийг таньж мэдэх, шалгах, зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчийн хурлын #А11-SHM 05/20 дугаар тогтоол (Хавсралт 3.21)-оор Цахим мөнгөний үйлчилгээ болох Кэнди/Candy/ брэнд нэрийг Монпэй/Мопрау/ гэж өөрчлөхөөр шийдвэрлэж, уг шийдвэрийн дагуу холбогдох журамд оорчлолт орсон. Энэхүү зааврын хувьд нэршил нь өөрчлөгдөөгүй ч зааврын 4.1-д Цахим мөнгөний үйлчилгээний журам, Төлбөр тооцооны журамд заасан утгаар ойлгохоор заасан байна.

**Sandy зээл төлөх ажлын заавар.** Гүйцэтгэх захирлын 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн АЗА-3088:01 дугаартай Зээл төлөх ажлын заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.20). Энэхүү заавар нь зээлийн эргэн төлөлт, буруу гүйлгээг залруулах ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна. 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчийн хурлын #А11-SHM 05/20 дугаар тогтоол (Хавсралт 3.21)-оор Цахим мөнгөний үйлчилгээ болох Кэнди/Candy/ брэнд нэрийг Монпэй/Мопрау/ гэж өөрчлөхөөр шийдвэрлэж, уг шийдвэрийн дагуу холбогдох журамд өөрчлөлт орсон. Энэхүү заавар хувьд нэршил нь





өөрчлөгдөөгүй ч зааврын 3.1-д Цахим мөнгөний үйлчилгээний журам, Зээл, зээлийн үйлчилгээний журамд заасан утгаар ойлгохоор таасан байна.

**Монпэй цахим монго хүлээн авагч (мерчант), төлөөлөгч, партнертай тооцоо нийлэх, баталгаажуулах ажлын заавар.** Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн АЗА-3103:03 дугаартай Монпэй цахим мөнгө хүлээн авагч (мерчант), төлөөлөгч, партнертай тооцоо нийлэх, баталгаажуулах ажлын заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.22). Энэхүү заавар нь Монпэй үйлчилгээний төлөөлөгч, цахим монго хүлээн авагчтай байгуулсан гэрээний заалтуудыг дагаж мөрдөх, Компанийн Цахим мөнгөний үйлчилгээний журмын 7.7.2.3, Монголбанкны цахим мөнгөний журам 3.5.9 дэх заалтуудыг дагаж мөрдөх зорилготой бөгөөд тооцоо нийлэх акт бэлтгэх, баталгаажуулах, тайланд тусгах, тайлан бэлтгэх, архивлах, гүйцэтгэх зэрэг Компани болон монпэй мерчант, төлөөлөгч, партнерын хооронд голбор тооцоотой холбоотой харилцааг зохицуулсан байна.

**Монпэй цахим мөнгөний системийн төлбөр тооцоо гүйцэтгэх ажлын заавар.** Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн АЗА-3126:04 дугаартай Монпэй цахим мөнгөний системийн төлбөр тооцоо гүйцэтгэх ажлын заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.23). Энэхүү заавар нь цахим дансанд даа орлого хийх, цахим мөнгөний системээс гаргах, цахим данс хооронд гүйлгээ, зээл төлөлтийн гүйлгээ хийхэд шаардлагатай баримт бүрдүүлэлт болон гүйлгээ хийх аргачлалтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

**Монпэй цахим мөнгө хүлээн авагч (мерчант), төлөөлөгчийн данс нээх, данс цуцлах ажлын заавар.** Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн АЗА-3100:04 дугаартай Монпэй цахим мөнгө хүлээн авагч (мерчант), төлөөлөгчийн данс нээх, данс цуцлах ажлын заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.24). Энэхүү заавар нь www.merchant.monpay.mn нэвээр ирсэн хүсэлтээр мөн ХХМ, ДБМ, ДСБХ-ийн мэргэжилтнүүд иргэн хуулийн этгээдтэй мерчант, төлөөлөгчийн гэрээг байгуулах, гэрээний бүрдлийг хангах, данс нээх, төлөв өөрчлөх, данс цуцлах, гэрээ архивлахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

**Банкны дансанд Кэнди шилжүүлэх заавар.** Гүйцэтгэх захирлын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн АЗА-3102:01 дугаартай Банкны дансанд Кэнди шилжүүлэх заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.25). Энэхүү заавар нь Кэнди буюу монпэйг банкны дансруу шилжүүлэх, гүйлгээний нууцлал, аюулгүй байдал тэдгээрийн хоорондын гүйлгээний уялдаа холбоотой харилцааг зохицуулсан байна. 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчийн хурлын #АН-SHM 05/20 дугаар тогтоол (Хавсралт 3.21)-оор Цахим мөнгөний үйлчилгээ болох Кэнди/Candy/ брэнд нэрийг Монпэй/Monpay/ гэж өөрчлөхөөр шийдвэрлэж, уг шийдвэрийн дагуу холбогдох журамд өөрчлөлт орсон. Энэхүү заавар хувьд нэршил нь өөрчлөгдөөгүй ч зааврын 5-д Цахим мөнгөний үйлчилгээний журам, МХ үйлчилгээний төлбөр тооцооны журамд заасан утгаар ойлгохоор таасан байна.

**Зээлийн эрх нээх, гэрээ байгуулах, хадгалах ажлын заавар.** Гүйцэтгэх захирлын 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Зээлийн эрх нээх, гэрээ байгуулах, хадгалах ажлын заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.26). Энэхүү заавар нь зээл авах хүсэлтэй холбоотой хэрэглэгчид мэдээлэл өгч, зээлийн эрх нээх гэрээ байгуулах, одрийн тогтоолд хийсэн гэрээний бүрдэл, программын бүртгэл хийх, тайлагнах, хянах, хянасан гэрээгээ эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгч хадгалуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

**Зээлийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх ажлын заавар.** Гүйцэтгэх захирлын 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн АЗА-3130:01 дугаартай Зээлийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх ажлын заавар батлан мөрдүүлж байна (Хавсралт 3.27). Энэхүү заавар нь нэмэлт үйлчилгээний маягтын дагуу зээлийн гэрээг цуцлах, зээлийн эрх түр хаалгах, зээлийн эрх нээлгэх, тодорхойлолт гаргуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.





**СЗХ**  
2021.09.22 өдөр  
**БҮРТГЭВ**  
№ 01

2021-09-31

Бидний хийсэн дүн шинжилгээ болон Компанийн гүйцэтгэх захирлын мэдэгдлийн үндсэн дээр Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-оос баталсан "Компанийн засаглалын кодекс"-г нийцсэн гэж дүгнэв.



16)



СЭХ  
2021 оны 09. 22  
БҮРТГЭВ  
№ 01

2021-09-31  
БҮРТГЭВ

Тусгай зориулалтын хөрөнгийн үйл ажиллагаанд холбоотой бусад хэрэгсэл, тусгай зориулалтын үйл ажиллагаанд холбоотой бусад хэрэгсэл, тусгай зориулалтын үйл ажиллагаанд холбоотой бусад хэрэгсэл

Бид тус Компаниас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

**Контракт гэрээ.** (Хавсралт 1.1) Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээг 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр нэг жилийн хугацаагаар байгуулсан. Тус гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, түүний дотор ХЭХ-ын зөвшөөрөлтэйгээр хэрэгжүүлэх эрх, үүрэг, Гүйцэтгэх захирлын хүлээх хариуцлага, үл өрсөлдөх, оюуны өмч, цалин хөлс, гүйцэтгэлийн үнэлгээ, амралт, илүү цаг, алан үүргээ түр шилжүүлэх, орлох, ажлын үр дүнг үнэлэх, аудит хийх, давагдашгүй хүчин зүйл, гэрээ дуусгавар болгох нөхцөл, нууцлал зэргийг тодорхойлсон нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцж байна.

**Ажил гүйцэтгэх гэрээ /Аутсорсинг гэрээ/.** (Хавсралт 1.2) "Мобиком Корпораци" ХХК болон "Мобифинанс" ХХК нарын хооронд 11-905-20-1797, 14-905-20-0823 тоот "Ажил гүйцэтгэх гэрээ (outsourcing agreement)" 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдөр 1 жилийн хугацаагаар байгуулсан. Энэхүү гэрээгээр Компани нь Техникийн ашиглалт үйлчилгээ болон сүлжээний хяналт, тогтвортой ажиллагаа хангах ажил, Системийн төлөвлөлт, байгуулалт, мэдээллийн технологийн үйлчилгээний ажил, Хүний нөөц бүрдүүлэлт, сургалт хөгжүүлэлтийн ажил, Бэлтгэн нийцүүлэлт, ложистик, агуулах, захиргааны чиглэлийн ажил, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, зах зээлийн судалгаа, маркетинг сурталчилгаа, олон нийттэй харилцах ажил, Нэгдсэн дуудлагын төвийн үйлчилгээ, хэрэглэгчийн үйлчилгээний ажил, Төлөөлөгчийн ажил, Хууль эрх зүй, бодлого зохицуулалтын ажил, Дээд түвшний удирдлагын ажил гэж нийт 10 төрлийн ажил үйлчилгээг гурвавагч этгээд буюу өөрийн толгой компани болох "Мобиком корпораци" ХХК-иар гүйцэтгүүлж байна. Энэхүү гэрээний 2.2-д "Гэрээний хугацаа дуусахаас 30-нас доошгүй хоногийн өмнө талуудын аль нэгнээс гэрээ цуцлах буюу дуусгавар болгох талаар саналыг бичгээр гаргаагүй бол гэрээг энэ гэрээнд заасан ижил нөхцөл, ижил хугацаагаар дахин сунгагдсан тооцно" гэж заасан.

**Хэрэглэгчийн гэрээ /домэйн нэр ашиглах цахим гэрээний загвар/.** Худалдагч нь www.monpay.mn домэйн эрхийг эзэмших эрхийг Компанийн тээвшилд шилжүүлэх, Компани тогтоосон хугацаанд хүлээн авч тохирсон үнийг төлөх худалдах худалдан авах хэлшийн нөхцөл, талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага болон холбоотой бусад харилцааг зохицуулах зорилгоор 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 14-702-20-0800 тоот худалдах, худалдан авах гэрээ (Хавсралт 4.3)-г иргэн ХХ-тэй байгуулсан. Энэхүү гэрээгээр нийтлэг үндэслэл, гэрээний үнэ, төлбөр төлөх нөхцөл, гэрээний хугацаа, талуудын эрх, үүрэг, нууц хадгалах, талуудын хүлээх хариуцлага, нэмэлт өөрчлөлт, үйлчлэх хууль, давагдашгүй хүчин зүйл, маргаан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан нь Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1-д нийцсэн байна. Түүнчлэн Компани нь домэйн нэрийг ашиглах, төлбөр тооцоотой холбогдох харилцааг "Датаком" ХХК-ийн цахим бүртгэлийн үндсэн дээр талууд цахим онлайн орчинд хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний журам (Хавсралт 4.4)-аар зохицуулдаг байна. Дээрх журмын дагуу Датаком ХХК-ийн үйлчилгээ болох домэйн нэрийн бүртгэл, сунгалт, төлбөр тооцоо болон талуудын хүлээх эрх, үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан ба тус домэйн нэр нь 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хүчинтэй байна.

**Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:**

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн (Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 5,019,860,000 төгрөг бөгөөд үүний 5 хувь нь 250,993,000 төгрөг) бүхий үүрэг хүлээсэн гэрээ байгуулаагүй байна. (Хавсралт 11.15)

mobifinance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 5373271

mobicom  
188  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК  
9021031104 6182855

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД КӨ  
КАПИТАЛ УСК  
ХХК  
9021031104 6182855



**Түрээс, хороонгийн менежментийн цогц үйлчилгээний гэрээ.** (Хавсралт 4.5) Компани нь Мобиком Корпораци ХХК-тай 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдөр 11-206-19-0780/14-206-19-0581 тоот "Түрээс, хороонгийн менежментийн цогц үйлчилгээний гэрээ" байгуулсан бөгөөд түүнд 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 14-206-19-0581-1/11-206-19-0780-1 тоот гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулснаас үзвэл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнесскогийн гудамж 28-д байрлах оффис, үйлчилгээний зориулалттай "Монполимет комплекс"-ын барилгад 211.9 кв талбайг 2029 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар түрээсэлж байна. Энэхүү гэрээ нь одоогоор хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Тус гэрээний дагуу түрээсэлж буй хөрөнгө нь гуравдагч этгээдийн өмчлөлийн хөрөнгө бөгөөд өмчлөгч болон "Ньюком проперти" ХХК нарын хооронд байгуулагдсан түрээсийн гэрээний үндсэн дээр тус талбайг ашиглан үйл ажиллагаа явуулж байна гэж Компани бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт: 11.15).


**Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний загварууд:**


**Зээл, зээлийн эрх нээх гэрээний загвар.** (Хавсралт 4.6) Компанийн харилцагчтай байгуулдаг зээл, зээлийн эрх нээх гэрээний загварын дагуу Компаниас санал болгож буй зээлийн болон шингэр гаргах зээлийн бүтээгдэхүүн, бусад санхүүгийн үйлчилгээний нөхцөлийн дагуу Зээлдэгчид зээлийн эрх нээх, нээсэн эрхийн дагуу зээл олгох болон зээлдэгч нь авсан зээлээ түүний хүү, шимтгэлийн хамт хугацаанд эргүүлэн төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү цахим зээлийн эрх нээх гэрээний загварыг хянаж үзэхэд зээлийн нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний хугацаа дуусгавар болох, түүнийг цуцлах, маргаан шийдвэрлэх зэргийг тусгасан зэрэг нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

**Монпэй цахим мөнгөний үйлчилгээний хэрэглэгчийн гэрээний загвар.** (Хавсралт 4.7) Хэрэглэгчтэй байгуулдаг энэхүү гэрээний дагуу хэрэглэгч нь цахим мөнгөний Монпэй данс эзэмших, тухайн дансаар цахим мөнгөний үйлчилгээ авахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү Монпэй цахим мөнгөний үйлчилгээний хэрэглэгчийн гэрээний загварыг хянаж үзэхэд Компани болон хэрэглэгчийн эрх үүрэг, хариуцлага, Тухайн цахим мөнгөний гүйлгээний төрөл, ашиглаж болох тохөөрөмж, хэрэгсэл, гүйлгээний үнийн дүнгийн болон давтамжийн хязгаарлалт, цахим мөнгөний үйлчилгээнд нэвтрэх эрх, нууц үгийг нууцлах тухай, гомдол, маргаантай болон луйврын гүйлгээний талаар мэдэгдэх хэлбэр, хугацаа, түүнд хариу өгөх, арга хэмжээ авах хугацаа, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хэмжээ, түүнийг авах нөхцөл, хугацааны талаар мэдээлэл зэргийг тусгасан нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Иргэний хууль болон Монголбанкнаас баталсан 2018 оны Цахим мөнгөний журамд нийцсэн байна.

**Монпэй цахим мөнгөний үйлчилгээний байгууллагын гэрээний загвар.** (Хавсралт 4.8) Байгууллагатай байгуулдаг энэхүү гэрээний дагуу байгууллага нь цахим мөнгөний Монпэй данс эзэмших, тухайн дансаар цахим мөнгөний үйлчилгээ авахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү Монпэй цахим мөнгөний үйлчилгээний байгууллагын гэрээний загварыг хянаж үзэхэд Компани болон хэрэглэгчийн эрх үүрэг, хариуцлага, Тухайн цахим мөнгөний гүйлгээний төрөл, ашиглаж болох тохөөрөмж, хэрэгсэл, гүйлгээний үнийн дүнгийн болон давтамжийн хязгаарлалт, цахим мөнгөний үйлчилгээнд нэвтрэх эрх, нууц үгийг нууцлах тухай, гомдол, маргаантай болон луйврын гүйлгээний талаар мэдэгдэх хэлбэр, хугацаа, түүнд хариу өгөх, арга хэмжээ авах хугацаа, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хэмжээ, түүнийг авах нөхцөл, хугацааны талаар мэдээлэл зэргийг тусгасан нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Иргэний хууль болон Монголбанкнаас баталсан 2018 оны Цахим мөнгөний журамд нийцсэн байна.

**Монпэй цахим мөнгөний үйлчилгээний гэрээт төлөөлөгчийн гэрээний загвар.** (Хавсралт 4.8) Энэхүү гэрээ нь Компани болон Гэрээт төлөөлөгчийн хамтын ажиллагаа, төлбөрийн нөхцөл, талуудын эрх үүрэг, хариуцлага, гэрээний хугацаа, үйлчилгээний шимтгэлийн нөхцөлийн талаар зохицуулжээ. Уг Монпэй цахим мөнгөний үйлчилгээний гэрээт төлөөлөгчийн гэрээний загварг Төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулах хаяг, байршил, Цахим мөнгөний гүйлгээнд үүсэх





маргааныг хэрхэн зохицуулах, залруулгын гүйлгээг хэрхэн гүйцэтгэх тухай, Гэрээт төлөөлөгчийн оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, хаяг, утасны дугаарыг олон нийтэд ил тод байршуулахыг зөвшөөрөх талаар тусгасан нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Иргэний хууль болон Монголбанкнаас баталсан 2018 оны Цахим мөнгөний журамд нийцсэн байна.

**Монпэй цахим мөнгөний үйлчилгээний гэрээт төлөөлөгчийн гэрээний загвар (Партнер).** (Хавсралт 4.10) Энэхүү гэрээ нь Компани болон Гэрээт төлөөлөгчийн хамтын ажиллагаа, талуудын эрх үүрэг, хариуцаага, гэрээний хугацааны талаар заасан бөгөөд Төлөөлөгчийн ажил үйлчилгээнд шимтгэл тооцохгүй ажиллана мөнгө зөвхөн цахим мөнгө шилжүүлэх ажил гүйлгээг хийнэ гэж зохицуулжээ. Уг Монпэй цахим мөнгөний үйлчилгээний гэрээт төлөөлөгчийн гэрээний загвар (Партнер)-т Төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулах хаяг, байршил, Цахим мөнгөний гүйлгээнд үзэх маргааныг хэрхэн зохицуулах, залруулгын гүйлгээг хэрхэн гүйцэтгэх тухай, Гэрээт төлөөлөгчийн оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, хаяг, утасны дугаарыг олон нийтэд ил тод байршуулахыг зөвшөөрөх талаар тусгасан нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Иргэний хууль болон Монголбанкнаас баталсан 2018 оны Цахим мөнгөний журамд нийцсэн байна.

**Монпэй цахим мөнгөний үйлчилгээний цахим мөнгө хүлээн авагчийн гэрээний загвар (Мерчант).** (Хавсралт 4.11) Цахим мөнгө хүлээн авагч (хуулийн этгээд)-тай байгуулдаг энэхүү гэрээгээр Монпэй үйлчилгээний хамтын ажиллагаа, төлбөр тооцоотой холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү Монпэй цахим мөнгөний үйлчилгээний цахим мөнгө хүлээн авагчийн гэрээний загварыг хянаж үзэхэд Цахим мөнгө хүлээн авагчийн үйл ажиллагаа явуулах хаяг, байршил, тухайн цахим мөнгийг бэлэн мөнгөний нэгэн адил тооцож ижил үнээр бараа, ажил, үйлчилгээний төлбөрт хүлээн авах, ямар нэгэн нэмэлт шимтгэл авахгүй байх талаар мөн тухайн цахим мөнгийг зөвхөн бараа, ажил, үйлчилгээний төлбөр төлөх зорилгоор ашиглах тухай зэргийг тусгасан нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Иргэний хууль болон Монголбанкнаас баталсан 2018 оны Цахим мөнгөний журамд нийцсэн байна.

**Монпэй цахим мөнгөний үйлчилгээний цахим мөнгө хүлээн авагчийн гэрээний загвар (Мерчант).** (Хавсралт 4.12) Цахим мөнгө хүлээн авагч (хувь хүн)-тай байгуулдаг энэхүү гэрээгээр Монпэй үйлчилгээний хамтын ажиллагаа, төлбөр тооцоотой холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү Монпэй цахим мөнгөний үйлчилгээний цахим мөнгө хүлээн авагчийн гэрээний загварыг хянаж үзэхэд Цахим мөнгө хүлээн авагчийн үйл ажиллагаа явуулах хаяг, байршил, тухайн цахим мөнгийг бэлэн мөнгөний нэгэн адил тооцож ижил үнээр бараа, ажил, үйлчилгээний төлбөрт хүлээн авах, ямар нэгэн нэмэлт шимтгэл авахгүй байх талаар мөн тухайн цахим мөнгийг зөвхөн бараа, ажил, үйлчилгээний төлбөр төлөх зорилгоор ашиглах тухай зэргийг тусгасан нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Иргэний хууль болон Монголбанкнаас баталсан 2018 оны Цахим мөнгөний журамд нийцсэн байна.

**Хөдөлмөрийн гэрээний загвар.** (Хавсралт 4.13) Компанийн ажилтнуудтайгаа байгуулдаг хөдөлмөрийн гэрээний загварт Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан гэрээнд тусгах гол нөхцөлүүд болох ажлын байрны буюу албан тушаалын нэр, ажлын байрны тодорхойлолт заасан ажил, үүрэг, үндсэн шалтгаан буюу албан тушаалын цалингийн хэмжээ, хөдөлмөрийн нөхцөлийг тусгасан бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.

**Эд хоронгийн бүрэн хариуцлагын тухай гэрээний загвар.** (Хавсралт 4.14) Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.3-т заасны дагуу эд хоронгийн бүрэн хариуцаага хүлээлгэж болох ажил, албан тушаалын жагсаалтын дагуу ажилтантай байгуулах эд хоронгийн бүрэн хариуцлагын тухай гэрээний загварыг баталсан нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.

**Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ** (Хавсралт 4.15). “Мобифинанс ББСБ” ХХК-ийн нэр ганц хувьцаа эзэмшигч “Мобиком корпораци” ХХК болон түүний охин компаниуд нь Прайсуотерхаускуперс Аудит ХХК-тай 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдөр санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулсан бөгөөд тус гэрээний дагуу 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын ажлыг хийж






гүйцэтгэсэн болно. Дэрх гэрээ нь Мобиком Корпораци ХХК-ийн байгууллагын нууцал хамаардаг (Хавсралт 11.15) бөгөөд тэдгээр нь аливаа эрх зүйн зөрчил, маргаангүйгээр хэрэгжиж байгаа болохыг Компанийн санхүүгийн асуудал эрхэлсэн лэд захирал бидэнд мэдэгдсэн болно.

**Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ** (Хавсралт 4.16). Үнэт цаас гаргагчийн Монголын Хөрөнгийн Биржид нээлттэй Бондыг гаргах ажлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3-д заасан Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах /Best Effort/ хэлбэрээр ажлыг зохион байгуулах, андеррайтерийн үйлчилгээг үзүүлэх, Бонд гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдуулан талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулсан 4-804-21-0081 тоот "Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ"-г 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдөр андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний ТЗ 301/42 дугаар <http://www.frc.mn> /6701/, 5183855 регистрийн дугаартай "Өлзий энд Ко капитал УЦК" ХХК-тай байгуулсан. Энэхүү гэрээ нь Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

**Бондын гэрээ** (Хавсралт 4.17). Нэг талаас Компани, нөгөө талаас хөрөнгө оруулагчдын эрх ашгийг төлөөлөн "Өлзий энд Ко Капитал УЦК" ХХК-ийн хооронд 2021 оны 07 дугаар сарын 29-ний өдөр бондын нөхцөл, төлбөрийг тооцоолох аргачлал, мөнхэй аппликейшнээр дамжуулан бонд захиалах, худалдах, худалдан авах, бонд гаргагч хөрөнгө оруулагчдын өмнө үүргээ гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан 14-906-21-1130 тоот "Бондын гэрээ" байгуулсан. Энэхүү гэрээ нь СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болох "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

Үнэт цаас гаргагчийн байгуулсан түүний үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой дээр дурдсан гэрээ, гэрээний загвар нь хууль тогтоомжид нийцсэн байна.



*Өлзий энд Ко*




5. Хуулийн дүгнэлт гаргах явцад бид тус компанид албан ёсоор хандсанаар сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй дор дурдсан хэлцлүүдийг ирүүлснийг хянав.

Хуулийн дүгнэлт гаргах явцад бид тус компанид албан ёсоор хандсанаар сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй дор дурдсан хэлцлүүдийг ирүүлснийг хянав.

№	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл	Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй алин болох	Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх
1.	“Мобико м корпораци” ХХК	“Мобифинанс ББСБ” ХХК нь “Мобиком корпораци” ХХК-тай Компанийн техникийн ашиглалт үйлчилгээ болон сүлжээний хяналт, тогтвортой ажиллагаа хангах ажил, Системийн төлөвлөлт, байгуулалт, мэдээллийн технологийн үйлчилгээний ажил, Хүний нөөц бүрдүүлэлт, сургалт хөгжүүлэлтийн ажил, Бэлтгэн нийцүүлэлт, ложистик, агуулах, захиргааны чиглэлийн ажил, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, зах зээлийн судалгаа, маркетинг сурталчилгаа, олон нийттэй харилцах ажил, Нэгдсэн дуудлагын төвийн үйлчилгээ, хэрэглэгчийн үйлчилгээний ажил, Төлөөлөгчийн ажил, Хууль эрх зүй, бодлого зохицуулалтын ажил, Дээд түвшний удирдлагын ажил гэж нийт 10 төрлийн ажил үйлчилгээг толгой компани болох “Мобиком корпораци” ХХК-н гүйцэтгүүлэхээр “Ажил гүйцэтгэх гэрээ (outsourcing agreement)” 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдөр 11-905-20-1797, 14-905-20-0823 тоот гэрээ (Хавсралт 4.2) байгуулсан.	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Хэрэгжиж буй
2.	“Мобико м корпораци” ХХК	Компани нь Мобиком Корпораци ХХК-тай 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдөр 11-206-19-0780/14-206-19-0581 тоот “Түрээс, хөрөнгийн менежментийн цогц үйлчилгээний гэрээ” байгуулсан бөгөөд түүнд 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 14-206-19-0581-1/11-206-19-0780-1 тоот гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулснаас үзвэл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнескогийн гудамж 28-д байрлах оффис, үйлчилгээний зориулалттай “Мовполимет комплекс”-ын барилгад 211.9 кв талбайг 2029 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар түрээсэлж байна. (Хавсралт 4.5)	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Хэрэгжиж буй
3.	“Мобико м корпораци” ХХК	“Мобифинанс ББСБ” ХХК нь “Мобиком корпораци” ХХК-тай Мобифинансын цахим мөнгөний мөнгөй үйлчилгээгээр дамжуулан Мобикомын бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан борлуулах, төлбөр цуглуулах.	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Хэрэгжиж буй



*Handwritten signature*



	төлбөрөөс Мобифинанс шимтгэл авахаар 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр МС-11-901-21-0978, MF-04-901-0113 тоот "Хамтын ажиллагааны гэрээ" (Хавсралт 5.1) байгуулсан.		
--	--	--	--

**Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:**

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй хэлцэл 3-г хийсэн бөгөөд тус хэлцэл нь хэвийн хэрэгжиж байгаа. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ямар нэгэн зорчил маргаан гараагүй тухай Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно. (Хавсралт 11.15). Компанийн тухай хуулийн "89.3.Энэ хуулийн арван хоёрдугаар бүлгийн заалтууд дараах тохиолдолд үл хамаарна: 89.3.1.компанийн бүх энгийн хувьцааг нэг этгээд эзэмшиж байгаа бөгөөд уг этгээд гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа" гэдэгт дээр дурдсан сонирхлын зөрчилтэй хэлцэл хараахан хамаарахгүй байгаа хэдий ч уг хэлцлийг байгуулсан "Мобиком корпораци" ХХК-ийн гүйцэтгэх захирал нь Компанийн дүрмийн 5.1-д "...Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Мобиком Корпорацийн Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ" хэмээн заасан тул уг бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь энэхүү хэлцлийг байгуулах хүсэл зоригтой байсан гэж дүгнэв.


**Их хэмжээний хэлцлийн талаар:**

Компани сүүлийн 3 жилийн дотор их хэмжээний хэлцэл байгуулаагүй болохыг Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно. (Хавсралт 11.15).









				2021.10.17
2.	MobiXpress	10741	9435	2011.10.17-2021.10.17
3.	MobiXpress /your e-wallet/	12857	11446	2013.04.18-2023.04.18
4.	MobiXpress /таны цахим хэтэвч/	12856	11722	2013.04.19-2023.04.19
5.	Mon Pay	40-2020-0025610	40-0022431	2020.02.20-2030.02.20

Компанийн нэр дээр байх дээрх барааны тэмдгийн өмчлөх, эзэмших эрх нь Дүгнэлт гаргах одрийн байдлаар хүчин төгөлдөр бөгөөд хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр эрхээ хэрэгжүүлэхэд нь бодитой нөлөөлж болох, эсхүл бусдын эрхээр хязгаарлагдсан нөхцөл илрээгүй болно.





Улсын газар зохирлын гүйцэтгэх захирлын албан бичиг

**Үнэт цаас:**

Компани нь охин болон хараат компанигүй ба аливаа үнэт цаас эзэмшдэггүй болохыг Компанийн Гүйцэтгэх захирал албан ёсоор бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 11.15).

**Үнэт цаас гаргагчийн барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө:**

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө нь барьцаалагдаагүй байна (Хавсралт 7.1, Хавсралт 7.2).

**Тээврийн хэрэгсэл.** Компани нь 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар аливаа тээврийн хэрэгслийг өмчилдөггүй байна (Хавсралт 11.11, Хавсралт 11.15).

**Газар эзэмших эрх.** Компанийн гүйцэтгэх захирлын албан бичиг (Хавсралт 11.15) болон Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалтын албаны 2021 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 03-09/4583 тоот албан бичиг (Хавсралт 11.10), Сүхбаатар дүүргийн газар зохион байгуулалтын албаны 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 14/1365 тоот албан бичиг (Хавсралт 11.14)-ээс үзвэл Компани нь Нийслэл болон дүүрэгт аливаа газар эзэмших эрх эзэмшдэггүй болно.

**Үл хөдлөх эд хөрөнгө.** Компанийн Гүйцэтгэх захирлын албан бичиг (Хавсралт 11.15) болон Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Эд Хөрөнгийн Бүртгэлийн Газрын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 25 тоот лавлагаа (Хавсралт 11.12)-нд дурдсанаас үзвэл Компани нь аливаа үл хөдлөх хөрөнгө өмчилдөггүй болно.

26-32





Угт цаасны зардал болон өндөрлөх зөвлөлийн үндэстэй төлбөрийн хамт. Угт цаасны бүртгэл болон өндөрлөх зөвлөлийн үндэстэй төлбөрийн хамт. Угт цаасны бүртгэл болон өндөрлөх зөвлөлийн үндэстэй төлбөрийн хамт.

Компанийн Хувьцаа эзэмшигчийн 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн АН-SHM 06/21 тоот тогтоол болон түүний хавсралт (Хавсралт 8.1)-аар “Мобифинанс ББСБ” ХХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор дараах нөхцөлөөр өрийн бичиг гарган нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

1	Үнэт цаасны төрөл	Нээлттэй өрийн бичиг (бонд)
2	Олон нийтэд санал болгох нийт дүн	1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг
3	Бондын нэрлэсэн үнэ	100,000 (нэг зуун мянга) төгрөг
4	Тоо ширхэг	10,000 (хорин мянга) ширхэг
5	Хүү (жилийн буюу 365 хоног)	14% (арван дөрвөн хувь)
6	Хугацаа	12 (арван хоёр) сар /365 хоног/
7	Хүү төлөх хугацаа	Хугацааны эцэст үндсэн төлбөрийн хамт
8	Бондын эргэн төлөлт хийгдэх	Бондын хоёрдогч зах зээл нээгдсэн өдрөөс хойш 1 жилийн дараа буюу 2022 оны мөн сарын мөн өдөр (амралтын өдөр бол дараагийн ажлын өдөр)
9	Баталгаа	“Мобиком Корпораци” ХХК төлбөрийн баталгааг 100% гаргана
10	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт
11	Андеррайтерийн хөлс	Андеррайтертай байгуулах гэрээний үндсэн дээр Гүйцэтгэх захирал тодорхойлох
12	Нийтэд санал болгон гаргах хугацаа	2021 оны III улирал

Уг тогтоолоор шийдвэрийн хүрээнд шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн, холбогдох журмын дагуу арга хэмжээ авч ажиллах бүрэн эрхийг Гүйцэтгэх захиралд олгосон ба тус тогтоол нь Компанийн тухай хуулийн 4.3 дахь хэсэг, 41.2, 41.3 дахь хэсэг, 42.1 дэх хэсэг, 55.9 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1.2 дахь заалт, 6.1 дэх хэсэг, Компанийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрмийн 5.6.10 дахь заалтуудад тус нийцэж байна.

Компанийн гаргаж буй өрийн бичгийн эргэн төлөлтийн баталгааг “Мобиком корпораци” ХХК<sup>2</sup> гаргасан байна. “Мобиком корпораци” ХХК-ийн 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлын тогтоолоор Компаниас олон нийтэд зарлах бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд 100 хувийн баталгаа гаргах асуудлыг зөвшөөрч, тус шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай бүхий л арга хэмжээ авах эрхийг Корпорацийн ерөнхий захирал Тацуяа Хамадад олгожээ. (Хавсралт 8.2)

“Мобиком корпораци” ХХК-ийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Мобифинанс ББСБ ХХК-иас нийтэд санал болгох бонд гаргах болсонтой холбогдуулан баталгаа гаргах тухай” бичгээр охин компани болох “Мобифинанс ББСБ” ХХК-ийн зүгээс нийтэд санал болгосон бондыг хугацаанд төлөхгүй бол андеррайтераас бичгээр тавьсан шаардлага болон холбогдох бүхий л шаардлагатай нотлох баримт буюу тухайн үед үнэт цаас гаргагчийн хүлээх үүргийн хэмжээг тодорхойлсон ҮЦГХТ-ийн бичиг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор нийтэд санал болгох бондын нөхцөлийн дагуу Мобифинанс ББСБ ХХК-ийн бондын эргэн төлөлттэй холбоотой бүх өр төлбөрийг төлж барагдуулах үүргийг андеррайтерийн өмнө

<sup>2</sup> “Мобиком корпораци” ХХК-ийн “Мобифинанс ББСБ” ХХК-тай ямар холбоо хамраалтай талаар дүгээлдлийн 9-р бүтэг “Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох” хэсгээс дэлгэрэлгүй харна уу.





хүлээсэн бөгөөд үүрэг нь нийтэд санал болгох бондын үнийн дүн, хамаарах хуримтлагдсан хүү болон алданги (өдөрт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1%)-ийн нийлбэр дүнгээс хэтрэхгүй байхаар 2 жилийн хугацаатай баталгааг Монгол Улсын хуулийн дагуу гаргасан байна (Хавсралт 8.3). Бидэнд ирүүлсэн "Мобиком корпораци" ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлангаас үзвэл тус компанийн тайлант жилийн ашиг 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 47,268,105,000 (дөчин долоон тэрбум хоёр зуун жаран найман сая нэг зуун таван мянга) төгрөг байна. (Хавсралт 8.4) Ийнхүү "Мобиком корпораци" ХХК-иас баталгаа гаргаж буйтай холбоотой "Мобиком корпораци" ХХК болон "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК нарын хооронд "Мобифинанс ББСБ" ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй өрийн бичгийн эргэн төлөлтийг "Мобиком корпораци" ХХК нь өөрийн хууль ёсны эрхийн дагуу баталгаа гаргахтай холбогдсон хэлцлийн нөхцөл, түүнийг хэрэгжүүлэх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариушлагыг тодорхойлсон 11-906-21-1077 тоот "Баталгааны гэрээ"-г 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан байна. (Хавсралт 8.5)

Нийтэд ил болсон мэдээлэл, торийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулсан, Компани, түүний холбогдох этгээд болон гуравдагч этгээдээс гаргуулсан мэдээллүүдийг шинжилсний үндсэн дээр Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна гэж дүгнэв.



СХ  
2021.09.22  
БҮРТГЭЭ  
№ 01

2021-09-31  
БҮРТГЭЭ-03

**Үнэт цаас гаргах өмчийн хяналтын жинхэнэ гэрч үзүүлэх үйл ажиллагаа**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 21900002000129 тоот Компанийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (Хавсралт 11.13)-г гаргуулан судалсан. Дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг "Мобиком корпораци" ГХО ХХК эзэмшиж байна. (Хавсралт 1.4)

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг эзэмшиж байгаа Монгол Улсын хуулийн этгээд "Мобиком корпораци" ГХО ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан дүрэм (Хавсралт 9.1, Хавсралт 9.2)-ийн 4.1-д зааснаар дээрх компанийн энгийн хувьцааны 1.156 хувийг Монгол Улсын хуулийн этгээд "Ньюком" ХХК, 98.844 хувийг Нидерланд улсын хуулийн этгээд "Кэй Ди Ди Ай Оверсийс Холдингс" Би. Ви. эзэмшиж байна.

Нидерланд Улсын хуулийн этгээд "Кэй Ди Ди Ай Оверсийс Холдингс" Би. Ви.-ийн хувьцааг Япон Улсын иргэн Тацуяа Хамала (Tatsuya Hamada) буюу "Мобиком корпораци" ГХО ХХК-ийн ерөнхий захирал эзэмшиж байгаа бөгөөд 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр түүнийг "Мобифинанс ББСБ" ХХК-ийн эцсийн өмчлөгчөөр бүртгэсэн байна. (Хавсралт 11.13)

Иргэний хуулийн 26.4-т: "Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд орно" гэж заасан тул бид эдгээр компаниудын хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж, шийдвэр гаргахад хамгийн нөлөө бүхий хувь хүн (хүмүүс) Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байна гэж үзэв. Ингэхдээ Компанийн тухай хуулийн компанийн нэгдлийн талаар зохицуулсан 6 дугаар зүйл, нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлсон 99.1-д дурдсан зохицуулалтыг анхааралдаа авсан болно.

Түүнчлэн "Мобифинанс ББСБ" ХХК-ийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрмийн 5.1-д "ХЭХ нь Компанийн удирдах дээд байгууллага байна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Мобиком Корпорацийн Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ" гэж заасан байна.

Дээрх бүх анализын үндсэн дээр Дүгнэлт гаргах өдрийн байдлаар "Кэй Ди Ди Ай Оверсийс Холдингс" Би. Ви.-ийн хувьцаа эзэмшигч, "Мобифинанс ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч (Хавсралт 11.13) Тацуяа Хамала (Tatsuya Hamada)-г "Мобифинанс ББСБ" ХХК-ийн жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч гэж үзэв. Энэхүү Дүгнэлт нь бусад хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөх боломжтойг дурдаж байна.



СЗХ  
2021.09.22 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

Б.Т.Т. Ганзориг  
2021-09-31  
БҮРТГЭВ

10. Тухайн Компанийн үзэсн бүртгэл татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой өргөтгөл ханддаг зөвхөн бидний шинэчлэлтээс үүсдэггүй.

Компани нь 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар Гаалийн байгууллагад татварын өргүй (Хавсралт 10.1), 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын тодорхойлолтоор нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй (Хавсралт 10.2) байна. 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн Монголын татварын албаны тодорхойлолтоор татварын байгууллагад дутуу төлөлтгүй, 112,408,022.62 төгрөгийн илүү төлөлттэй (Хавсралт 10.3) байна. Түүнчлэн 2021 оны 07 дугаар сарын 24-ний өдөр зээлийн мэдээллийн сангаас компанийн регистрийн дугаараар хайлт хийхэд тухайн утганд тохирох зээлдэгчийн мэдээлэл олдсонгүй гэх илэрсн гарч ирсэн. (Хавсралт 10.4)

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанид нийгмийн даатгал, татварын дутуу төлөлттэй холбоотой нөхөн татвар, торгууль, алданги оногдуулаагүй байна.

30-32

  
mobi  
finance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 ☎ 5373271

  
200 УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК  
9021000552 ☎ 2072572

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЦК  
ХХК  
6183055  
9021031155 ☎ 5702000

СЗХ  
2021.09.22  
БҮРТГЭЭД  
№01

2021-08-31

1) Тухайн компанийн эрхлэх үйл ажиллагааны хариуцагчийн үндсэн ахуйт үүрэг, мөн тус үйл ажиллагааны мөнөөмөлд

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны болон МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ич холбогдолтой гэж үзэн хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, тус Компанитай холбоотой дараах ноцол байдлуудыг тогтоосон болно. Үүнд:

- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитрын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 4/984 тоот Тодорхойлолт (Хавсралт 11.1)-д тусгаснаар тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт “Мобифинанс ББСБ” ХХК нь 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албанаас 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр гаргасан 0017197 тоот Тодорхойлолт (Хавсралт 11.2)-д “Мобифинанс ББСБ” ХХК нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээлд өр төлбөргүй байна;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн төрөлжсөн архиваас 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдөр гаргасан Тодорхойлолт 1/8819 (Хавсралт 11.3)-д тусгаснаар “Мобифинанс ББСБ” ХХК нь сүүлийн 3 жилийн байдлаар Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй болохыг тодорхойлсон байна. Гүйцэтгэх захирлын албан бичиг (Хавсралт 11.15)-т дурдсанаар “Мобифинанс ББСБ” ХХК хариуцагчаар оролцож буй иргэний хэрэг байхгүй байна. Түүнчлэн Компани нь 2018 оноос хойших хугацаанд нийт 1836 хэрэгт нэхэмжлэгчээр оролцсон бөгөөд үүнээс шүүхийн шатанд хянан шийдвэрлэгдэж байгаа 420 иргэний хэрэг байна. Эдгээр нь Зээлийн үйлчилгээний журмаар тогтоосон 1 сая төгрөгийн дээд хязгаараас хэтрээгүй байна;
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн тамгын газраас 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдөр гаргасан 5035 тоот албан бичиг (Хавсралт 11.4)-т тусгаснаар “Мобифинанс ББСБ” ХХК нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилд оролцоогүй байна;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдөр гаргасан 01/1511 тоот албан бичиг (Хавсралт 11.5)-т тусгаснаар “Мобифинанс ББСБ” ХХК нь Өрсөлдөөний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д заасны дагуу давамгайл байдлтай аж ахуй эрхлэгчээр тогтоогдоогүй ба мөн тус газраас 2018, 2019, 2020 онуудад Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн гэх үндэслэлээр тус компанид захиргааны шийтгэл оногдуулаагүй байна;
- 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 3/340 тоот Оюуны өмчийн газрын албан бичиг (Хавсралт 11.6)-т дурдсанаар “Мобифинанс ББСБ” ХХК-ийн нэр дээр нийт 5 барааны тэмдэг бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн ба тэдгээртэй холбоотой аливаа лийцензийн гэрээ тус газарт бүртгэгдээгүй байна. “Мобифинанс ББСБ” ХХК-ийн нэр дээр шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар бүртгэгдээгүй байна. 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 3/332 тоот Оюуны өмчийн газрын албан бичиг (Хавсралт 11.7)-т тусгаснаар Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн мэдээллийн санд “Мобифинанс ББСБ” ХХК-ийн нэр дээр зохиогчийн эрх бүртгэлгүй байна.
- Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдөр гаргасан 9/2521 тоот албан бичиг (Хавсралт 6.3)-т тусгаснаар “Мобифинанс ББСБ” ХХК-д тус Хорооны 2010 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 230 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг анх олгосон бөгөөд 2016 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 128 дугаар





тогтоолоор зээлийн үйл ажиллагаа, 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 237 дугаар тогтоолоор төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 328 дугаар тогтоолоор гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус нэмж олгосон. 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар “Мобифинанс ББСБ” ХХК нь банк бус санхүүгийн зээл, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, 1 хувьцаа эзэмшигчтэй /“Мобиком корпораци” ХХК/, 5,019,860,000 /таван тэрбум арван есон сая найман зуун жаран мянга/ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна. “Мобифинанс ББСБ” ХХК нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байсан хугацаандаа ямар нэгэн зорчил гаргаж захиргааны хариуцлага хүлээж байгаагүй болохыг мөн дурдсан байна;

- Гаалийн ерөнхий газраас 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдөр гаргасан 03-1/1709а тоот тодорхойлолт (Хавсралт 10.1, Хавсралт 11.8)-д тусгаснаар “Мобифинанс ББСБ” ХХК нь гаалийн байгууллагад татварын өргүй болохыг тодорхойлсон байна;
- Цагдаагийн Ерөнхий Газар Мэдээлэл, Дүн Шинжилгээ, Шуурхай Удирдлагын Албаас 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 80/1261 (Хавсралт 11.9)-д “Мобифинанс ББСБ” ХХК-ийг эрүүгийн хариуцлага хүлээж, гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байсан эсэхийг цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас шалгахад холбогдох мэдээлэл бүртгэгдээгүй байна;
- Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаас 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдөр гаргасан №03-09/4583 тоот албан бичиг (Хавсралт 11.10)-т тусгаснаар “Мобифинанс ББСБ” ХХК-ийн нэрээр бүртгэлтэй Нийслэл, дүүргийн засаг даргын захирамжтай газар эзэмших, ашиглах эрх болон газрын төлбөр төлөлтийн түүх 2021 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар газрын мэдээллийн санд бүртгэгдээгүй байна.
- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн газар зохион байгуулалтын албанаас 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдөр гаргасан 14/1365 тоот албан бичиг (Хавсралт 11.14)-ээр Сүхбаатар дүүргийн газар зохион байгуулалтын албаны газрын кадастрын мэдээллийн санд хайлт хийж үзэхэд 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Д-21/147 тоот албан бичигт тусгагдсан аж ахуйн нэгж байгууллагуудын нэр дээр өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрын бүртгэл байхгүй байна.
- Автотээврийн үндэсний төвөөс 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдөр гаргасан 10 тоот лавлагаа (Хавсралт 11.11)-т дурдсанаар “Мобифинанс” /5373271/ нэр дээр 2021 оны 7 дугаар сарын 20-ны байдлаар тээврийн хэрэгсэл бүртгэлгүй байна.
- Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр гаргасан 25 тоот эд хөрөнгө бүртгэлгүй тухай лавлагаа (Хавсралт 11.12)-т Хуулийн этгээд 5373271 дугаартай 9015002025-н өмчлөл урьд нь болон өнөөдрийн байдлаар бүртгэгдээгүй байна.

**Гол дүгнэлт**

“Мобифинанс ББСБ” ХХК-ийн Үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн байна. Энэ тухай Хавсралт 01-ээс үзнэ үү.

**ХҮНДЭТГЭСЭН,**





СЭХ  
02021.09.22  
БҮРТГЭВ  
№ 01

2021-09-31  
ХАВСРАЛТ-1

Хууль зүйн сайдын 2016 оны  
А/204 дүгээр тушаалаар баталсан.

**МОНГОЛ УЛС**  
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**  
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**  
**000102924**

<u>2010.04.22</u> <i>/ Бүртгэсэн өдөр, сар, өдөр /</i>	<u>9015002025</u> <i>/ Хуулийн хэргийн дугаар /</i>	
	<u>5373271</u> <i>/ Регистрийн дугаар /</i>	
<u>Мобифинанс ББСБ</u> <span style="margin-left: 100px;"><u>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</u></span> <i>/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /</i>		
<b>Дүрэм</b> <i>/ Үүсгэн байгуулах баримт бичиг /</i>		
<u>Шийдвэр</u> <i>/ Шийдвэрийн нэр /</i>	<u>10/01</u> <i>/ Дугаар /</i>	<u>2010.04.20</u> <i>/ Он, сар, өдөр /</i>

<u>6419</u> <i>/ код /</i>	Банк бус санхүүгийн үзэм төлбөр тооцоо, мөнгөн гурвуулга <i>/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /</i>
<u>6452</u>	Зээлийн үйлчилгээ
<u>6819</u>	Төлбөр тооцооны хэрэгсэл гэрлэх
<u>Тод</u>	<i>/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /</i>

<u>Хугацаагүй</u> <i>/ Хугацаа /</i>	<u>1</u> <i>/ Хугацааны тоо /</i>	<u>5,019,860.0</u> <i>/ Өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /</i>
<u>Улаанбаатар, Чингэлтэй, 5-р хороо, баруун салбийн гудамж 22/1, У1 бөдөр 2-р давхар, Утас: 976-75752256, Утас2: , Факс: 976-70142255</u> <i>/ Хуулийн этгээдийн албан ёрын хаяг /</i>		

Гэрчилгээ дахин олгосон **2019 оны 4 сар 19 өдөр**

**Улсын бүртгэлийн ерөнхий газар**  
**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар**  
*/ Бүртгэсэн өдөр, сар, өдөр /*

**mobi**  
**finance**  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021111075 Ж 5373271

УЛААНБААТАР ХОТ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ  
0021002924 Ж 2072974

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗЛИГ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЙЦ  
ХХК

СЗХ  
2021.09.22  
БҮРТГЭВ  
№ 01

2021-09-31  
БҮРТГЭВ

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлийн бүртгэл

Д/А	Нэмэлт өөрчлөлийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Лүрээвэрэн овогтой Цэвэлдэв-е Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2019.04.19	С.Мөнхсанчир
2	Дахин гэрчилгээ олгов.	2019.04.19	С.Мөнхсанчир
3	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, ханеса, МПМ цагацалбар тоот Утас1: 75752255, Утас2: , Факс: 976-70142255 хаягидыг шинээр бүртгэв.	2019.09.11	С.Цолмон
4	64980 Гадаад валютын үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааг шинээр бүртгэв.	2019.12.11	Г.Санжваа
5	Эцсийн өмчлөгч ирээд бүртгэв.	2020.09.25	Д.Гангэмдэн
6	Шэгжэмба овогтой Оюунчимээ-а Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.05.20	Ш.Очирсүрэн



**mobi finance**  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 5373271

**mobi**  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФОН КОРПОРАЦИ ХХК  
9021000562 2072572  
204

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЭГЭЙ ЭНД КӨ  
КАПИТАЛ ҮЦК  
ХХК  
9021031195 6702200

*Улаанбаатар*

СХ  
2021.09.22  
БҮРГЭЭВ

ХАВСРАЛТ-2

2021-09-22

МОНГОЛ УЛС



МОНГОЛБАНК

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
ГЭРЧИЛГЭЭ

20 18 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Монгол Улсын "Тов банк (Монголбанк)-ны тухай хууль",  
"Үндэсний толборний системийн тухай хууль", бусад хууль  
тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Монголбанкны  
Ерөнхийлөгчийн 20 18 оны 09 сарын 27 өдрийн А-240 дугаар  
тушаалаар "Мобифинанс ББСБ" ХХК -д  
цахим мөнгө гаргах  
толборний үйлчилгээ эрхлэх зовшоорол олгов.



*Энэхүү Гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй!*

ЕРӨНХИЙЛӨГЧ

*Баяртсайхан*

Н.БАЯРТСАЙХАН





mobi  
finance  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 ☎ 5373271

УЛААНБААТАР ХОТ  
ОБНОВЛОН КОРПОРАЦИ ХХК  
902100552 ☎ 2072572

205

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ УЦК  
ХХК  
9021031155 ☎ 572420

*Олзийтсүх*



Үнэт цаасны материалтай холбоотой мэдээлэл өгөх хариуцлагатан		
Байгууллагын нэр	"МОБИФИНАНС ББСБ" ХХК	"ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК
Хариуцах ажилтан	Ш.Оюунчимэг	Б.Өлзийбаяр
Албан тушаал	Гүйцэтгэх захирал	Гүйцэтгэх захирал
Утас	9411-1036	9910-3838
Цахим шуудан	<a href="mailto:mobifinance@mobicom.mn">mobifinance@mobicom.mn</a>	<a href="mailto:info@ucc.mn">info@ucc.mn</a>



СЭХ  
2021.08.22  
БҮРТГЭВ  
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2021-08-31  
БҮРТГЭВ-03

  
mobi  
finance  
*[Signature]*  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИФИНАНС ББСБ ХХК  
9021101075 д. 5373271

  
mobicom  
*[Signature]*  
УЛААНБААТАР ХОТ  
МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК  
9021090552 д. 2072572

б)

УЛААНБААТАР ХОТ  
ӨЛЗИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ҮЦК  
ХХК  
*[Signature]*  
5183855  
9021031195 д. СТС2470



2021 OH